




АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
ШУДАРГА НИЙГМИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА



ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ, ТУРШЛАГА, СУРГАМЖ

Хянан тохиолдуулсан: Д.Дуламсүрэн /Авлигатай тэмцэх газрын
Судалгаа шинжилгээний албаны дарга, ахлах комиссар/
Тоймлон орчуулсан: Ц.Шинэбаяр /Авлигатай тэмцэх газрын
Судалгаа шинжилгээний албаны ахлах ажилтан, ахлах комиссар/
Д.Жаргалан /Авлигатай тэмцэх газрын
Судалгаа шинжилгээний албаны ажилтан, комиссар/
Б.Баярсайхан /Авлигатай тэмцэх газрын
Судалгаа шинжилгээний албаны ажилтан, комиссар/

Эх бэлтгэлд: 2015 оны 5 дугаар сарын 5-нд
Хэвлэлтэд: 2015 оны 5 дугаар сарын 11-нд
Цаасны хэмжээ: 60x84/8
Хэвлэлийн хуудас: 7 х.х
Хэвлэсэн тоо: 1000 ш
“Шидэт өнгө” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

© Авлигатай тэмцэх газар, 2015 он
Зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулахыг хориглоно.

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА 2013-2014 ОНД

ОРШИЛ

Авлига нь нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд аюул занал учруулж, ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг доройтуулах, хууль дээдлэх ёсонд хохирол учруулахуйц гэмт үзэгдэл болохын хувьд түүний эсрэг тууштай, үр дүнтэй тэмцэхэд хүсэл эрмэлзлэл нэн чухал байна. Монгол Улс Их Хурлаас 2005 онд НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийг, 2006 онд Авлигын эсрэг хуулийг батлан улмаар 2007 онд Авлигатай тэмцэх газар (АТГ)-ыг байгуулан ажиллуулсанаас хойш 8 жил болжээ. Шударга, ил тод, хариуцлагатай байдлыг ханган авлигын эсрэг тууштай, үр дүнтэй тэмцэхэд бүх нийтээр хамтран нэгдсэн хүчин чармайлтаар улс орондоо шударга ёсыг бэхжүүлэн, авлигагүй эрүүл тунгалаг нийгмийг цогцлоон хөгжүүлэх эрхэм зорилгод хүчээ нэгтгэж, хүсэл зоригоо илэрхийлэх нь өнөөгийн тулгамдаж буй зорилт болоод байна.

НҮБ-аас Авлигын эсрэг конвенцийг 2003 онд баталсан бөгөөд 2015 оны 4 дүгээр сарын байдлаар уг конвенцид дэлхийн 140¹ улс орон нэгдэн ороод байгаа нь авлига бүхий л улс орнуудын хувьд асуудал болж байгааг илтгэж байна. Нөгөө талаас, дэлхийн улс орнуудын түвшинд авлигын эсрэг амжилттай тэмцэж бүрэн ялсан, эсхүл авлигаас бүрэн ангижирсан улс орон хараахан үгүй байгаа нь энэ ажил хир хүнд хэцүү бөгөөд бэрхшээлтэй болохыг нотолж байгаа юм. Хэдий тийм ч авлигын эсрэг амжилттай тэмцэх алхам хийж буй улс орнуудын туршлагыг судлах, суралцах, нэвтрүүлэх, талуудын оролцоог хангасан үйл ажиллагаа, идэвх санаачилгыг дэмжих өрнүүлэх шаардлага зайлшгүй юм.

Иймд авлигыг таслан зогсоох, устгахад хүн бүрийн оролцоо, дэмжлэг, хувь нэмрийг чухалчлан үзэж бүх талын санаачилга, хүчин чармайлт нэн шаардлагатайг тэмдэглэн АТГ нь бусад улс орнууд болон олон улс, бүс нутгийн түвшинд авлигатай тэмцэж байгаа туршлага, сургамж, ололттой талуудыг тухай бүр судалдаг бөгөөд тэдгээрийг сонирхогч бүлэг, этгээдтэй хуваалцах, мэдээлэл өгөх зорилгоор сүүлийн 2 жилийн хугацаанд энэ чиглэлээр дэлхий дахинд болсон онцлох үйл явдал, тэргүүн туршлага, сургамжаас түүвэрлэн тойм эмхэтгэл бэлтгэн Та бүхэнд толилуулж байна.

Энэхүү эмхэтгэл уншигч Та бүхэнд шинэ санаа, сэдлийг өгч, улмаар тэдгээр нь үр дүнтэй ажил болон хэрэгжиж шударга ёсыг бэхжүүлэх, төрийн албаны нэр хүндийг өсгөх, иргэд, олон нийтийн зүгээс хүлээлгэж буй итгэлийг нэмэгдүүлэхэд тусална гэдэгт итгэж байна. Хэрэглэгчдэд эмхэтгэлийг ашиглахад хялбар байх үүднээс тусгайлан “индекс”-ийг төгсгөл хэсэгт бэлтгэж оруулсан бөгөөд сонирхсон чиглэлээр “индекс” ашиглан олох боломжийг бүрдүүлж өгсөн болно.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

¹ НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба:
<http://www.unodc.org/unodc/en/treaties/CAC/signatories.html>

**НЭГ. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА 2014 ОНД**

1. Румын Улсын Ерөнхий сайд асан авлигын хэргээр шоронд хоригдлоо² (2014.01.06)

Румын. Барилгын бизнес эрхлэгчээс нийтдээ 858000 ам.долларын хээл хахууль авсан хэрэгт Румын Улсын Ерөнхий сайд асан Адриан Настасе³-ыг буруутай болохыг тогтоож, шүүхээс түүнийг 4 жилийн хугацаанд шоронд хорих шийдвэр гаргажээ.

Төрийн байгууллагын нэгэн даргын албан тушаалд барилгын бизнес эрхлэгч Ирина Жану⁴-г томилохын тулд түүнээс хээл хахуульд 858000 ам.доллар авсан хэрэгт 63 настай Адриан Настасег буруутай болохыг тогтоолоо.

Түүнийг авлигын хэргээр шоронд хоригдоод суллагдсанаас хэдхэн сарын дараа дахин ийнхүү ял ногдуулж, шоронд хорих шийдвэрийг гаргасан юм. Гэвч тэрээр ямар нэгэн хууль бус үйлдэл хийгээгүй гэдгээ илэрхийлсээр байгаа бөгөөд энэ хэргийг бүхэлдээ улс төрийн сэдэлтэй гэж үзэж байна.

Прокуроруудын үзэж байгаагаар 2002-2004 оны хооронд Адриан Настасе болон түүний эхнэр Даниела нар Хятад Улсад очиж хэд хэдэн удаа юм худалдан авахад нь зориулж барилгын бизнес эрхлэгч Ирина Жану мөнгөн дэмжлэг үзүүлсэн байна.

Тэдний худалдан авсан сийлбэр тавилга, хүрэл баримал зэрэг бараа, бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд олон тооны чингэлэг шаардлагатай болсон байна. Мөн Ирина Жану нь 2000-2004 оны хооронд Засгийн газрыг тэргүүлж байсан, ардчилсан Ерөнхий сайд Адриан Настасегийн хоёр харшид засвар хийх төлбөрийг нь төлсөн байна.

Тус улс 1989 онд коммунист системээс шилжсэнээс хойш шоронд хоригдсон анхны Ерөнхий сайд бол Адриан Настасе болж байгаа юм. Тэрээр 2004 оны сонгуулийн ажлын үеэрээ 1.5 сая евротой тэнцэх хэмжээний хөрөнгийг хууль бусаар ашигласан хэрэгт буруутгагдан 2012 оны 6 дугаар сард 2 жилийн хугацаанд шоронд хоригдох ял аваад байсан бөгөөд түүнийг хугацаанаас нь өмнө буюу 2013 оны 3 дугаар сард суллаад байсан юм.

2. Авлигын гэмт хэрэгтнүүд хөнгөн ял авч байна⁵ (2014.01.13)

Индонез. Индонезийн авлигатай тэмцэх ашгийн бус байгууллага болох “Indonesia Corruption Watch”-аас гаргасан тайланд дурдснаар 2013 онд авлигын гэмт хэрэгтнүүдэд ногдуулсан ялын хэмжээ хэтэрхий бага байжээ.

Тус байгууллагын судлаачийн хэлснээр 2013 онд авлигын гэмт хэрэгт ногдуулсан хорих ялын дундаж хэмжээ 35 сар буюу 2 жил 11 сар байсан байна.

“Indonesia Corruption Watch” байгууллагаас уг судалгааг явуулахдаа ялын хугацааг 0-4 жил буюу хөнгөн, 4-10 жил буюу хүндэвтэр, 10-аас дээш жил буюу хүнд гэж ангилж үзсэн байна.

Судлаачийн хэлснээр 2013 онд ял шийтгүүлсэн 184 авлигын хэрэгт 279 хүн яллагдсан байгаагийн 232 хүн буюу 78.64 хувь нь хөнгөн ял, 40 хүн буюу 13 хувь нь хүндэвтэр, зөвхөн 7 хүн 10-аас дээш жилийн ял авсан байгаа юм.

Уг тайланд дурдснаар эдгээр 184 хэргийн улмаас 3.46 их наяд индонез руппи (28.3 сая ам.доллар)-тэй тэнцэх хэмжээний хохирол учирсан бол нийт хээл хахуулийн хэмжээ 13.18 тэрбум индонез руппитэй тэнцэж байгаа юм. Харин эдгээр гэмт хэргийн

² <http://www.aljazeera.com/news/europe/2014/01/romanian-ex-pm-jailed-corruption-201416183850844808.html>

³ Adrian Nastase

⁴ Irina Jianu

⁵ <http://www.thejakartapost.com/news/2014/01/13/graft-defendants-get-leniency.html>

улмаас учирсан хохирлоос торгууль ногдуулах байдлаар 36.95 тэрбум руппи, хөрөнгө хураах байдлаар 515.5 тэрбум руппитэй тэнцэх хэмжээний хохирлыг нөхөн төлүүлсэн байна.

3. Норвегийн “Yara”-д авлигын улмаас 48 сая ам.долларын торгууль ногдуулаа⁶(2014.01.15)

Норвеги. Тус улсын Эдийн засгийн гэмт хэрэгтэй газраас бордоо нийлүүлэгч “Yara” компанийг Орос, Ливи, Энэтхэг зэрэг улс оронд хээл хахууль өгч гэрээ байгуулсан хэрэгт буруутган 295 сая кронер (48 сая ам.доллар)-ын торгууль ногдуулаад байна.

Азотын бордоо нийлүүлэлтээрээ дэлхийд тэргүүлэгч “Yara” компани нь 2004-2009 оны хооронд нийт 70 сая гаруй кронер (12 сая ам.доллар)-гийг дээрх гурван улсад хээл хахууль хэлбэрээр зарцуулсан болохыг тогтоосон байна.

Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газраас уг гэмт хэрэгт компанийн тодорхой ажилтнуудыг буруутай эсэхийг тогтоохоор мөн шалгаж эхэлжээ.

Осло хотод байрлах “Yara” компани нь 50 улс оронд үйл ажиллагаагаа явуулдаг ба 10000 орчим ажилтантай юм. Тус компани нь 150 улс оронд бордоо болон газар тариалангийн бүтээгдэхүүнээ борлуулдаг байна.

4. Филиппин Улсын Засгийн газар бэлэн мөнгө хэрэглэхгүй⁷(2014.01.15)

Филиппин. Тус улс Засгийн газрын үйл ажиллагаанд өргөн тархсан авлигатай тэмцэхийн тулд бэлэн мөнгөөр гүйлгээ хийхгүй болж байна.

Пасай хотод болсон “Сайн засаглалын чуулга уулзалт”-д Ерөнхийлөгч Бенино Акино⁸ хэлсэн үгэндээ засгийн газрын сангуудын хөрөнгийг хууль бусаар зарцуулахаас сэргийлэхийн тулд Бэлэн мөнгөний бус худалдаа (CPC) картын хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлж эхэлж байгаагаа дурджээ.

“Сүүлийн үеийн судалгаагаар Засгийн газрын байгууллагууд бэлэн мөнгөөр төлбөр хийж байгаа нь санхүүгийн томоохон эрсдлүүдийн нэг болохыг тогтоосон. Энэ системд эрсдэл учрах нь гарцаагүй юм. Албан байгууллагад маш их хэмжээний мөнгө бэлнээр байна гэдэг нь хамгийн шударга ажилтны ч хүслийг төрүүлж болох юм” гэж Бенино Акино хэлсэн юм.

АНУ, Испанийн колони байсан тус улсын хувьд авлига бол хамгийн том асуудал байсаар ирсэн билээ. 400 орчим жилийн колонийн хугацаанд бий болгосон дээрэм, хулгайн сэтгэлгээнээс салахын тулд филиппинчүүд төрийн маш олон байгууллага, засаглалын системд гүн гүнзгий нэвчсэн шударга бус зүйлтэй тэмцэж байгаа юм.

Бенино Акино “санхүүгийн хяналт болон орчин үеийн арга хэрэгслүүдийг хослуулан хэрэглэснээр авлигын улмаас учирч буй бэрхшээлийг даван туулж чадна” гэжээ.

⁶ <http://www.utsandiego.com/news/2014/jan/15/norways-yara-fined-48-million-for-corruption/>

⁷ <http://gulfnnews.com/news/world/philippines/philippines-takes-cash-out-of-government-transactions-1.1277871>

⁸ Benigno Aquino III

Одоогийн байдлаар тус улсын нийт гүйлгээний 98 хувь нь бэлэн мөнгөөр хийгддэг ч төрийн байгууллагын хүрээнд санхүүгийн гүйлгээний 54 хувь нь бэлэн бусаар хийгдэж байгаа юм.

5. Авлигач төрийн албан хаагчийг барихад тусалсан иргэнийг 100 мянган руппигээр урамшуулав⁹ (2014.01.28)

Энэтхэг. Хээл хахууль авч байгаа нэгэн төрийн албан хаагчийг барихад тусалсан иргэнд “Авлигын эсрэг хөдөлгөөний хороо”-ноос 100 мянган руппигээр урамшуулсан байна.

Өнгөрсөн жилийн 10 дугаар сард уг иргэн газрын эрх шилжүүлэх зорилгоор Энэтхэг Улсын Сулур мужийн ойролцоох Паппамараттигийн орон нутгийн захиргааны нэгэн ажилтанд хандахад түүнийг хээл хахуульд 6000 руппи төлөхийг шаардсан байна.

Тэрээр дараа нь цагдаагийн байгууллагад хандаж, цагдаа нартай хамтран орон нутгийн захиргааны ажилтанд хээл хахууль өгөх, урхи бэлтгэн ажилласан бөгөөд орон нутгийн захиргааны ажилтан түүнээс хээл хахууль авч байх үедээ баривчлагдсан юм.

Төрийн албан хаагчийн үнэн төрхийг илчлэхэд түүний оруулсан хувь нэмрийг үнэлж, бусад иргэдэд үлгэр дуурайл болгох зорилгоор “Авлигын эсрэг хөдөлгөөний хороо”-ноос түүнд энэхүү урамшууллыг олгосон байна.

Энэтхэг дэх авлигын эсрэг 20 гаруй байгууллагыг нэгтгэсэн уг хорооноос аль хэдийн 3 хүнд энэ төрлийн урамшууллыг олгоод байгаа юм.

6. Европын Холбооны түвшин дэх авлига¹⁰ (2014.02.03)

Европын холбоо. Европын холбоо (ЕХ)-ны түвшин дэх авлигын цар хүрээ маш их байгаа бөгөөд тус холбоонд авлигын улмаас жилд дунджаар хамгийн багадаа 120 тэрбум евротой тэнцэх хэмжээний хохирол учирдаг байна.

ЕХ-ны Дотоод хэргийн асуудал хариуцсан комиссар Сесили Малтстром¹¹ ЕХ-ны гишүүн 28 улсын авлигын нөхцөл байдлын талаар явуулсан анхны судалгааны тайланг танилцуулахдаа “авлигын улмаас жилд дунджаар 120 тэрбум еврогийн хохирол ЕХ-нд учирч байна. Бодит хохирлын хэмжээ 120 тэрбум еврогоос магадгүй их байх” гэсэн юм.

Судалгаанд оролцсон Европчуудын 3/4 нь ЕХ-ны түвшинд авлига өргөн тархсан, мөн тэдний 1/2 нь авлигын түвшин өсч байна гэж хариулжээ.

Европ дахь авлигын цар хүрээ маш өргөн байгаа бөгөөд авлигын улмаас учирч байгаа хохирлын хэмжээ тус холбооны жилийн төсвийн хэмжээтэй тэнцүү хэмжээтэй байгаа юм.

Уг судалгаагаар Их Британийн 1115 иргэний зөвхөн 5 нь (1 хүрэхгүй хувь) хээл хахууль өгсөн гэж хариулсан байгаа нь ЕХ-ны түвшин дэх хамгийн сайн үзүүлэлт болж байна. Гэвч судалгаанд оролцсон Их Британийн иргэдийн 64 хувь нь Их Британид авлига өргөн тархсан гэж үзсэн байгаа бол энэ үзүүлэлт ЕХ-ны дунджаар 74 хувь байгаа юм.

⁹ http://www.business-standard.com/article/pti-stories/man-who-helped-nab-corrupt-govt-official-given-rs-11-as-award-114012800026_1.html

¹⁰ <http://www.bbc.co.uk/news/world-europe-26014387>

¹¹ Cecilia Malmstroem

Хорват, Чех, Литв, Болгар, Румын, Грек улсаас судалгаанд оролцогчдын 6-29 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгөхийг шаардсан, хэн нэгэнд хээл хахууль өгсөн гэж хариулсан байна.

Польш (15%), Словак (14%), Унгар (13%) улсад авлига хамгийн өргөн тархсан салбар бол эрүүл мэндийн салбар гэж үзэж байгааг уг тайланд онцолжээ.

“Авлига бол ардчилалд итгэх итгэлийг бууруулж, эдийн засгийн нөөцийг багасгаж байна” гэж Сесили Малтстром хэлсэн байна. Тэрээр мөн “авлигыг устгахад улс төрийн оролцоо, амлалт дутагдаж байна” гэсэн юм.

Уг тайланд мөн онцлохдоо:

- ЕХ-ны ДНБ-ий 1/5-тэй тэнцэх хэмжээний төрийн худалдан авах ажиллагаа авлигад өртөх магадлалтай байгаа бөгөөд эдгээрт илүү сайн хяналт, стандартыг бий болгох хэрэгтэй байна;
- Авлигын эрсдэл муж болон орон нутгийн түвшинд их байна;
- Улс төрийн намын санхүүжилт болон ёс зүйн асуудалтай холбоотой шийдвэрлэх олон асуудлууд байсаар байна;
- Ашиг сонирхлын зөрчлийн талаарх зохицуулалтыг хангалтгүй мөрдөж байна.
- Авлигын мөрдөн байцаалтын ажил ЕХ-ны хэмжээнд харилцан адилгүй байна гэжээ.

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгч 10 хүн тутмын 4 нь Европт бизнес эрхлэхэд тулгардаг саад бэрхшээлээр авлигыг нэрлэсэн байна.

Сесили Малтстром ил тод, нээлттэй байдлын талаарх хуулийн чухлыг онцлон “Швед бол маргаангүй авлигын хамгийн бага асуудалтай улс юм. Тиймээс ЕХ-ны бусад улсууд Авлигатай тэмцэж буй Швед загвар, туршлагаас суралцах ёстой” гэжээ.

7. АНУ, Канад Улсууд Карибын бүс дэх татвараас зайлсхийх явдлыг зогсоох гэрээнд гарын үсэг зурлаа¹² (2014.02.07)

АНУ. Гадаадад байршиж буй дансанд татварын хуулийг дагаж мөрдөх тухай хууль (FATCA¹³)-ийг хэрэгжүүлэх, Карибын тэнгисийн болон бусад улс орнуудад татвараас зайлсхийх оффшор үйл ажиллагааг зогсоох зорилгоор Канад Улстай Засгийн газар хоорондын гэрээ байгуулсан талаар АНУ-ын Сангийн яамнаас мэдээллээ.

АНУ-ын Сангийн яамнаас мэдээлэхдээ энэ гэрээтэй адил төстэй гэрээг мөн өнгөрөгч долоо хоногийн эхээр Унгар, Итали, Мавритан Улстай байгуулсан талаар мэдээлсэн байна.

Кариб зэрэг бүс нутагт данс эзэмшиж буй АНУ-ын татвар төлөгчдөд зориулсан FATCA хуулийг АНУ-ын Конгресс 2010 онд баталсан юм.

“Энэ хуулийг баталсан нь татварын ил тод байдлыг нэмэгдүүлэх нийтлэг стандарт” болж байгааг Сангийн яамны мэдэгдлийн үеэр онцолсон байна. Одоогийн байдлаар тус яам засгийн газар хоорондын 22 гэрээнд гарын үсэг зурсан байна.

"FATCA хуулийн хэрэгжилт нь олон улсын түвшинд татвараас зайлсхийхтэй тэмцэх, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд нэн чухал алхам юм. FATCA хуулийн хүрээнд олон улс орнуудтай санал нэгдэж байгааг энэхүү гэрээнүүд харууллаа. Бид энэ асуудлын хүрээнд дэлхий нийтийг манлайлан оролцож байгаадаа баяртай байна”

¹² <http://jamaica-gleaner.com/gleaner/20140207/business/business92.html>

¹³ Foreign Account Tax Compliance Act

хэмээн тус яамны Олон улсын татварын асуудал хариуцсан орлогч нарийн бичгийн дарга Роберт Б.Стак¹⁴ тэмдэглэн хэлэв.

8. Самоа дахь оффшор компаниуд Хятад Улсад 1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн¹⁵ (2014.01.29)

БНХАУ. Хятад Улсад 2012 онд хийсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ 10 дахь том улс бол Самоа юм.

Хятад Улсад хөрөнгө оруулсан дээрх хөрөнгө оруулагчдын дунд Самоа улсын татварын чөлөөт орчин буюу оффшор бүсэд бүртгэгдсэн Хятадын компаниуд багагүй хувийг эзэлж байна.

“South China Morning Post” сонины шинжээч Том Холланд¹⁶-ийн тооцоолж байгаагаар Хятад Улсад өнгөрсөн онд хийсэн 118 тэрбум ам.доллартай тэнцэх гадаадын шууд хөрөнгө оруулалтын 50 тэрбум ам.доллар орчим нь хилийн чанадын оффшор бүсэд бүртгэлтэй, эх газрын Хятадаас гаралтай компаниудынх юм.

Түүний бичснээр “Хууль бусаар оффшор бүсэд мөнгөө байршуулж байгаа нь нэг хэрэг юм. Нөгөө талаас дээрх бүсэд хууль бусаар байршуулсан мөнгөнийхөө төрхийг гадаадын шууд хөрөнгө оруулалт болгон өөрчлөн, татварын хөнгөлөлт эдэлж байна” гэжээ.

Хятад дахь татвар төлөгчдийн чиглэлээр явуулсан нэгэн судалгаагаар Хятадын орон нутгийн компаниуд орлогынхоо дунджаар 8 хувьтай тэнцэх хэмжээний татварыг төлж байгаа бол гадаадын компаниуд дөнгөж 3 хувьтай тэнцэх хэмжээний татвар төлдөг болохыг тогтоож байсан юм.

“Хятадын санхүүгийн зах зээлд тэргүүлэгч оффшор бүсээр Британийн Виржин Арал, удаах байрт Самоа, Хонконг, Тайванийн оффшор бүсүүд орж байгаа нь Азийн бизнесийн зах зээлд Самоагийн оролцоо их болохыг харуулж байгаа юм” гэжээ.

9. Турк Улс авлигын гэмт хэрэг дэх интернэт хяналтаа нэмэгдүүллээ¹⁷ (2014.02.06)

Турк. Авлигын талаар ярьсан нэгэн утасны яриа интернэтэд тархсаны дараа Туркийн парламентаас Ерөнхий сайд Р.Т.Эрдоген¹⁸-ийн Засгийн газарт цахим хуудаснуудад хяналт тавих, шаардлагатай бол хаах эрх олгосон хууль батлаад байна.

Уг хуулийн дагуу цахим хуудас хувийн мэдээллийг нь задруулсан гэж үзэж болохуйц гомдол мэдээлэл ирсний дараа, ямар нэгэн шүүгчийн шийдвэргүйгээр, Туркийн Цахилгаан холбооны газраас 4 цагийн дотор тухайн цахим хуудас, контентыг хаах эрхийг парламентаас олгосон байна. Гэхдээ ийнхүү цахим хуудас хааснаас 48 цагийн дотор шүүгч уг шийдвэрийг шаардлагагүй гэж үзвэл цуцлах боломжтой билээ.

Засгийн газрын ажилтнууд болон бизнесменийн хоорондын утасны ярианы бичлэг интернэтэд тархсан даруйд уг хуулийн төслийг парламентад танилцуулсан юм. Истанбулийн “Gezi” цэцэрлэгт хүрээлэнд өнгөрсөн 6 дугаар сард болсон эсэргүүцлийн жагсаалыг хүчээр тараасан, авлигын гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд цагдаа, прокурорын ажилтнуудыг ажлаас нь халсан зэрэгт Европын холбооны зүгээс зэмлэл хүртээд буй одоогийн Ерөнхий сайд Р.Т.Эрдогений удирдлага доор Турк Улс дахь хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан хэрэг болж байна.

¹⁴ Robert B. Stack

¹⁵ <http://www.pidp.org/pireport/2014/January/01-29-16.htm>

¹⁶ Tom Holland

¹⁷ <http://www.bloomberg.com/news/2014-02-06/turkey-increases-control-over-internet-amid-corruption-probe.html>

¹⁸ Recep Tayyip Erdogan

Сөрөг хүчин болох “Бүгд найрамдах ардын нам”-ын парламент дахь гишүүн Хасан Орен¹⁹ хэвлэлийнхэнд утсаар өгсөн ярилцлагадаа “Засгийн газар авлигын хэргийнхээ талаар тайлбар өгөхийн оронд, авлигын хэргийн талаарх мэдээллийг олон нийтэд тархах явдлыг хязгаарлахын тулд интернэт дэх хяналтаа чангатгасан. Ийнхүү хэвлэл мэдээллийн эрх чөлөөг зөрчих алхам хийснээрээ Европын холбооны эсэргүүцэлтэй тулгарах нь гарцаагүй юм. Турк Улс улам бүр дарангуйлагч тогтолцоо руу шилжиж байгаад би харамсч байна” гэжээ.

10. Авлигачдын тэргүүнд гаальчид²⁰ (2014.02.04)

Вьетнам. Дэлхийн банк болон Вьетнамын Бизнес форумын тайланд дурдснаар Вьетнам Улсын Засгийн газрын хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд хамгийн их авлигад автсан нь гаалийн байгууллага болохыг онцолсон байна. Мөн тус тайланд дурдснаар “асуудлыг хурдан шийдвэрлүүлэхийн тулд нийт бизнес эрхлэгчдийн 63 хувь нь албан бус төлбөр төлдөг” байна.

Вьетнамын Бизнес форумын 2013 оны тайланд дурдснаар “гаалийн шат дамжлагыг цөөрүүлэх, гаальчидтай харилцаагаа хэвээр нь хадгалахын тулд бизнес эрхлэгчид гаальчдад ‘тосолгооны төлбөр’-т хээл хахууль өгдөг гэжээ. Ийнхүү гаальчид төлбөр авснаараа гаалийн мэдүүлгийг буруу бөглөх, хориотой бараа импортлох, хууль бусаар хилээр нэвтрүүлэх зэрэгт ‘чихээ таглаж’ өнгөрүүлдэг байна.

Уг судалгаагаар авлигын нөхцөл байдал хамгийн ноцтой гурван салбар, байгууллагыг (гаалийн байгууллага 55.2 хувь, татварын байгууллага 46.2 хувь, газар зохион байгуулалтын байгууллага 39.8 хувь) тогтоосон байна.

Энэ судалгаанаас өмнө буюу 2012 оны 11 дүгээр сарын сүүлээр тус улсын Засгийн газар, мөн Дэлхийн банктэй хамтран зохион байгуулсан судалгаагаар авлигад хамгийн их автсан 4 салбарын нэгээр гаалийн байгууллага шалгарч байсан юм.

Сүүлийн жилүүдэд авлига, хээл хахуулийн хэрэгтэй холбоотойгоор тус улсын олон тооны гаальчдад шийтгэл ногдуулаад байгаа билээ.

Тухайлбал, нэг аж ахуйн нэгжээс хээл хахуульд 1.5 тэрбум вьетнам дон авсан “Muong Khuong” дахь гаалийн дарга асан Тран Мин Тоунг²¹ -д 2013 оны 6 дугаар сард шүүхээс 20 жилийн хорих ял, Нгуен Ван Чоунг²²-д 12 жилийн хорих ял тус тус ногдуулсан юм.

Сүүлийн 5 жилийн хугацаанд олон төрлийн шалтгаанаар 295 гаальч шалгагдан их, бага хэмжээгээр шийтгэгдээд байгаа юм.

11. Авлигын эсрэг арга хэмжээнээс үүдэлтэйгээр Хятадын баячууд АНУ-руу зугтаж байна²³ (2014.02.04)

БНХАУ. Америкийн баячууд гадаадад гарч амьдарна гэдгээрээ сүрдүүлдэг байсан. Мэдээж хэрэг тэдний ихэнх нь ийм алхам хийгээгүй л дээ.

Харин Хятад Улсад, ялангуяа тус улсын баячуудын хувьд хилийн чанадад амьдарна гэдэг үг сүрдүүлэг биш болоод байна.

Авлигатай тэмцэх ажиллагаа өргөжсөнөөр Хятадын баян иргэд хилийн чанадад илүү амар тайван амьдралыг эрж хайх болжээ. Өөрөөр хэлбэл, Хятадын баячуудын тэмүүлэх болсон газар нь АНУ юм.

¹⁹ Hasan Oren

²⁰ <http://english.vietnamnet.vn/fms/business/93840/customs-always-top-corruption-reports.html>

²¹ Tran Minh Thuong

²² Nguyen Van Cuong

²³ <http://www.globalpost.com/dispatch/news/regions/asia-pacific/china/140131/war-corruption-ramps-china-s-wealthy-flock-america>

“Hurun Report” сэтгүүлээс Хятадын 393 саятны дунд явуулсан нэгэн судалгаанаас сонирхолтой дүгнэлт хийсэн байна. Тус судалгааны дүнгээр Хятадын баян иргэд (1.6 сая ам.доллар болон түүнээс их хөрөнгөтэй)-ийн 64 хувь нь хилийн чанадад шилжсэн, эсхүл шилжихээр төлөвлөж байгаа гэжээ. Мөн тус судалгааны дүнгээр маш баян иргэд (16 сая ам.доллар болон түүнээс их хөрөнгөтэй)-ийн гуравны нэг нь өөр улсад харьяалалтай болжээ.

Эдгээр баячуудын ихэнх хувь нь үр хүүхдээ хилийн чанадад өсгөх сонирхолтой байгаа бол мөн 80 хувь нь хүүхдүүддээ гадаадын боловсрол олгохыг хүсч байна. Баячуудын үзэж байгаагаар хүүхдүүддээ боловсрол олгохын тулд нэн түрүүнд АНУ, дараа нь Их Британийн их сургуулиудыг сонгож байгаа юм.

Хятадын баячууд өөрийн орны боловсролын системд итгэхгүй байна. Хилийн чанадыг илүүд үзэх байдал нь Хятадын баячууд АНУ-ын “ногоон карт” авах байдлыг улам бүр нэмэгдүүлж байна. 2010 онд Хятадын 772 иргэн хөрөнгө оруулагчийн ногоон карт (АНУ-д хамгийн багадаа 1 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн хүнд олгодог тусгай эрх)-ыг авч байсан юм. Харин энэ байдал 2012 онд даруй 8 дахин нэмэгдэж 6124-т хүрээд байгаа юм.

Хятадын эдийн засагт үйл ажиллагаа явуулж баян болсон эдгээр хүмүүс яагаад хилийн чанадыг илүүд үзэх болов? Өөр нэг нөлөөлж буй хүчин зүйл нь бохирдол юм. Хятад Улсын баячууд байнга гомдол мэдүүлдэг сэдэв бол тус улс дахь агаарын болон усны бохирдол билээ.

Мэдээж хэрэг нөлөөлж буй өөр нэг шалтгаан бол авлигатай тэмцэж буй байдал юм.

Сүүлийн нэг жилийн хугацаанд Хятад Улсын дарга Ши Зиньпин тус улсын хамгийн баян болон Коммунист намд хамгийн нөлөөтэй хүмүүсийн заримыг авлигын хэргээр шалгасан юм.

Нэгдүгээр сараас Ши Зиньпиний авлигын эсрэг үйл ажиллагаа хилийн чанадад хүүхэд болон эхнэр/нөхөр нь амьдарч буй төрийн албан хаагчид руу илүү чиглэх болоод байна. Хүүхэд болон эхнэр/нөхөр нь хилийн чанадад амьдарч буй төрийн албан хаагчдыг авлигад хамгийн их өртөмтгий гэж үзэн ‘нүцгэн’ албан хаагч гэж нэрлээд байгаа юм.

Төрийн мэдлийн Синхуа агентлагаас мэдээлж байснаар “эдгээр ‘нүцгэн’ албан хаагчид нь авлигын маш өндөр эрсдэлтэй” юм. Эдийн засгийн гэмт хэрэг (Хятад Улсад залилан, шамшигдуулах зэрэг хэргийг эдийн засгийн гэмт хэрэг гэж үздэг)-ийн 40 орчим хувь, авлига, хээл хахуулийн хэргийн 80 орчим хувьд нь ‘нүцгэн’ төрийн албан хаагчид оролцсон байдаг.

Энэхүү томьёолол нь маш өргөн хүрээг хамарч байгаа юм. Хонконгийн “Oriental Daily” сонинд мэдээлснээр 2013 оны Хятадын Ардын Их Хурлын гишүүдийн ихэнх нь ‘нүцгэн’ ангилалд хамаарч байгаа юм.

Бодит байдалд дарга Ши Зиньпин ч өөрөө энэ ангилалд хамаарч байгаа юм. Түүний охин нь нэрээ нууцлан Харвардын их сургуульд сурдаг.

Мэдээж, зөвхөн Хятадын баячууд л эх орноо орхин гараад байгаа үзэгдэл бас биш юм. “Center for China and Globalization”-ны судалгаагаар өнгөрсөн жил 9 сая гаруй хятад иргэд гадагш шилжсэн бөгөөд тэдний ихэнх нь дундаж түвшний орлоготой 35-55 насныхан байсан. Гадагшаа шилжих хөдөлгөөнд орж буй эдгээр Хятад иргэдийн хамгийн их очиж буй газар бол АНУ бөгөөд 2012 оны байдлаар Хятадын 81784 иргэн АНУ-аас түр иргэншил аваад байна.

12. Индонез Улс авлигатай тэмцэх үйл ажиллагааны үр дүнд ихээхэн хэмжээний хөрөнгө нөхөн төлүүлсэн²⁴ (2014.02.10)

Индонез. Сүүлийн 3 жилийн хугацаанд Индонез Улс авлигатай тэмцэх үйл ажиллагаандаа ихээхэн амжилт олоод байна.

Албаныхны хэлж байгаагаар 2011 оноос хойш хөрөнгө хураан авч, нөхөн төлүүлснээрээ авлигатай тэмцэх үйл ажиллагаанд тоон болон чанарын ахиц гарсан гэж үзэж байгаа юм. Индонезийн Авлигыг устгах хорооноос мэдээлж байгаагаар 2013 оны хэмжээнд авлигын гэмт хэргийн улмаас 91 сая ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө хураан авч, нөхөн төлүүлсэн нь 2012 оныхоос өсчээ.

Индонезийн Ерөнхий прокурор Басриф Ариф²⁵ “VOA” агентлагт мэдээлснээр тус байгууллага 2013 онд 1696 авлигын хэрэг шалгасан бөгөөд 2012 онд 833 хэрэг шалгаж байсан.

Түүний хэлснээр “2012 онд тус улс авлигын хэргээс 20 сая ам.доллар төлүүлж байсан бол 2013 онд дөрөв дахин нэмэгдэж 91 саяд хүрсэн ба эдгээр хөрөнгийн ихэнхийг нь гааль, татварын салбар дахь авлигаас төлүүлсэн” байна.

Транспаренси Интернэшнл байгууллагын судалгаагаар авлигын хэмжээгээрээ Индонез Улс 177 улс орноос 144 дүгээр байрт орж байгаа билээ.

13. Авлигын эсрэг сурталчилгаа ихээхэн маргаан дэгдээгээд байна²⁶ (2014.02.11)

Тайланд. Төр, хувийн хэвшлийн 47 байгууллагаас бүрдсэн бүлэг буюу Тайландын Авлигатай тэмцэх байгууллага²⁷-аас гаргасан телевизийн сурталчилгаа маш богино хугацаанд ихээхэн маргаан дэгдээгээд байна.

Энэхүү маргаан нь тус улсын нийгэм дэх авлигын талаарх суурь үнэлэмжийн ялгаатай байдлыг илтгэн харуулж байна.

Цувралын дөрөв дэх нь болох уг сурталчилгаанд ээж нь авлигач болсны улмаас сургуулийнхаа найзуудад гадуурхагдаж буй хүү, энэ байдлыг мэдрэн шаналж буй ээжийг дүрслэн харуулснаараа “Тайландын нийгэмд авлигач хүмүүсийг байлгах ямар ч орон зай үлдээгүй” болохыг илтгэсэн юм.

Сурталчилгаа гарсан даруйдаа олон нийтийн сүлжээгээр тархан, олон тооны санал сэтгэгдэл, шүүмжлэлийг аваад байгаа юм.

“Pantip.com” цахим хуудсанд тавигдсан нэгэн сэтгэгдэлд “Энэ сурталчилгааны цаад агуулгыг дэмжиж байна. Хүүхэд үүнд өртөж байгаа бол хэн түүний зовлонд буруутай вэ?” гэжээ.

Мөн өөр нэгэн сэтгэгдэлд “Тайландын нийгмийг өөрчлөх цаг нь болсон. Бид энэ байдалтайгаар дараагийн 100, эсхүл 200 жил байж болохгүй. Ямар ч байсан, авлигач байдлын үр дагавар бидний гэр бүл, үр хүүхдэд нөлөөлдөг гэдгийг бодох хэрэгтэй. Зөвхөн бид өөрсдөө биш гэр бүлийн гишүүн бүр хариуцлагатай байх ёстой” гэжээ.

²⁴<http://www.voanews.com/content/indonesia-claims-gains-in-fight-against-corruption/1848516.html>

²⁵ Basrief Arief

²⁶ <http://www.bangkokpost.com/news/local/394389/tv-ad-by-anti-corruption-organisation-quickly-politicised-on-web>

²⁷ Орч: Төр, хувийн хэвшлийн санаачилгаар байгуулсан нэгж нь Тайландын Авлигатай тэмцэх байгууллага буюу “Anti-Corruption Organisation of Thailand” юм. Харин төрийн авлигатай тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага нь Үндэсний авлигатай тэмцэх хороо “National Anti-Corruption Commission of Thailand” юм.

Өөр нэгэн сэтгэгдэлд “Би энэ сурталчилгааг зөвхөн ёс зүйгүй эцэг, эхийн гар дээр хүмүүжиж буй хүүхдүүдэд л нөлөөлнө гэж үзэхгүй байна. Хэн ч хүүхдээ буруутгахгүй. Авлигад холбогдсон эцэг, эх энэ сурталчилгааг үзэж чадахгүй” гэжээ.

Ийнхүү энэ сурталчилгааг дэмжих хэсэг байгаа бол эсэргүүцэх хэсэг ч мөн байна.

Энэ сурталчилгааны талаар шүүмжилсэн нэгэн сэтгэгдэлд “(Шошигожуулах, хилсээр буруутгахын оронд) авлигатай тэмцэх хамгийн зөв арга бол авлигын хэрэгт холбогдохоос зайлсхийх, нотлох баримтыг цуглуулан цагдаа, хэвлэл мэдээллийнхэнд өгөх юм. Энэ сурталчилгаа хүчирхийллийн хэлбэрийг харууллаа” гэжээ.

Мөн өөр нэгэн шүүмжлэлд “энэ сурталчилгаа Нацистын 'Jüdischen Schüler und Lehrer von der Schulen verwiesen' (еврей багш, сурагчид сургуулиас хөөгдөж байгаа талаар гардаг) хэмээх суртал ухуулга болон семитийн эсрэг үзэл суртлы илэрхийлсэн еврей хэлээр гарсан хүүхдийн ном болох 'Der Giftpilz' буюу 'Хортой мөөг' номыг санагдууллаа. Эдгээр суртал ухуулгад хүний мөн чанарыг нь орхигдуулан хар, эсхүл цагаан, сайн, эсхүл муу гэсэн байдлаар ерөнхийд нь авч үздэг. 'Авлигач' үйлдлийнх нь талаар ямар ч асуулт асуудаггүй. 'Авлигач' л бол ямар ч шалтгаангүй. Ерөнхийдөө бол энэ сурталчилгаа хүүхдүүдэд хэрхэн нөлөөлөх талаар анхаарч үзээгүй байна” гэжээ.

Сурталчилгааг доорх линкээс үзэж болно.

<http://www.youtube.com/watch?v=U2IICGSS1Uo>

14. Хятад Улс авлигач эрдэмтдээ шийтгэсээр байна²⁸ (2014.02.27)

БНХАУ. Эрдэмтэд ихэвчлэн өөрсдийн судалгааны ажилдаа анхаарлаа хандуулж ажилладаг байхад Хятад Улсын зарим эрдэмтэд өөр зүйлд анхаарлаа хандуулдаг аж. Өөрөөр хэлбэл, тус улсын зарим эрдэмтэд татвар төлөгчдийн мөнгөнөөс олон сая ам.доллар хэрэглэх, судалгааны зардлаа хэтрүүлэх, өөрсдийн гэр бүлийн гишүүдэд зориулсан албан ёсны зардлын данс ажиллуулдаг зэрэг дутагдалтай тал илэрсээр байна.

Хятадын Коммунист намын тэргүүлэх эрдэмтэд болон судлаач-албан хаагчид²⁹ зэрэг тодорхой тооны хүмүүст энэ төрлийн үйл ажиллагааны улмаас шийтгэл ногдуулсан байна. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын мэдээлж байгаагаар Хятадын Гуандон мужийн шинжлэх ухаан, технологийн 50 гаруй эрдэмтэнд энэ төрлийн хэрэгт холбогдуулан шийтгэл ногдуулсан байна.

Тухайлбал, Коммунист намын авлигатай тэмцэх байгууллага болох Сахилгын хяналтын төв хорооноос мэдээлж байгаагаар “хуулийг ноцтой зөрчсөн” хэрэгт холбогдуулан Сингапурт байрлах Ази, номхон далайн шинжлэх ухаан, технологийн төвүүдийн сүлжээний дэд захирал Ван Кэвей³⁰-г мөн шалгаж байна.

Гуандон мужийн Шинжлэх ухаан, технологийн төвийн захирал Ли Шинхуа³¹-г мөн өнгөрсөн 7 дугаар сараас хойш шалгаж байгаа бөгөөд 1 дүгээр сард Коммунист намаас хөөсөн юм.

Эрдэмтдийн хууль бус үйл ажиллагааных нь талаар дэлгэрэнгүй мэдээлэл хараахан гараагүй байгаа ч Хятадын хэвлэл мэдээллийн байгууллагуудын үзэж байгаагаар ихэнх нь судалгааны зардлыг шамшигдуулсан хэрэгт холбоотой юм.

Тэдний авлигын хэргийн дараалал нь эрдэмтэд санхүүжилт хүлээн авч эдгээр санхүүжилтээ хувийн зорилгоор (гэр бүлийн гишүүддээ) ашигладаг бол зарим хэсэг нь төслийн бус үйл ажиллагаанд нэмэлт санхүүжилт авах, шинжлэх ухааны үнэтэй тоног төхөөрөмж худалдан авах, илүү төлбөр хийх, худалдан авсан газраасаа хөнгөлөлт хүртэх зэргээр үргэлжилдэг байна.

²⁸ <http://www.theepochtimes.com/n3/531166-corrupt-chinese-scientists-punished-in-campaign/>

²⁹ semiofficial researcher

³⁰ Wang Kewei

³¹ Li Xinghua

“Дээрх төрлийн авлигын хэрэг өргөн тархсан болохыг жил бүрийн аудитын тайлан харуулсан” гэж Синхуа агентлаг мэдээлжээ.

Шинжлэх ухаан, технологийн Хятадын холбоо “бодит байдалд, шинжлэх ухааны судалгаануудад зарцуулж буй санхүүжилтийн зардлын зөвхөн 40 хувь нь л тухайн судалгаандаа зарцуулагдаж, үлдсэн хэсэг нь судалгаатай холбоогүй үйл ажиллагаанд зарцуулагддаг” гэсэн байна.

Шинжлэх ухааны санхүүжилтэд улс төржсөн байдлаар хандах, мөн ил тод бус, хяналтгүй байх зэрэг нь дээрх хэрэг үйлдэгдэх гол шалтгаан болсон байна.

“Battelle” судалгааны байгууллагын үзэж байгаагаар сүүлийн 20 орчим жилийн хугацаанд Хятад Улс судалгаа, хөгжлийн зардлаа жил бүр 12-20 хувиар нэмэгдүүлж ирсэн байна.

15.Иран дахь авлигын гэмт хэрэгт дэд Ерөнхийлөгч асныг буруутгав³² (2014.02.25)

Иран. Ираны төрийн мэдээллийн агентлаг болох “IRNA”-аас мэдээлснээр Ираны Ерөнхийлөгч асан Махмуд Ахмадинежад³³-ийн үед дэд ерөнхийлөгчийн албыг хашиж байсан Мохамэд-Реза Рахим³⁴-ийг авлигын хэрэгт холбогдуулан шүүхээс буруутгаад байгаа талаар мэдээллээ.

Ираны Ерөнхий прокурор Голам-Хосейн Мохсен³⁵ үүнийг үгүйсгээгүй ч “энэ талаарх мэдээллийг үнэн худал эсэхийг нь баталгаажуулах зорилгоор удахгүй хэвлэлийн бага хурал хийх болно” гэжээ.

Ираны нэгэн даатгалын компанийн эсрэг 3 тэрбум ам.долларын санхүүгийн луйврын хэрэгт дэд ерөнхийлөгчийн нэр холбогдоод байсан юм. Мохамэд-Реза Рахим дэд ерөнхийлөгчийн албан тушаалыг хашиж байхад нь уг хэрэг шүүхэд шилжиж байсан бөгөөд уг хэрэгт дэд ерөнхийлөгч болон түүний зөвлөх, Тегеран хотын дарга, Боловсролын сайд нар холбогдоод байсан юм.

Шүүх хурлын үеэр яллагдагчдын нэг 600.000 ам.долларыг дэд ерөнхийлөгчийн хувийн дансанд шилжүүлсэн талаар мэдүүлэг өгсөн байдаг.

Үүний дараа буюу 2013 оны 12 дугаар сарын Тегераны прокурорын газраас шийдвэр гаргаж, дэд ерөнхийлөгчийг уг гэмт хэрэгт албан ёсоор сэжигтнээр татаад байсан билээ.

16.Карибын улс орнууд мөнгө угаах гэмт хэрэг өндөртэй улсаар нэрлэгдлээ³⁶ (2014.03.04)

АНУ. АНУ-ын зүгээс олон улсын хэмжээнд мансууруулах бодисын хууль бус худалдаагаар дамжуулан мөнгө угаах гэмт хэрэг ихээхэн гардаг улс орноор Карибын хэд хэдэн улс орныг нэрлээд байна.

АНУ-ны Төрийн департаментын “Олон улсын мансууруулах бодисын хяналт 2014 оны тайлан”-д дэлхий дахинд мөнгө угаах гэмт хэрэг ихээхэн гардаг улс орнуудын дунд Карибын Гайти, Белиз, Багам, Барбуда ба Антигуа, Карибын арлууд, Британийн Виржинийн арлууд, Кайманы арлууд зэрэг улс орныг нэрлээд байгаа юм.

³² <http://en.trend.az/news/politics/2245862.html>

³³ Mahmoud Ahmadinejad

³⁴ Mohammad-Reza Rahimi

³⁵ Gholam-Hossein Mohseni

³⁶ http://www.jamaicaobserver.com/news/Caribbean-states-named-among-major-money-laundering-countries_16180129

Тус тайланд мөн мөнгө угаах гэмт хэрэг гардаг томоохон улсаар Их Британи, АНУ, Австрали, Бразил, ОХУ, Франц, Канад, Доминикан, Герман, Грек, Нидерланд зэрэг улсыг нэрлэсэн юм.

“Өнгөрсөн онд хууль бусаар мансууруулах бодис үйлдвэрлэх, худалдаалах, хэрэглэх болон мөнгө угаах, санхүүгийн гэмт хэргийг бууруулахаар тодорхой алхмуудыг дэлхийн 90 орчим улс орон авч хэрэгжүүлсэн байна. Мөнгө угаах гэмт хэргүүд нь ерөнхийдөө мөнгө шилжүүлэх хэлбэрээр өрнөдөг тул зарим хэргийн хувьд мансууруулах бодисын худалдаанаас олсон орлого уу, эсхүл бусад онц ноцтой гэмт хэргээс олсон орлого уу гэдгийг нарийн ялгаж авч үзэхэд хүндрэлтэй байна” гэж тайланд дурдсан байна.

Мөн бусад онц ноцтой гэмт хэргийн улмаас олсон хөрөнгийг шилжүүлэхэд зарим улс орнуудын санхүүгийн институциуд оролцож байгаа нь мансууруулах бодистой холбоотой мөнгө угаах явдлыг улам бүр нэмэгдүүлж байгааг тэмдэглэжээ.

АНУ-ын Төрийн Департаментаас тодорхойлж байгаагаар Карибын улс орнуудаас гадна мансууруулах бодисын худалдаанд Афганистан, Болив, Мьянмар, Колумб, Коста Рика, Доминиканы Бүгд Найрамдах Улс, Эквадор, Эл Сальвадор, Гватемал, Гондурас, Энэтхэг, Лаос, Мексик, Никарагуа, Пакистан, Панам, Перу, Венесуэл зэрэг улсууд оролцдог байна.

17. Дотоод мэдээлэл ашиглаж санхүүгийн луйвар хийсэн хэрэгт буруутган “Ahli Bank”-ны тэргүүнийг 5.3 сая ам.доллараар торгов³⁷ (2014.03.03)

Кувейт. Зах зээл дэх хувьцааны хэмжээгээрээ Кувейт Улсад 8 дугаар байрт орох “Al Ahli Bank” банкны тэргүүнийг дотоод мэдээлэл ашиглаж тус банкны хувьцаанаас санхүүгийн луйвар хийсэн хэрэгт шүүхээс буруутган 1.5 сая динар (5.3 сая ам.доллар)-тай тэнцэх хэмжээний торгууль ногдуулсан байна.

Энэ талаар тус улсын хөрөнгийн биржийн цахим хуудас дахь “Al Ahli Bank” банкны мэдэгдэлд Хөрөнгийн зах зээлийн агентлаг³⁸-ийн гомдлын дагуу тус улсын бизнесийн хүрээний томоохон гишүүдийн нэг болох Ахмед Иосэф Бэхбэхани³⁹-ийд шүүхээс торгууль ногдуулсан гэжээ.

Мэдэгдэлд дурдснаар Ахмед Иосэф Бэхбэхани нь ямар нэгэн хууль бус үйл ажиллагаанд буруугүй, холбоогүй болохоо илэрхийлж байгаа бөгөөд Кувейтийн Давж заалдах шүүхэд уг шийдвэрийг эсэргүүцэн гомдол гаргах юм байна.

Тус банкны мэдэгдэлд “Хөрөнгийн зах зээлийн агентлагаас Кувейтийн ‘Al Ahli Bank’-ны хувьцаатай холбоотой дотоод мэдээллийг хууль бусаар ашиглан хөрөнгийн зах зээлд хувьцааны арилжаа хийж байна гэдэг үндэслэлээр түүнийг сэжиглэж байгаа” гэжээ.

“Al Ahli Bank”-ны хөрөнгийн зах зээл дэх хувьцааны нийт өртөг нь 2.5 тэрбум ам.доллар орчим бөгөөд уг явдлаас хойш хувьцааны ханш 3.5 хувиар унаад байгаа юм.

2011 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн Хөрөнгийн зах зээлийн агентлаг нь сүүлийн үед хөрөнгийн зах зээлд гарч буй хууль бус үйл ажиллагааг бууруулах зорилготой юм.

³⁷ <http://www.reuters.com/article/2014/03/03/ahli-bank-kuwait-court-idUSL6N0M01DK20140303>

³⁸ Capital Markets Authority

³⁹ Ahmed Yousef Behbehani

18.Хятад дахь авлигын эсрэг тэмцэл нь хөрөнгө мөнгө гадагшаа гарахад хүргэж байна⁴⁰ (2014.03.22)

БНХАУ. 2012 оны сүүлчээр БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Зиньпин улс төрийн товчооны гишүүдэд хандан хэлсэн үгийн үндсэн санаа нь “Авлигын улмаас нам задран унаж, улс орон сүйрч болзошгүй” гэсэн утгатай байлаа.

Тухайн үед Хятадын хэвлэлүүдэд хятад хүмүүс болон намын амьдралд гүн гүнзгий нэвчсэн авлига болон хээл хахууль өгөх, авах ёс заншлыг устган амьдралын шинэ хэм хэмжээнд хөтлөн оруулах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэж байлаа.

Авлигын эсрэг хийсэн Хятадын эрх баригчдын тэмцэл санхүүгийн болон хөрөнгийн зах зээлд санаанд оромгүй ул мөрөө үлдээж эхэлсэн нь “эрвээхэйн нөлөөлөл” хэмээх онолыг батлах мэт байлаа. Энэ нь Бразилд эрвээхэй далавчаа дэвэх нь Техаст хар шуурга дэгдэхэд хүрдэг гэж үздэгтэй адил юм.

Бээжингийн засаг захиргааны авлига, хээл хахууль, гар хүндрүүлэх явдал, үнэтэй бэлэг сэлт өгдөг явдлын эсрэг өргөн цар хүрээтэй дайралт нь зах зээлд янз янзын үр дагавар үүсгэв. Үүнд Швейцарийн үнэтэй брэндийн цагны борлуулалт огцом унаж, дөрвөн одтой тансаг зочид буудлын өрөөний эрэлт эрс нэмэгдэж, Австралийн үл хөдлөх хөрөнгийн үнэ гэнэт өсч, хятадын урлагийн бүтээлийн үнэ нэмэгдэв.

Сүүлийн 12 сарын хугацаанд Сидней хотын орон сууцны үнэ 14 хувиар, Мелбурн хотынх 12 хувиар өсөв. Хятадын худалдан авагчид Австралид зарагдаж буй орон сууцны 12 хувийг худалдан авч буй бөгөөд үүнд жил бүр 5.4 тэрбум ам.доллар зарцуулж байгааг шинжээчид хэлж байна.

Хятадын худалдан авагчид үндсэндээ 2 янз ажээ. Нэг дэх бүлэг нь олон улсын компанид ажилладаг хятад залуучууд бөгөөд тэд аливаа зарлага гаргахдаа ихээхэн тооцоотой ханддаг байна. Харин хоёр дахь бүлэг хүмүүс бол хөрөнгөө Хятадаас Австрали руу зөөж байгаа хөрөнгө чинээ ихтэй хятадууд юм. Хоёр дахь бүлгийн хувьд гол асуудал нь хөрөнгө мөнгөө найдвартай байдалд байлгах нь чухал бөгөөд худалдан авч буй үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнэ төдийлөн чухал биш байдаг. Зарим үед үнийг нь ч асуудаггүй гэнэ.

Сиднейн Технологийн их сургуулийн нэгэн хятад судлаач “бүгд л хууль бус зүйл хийдэг, Хятадад эртнээс тогтсон заншил ёсоор хэн нэг нь ямар нэг зүйл хийхийн тулд заавал төлбөр төлж ирсэн шүү дээ” гэж хэлсэн юм. Энэ үүднээс тайлбарлавал, өмч хөрөнгөө гадагш зөөж байгаа нь өргөн хүрээтэй үргэлжилж буй хяналт шалгалтад өртөхөөс айсан хэрэг юм. Хэн нэг хүнтэй холбоотой мөрдөн шалгалт зуугаас ч илүү хүнийг хамарсан сүлжээг шалгахад хүргэдэг байна.

Хэрэв Хятадын Засгийн газар хүмүүсийг хэрхэн хөрөнгөжсөнийг шалгах ажлаа улам өргөжүүлэх юм бол хөрөнгө мөнгө улам ихээр гадагш гарах байх гэж зарим хүн үзэж байна. Тэдний бодлоор энэ нь авлигатай холбоотой юм. Хэрэв засгийн газар ямар нэг байдлаар хууль бус үйлдлийнх нь тухай мэдлээ гэхэд тэр үед хөрөнгө мөнгө болон үр хүүхдээ аль хэдийн гадаадад гаргасан байхыг хичээж байна.

19.Итали Улсад төрийн мэдлийн компаниудын захирлуудын зөвлөлийг цэвэрлэхийг хүсч байна⁴¹ (2014.03.28)

Итали. Тус улсын Засгийн газар төрийн мэдлийн компаниудын захирлуудын зөвлөлийн бүрэлдэхүүнээс санхүүгийн гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийг зайлуулж,

⁴⁰

http://www.afr.com/p/business/property/corruption_crackdown_sends_ripple_yMp1juvVwXuL3WnHMgXJXN

⁴¹ <http://www.trust.org/item/20140328155746-syn6j/>

ингэснээр авлигатай тэмцэх, компанийн үйл ажиллагааны шударга байдлыг нэмэгдүүлэхийг зорьж байна.

Сангийн Сайдаас төрийн мэдлийн компаниудад захидал илгээжээ. Уг захидалд хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр компанийн удирдлагын асуудалд илүү хатуу байр суурьтай байж, тавигдах шаардлагыг чангатгахыг хүсчээ.

Захидалд дурдахдаа албан тушаалын болон санхүүгийн гэмт хэрэг үйлдсэнд сэжиглэгдсэн л бол шүүхээс гэм бурууг тогтоохыг хүлээлгүйгээр төрийн мэдлийн компаниудын удирдлагаас албан тушаалтнуудыг зайлуулж байх ёстой гэжээ.

Италийн шүүх тогтолцоо нь маш төвөгтэй, удаан үргэлжилдэг учраас эцсийн шийдвэр гарах хүртэл арваас дээш жил болох тохиолдол ч бий.

20. Папуа шинэ Гвиней Улс авлига, луйврын хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхээр боллоо⁴² (2014.03.22)

Папуа шинэ Гвиней. Тус улс авлига, луйврын хэргийг хялбаршуулсан журмаар⁴³ шийдвэрлэхээр болсон нь шүүх систем дэх энэ төрлийн хэргийг шийдвэрлэх хугацааг богиносгох ач холбогдолтой болж байна.

Тус улсын тэргүүн шүүгч ноён Саламо Инжи⁴⁴ “авлигын хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхээр болсон нь бид авлига, луйврын хэргүүдэд тусгайлан анхаарал хандуулах боломжтой болж байгаа юм” гэж тэмдэглэж байна.

Шүүхийн нийгэмлэгийн гишүүдийн уулзалтаар уг шийдвэрийг гаргасан байна.

Авлигатай холбоотой гэмт хэргүүдийг богино хугацаанд шийдвэрлэж чадахгүй байгаа үйл явцыг түргэсгэх зорилготойгоор уг шийдвэрийг гаргасан юм.

Тэргүүн шүүгч ноён Саламо Инжи үүнийг тайлбарлахдаа энэ алхам бол авлигын хэрэгт шүүхийн зүгээс тавих анхаарлыг нэмэгдүүлэх, хэргийг шийдвэрлэх хугацааг богиносгох зорилгоор шүүх системд хийж буй бүтцийн өөрчлөлт юм гэжээ.

21. Доод түвшинд авлига маш түгээмэл болсон⁴⁵ (2014.04.06)

Тайланд. Авлигад автсан улс төрчид орон нутгийн төрийн байгууллагуудыг ашиг орлого олох хэрэгсэл болгон ашиглаж байна хэмээн Тайландын Авлигатай тэмцэх үндэсний байгууллагын гишүүн Вичан Махакун мэдэгджээ. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагаа нь ил тод, шударга бус байдгийг улс төрчид ашигладаг. Нөгөө талаас орон нутгийн захиргааны албан тушаалтнууд улс төрчдийн нэгэн адил энэ асуудалд гар нийлж байна гэж онцолсон байна. Түүнчлэн Тайланд дахь авлига нь хилийн чанад дахь гэмт хэргийн бүлэглэлүүдтэй холбоотой байдгийг тэрээр тэмдэглээд, ээлжит засгийн газрууд асуудлыг шийдвэрлэж чадаагүй тул хуулийг эргэж харах хэрэгтэй гэсэн байна.

22. Шинэ Зеландын регби тоглогчид авлигаас ангид байхаар зорьж байна⁴⁶ (2014.04.03)

Шинэ Зеланд. Тус улсын регби тоглогчид энэхүү тоглоомыг авлигаас ангид байлгахгаар дээд түвшний тоглогч, захиргааны ажилтнуудаар амлалт бичүүлж эхэлсэн байна. Тус тоглоом тоглогчдын үйлдвэрчний эвлэлийн ерөнхий менежер Нил Соренсен мэдэгдснээр “Бид энэ тоглоомыг авхаалж самбаа, ур чадвараа харуулсан

⁴² <http://www.emtv.com.pg/home/latest-news/item/fraud-and-corruption-offences-track-launched>

⁴³ track court

⁴⁴ Salamo Injia

⁴⁵ <http://www.bangkokpost.com/news/politics/403654/graft-rife-at-grass-roots-level-nacc>

⁴⁶ <http://www.newsdaily.com/sports/dc5dedcbfb2f0e1e385d6767bd711a88/new-zealand-rugby-launches-anti-corruption-drive>

шударга спорт байлгах зорилгоор кампанит ажлыг эхлүүлээд байна. Бидний спорт сайн нэртэй, энэ нэрийг цаашид хэвээр хадгалахыг хүсч байна” гэжээ.

Мэргэжлийн хэд хэдэн тоглолтод авлигын хэрэгт холбогдсноос хойш энэ асуудал маш чухал болсон бөгөөд Шинэ Зеландын регби гэсэн спортыг хээл хахуулиас ангид байлгах зорилготой гэсэн байна.

“Бид авлигын асуудал спортод ямар хохирол авчирдгийг олон улсын жишээнээс харсан. Иймээс бид регбид ийм юм битгий тохиолдоосой гэж хүсч байна” хэмээн тэр хэлсэн байна.

Шинэ Зеландын дээд түвшний 2000 гаруй тоглогч, менежерүүд энэхүү амлалтыг өгөөд байна. Түүнчлэн дэлхийн ямар ч өнцөг буланд тоглож байхдаа өөрсдийн нэр дээр бооцоо авахгүй байх, ямар нэгэн урамшуулал авч тоглолтын үр дүнд нөлөөлөхөөс татгалзах зэрэг амлалт орсон байна. Хэрэв амлалтаас няцвал насан туршид регби тоглох эрхээсээ татгалзах юм.

23. Авлигатай тэмцэх байгууллага хорих байгууллагыг авлигаас цэвэрлэх ёстой гэж Баруун Австралийн цагдаагийн дарга мэдэгдэв⁴⁷ (2014.04.10)

Австрали. Баруун Австралийн Цагдаагийн газрын дарга Карл О’Каллахан⁴⁸ муж улсын хорих байгууллагад үүрлэсэн авлигыг цэвэрлэх үүрэг Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх хороонд биш цагдаагийн байгууллагад ногдоод байгаа талаар асуудал үүсгэж байна.

Цагдаагийн нууц ажиллагаагаар муж улсын шорон хар тамхи, мансууруулах бодисоор бялуурч байгаа нь илэрхий болжээ. Нийтдээ 40 гаруй хүн баригдсаны зарим нь хоригдлуудад гар утас, мансууруулагч зөөж өгдөг эмэгтэй хянагч байна.

Шорон дотор явуулж буй ажиллагааг цаашид үргэлжлүүлэн явуулахыг Цагдаагийн даргаас Засан хүмүүжүүлэхийн Сайд Жо Франсис⁴⁹ хүсчээ. Гэвч цагдаагийн дарга энэ талаар “ABC” агентлагийн орон нутгийн радиод ярилцлага өгөх үеэрээ “засан хүмүүжүүлэх байгууллагын хэмжээнд бол тэднийх (*Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх хороог хэлж байна*) л илүү их ажилламаар байгаа юм” гэсэн байна. Тэрээр цааш “сүүлийн хэдэн сарын турш ‘Улисс ажиллагаа’⁵⁰ явуулж байж бидний олж мэдсэн зүйлийн зарим нь хорих байгууллагын албан тушаалтнуудын хууль бус үйлдэлтэй холбоотой байсан. Заримдаа илүү ноцтой асуудал илэрч байв. Иймэрхүү авлигатай холбоотой 28 хэргийг бид Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх хороонд шилжүүлсэн. Энэ асуудлаар дагнан ажиллах тусгай баг, эсхүл шуурхай бүлгийг байгуулах санал аваад байгаа, гэтэл шоронд болоод байгаа энэ асуудлын нэлээд тодорхой хэсэг нь албан тушаалтнуудын авлига, хээл хахуулийн асуудал юм шүү дээ, цаашдаа бидэнд Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх хороо гэх мэт энэ асуудлаар дагнан зохион байгуулагдаж, мэргэшсэн байгууллагын оролцоо их хэрэгтэй байна” гэж тэмдэглэв.

Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх хорооны шуурхай ажиллагааны дарга Ким Папалиа⁵¹ “хорих байгууллагын албан тушаалтнуудын ноцтой хууль бус үйлдлүүдийг нэн тэргүүнд анхааралдаа авч байгаа. 2013 оны нэгдүгээр сараас хойш 26 хэрэг дээр мөрдөн шалгалт явуулаад байна. Эдгээрээс нэг хэрэг дээр нь бид Баруун Австралийн цагдаагийн газартай, нэг дээр нь Засан хүмүүжүүлэх албатай, гурав дахь хэрэг дээр Холбооны цагдаагийн газартай хамтран ажилласан. Энэ хэргүүд бүгд хар тамхи, мансууруулах бодис зөөвөрлөсөн асуудалтай холбоотой байсан юм. 2012 оноос хойш

⁴⁷ <http://www.abc.net.au/news/2014-04-10/wa-police-commissioner-karl-ocallaghan-prison-crime-corruption/5381128?section=wa>

⁴⁸ Carl O’Callaghan

⁴⁹ Joe Francis

⁵⁰ the Operation Ulysses

⁵¹ Kim Papalia

манай байгууллага шоронд хууль бусаар эд зүйл зөөвөрлөн оруулах, хоригдлууд болон харгалзагч нар хоорондоо хууль бус харилцаа тогтоох, хоригдлуудын эсрэг хүч хэрэглэх гэмт хэрэг, зөрчилд анхаарлаа хандуулж байгаа. Энэхүү стратегийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ манай байгууллага Баруун Австрали муж улсын Засан хүмүүжүүлэх удирдах газартай нягт хамтран ажиллаж Цагдаагийн байгууллагатай хэлхээ холбоотой байгаа” гэж хэлжээ.

Гэтэл Цагдаагийн дарга О’Каллахан үүнийг үгүйсгэж байна. Тэрээр Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх хорооны энэ стратегийн талаар юу ч мэдэхгүй гэв. “Хэрэв тэднийхээс ямар нэг асуудал дэвшүүлсэн бол бид мэдэх л байсан. Яагаад гэвэл нэг талбар дээр зэрэгцээд л ажиллаад байсан болж таарч байна, гэтэл бид мэдээгүй” гэжээ. Цагдаагийн дарга цааш нь “Миний ойлгож байгаагаар Засан хүмүүжүүлэх албаныхан тухайн үед дотоод мөрдлөгийн албаа шинэчлэн зохион байгуулсан байх юм, тэгэхээр хэн энэ бүхний хариуцлагыг хүлээх болж байна вэ гэж асуумаар байна. Цагдаагийн газар хариуцлага хүлээх ёсгүй. Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх хорооны ажил, яагаад гэвэл тэд үүний төлөө л байгуулагдсан” гэсэн байна.

Засан хүмүүжүүлэхийн Сайд Франсис “Улисс’ ажиллагааны ачаар нэр цэвэр үлдэнэ гэж гэдэгтэй итгэлтэй байна. Тэрээр сайдын албан тушаалд томилогдсоныхоо дараахнаас л шоронгуудад ямар нэг юм болохгүй байна гэсэн мэдээлэл ар араасаа ирээд байсан тул цагдаагийн нууц ажиллагаа явуулах санаачилга гаргасан гэв.

Цагдаагийн дарга “шоронд гарч буй гэмт хэргийг таслан зогсоох үйл ажиллагаанд цагдаагийн газар оролцсонд сэтгэл хангалуун байгаа боловч авлигын асуудал бол Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх хорооны хийх ажил байсан юм. Үндсэндээ хоёр асуудал байна. Гэмт хэрэг ба авлига. Гэмт хэргийг цагдаагийн газар хариуцна. Цаашдаа ч хатуу үүрэг хариуцлага үүрэх болно. Төрийн албан тушаалтнуудын авлигын асуудал бас байна. Энэ чинь төрийн өөр байгууллагын ажил биз дээ. Тусгай баг, эсхүл шуурхай бүлэг байгуулна гэдэг ихээхэн хөрөнгө мөнгө шаардах ажил. Энэ талаар санаа зовж хөөцөлдөх ёстой Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх хороонд бол аль хэдийн төсөв хуваарилагдсан байгаа. Бид хийх ёстой ажил болон тэдний хийх ёстой ажлыг тодорхой зааглаж өгмөөр байна. Тэгвэл нөөц бололцоо, хөрөнгө мөнгөө хоёр талаас зохицуулж, хуваалцмаар байна” гэж хэлжээ.

24. Зэвсгийн худалдааны үед хээл хахууль өгсөн хэрэгт сэжиглэгдсэн этгээд 2.5 сая еврог Грекийн Засгийн газарт эргүүлэн төлөв⁵² (2014.04.14)

Герман. Германы компанитай хийсэн зэвсгийн худалдааны үеэр хээл хахууль өгсөн хэрэгт гол сэжигтнээр татагдсан Грекийн бизнесмен Панаиотис Ефстайоу⁵³ 2.5 сая орчим еврог Грекийн Засгийн газарт эргүүлэн төлөв. Өмгөөлөгчийнх нь мэдэгдснээр сэжигтэн Ефстайоу Грекийн Засгийн газрын дансанд 2552435 еврог шилжүүлсэн бөгөөд хийсэн хэргийнхээ төлөө грекчүүдээс уучлалт гуйжээ.

Одоо 83 настай Ефстайоу нь Германы Атлас Электроник⁵⁴ компанийн төлөөлөгчөөр ажиллаж байсан билээ. Грекийн Батлан хамгаалах яамны зэвсэглэл хариуцсан Төрийн нарийн бичгийн даргын алба хашиж байсан Антонис Кантас нь зэвсгийн худалдааг баталгаатай хийнэ гэж амлан түүнээс мөнгө авсан гэдгээ хүлээн зөвшөөрч мэдүүлсний дараа Ефстайоу мөнгө угаасан болон хээл хахууль өгсөн хэрэгт татагдсан юм. Тэрээр нэгдүгээр сард мэдүүлэг өгөх үеэрээ шумбагч завь болон бусад техник хэрэгслийн худалдаатай холбоотойгоор Батлан хамгаалах яамны албан тушаалтнуудад хээл хахууль өгсөн гэдгээ хүлээсэн байна. Түүнийг цагдан хорьж байсан боловч хорт хавдраар шаналж байгааг нь харгалзан үзэж 500 мянган еврогийн

⁵² <http://greece.greekreporter.com/2014/04/14/arms-bribery-suspect-returns-e2-5m-to-greek-state/>

⁵³ Panayiotis Efsthioy

⁵⁴ Atlas Elektronik

барьцаатайгаар суллажээ. Зэвсгийн наймааны хээл хахуулийн хэрэгт татагдсан бусад хүмүүс нийтдээ 30 орчим сая еврог Грекийн Засгийн газарт буцаан өгч магадгүй болоод байгааг мэдээлж байна.

25. Үндсэн хуульд тусгах ёстой авлигын эсрэг заалтууд буюу авлигад Үндсэн хууль хэрхэн нөлөөлж болох вэ?⁵⁵ (2014.04.17)

Транспаренси Интернэшнл. Маш сайн бичигдсэн Үндсэн хууль бол хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх засаглалын хоорондох эрх мэдлийн хуваарилалтыг нарийн тодорхойлж, холбогдох суурь эрхийг нь хамгаалж, хууль сахих ёсыг дэмжиж өгснөөрөө засаглалын бүтцийг илүү бат бэх болгож өгдөг. Хамгийн сайн үндсэн хуулийг олж тогтоох нь тийм ч хялбар ажил биш юм. Үндсэн хуульд тухайн улсын өөрийн онцлогийг агуулсан тодорхой заалтууд их байдгаас сайн туршлагыг нь авч өөр ямар нэгэн улсад ашиглах боломжгүй байдаг. Гэсэн хэдий ч авлигатай тэмцэх чиглэлээр Үндсэн хуульд тусгаж болох зарим нэг сайн туршлагуудыг доор харуулав.

- **Нийтийн албан тушаалтны шударга, хариуцлагатай байдлын талаар механизмыг тусгах:** Белиз (1981), Колумб (2005), Серби (2006) зэрэг олон тооны улсын Үндсэн хуульд энэ талаар тусгасан байдаг бөгөөд үүний зэрэгцээ төсвийн зарцуулалтын талаар олон нийтэд мэдээлэх, хараат бус аудит хийх, нийтийн албан тушаалтны ёс зүй, сонирхлын зөрчил, хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлэх шаардлагын талаар заалтууд орсон байдаг.
- **Улс төрийн амьдрал, ардчиллын процесст шударга байдлыг эрхэмлэх:** ардчиллын процесс нь нийтийн бус сонирхол, нөлөөллөөс ангид байх учиртай. Зарим Үндсэн хуульд сонгуулийн үйл ажиллагаа болон улс төрийн намын санхүүжилтийн талаар тусгай заалтууд орсон байдаг. Эдгээр улс орнууд бол Тайланд (2007), Грек (2008), Доминиканы Бүгд найрамдах Улс (2010) юм.
- **Нийтийн сонирхол, шударга байдлыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгох:** Катар (2003), Колумб (2005), Ангол (2010) зэрэг улс энэ чиглэлийн заалт оруулсан байдаг.
- **Авлигыг мөрдөн байцаах, хяналт тавих байгууллага байгуулах:** Тайланд (2007), Бутан (2008), Кени (2010), Марокко (2011) зэрэг улсууд авлигатай тэмцэх мэргэшсэн байгууллага байгуулах талаар тусгасан байдаг.
- **Шударга байхыг бүх иргэдийнхээ үндсэн үүрэг болгож заах:** Энэ заалт харьцангуй нийтлэг бус байдаг ч Бутан (2008), Болив (2009), Мадагаскар (2010) зэрэг улсын хуульд байдаг.
- **Тухайн улс авлигатай тэмцэхээ ил тодоор зааж өгөх:** Энэ чиг хандлагыг Нигер (1999), Судан (2005), Эквадор (2008) улсын хуульд зааж өгсөн байдаг.

Засгийн газруудыг авлигатай тууштай тэмцэхэд нь иргэний нийгмийн байгууллагууд тэргүүлэх чиг үүрэгтэй оролцож ирсэн юм. Тухайлбал, Транспаренси Интернэшнл байгууллага улс орнуудын Үндсэн хуульд авлигатай тэмцэх үйл ажиллагааг баталгаажуулсан, дэмжсэн заалтуудыг тусган оруулахыг зөвлөмж болгож байгаа юм.

Сайн Үндсэн хуультай болох нь авлигатай тэмцэхэд чухал алхам болдог. Гэвч тухайн улс орнууд юуг амласан, цаасан дээрх заалтуудыг бодит ажил болгохын тулд юу хийх зэргээ бодит байдалд баталгаажуулах нь хамгийн чухал юм.

55

http://www.transparency.org/news/feature/key_anti_corruption_ingredients_for_constitutions_what_you_need_to_know

26. Шүүхийн шударга байдлын тухай онлайн хэлэлцүүлгийн үр дүн гарав⁵⁶ (2014.04.15)

НҮБ. Ардчилсан улс орны хуулийн тогтолцоон дахь хамгийн чухал зүйл бол шүүхийн хараат бус, шударга байдал билээ. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс холбогдох сүлжээ (DGP-Net, the AP-INTACT Network, and the Asia-Pacific Access to Justice Network)-гээрээ дамжуулан 2013 оны 11 дүгээр сарын 4-нөөс 12 дугаар сарын 3-ныг хүртэлх хугацаанд **Шүүхийн шударга байдал** сэдэвт онлайн хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Хэлэлцүүлгийг үндсэн хоёр үе шаттайгаар (1-р үе шат: Үндэсний түвшинд шүүхийн шударга байдлыг хэмжих судалгаа байдаг эсэх, тэдгээрийн сайн туршлага, 2-р үе шат: Шүүхийн хариуцлагатай байдлыг хянах, хяналтын механизм, шалгуур үзүүлэлтийн талаарх тэргүүн туршлага) зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлгээс дараахь үр дүн гарсан байна. Үүнд:

1-р үе шатны зарим үр дүн:

Энэхүү үе шатанд оролцогчид шүүхийн үйл ажиллагаа болон шүүхийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн төсөөллийн талаарх эмпирик байдалд үндэслэсэн, системтэй, тогтмол үнэлгээг хийж байхын ач холбогдлыг онцолсон юм.

Хэлэлцүүлэгт оролцогч улс орнуудын төлөөллөөс Бангалорын зарчимд тулгуурлан шүүхийн хяналтын механизмыг нэмэгдүүлэхийн тулд дотоод, гадаад хяналт, ёс зүйн дүрмийг сайжруулах; шүүхийн хариуцлагатай, ил тод байдлыг бүрдүүлэхийн тулд парламентын болон иргэний нийгмийн хяналтыг бий болгох шаардлагатай гэж үзсэн байна.

Ливан Улсад шүүхэд хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаан дахь урт хугацааг багасгахын тулд Шүүхийн ерөнхий зөвлөл болон Хууль зүйн сайд хамтран **шүүгчийн хэрэг шийдвэрлэлтийн дундаж хугацааны** талаарх статистикийг хөтөлж байна. Энэхүү статистикийг хөтлөх болсноор 2012 оноос хойших хугацаанд багагүй амжилт гарч, хэрэг шийдвэрлэх дундаж хугацаа буурсан байна. Үүнээс гадна тус улс шүүхийн хараат бус байдлыг нэмэгдүүлэхийн тулд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг сонгох хуульд өөрчлөлт оруулахаар төсөл бэлтгэсэн. **Уг хууль батлагдвал Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүд гүйцэтгэх засгаас томилогдохын оронд шүүгчдээсээ сонгогдох юм.** Энэ нь шүүхийг гүйцэтгэх засаглалаас ангид байлгах алхам юм.

Балба Улсад шүүхийн шударга байдлыг нэмэгдүүлэхийн тулд “Шүүхийн хэрэглэгчийн мэдээллийн самбар”-ыг хэд хэдэн муж, дүүрэгт туршиж байна. Энэхүү самбар нь шүүхийн оролцогч талуудын хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, шүүхийн систем дэх хүмүүсийн итгэлийг нэмэгдүүлэх зорилготой юм. Үүнээс гадна Үндсэн хуульд оруулж буй нэгэн өөрчлөлт бол Дээд шүүхийн шүүгчийг **парламентаас томилох шатанд олон нийтийн дунд нээлттэй сонголт зохион байгуулахаар болж байгаа юм.**

2-р үе шатны зарим үр дүн:

Шүүхийн шударга байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлохыг энэ хэсэгт үндсэн чиглэл болгосон юм. Хэлэлцүүлэгт оролцогчид өөрсдийн улс орны туршлага, болох хувийн үзэл бодлынхоо талаар саналаа солилцсон юм.

Ихэнх улс орнуудад шүүхийн шинэчлэлийн хүрээнд шүүх, прокурорын ёс зүйн дүрмийг баталсан байна. Ёс зүйн дүрмийг мөрдүүлэх, түүнд хяналт тавих, зөрчил гаргасан тохиолдолд сахилгын арга хэмжээ авах этгээд нь Шүүхийн зөвлөл байна. Итали Улсад шүүгчийн үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйлдэл хийвэл шүүгч эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээдэг байна. Шүүхээс энэ талаарх тайлангаа жил бүр Сахилгын хороонд илгээж, тайлагнадаг байна. Шаардлагатай гэж

⁵⁶ <https://undp.unteamworks.org/node/433920>

үзвэл энэ талаар сахилгын нээлттэй сонсголыг Үндэсний радиогоор дамжуулан зохион байгуулан явуулдаг байна.

Францад Сахилгын талаарх хэлэлцүүлгийг олон нийтэд нээлттэй зохион байгуулж, сахилгын шийтгэлийн талаар шүүхийн жилийн тайланд тусгадаг байна. Харин Их Британи Улсад **Шүүхийн гомдлын газар шүүх болон шүүгчийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л гомдол, мэдээллийг хүлээн авдаг байна.** Энэ гомдол мэдээлэл нь үндэслэлтэй байна гэж үзвэл шүүгчид холбогдох сахилгын шийтгэлийг ногдуулдаг байна.

Сахилгын шийтгэлийн талаарх ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд тоон болон чанарын мэдээлэл (**шүүгчийн шийдвэрийн тоо, төрөл, хориг арга хэмжээ болон цагаатгасан тоо хэмжээ, шийдвэрийн үндэслэлийн талаарх мэдээлэл**)-ийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх хэрэгтэй юм. Эдгээр мэдээллийн систем ил тод байснаараа дүн шинжилгээ хийх, шүүхийн хараат бус байдал, чадавхийн талаар чухал мэдээлэл өгөх боломжийг бий болгох юм.

Шинэ Зеландын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр Номхон далайн 14 улсын шүүх системийн шударга байдал, шүүхийн чадавхийг Шүүхийн ёс зүйн дүрмийн Бангалор зарчим болон Шүүхийн хараат бус үйл ажиллагааны талаарх Сува⁵⁷-гийн тунхаглал зэрэгт тулгуурлан үнэлсэн нэгэн жишээг дурдаж болох юм. Энд шалгуур үзүүлэлтийг “Cook Island Indicators” хэмээн нэрлэж байгаа бөгөөд үндсэн 5 үзүүлэлтэд гарсан өөрчлөлтөөр явцыг хэмждэг байна. Үүнд: **1. Кейс менежмент, 2. Шүүх хуралдаанд оролцогчдод хялбар байдал, 3. Санал, гомдлын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг нийтэлсэн байдал, 4. Хүний нөөц, 5. Ил тод байдал гэсэн 5 хэсгээр үнэлсэн байна.**

Бангалорын зарчим олон улс оронд шүүгчийн ёс зүйн дүрмийг бий болгоход дэмжлэг болсон байна. Энэ талаар мөн Германы хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага Гүрж зэрэг улс оронд “integrity scan” сэдэвт туршилт судалгааг явуулсан байна. **Уг судалгааг Бангалорын зарчмын дагуу асуулга боловсруулж, орон нутгийн хуульчид болон шүүгчдийг өөрсдийг нь оролцуулсан ярилцлага, чанарын судалгаа хэлбэрээр зохион байгуулсан байна.** Энэхүү арга нь зөвхөн шүүх систем дэх оролцогч талуудад учирч буй хүндрэл бэрхшээлийг нарийн тодорхойлоход ач холбогдолтой болох нь тогтоогдсон байна.

27. Энэтхэгийн гурван эмч 15 сая ам.долларын эрүүл мэндийн даатгалын мөнгө зүй бусаар ашигласан хэрэгт Холбооны шүүхээс буруутгагдаад байна⁵⁸ (2014.05.01)

Энэтхэг. Шахзад Мирза (43 настай), Жигар Пател (30 настай) болон гадаадад анагаах ухааны сургууль төгссөн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх эрх аваагүй Шринивас Рэдди (38 настай) нар нь 2008 оноос 2011 оны 9 дүгээр сарын хооронд эрүүл мэндийн даатгалын мөнгөнөөс зүй бусаар ашигласан хэрэгт буруутайд тооцогдсон талаар Ерөнхий прокурор Давид Онил мэдэгдлээ.

Холбооны эрүүл мэндийн даатгалын сангаас өрхийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн хэмээн хуурамч бичиг баримт бүрдүүлж мөнгө завшсан хэрэгт Мирза, Пател хоёр буруутайд тооцогдсон бол Реди нь физик эмчилгээний эмч нар гэрээр эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн хэмээн хуурамч бичиг баримт бүрдүүлсэн байна. Түүнчлэн Пател нь мөнгө угаасан хэрэгт буруутгагдсан байна. Эрүүл мэндийн сангаас

⁵⁷ Suva

⁵⁸ <http://timesofindia.indiatimes.com/nri/us-canada-news/3-Indians-convicted-for-role-in-15-million-fraud-in-US/articleshow/34463103.cms>

завшсан мөнгийг эрүүл мэндийн үйлчилгээний нэгэн компанийн дансаар оруулж угаасан байна.

28. Японы шүүхийн тогтолцоо авлигад идэгдсэн тухай тааламжгүй үнэнийг шүүгч асан нийтэд дэлгэв⁵⁹ (2014.04.30)

Япон. Японы шүүхэд ажилд орсон л бол бүх итгэл найдвараа алдана. Шүүгч асан Хироши Сеги “Жапан Таймс” сонинд ярилцлага өгөхдөө “Японы шүүхийн тогтолцоо бол өөрсдийн ая тухыг дээд зэргээр хангасан бөгөөд хүнд сурталд автагдсан дээдсүүдийн орогнох газар болоод байна. Энэ тогтолцоонд шатлан захирах ёсны хатуу зарчим дангаар ноёрхож, чөлөөтэй сэтгэдэг, нээлттэй хувь хүмүүсийг шахан гаргаж байна” гэжээ.

Хироши Сеги 30 жил шүүгчээр ажилласныхаа дараа шүүхийн авлигажсан, ой гутмаар байдалд маш их урам хугарч ажлаа өгөөд Мейжи Их сургуулийн хуулийн сургуулийн профессор болсон гэлээ. Энэхүү тогтолцооноос сугарч гарсныхаа дараа тэрээр ном бичиж хэвлүүлсэн бөгөөд энэ номдоо шүүгч нарын ёс зүйн доройтол, шүүгч, прокуроруудын хуйвалдаан, тогтолцоондоо хүлцэнгүй хандах хандлага зэргийг өөрийн туршлага дээр үндэслэн өгүүлжээ.

Энэ оны 2 дугаар сард ном хэвлэгдэн гарснаас хойш долоо ч хоноогүй байхад Японы Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Такесаки ажлаа өгөх тухайгаа зарласан бөгөөд үүнийгээ эрүүл мэндийн шалтгаанаар гэж тайлбарласан боловч олон нийт түүний ажлаа өгөх болсон жинхэнэ шалтгааныг номноос болсон байх гэж таамаглаж байгаагаа интернэтээр илэрхийлж байна.

Зохиогч “номд тусгагдсан Японы шүүхийн тогтолцоон дахь ужгирсан хүнд суртал болоод зөвхөн байгууллагын эрх ашгийг урьтал болгосон үзэл санаа нь яг үнэндээ Япон Улсын өнөөгийн нөхцөл байдалд бүхэлд нь хамаатай бөгөөд манай улс яагаад эдийн засгийн хувьд уналтад орж буйн шалтгаан нь үүнд л байгаа юм” гэж тэмдэглэв.

29. Нигерийн Засгийн газрын авлигад идэгдсэн байдал Боко Харамыг бий болох нөхцөлийг бүрдүүлжээ⁶⁰ (2014.05.09)

Нигер. Тус улсын Засгийн газарт нэвчсэн клептокраци⁶¹ нь Боко Харамыг үүсэн бий болоход хүргэсэн байх гэж шинжээч хэлж байна. Судлаач Сара Чейз дэлхийн улс орнуудын засгийн газрууд дахь тогтолцоожсон авлига болон хэт даврагч үйл ажиллагааны хоорондын уялдааг судалдаг бөгөөд Нигер гэх мэт тогтолцоожсон авлигатай улс орнуудыг клептократ маягийн бүлэглэлүүд удирддаг гэв.

Лос Анжелес Таймс сонинд нийтлүүлсэн ор-ад⁶² өгүүлэлдээ Чейз “олон Нигер иргэдийн бодлоор Боко Харам ингэж хүчээ авч байгаа нь тогтолцоожсон авлигын нэг үр дагавар юм. Өөрөөр хэлбэл, авлига нь аюулгүй байдалд аюул занал учруулдаг” гэжээ. Газрын тосноос орж ирж буй орлогын зарим хэсэг эрүүл мэнд, боловсролын хөтөлбөрт зарцуулагдах ёстой боловч үнэн хэрэгтээ засгийн газрын өндөр албан тушаалтнууд болон төрийн албан хаагчдын халаасанд ордог байна.

⁵⁹ http://www.japantimes.co.jp/news/2014/04/30/national/crime-legal/ex-judge-lifts-lid-japans-corrupt-judicial-system/?utm_source=rss&utm_medium=rss&utm_campaign=ex-judge-lifts-lid-japans-corrupt-judicial-system#.U3FyEvmSzk9

⁶⁰ <http://www.cbc.ca/news/world/boko-haram-formed-amid-nigerian-government-corruption-1.2636547>

⁶¹ Албан тушаалын эрх мэдэл, нөлөөгөө ашиглан төрийн өмчийн хувьдаа ашиглаж хөрөнгөждөг хүмүүсийн бүлэглэл буюу засаглал, үгчилбэл “хулгайч нарын засаглал”.

⁶² ‘Op-ed’-Зөвхөн зохиогчийн үзэл бодлыг илэрхийлсэн бөгөөд редакцийн чиг шугамд үл хамаарах нийтлэл

Энэ оны 2 дугаар сард Нигерийн Ерөнхийлөгч Жонатан Гүүдлак тус улсын төв банкны тэргүүнийг ажлаас халсан нь хүмүүсийн дунд эргэлзээ төрүүлээд байгаа бөгөөд учир нь газрын тосны орлого болох 20 тэрбум ам.доллар дутагдсан хэргийг шалгах үүргийг төв банкны тэргүүн өгөөд байжээ.

Боко Харам бүлэглэлийн үйлдсэн хэргийн талаар бүгд анхаарал хандуулах боловч алга болсон 20 тэрбумын талаар Ерөнхийлөгч Гүүдлак болон бусад хүн анхаарахгүй байна гэж Сара Чейз хэлэв.

2002 онд байгуулагдсан Боко Харам байгууллагын нэр нь “Барууны боловсрол бол нүгэл” гэсэн утгатай юм. Гэхдээ энэ нь барууныхны нотолж байгаа шиг Талибан маягийн дундад зууны хуучинсаг эсэргүүцэл гэсэн үг биш гэж Сара Чейз хэлж байна. Үнэндээ энэ нь авлигад автсан бөгөөд элит хэсгийн ашиг сонирхолд нийцэж байдаг боловсролын тогтолцоог эсэргүүцэж буй хэрэг юм.

Нигерийн төрийн албанд орохыг хүсвэл сургуульд сурах хэрэгтэй болдог. Гэвч иргэдийн ярьдгаар Нигерийн боловсролын тогтолцоо нь Британийн колончлолын үлдэгдэл юм. Нигерийн оюутнууд тэр тогтолцоогоор нэгэнт дамжсан л бол тэдэнд төрийн албанд ажил олдох боломжтой болдог байна. Энэхүү боловсролын тогтолцооны хувьд оюутнууд анх сургуульд орохдоо хахууль өгөх бөгөөд цаашдаа мөн шалгалт өгч төгсөхдөө ч хахууль өгдөг байна. Хүмүүсийн яриад байгаа барууны боловсрол бол нүгэлт зүйл гэдгийн гол утга санаа нь авлигад идэгдсэн байдлыг нь хэлээд байгаа хэрэг юм. Нигерийн боловсролын тогтолцоо нь авлигад гүн идэгдсэн засгийн газрынхаа тусгал нь юм.

30. Авлигын эсрэг тэмцэгч нэгэн Балба эмэгтэйн түүх⁶³ (2014.05.15)

Балба. Сүрлэг уулс болон Буддагийн төрсөн газар гэдгээрээ алдартай Балба орон одоо авлигын хэргүүдээрээ алдаршиж байна. Транспаренси Интернэшнл байгууллагын 2013 оны авлигын төсөөллийн индексээр Балба 177 орноос 116-д оржээ. Балбын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр улсын хөрөнгийг ашиглан завшсан хэргийн талаар удаа дараа мэдээлсээр байна.

Өөрөөр хэлбэл, нэгэн балба эмэгтэй энэ бүхнийг өөрчлөхөөр тэмцэж байна. Шарада Бхусал Жха⁶⁴ сүүлийн 3 жилийн дотор гурван удаа өлсгөлөн зарлаад байна. Тэрээр мөнгөө хэмнэхийн тулд өдөрт нэг удаа хооллож, явган явж байна. Жха Балбын засгийн газрын байгууллагуудад бугшсан авлигын эсрэг цор ганцаараа сөрөн тэмцэл хийж байгаа юм. Жха өөрийн амьдарч байсан тосгонд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах байдлыг харж тэвчилгүй тэмцэхээр шийдсэн бөгөөд эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүрээнд хүчирхийлэх, хүчиндэх, олон эхнэр авах болон боолчлох зэргээр хүнлэг бус хандах явдлыг тосгоны эрх баригчид үл хайхарч байлаа.

Таван жил гаруй хугацаанд Жха эмэгтэйчүүдийн эрхийг хөсөрдүүлэхийн эсрэг тэмцэж, үүндээ бусад эмэгтэйчүүдийг оролцуулж байв. Гэвч 1999 онд болсон нэг хэрэг явдал түүний амьдралын зорилгыг эрч өөрчилсөн юм. Нэг удаа тосгоны зөвлөлийн хурлын шийдвэр дээр түүнийг хүчээр гарын үсэг зуруулахаар албадан шахсан байна. Гэхдээ тэрхүү шийдвэртэй уншиж танилцахыг зөвшөөрөөгүй бөгөөд зөвхөн гарын үсэг зурахыг л шаарджээ. Тосгоны ахмадууд тосгоны жилийн төсвийг ямар нэг хэлэлцүүлэг хийлгүйгээр батлахыг оролдсон байна. Жха үүнийг нь эсэргүүцэн гарын үсэг зурахаас татгалзахад хуралд оролцож байсан тосгоны ахмадууд түүнийг зодож, хурууных нь хээг шийдвэр дээр хүчээр дарсан байна.

Болсон хэрэг явдлын талаар Жха дүүргийн захирагчид хэлэхэд захирагч асуудлыг бүртгэж авахаас татгалзсан төдийгүй түүнийг тосгоны зөвлөлийн хурлын үйл

⁶³ http://www.huffingtonpost.com/subhash-ghimire/nepals-inspiring-anticorr_b_5324790.html

⁶⁴ Sharada Bhusal Jha

ажиллагаанд саад учруулсан гэж үзэж баривчлан, арга хэмжээ авна гэж сүрдүүлсэн байна.

Тосгоны ахмадуудад зодуулж, захирагчид доромжлуулсан Жха тосгон дахь авлигын эсрэг тэмцэхээр зориг шулуудав. 1999 онд Жха Засгийн газарт өргөдөл гаргаж, Засгийн газраас тосгонд зориулан хуваарилж буй төсвийг зогсоохыг хүслээ. Учир нь тосгоны эрх баригчид нас барсан хүмүүсийн нэрийг ашиглан улсаас өгдөг өндөр насны тэтгэврийн сангаас завшиж байжээ. Засгийн газрын зүгээс түүний гаргасан өргөдлийн дагуу ямар нэг арга хэмжээ аваагүй юм.

Жха 2011 онд өөр гурван хүний хамт тосгондоо өлсгөлөн зарлав. Түүний энэ үйл ажиллагаа үндэсний хэмжээнд анхаарал татаж, Жхатай уулзахаар нийслэл Катмандугаас Засгийн газрын өндөр албан тушаалтан ирж, тосгоны зөвлөлийн үйл ажиллагаан дахь авлигыг мөрдөн шалгах аамласнаар Жха өлсгөлөнгөө зогсоов.

Гэвч дүүргийн засаг захиргааны албан хаагчид холбогдох бичиг баримт, бүрдүүлсэн нотлох баримтуудыг шатааж устгав. Тэр ч байтугай тус улсын хэмжээн дэх авлигын эсрэг тэмцэх дээд шатны байгууллага болох Албан тушаалтнуудын хууль бус үйл ажиллагааг мөрдөн шалгах хороо⁶⁵-ны мөрдөн байцаалтын баримт бичгийг хэн нэг нь устгасан байна. Тосгоны зөвлөлийн нарийн бичгийн даргыг ажлаас халснаас өөрөөр хэн ч хэрэгт татагдаж буруутгагдсангүй.

Албан тушаалтнуудын хууль бус үйл ажиллагааг мөрдөн шалгах хороонд Жха-гийн тусад нь өгсөн гомдлыг бас устгасан нь бүр хачирхалтай байлаа. Тэрээр гомдлын дагуу үүсгэсэн хэргийн 3956 гэсэн дугаарыг хүртэл санаж байдаг юм.

2013 онд Жха нийслэл Катманду хотод 9 хоногийн өлсгөлөн зарлаж тэмцлээ. Өмнөхтэй адил зөвшилцөл хийгдэж Засгийн газар мөрдөн шалгалт хийхээр амласан боловч харамсалтай нь юу ч хийсэнгүй. Түүний шаардлагыг үл тоож байгаа Засгийн газарт эсэргүүцлээ илэрхийлэн 2014 онд Жха гурав дахь удаагаа өлсгөлөн зарлав. Энэ удаад тэрээр нийслэл Катманду хотын хамгийн том олон нийтийн талбай дээр чимээгүй өлсгөлөн зарлаж 13 өдөр өнгөрүүлжээ.

Өлсгөлөн зарласан 13 дахь өдрийн төгсгөлд Жха Балбын Засгийн газарт зориулан Хиндү⁶⁶ уламжлалаар ёслол үйлдэв. Тэр үсээ хусч, цагаан нөмрөг өмссөн нь нас барагсдын ар гэрийнхний хийдэг ёс ажээ. Жха-гийн хэлснээр ард түмний хувьд Засгийн газар амьд байхаа больсон байна.

31.Саяхан гарсан илтгэл Хятадын компаниудад анхааруулга болов⁶⁷ (2014.05.14)

БНХАУ. Хятадын бизнесийн байгууллагуудад зориулсан нэгэн илтгэл нийтэд тараагдав. Энэ нь авлигатай тэмцэх асуудлаарх олон улсын хэм хэмжээ болон нийтлэг үйл ажиллагааг тусгасан анхны тайлан юм.

“Дэлхийн тавцанд гарах уу: Олон улсын бизнесийн үйл ажиллагаан дахь авлигын эсрэг дэг журмын талаарх судалгаа⁶⁸” гэсэн нэртэй энэхүү илтгэлийг Хятадын Төв Банк⁶⁹, Олон улсын худалдааны танхим⁷⁰, Хятадын Олон улсын худалдааны танхим⁷¹, Хятадын Ард түмний их сургууль⁷² хамтран гаргажээ.

Илтгэлд дурдснаар үндэсний компаниудыг олон улсын хэмжээнд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд хамгийн их саад болж байгаа зүйл бол авлига гэжээ.

⁶⁵ the Commission for Investigation of Abuse of Authority (CIAA)

⁶⁶ Hindu

⁶⁷ <http://www.ecns.cn/2014/05-14/113823.shtml>

⁶⁸ Go Global: International Business Anti-Corruption Rules Research

⁶⁹ the Bank of China

⁷⁰ the International Chamber of Commerce (ICC)

⁷¹ the China Chamber of International Commerce

⁷² Renmin University of China

Ард түмний их сургуулийн ерөнхийлөгч Чен Юулу⁷³ “Хятадын компаниудын хөгжилд авлига саад болж байна, хэрэв компаниуд олон улсын бизнесийн орчин, хэм хэмжээг ойлгодог болчихвол үүнээс зайлсхийж чадна” гэж хэлжээ.

Хятадын Төв банкны дэд захирал асан Занг Янлинг⁷⁴ энэхүү илтгэлийн төслийг бэлтгэх үйл ажиллагааг удирдсан бөгөөд түүний хэлснээр сүүлийн жилүүдэд Хятадын 12 компани авлигын хэрэгт холбогдож Дэлхийн банкны хар жагсаалтад орсон байна.

Илтгэлд мөн Хятадын компаниудын дотооддоо үйлдэж байгаа авлигын хэргүүд нь тэдний нэр хүндийг дэлхий дахинд унагааж байгаа талаар Худалдааны яам⁷⁵-наас гаргасан сануулгыг иш татаж оруулжээ.

АНУ-д авлигын хэргээр мөрдөн шалгагдаж, шийтгүүлсэн 74 компанитай холбоотой хэргүүдийн 24 нь Хятадын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн байна. Эдгээрийн дотор Сиенс⁷⁶, Ай-Би-Эм⁷⁷ зэрэг үндэстэн дамнасан компаниуд байгаа юм.

Авлигын эсрэг үйл ажиллагаа бол үндэсний болон олон улсын хэмжээнд адилхан чухал гэдгийг илтгэлд дурджээ. Хятадын Коммунист Намын 18 дугаар Их хурал⁷⁸-ын үеэр Засгийн газар авлигыг устгахын тулд бүх хүчээрээ тэмцэнэ гэдгээ зарласан билээ. Түүнчлэн 2009 оноос хойших Их-20-ийн уулзалт⁷⁹-уудад хэлэлцэж байгаа нэг гол асуудал бол авлига болоод байна.

Энэхүү илтгэл нь Олон улсын худалдааны танхимын Авлигатай тэмцэх талаарх Дэд хэсэг⁸⁰ болон Олон улсын худалдааны танхимын Авлигатай тэмцэх журам⁸¹-ын хятад орчуулга юм. Эдгээр баримт бичгүүдэд олон улсын бизнесийн гэрээ хэлэлцээрт мөрдөгддөг нийтлэг хэм хэмжээ, журмуудыг, тухайлбал, ажил хэргийн түншийн зүгээс санал болгож буй бэлэгтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх гэх мэт асуудлыг нарийвчлан тусгажээ.

Төслийн удирдагч Занг “энэхүү зөвлөгөөг хятадын бизнесийн хүрээнийхэн хүлээж авах байх. Тэднийг авлигаас ангид байж, цаашид энэ асуудлыг анхаарахад хүргэнэ гэж найдаж байна” гэж хэлжээ.

32. Өмнөд Азийн орнуудын авлигатай тэмцэх байгууллагууд илүү их бие даасан байх шаардлагатай байна (2014.05.21)

Транспаренси Интернэшнл. Авлигад нэрвэгдсэн Өмнөд Азийн орнуудын Засгийн газрууд авлигын хэргийг мөрдөн шалгаж шийдвэрлэдэг байгууллагуудаа илүү их бие даасан байдлаар ажиллуулах шаардлагатай гэж Транспаренси Интернэшнл байгууллага саяхан хийгдсэн судалгаандаа дурдлаа. Энэ судалгаа нь Өмнөд Азийн орнууд дахь ил тод байдал болон авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх бүрэн хэмжээний анхны судалгаа юм.

Бангладеш, Энэтхэг, Балба, Пакистан, Шри Ланк, Мальдив улсын нийт 70 байгууллагад судалгаа хийж эдгээр байгууллагад авлигатай тэмцэж чадсан туршлагыг судлан судалгааны тайланг гаргажээ. Эдгээр 6 орны засгийн газрын авлигатай тэмцэх чиг үүрэгтэй албан тушаалтнууд болон жирийн иргэд авлигын талаар мэдээлэх, илрүүлэх, мөрдөн шалгах, шүүн таслах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжоор тогтоосон саад тотгор, улс төрийн эсэргүүцэл болон хүчирхийлэлтэй байнга тулгарч байдаг талаар тайланд дурджээ.

⁷³ Chen Yulu

⁷⁴ Zhang Yanling

⁷⁵ the Ministry of Commerce

⁷⁶ Siemens

⁷⁷ IBM

⁷⁸ National Congress

⁷⁹ G20 summit

⁸⁰ the ICC Anti-corruption Clause

⁸¹ ICC Rules of Combating Corruption

Транспаренси Интернэшнл байгууллагын Ази, Номхон далайн бүсийн захирал Срирак Плипат⁸² “эдийн засгийн ийм өндөр өсөлт бүхий бүс нутгийн ядуурлын түвшин яагаад ийм их өндөр байна вэ? Хариулт нь авлига юм. Авлига бол хэдхэн тооны хүмүүсийг ямар ч хяналтгүйгээр баяжих боломж олгодог билээ. Авлигыг устгахын төлөө тэмцэхгүй бол Өмнөд Азийн ядуу зүдүү амьдарч байгаа хагас тэрбум хүний амьдрал дээшлэхгүй”, мөн “Ил тод байдлыг бий болгох нь Засгийн газруудын хийж чадах хамгийн том хөрөнгө оруулалт мөн. Авлигыг зогсоох талаар тодорхой зүйл хийж чадах байгууллага байна гэдэгт хүмүүс итгэж байвал улс төрчдөд итгэх итгэл өндөр байж чадна” гэжээ.

33.Хятадын эрүүл мэндийн салбарт авлига гамшиг мэт тархсан талаар нэгэн эмч буруутгагдаж байна⁸³ (2014.05.23)

БНХАУ. Хятадын эмнэлгүүдэд эмч нар өвчтнүүдэд шаардлагагүй эмчилгээ, үнэтэй эм тариа хийх байдал газар авснаар үйлчлүүлэгчид хааяа хүчирхийлэл үйлддэг болоод байна. Лан Юуфенг гэгч эхо оношилгооны эмч өөрийн ажиллаж байсан эмнэлгийг өвчтнүүдэд иймэрхүү байдлаар хандаж буй талаар олон нийтэд дэлгэсний төлөө эмнэлгийн зүгээс маш их эсэргүүцэлтэй тулгарсан билээ.

Тэр хоёр жилийн өмнө 53 настай эрэгтэй өвчтөнд тавьсан зүрхний стимуляторын хэрэгцээг олж хараагүй ба ямар ч шаардлагагүй төхөөрөмж тавьсан гэсэн дүгнэлт хийжээ. Үүнээс болж ажиллаж байсан эмнэлэг нь түүнийг халсан ч тэрээр өдөр бүр эмнэлэг дээрээ ирдэг ба олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр “хонгилын эмч” гэсэн нэр зүүгээд байна. Түүнийг хамт ажиллагсад нь эрүүл мэндийн салбарын нэр хүндийг гутаагч гэж үздэг байна.

Гэтэл Хятадын эрүүл мэндийн салбар, эмийн үйлдвэрүүд өвчтнүүдээсээ хээл хахууль авах, ямарч хэрэггүй эм тариа, эмчилгээ хийх явдал ихээр тархсан байна. Энэ нь зарим нэг тайлан, мэдээнд гарч буй байдлаар өвчтнүүдийн зүгээс эрүүл мэндийн ажилтнууд, эмч нарт халдах, амийг хөнөөх явдал ихэссэн гэсэн дүнтэй байна. 4 дүгээр сард Цянсуугийн Зүүн мужид 45 настай эрэгтэй өөрт нь хагалгаа хийсэн эмчийг буруу эмчилгээ хийсэн хэмээн амийг нь хөнөөсөн байна. Үүнээс 3 сарын өмнө Чжэцян мужид нэг эрэгтэйд чих хамар хоолойн эмчийг хөнөөсөн явдалд цаазаар авах ял оноожээ.

Таван жилийн өмнөхтэй харьцуулахад гурван эмнэлгийн хоёрт нь буюу 2012 оны байдлаар эмч, эмнэлгийн ажилтнуудад халдах явдал 50 хувиар нэмэгдсэн хэмээн Хятадын эмнэлгүүдийн холбооноос мэдэгджээ. Эмнэлгийн ажилтнуудыг айлган сүрдүүлэхээс эхлэн амийг хөнөөх хүртэл 21 тохиолдлоос 27 болж бүртгэгдсэн байна. Гэтэл үйлчлүүлэгчдийн дунд явуулсан судалгаагаар эмчид хандахад маш хэцүү байдаг гэж судалгаанд оролцогчдын 80 хувь нь үзсэн бол 95 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээ үнэтэй байсан гэжээ. Зардал өсөж байгаа нь эмнэлгүүдийн борлуулж буй эм, үйлчилгээнээс их хамааралтай юм. Зөвхөн эмнэлгүүд биш эмч нар хүртэл эмийн үйлдвэрийн компаниудаас бонус авдаг байна.

⁸² Srirak Plipat

⁸³ http://articles.economictimes.indiatimes.com/2014-05-23/news/50055374_1_healthcare-providers-doctor-patients

34.Казахстан дахь авлига бол гадаадын шууд хөрөнгө оруулалт дахь хамгийн том саад⁸⁴(2014.06.05)

Казахстан. Тус улсын Парламентын гишүүн Турсунбек Омурзаков⁸⁵ -ын хэлснээр “Казахстан Улсад төрийн үйлчилгээг авах цорын ганц арга зам бол авлига, хээл хахууль болоод байна” хэмээн Казахстаны “*Tengrinews*” агентлаг мэдээллээ.

“Казахстан дахь бизнесийн орчинг сайжруулахын тулд тус улсын Засгийн газраас ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа ч авлига, хээл хахуулийн улмаас эдгээр хүчин чармайлтууд нь талаар болж байна. Үндэсний банкны 2013 оны тайланд дурдснаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 17 хувиар буурсан байгаа нь Казахстан дахь хөрөнгө оруулалтын орчин хангалттай бүрдээгүйг илэрхийлж байна” гэж тэрээр хэлсэн байна.

Транспаренси Интернэшнл байгууллагын судалгаагаар тус улсын авлигын нөхцөл байдал улам бүр муудаж байгааг мөн онцлоод, “Транспаренси интернэшнл байгууллагын авлигын төсөөллийн индексийн судалгаагаар 180 улс орноос 140 дүгээр байрт бичигдэж байна, мөн сүүлийн жил 6 байраар ухарлаа. Эдийн засаг болон хөрөнгө оруулалтынхаа орчинг сайжруулахын тулд Казахстан Улс томоохон алхам хийх шаардлагатай байна. Судалгаагаар төрийн үйлчилгээг авах ганц арга, зам бол авлига, хээл хахууль болсон байна. Судалгаанд оролцсон иргэдийн 39 хувь нь бэлэг хэлбэрээр төрийн албан хаагчдад хахууль өгсөн байхад мөн 33 хувь нь төрийн үйлчилгээний хурдыг нэмэгдүүлэхийн тулд хээл хахууль өгсөн байна” гэж Турсунбек Омурзаков цохон тэмдэглэлээ.

Мөн түүний хэлж байгаагаар “Ernst and Young” фирмийн явуулсан судалгаагаар ирэх 3 жилийн хугацаанд бүх гадаадын шууд хөрөнгө оруулалтын 75 орчим хувь нь Казахстаны уламжлалт үйлдвэрлэл буюу эрчим хүч, уул уурхайд чиглэх юм.

Энэ оны эхээр Казахстаны Засгийн газар гадаадын хөрөнгө оруулагчдыг татахын тулд урамшууллын шинэ багцыг гаргаад байгаа бөгөөд энэ нь тус улс хөрөнгө оруулалтынхаа орчинг сайжруулах талаар ихээхэн анхаарал хандуулж байгаагийн нэгэн илэрхийлэл болж байна.

35.Яагаад зарим улс оронд авлигатай тэмцэх байгууллагууд илүү их амжилттай байна вэ? (2014.06.05)

Бангладеш. Авлигын эсрэг амжилттай тэмцсэн улс бол Сингапур, Хонконг юм. Эдгээр улсуудад авлигын эсрэг үйл ажиллагаанд тухайн улсын авлигатай тэмцэх байгууллага голлох үүрэгтэйгээр оролцож, маш богино хугацаанд амжилтад хүрсэн байдаг.

Харин Бангладеш, Энэтхэг зэрэг улсуудад авлигатай тэмцэх байгууллага яагаад амжилтад хүрэхгүй байна вэ? Харвардын их сургуулийн профессор Нурул Ислам “Бангладеш Улс дахь авлига, авлигыг хянах, өөрчлөлтийг чиглүүлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний бүтээл ном гаргаад байна. Уг номд Бангладеш дахь авлигын шинж байдлын талаар өргөн хүрээний мэдээлэл болон тус улсын авлигатай тэмцэх байгууллага яагаад амжилтад хүрэхгүй байгаа зэргийг тодорхой авч үзсэн байна.

Бангладеш Улсын авлигатай тэмцэх байгууллагын удирдлагын нэрлэж байсанчлан тус улсын авлигатай тэмцэх байгууллага нь “шүдгүй арслан” шиг байгаа юм. Нурул Исламын үзэж байгаагаар ерөнхийдөө авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагааг зөвхөн нэг хуульд нарийн тусгаснаар амжилтад хүрэхгүй болно. Авлигатай тэмцэх байгууллагыг амжилтад хүргэхийн тулд хуулиас гадна хараат бус

⁸⁴ http://en.tengrinews.kz/laws_initiatives/Corruption-in-Kazakhstan-is-a-major-obstacle-to-FDI-MP-253963/

⁸⁵ Tursunbek Omurzakov

байдлыг нэмэгдүүлэх үндсэн дөрвөн шалгуурыг хангах ёстой гэж тэрээр үзэж байна. Үүнд:

- а. Гүйцэтгэх засаглалын хяналтаас гадуур байх,
- б. Санхүү болон байгууллагын үйл ажиллагааны хувьд бие даасан байх,
- в. Албан хаагчдын томилгоо нь хараат бус байх,
- г. Гүйцэтгэх болон мөрдөн шалгах ажиллагааны хувьд бие даасан байх зэрэг юм.

Дээрх дөрвөн шалгуурын хувьд хараат бус байх явдлыг хангах нь зөвхөн авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагааг амжилттай явуулахад баталгаа болохоос гадна тухайн байгууллагад итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг хэмээн тэрээр үзэж байна.

Уг бүтээлийг дараахь холбоосоор орж үзэх боломжтой юм.

<http://www.bids.org.bd/publication/Corruption,%20Its%20Control%20and%20Drivers%20of%20Change.pdf>

36. Мьянмар Улсын шашны асуудал эрхэлсэн сайд хөрөнгө урвуулан ашигласан хэрэгт буруутгагдлаа⁸⁶(2014.06.19)

Мьянмар. Орон нутгийн хэвлэлүүдийн мэдээлж байгаагаар Буддын шашин давамгайлсан Мьянмар Улсын Шашны асуудал эрхэлсэн сайд Хсан Шинт⁸⁷ авлигын хэрэгт буруутгагдан, саатуулагдаад байна.

Мөн тус улсын ерөнхийлөгч Тейн Сейн⁸⁸ Хсан Шинт авлигын хэрэгт холбоотойгоор ажлаасаа халагдсан гэж төрийн мэдээллийн хэрэгслээр мэдэгджээ.

Мьянмарын “7Day Daily” агентлагийн мэдээлж байгаагаар өнгөрсөн оны 1 дүгээр сард Шашны асуудал хариуцсан сайдаар томилогдсон Хсан Шинт сайдын төсвийн багцыг урвуулан ашигласан хэрэгт буруутгагдаж түүнийг “төсвийн мөнгийг хувьдаа завшсан” хэрэгт буруутган шүүхэд дуудаад байна.

Зарим эх сурвалжийн мэдээлж байгаагаар сайдын төсвөөсөө 10740 ам.доллар зарцуулан өөрийн гэр бүлийн нэрээр жижиг хийд бариулсан юм. Мөн уг барилгын ажилд 3375 ам.долларын өртөг бүхий албаны машин, түлш зэргийг байгууллагаасаа зарцуулсан байна. Эх сурвалжийн мэдээлж байгаагаар дээрх мөнгөн дүнгээс зөвхөн 2860 ам.долларыг л 11 дүгээр сард буцаан төлсөн байна.

Уг хийдийн барилгын ажил өнгөрсөн оны 12 дугаар сард дууссан бөгөөд энэ үед сайдын төсвөөсөө мөн 7360 ам.доллартай тэнцэх хэмжээний мөнгийг завшсан гэж үзэж байна.

37. Хятадын 3 өндөр албан тушаалтан авлигын хэргээр намаас хөөгдөв⁸⁹(2014.07.03)

БНХАУ. Хятадын Засгийн газрын 3 албан тушаалтныг эрх баригч Коммунист намаас хөөлөө. Тэд Улс төрийн товчооны гишүүн асан Жоу Ёнкан⁹⁰-тай холбоотой байсан юм. Эдгээр шийдвэрүүд нь ноён Жоуд тулгаж буй ялын талаар эрх баригчдын зүгээс зарлахад бараг бэлэн болсны эцсийн дохио болж байна.

⁸⁶ <http://www.rfa.org/english/news/myanmar/minister-06192014183955.html>

⁸⁷ Hsan Sint

⁸⁸ Thein Sein

⁸⁹ http://www.nytimes.com/2014/07/03/world/asia/china-expels-3-officials-in-corruption-inquiry.html?partner=rss&emc=rss&_r=1

⁹⁰ Zhou Yonkang

Хайнан⁹¹ мужийн дэд захирагч асан Жи Венлин⁹² авлига, урван тэрсэлсэн⁹³, бусдын ашиг сонирхлын тулд албан тушаалаа ашигласан⁹⁴ зэргээр хууль, намын сахилга батын ноцтой зөрчил гаргасан тул намаас хөөсөн болохыг мэдээллийн Синхуа агентлаг⁹⁵ албан ёсоор мэдээлэв. Нийгмийг аюулаас хамгаалах яамны хамгаалалтын товчооны ахлах офицер⁹⁶ асан Тан Хонг⁹⁷ болон Коммунист намын Улс төр, хуулийн асуудал эрхэлсэн Комиссын төв аппаратын дэд дарга⁹⁸ асан Ю Ган⁹⁹ нарыг мөн адил үндэслэлээр намаас хөөжээ. Эдгээр гурван албан тушаалтныг эрүүгийн хэрэгт татан шалгах юм.

Хятад дахь нэр хүнд бүхий бизнесийн сэтгүүлүүдийн нэг болох Кайшин¹⁰⁰-ы нэгэн дугаарт мэдээлснээр эдгээр хүмүүс нь ноён Жоугийн туслахаар ажиллаж байжээ. 2012 оныг хүртэл гүйцэтгэх товчооны гишүүн байсан ноён Жоу болон түүний хэд хэдэн хамаатнууд одоо цагдан хоригдож байгаа бололтой.

Ерөнхийлөгч Ши Зиньпиний эхлүүлсэн авлигын эсрэг кампанит ажил Засгийн газрын бараг бүхий л түвшнийг хамарч байна.

38.Танай хотыг бусад хотуудтай хэрхэн харьцуулах вэ? “ISO” шинэ стандарт¹⁰¹(2014.05.14)

Олон улсын стандартын байгууллага (ISO). Тухайн хотын амьдралын чанар болон үйлчилгээний хүртээмжийг үнэлэх шинэ хэмжээсүүдийг агуулсан нэгэн шинэ стандарт “ISO 37120:2014”-ыг олон улсын стандартын байгууллагаас гараад байна. Уг стандартыг хотын дарга болон улс төрчид, судлаачид, бизнесийнхэн, төлөвлөгчид зэрэг бусад олон талынхан ашиглах боломжтой юм. *Яагаад бидэнд хотын шалгуур үзүүлэлт хэрэгтэй болов?*

Одоогийн байдлаар дэлхийн нийт хүн амын 53 хувь нь хотод амьдарч байгаа бөгөөд 2050 он гэхэд энэ тоо 70 хувь болж өсөх юм. Дэлхийн хотууд нь соёл, эдийн засгийн төв болж өнөөдрийн байдлаар дэлхийн нийт ДНБ-ий 70 хувийг бий болгож байна. Гэвч хөрөнгө оруулагчдад хотуудын тогтвортой, үр ашигтай байх эсэх нь чухал асуудал хэвээр байсаар байгаа бөгөөд шинэ стандарт ISO37120:2014 энэхүү бэрхшээлийг арилгахад туслах юм.

Уг стандартад орсон шалгуур үзүүлэлтүүд нь амьдралын чанар болон тогтвортой байдлыг хангах, засаглалын шалгуур зэрэг ерөнхий шаардлагын дагуу хотуудын авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явц болон түүний өөрчлөлтийг хэмжихэд туслах юм. Стандартаар хотуудыг харьцуулснаар амжилттай байгаа хотоос бусад нь суралцах, харилцан туршлага солилцох боломжийг мөн нэмэгдүүлэх юм.

ISO37120:2014 стандартад:

- эдийн засаг
- боловсрол
- эрчим хүч
- байгаль орчин

⁹¹ Hainan

⁹² Ji Wenlin

⁹³ adultery

⁹⁴ taking advantage of his posts to seek benefits for others

⁹⁵ The official Xinhua news agency

⁹⁶ senior officer in the guard bureau of the Ministry of Public Security

⁹⁷ Tan Hong

⁹⁸ deputy head of the general office of the party's Commission for Political and Legal Affairs

⁹⁹ Yu Gang

¹⁰⁰ Caixin

¹⁰¹ http://www.iso.org/iso/home/news_index/news_archive/news.htm?refid=Ref1848

- санхүү
- гал унтраах болон яаралтай тусламж
- **засаглал**
- эрүүл мэнд
- амралт
- аюулгүй байдал
- хатуу хог хаягдал
- цахилгаан холбоо
- тээвэр
- хотын төлөвлөлт
- бохир ус зайлуулалт
- ундны ус болон ариун цэвэр гэсэн асуудлууд багтаж байгаа юм.

Энэхүү стандарт нь хотын шалгуур үзүүлэлтийг бий болгож байгаа хамгийн анхны стандарт бөгөөд дэлхийн хотууд уг стандартыг нэвтрүүлснээр дараахь давуу тал бий болох юм. Үүнд:

- Засаглал болон үйлчилгээний хувьд илүү үр ашигтай байдлыг бий болгох;
- Олон улсын болон орон нутгийн түвшинд нэгдсэн нэг шалгуур үзүүлэлт ба зорилтыг тодорхойлох;
- Бодлого боловсруулах, шийдвэр гаргахад илүү мэдээллээр хангах;
- Харилцан туршлага солилцох;
- Хөрөнгө оруулагчдад нээлттэй, ил тод мэдээлэл бүрдэх;
- Хотуудыг харьцуулан шийдвэр гаргахад хялбар болох зэрэг юм.

39. АНУ гуравдагч ертөнцийн орнуудтай адил хэмжээгээр авлигад идэгдсэн үү?¹⁰² (2014.06.14)

АНУ. Шинэ Орлеан¹⁰³ хотын захирагч асан Рэй Нэйгин¹⁰⁴ албан тушаалаа урвуулан ашигласан хэргийн улмаас шоронгийн хаалга татлаа. Түүний өмнөхөн Детройт¹⁰⁵ хотын захирагч асан Кваме Килпатрик¹⁰⁶, Иллинойс¹⁰⁷ мужийг төлөөлсөн Конгрессийн гишүүн асан Жесс Жексон¹⁰⁸ нар ийм хэргээр шоронд суусан билээ. АНУ-ын төрийн өндөр албан тушаалтнууд ийнхүү албан тушаалын гэмт хэрэгт холбогдсоор байхад ихэнх америкчууд улс төрийн авлигыг ядуу буурай орнуудад л өргөн тархсан асуудал, харин Америкт бол тийм биш гэж үзэж байна. Бодит байдал дээр асуудал нэлээд төвөгтэй байх юм. Жишээ нь, Нигер болон Боливийг бодвол АНУ-д хээл хахуулийн хэрэг хамаагүй бага гардаг. Гэвч иргэдээс танай оронд авлига хэр их түгээмэл вэ гэж асуувал тэд хээл хахуулиас илүү өргөн хэмжээгээр бодож эхэлдэг. Тэд Засгийн газар болон улс төрийн тогтолцоо хэр шударга ажилладаг билээ, иргэдийн эсрэг байдаг эсэх талаар шүүн тунгааж эхэлдэг. Ийм л үндэслэлээр АНУ болон хөгжиж буй орнуудын хооронд нэг их ялгаа байхгүй байж болох талаар бодох шалтгаан гарч ирж байгаа юм.

¹⁰² <http://www.businessweek.com/printer/articles/212665-is-the-u-dot-s-dot-as-corrupt-as-the-third-world>

¹⁰³ New Orlean

¹⁰⁴ Ray Nagin

¹⁰⁵ Detroit

¹⁰⁶ Kwame Kilpatrick

¹⁰⁷ Illinois

¹⁰⁸ Jesse Jackson Jr.

Улс төрийн эрсдлийн шинжээчид¹⁰⁹, тусламжийн байгууллагын эдийн засагчид¹¹⁰, бодлогын судалгааны хүрээлэн, байгууллагуудын ажилтнууд¹¹¹-ын хувьд ер нь ямар улс орнуудыг авлигад идэгдсэн гэж үздэг болохыг тэдний энэ талаарх үзэл бодлын илэрхийлэл болсон Транспаренси Интернэшнл байгууллагын Авлигын Төсөөллийн Индексээс төвөггүйхэн харж болно. Дээд талын (гэгээлэг¹¹²) хэсэгт нь баян орнууд, үүнд 3-т Швед, 14-т Их Британи, 19-д АНУ байна. Доод талын (чөтгөрийн¹¹³) хэсэгт ядуу орнууд, үүнд 136-д Зааны Ясан Эрэг улс, 116-д Вьетнам, 111-д Танзани байна. Буурай хөгжилтэй орнууд авлигад гүнзгий идэгдсэн бөгөөд энэ нь тэдний ядуу байгаагийн маш том, магадгүй хамгийн гол шалтгаан гэдэгт барууны улс төрчид, ажил хэрэгч хүмүүс, тусламжийн байгууллагын ажилтнууд итгэсэн байдаг.

Компаниуд татвараас зайлсхийхээс авахуулаад Засгийн газрын зарласан тендерт ялах зэрэг янз бүрийн үйл ажиллагааны явцад гар цайлгах, шан харамж өгөх явдал¹¹⁴ хэр зэрэг түгээмэл байдаг талаар олон улсын хэмжээнд санал асуулгууд явуулахад тодорхой дүр зураг гарч ирдэг. Тухайн улс хэр зэрэг ядуу буурай байна төдий чинээ компаниуд ийм төрлийн зарлага их гаргадаг байна. Хувь хүмүүсээс хэзээ нэгэн цагт хээл хахууль өгч байсан эсэх талаар асуухад хариулт нь мөн л адил байдаг. Транспаренси Интернэшнл байгууллагын судалгаанаас үзвэл америкчуудын 10 хувь, англичуудын 6 хувь нь л тэднээс хээл хахууль нэхсэн тохиолдолтой таарсан гэж хариулжээ. Үүнтэй харьцуулбал туркуудын 22 хувь, пакистанчуудын 33 хувь, Сенегал, Гана, Ардчилсан Бүгд Найрамдах Конго Улсын иргэдийн талаас илүү хувь нь хэзээ нэгэн цагт хээл хахууль шаардуулж байсан гэжээ.

Нейгиний хэрэг хээл хахуулийнх байгаагүй. Гал тогооны тавилгын тавцан үйлдвэрлэдэг гэр бүлийн компанийнхаа бизнесийг эрхлэн явуулахад албан тушаалаа урвуулан ашигласан нь түүний гэм буруу байлаа. Энэ хэрэг явдал нь авлигын маш олон хэлбэр байж болохыг улам тодорхой харуулж байгаа юм. Хэрэв орон орны хүмүүсээс эх оронд нь авлигын асуудал байгаа эсэх талаар санал асуулга явуулбал ихэнх нь авлигыг хээл хахуулиас илүү өргөн хүрээнд тодорхойлох болно.

40. Авлигыг хяналтад авч чадвал буурай орнууд дахь хүүхдийн эндэгдэл буурна¹¹⁵(2014.07.15)

Хүүхдийг ивээх сан¹¹⁶. Шинээр хэвлэгдсэн илтгэлд дурдсанаас үзвэл ядуу буурай орнууд татвараас зайлсхийх, мөнгө угаах, хээл хахууль зэрэг хууль бус санхүүгийн гүйлгээний улмаас жил бүр 1 их наяд¹¹⁷ ам.долларыг улсын санд төвлөрүүлж чадалгүй алдаж байгаа нь дараагийн арван жилийн дотор хүүхдийн амь насыг аван одож байгаа урьдчилан сэргийлж болохуйц өвчлөлийн тархалтыг зогсоож чадах хэмжээний мөнгө юм.

Хүүхдийг ивээх сангийн дүн шинжилгээнээс үзвэл тэдгээр хууль бусаар зувчуулж буй мөнгийг эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахад зарцуулж чадвал хөгжиж буй орнуудад түгээмэл байгаа урьдчилан сэргийлэх боломжтой хүүхдийн эндэгдлийн бууруулж чадахаар байна.

¹⁰⁹ Political risk analysts

¹¹⁰ Aid agency economists

¹¹¹ think-thank staff

¹¹² virtuous

¹¹³ villainous

¹¹⁴ make side payment

¹¹⁵ <http://www.smh.com.au/world/reining-in-corruption-could-prevent-third-world-child-deaths-20140715-zt7jq.html>

¹¹⁶ Save the Children

¹¹⁷ trillion

41. Японд спортын авлигатай тэмцэх тусгай хэсэг¹¹⁸ байгуулахаар болж байна¹¹⁹(2014.07.21)

Япон. Японы Засгийн газар тус улсын спортын асуудал эрхэлсэн байгууллагуудад нүүрлэж болзошгүй авлигыг хянах, мөрдөн шалгах үүрэг бүхий тусгай хэсэг байгуулахаар төлөвлөж байгаа талаар зарлалаа. 2020 оны олимп Токио хотод болох гэж байгаатай холбоотойгоор Япон улс дахь спортын авлига болон гадаад орнуудын зүгээс учирч болзошгүй авлигын үйл ажиллагаатай тэмцэх зорилго бүхий энэ тусгай хэсэг нь бусад байгууллагуудтай хамтран ажиллана гэж Засгийн газрын албан тушаалтнууд мэдэгдэв.

Японы эрх баригч Либерал Ардчилсан Нам¹²⁰ спортын авлигатай тэмцэх тусгай хэсгийг байгуулах төлөвлөгөө 2013 оны 12 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн. Шинзо Абэ¹²¹ тэргүүтэй Японы Засгийн газар спортын авлигатай тэмцэх асуудалтай холбоотой олон улсын эрх зүйн тогтолцоог судлан үзсэн, цаашид энэ талаар олон улсын хэмжээнд талуудтай хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлэх болно гэж мэдэгдэв.

Японы түгээмэл спорт болох сумод найраа¹²² хийх явдал сүүлийн үед хэд хэд илэрсэнтэй холбоотойгоор тус улс спортын авлигад анхаарлаа хандуулж байна.

Тусгай хэсэг нь юуны өмнө спортын тэмцээний найраа, гүйцэтгэлийн үр дүнг засварлах¹²³ явдал болон спортын мөрийгөөр дамжуулан мөнгө угаах¹²⁴ үйл ажиллагаанд анхаарлаа хандуулна гэж холбогдох албаныхан танилцуулав.

42. Ираны шүүхээс Ерөнхийлөгч асан Ахмадинежадын үеийн төрийн албаны томилгоог эргэн шалгаж байна¹²⁵(2014.07.21)

Иран. Махмуд Ахмадинежадийн засаглалын үед алба хашиж байсан албан тушаалтнуудын хэргийг шүүхэд шилжүүлсэн талаар Парламентын мөрдөн шалгах хорооны хэвлэлийн төлөөлөгч мэдээлэв.

Гэхдээ Ираны парламентын “90 дүгээр зүйлийн Хороо”-ны¹²⁶ хэвлэлийн төлөөлөгч Мостафа Афзали Фард¹²⁷ ямар хэрэг, эсхүл өмнөх Засгийн газрын үеийн ямар албан тушаалтны хэрэг болохыг тодорхой дурдсангүй.

Парламентын гишүүн Голамали Жаффаризаде Иманабади¹²⁸ “өмнөх засаглалын үед 450 мянгаас 650 мянган хүн хууль бусаар ажилд орсон бөгөөд зарим нь гэр бүлийн болон танил талын хэлхээ холбоог ашигласан нь тодорхой байна” гэж хэлжээ. Эдгээрээс хамгийн ноцтой нь Боловсролын яаманд хамаарч байна гэж тэр үзэж байна. Ахмадинежадын Засгийн газрын ажилласан сүүлийн 2 жилийн хугацаанд Боловсролын яамны хэмжээнд ажилд орсон 76000 боловсон хүчний ойролцоогоор 2 хувь нь бичиг үсэггүй, 14 хувь нь зөвхөн анхан шатны боловсролтой, 19 хувь нь бүрэн бус дунд¹²⁹ боловсролтой, 1 хувь нь бүрэн дунд боловсролтой байжээ.

¹¹⁸ special unit

¹¹⁹ <http://www.sbcnews.co.uk/retail/2014/07/21/japan-to-set-up-special-sports-corruption-unit-ahead-of-tokyo-2020/>

¹²⁰ The Liberal Democratic Party

¹²¹ Shinzo Abe

¹²² match fixing

¹²³ tampered sports performance

¹²⁴ money laundering through sports betting

¹²⁵ <http://www.al-monitor.com/pulse/originals/2014/07/ahmadinejad-officials-corruption-cases.html#>

¹²⁶ the Iranian Parliament's Article 90 Commission

¹²⁷ Mostafa Afzali Fard

¹²⁸ Gholamali Jaffarizadeh Imanabadi

¹²⁹ middle school

Жаффарзаде Боловсролын яамны томилгоог “эмгэнэлт явдал” гэж тодорхойлоод Ахмадинежадыг засгийн эрх барьсан найман жилийн хугацаанд Боловсролын яам 332000 хүнийг ажилд авсан байна гэж хэлжээ.

Шинэчлэлийн талыг баримтлагч “Шарж Дайли”¹³⁰ сонины 7 дугаар сарын 17-ны өдрийн “Ахмадинежадын үед 450 мянган хүнийг гэр бүлийн хэлхээ холбоо болон шан харамжаар ажилд авчээ” гэсэн гарчигтай нийтлэлд албан тушаалтнууд, засаг дарга нар, сайд нарын гэр бүлийн гишүүдийг ажил, албан тушаалд томилсон томилгооны ихэнх нь хууль бус байв гэж бичсэн байна.

43. Авлигын хэргийг яллах олон улсын шүүх байгуулах хэрэгтэй байна¹³¹(2014.07.22)

НҮБ. Төрийн өндөр албан тушаалтнууд эрх мэдлээ хувийн зорилгоор урвуулан ашиглах нь “том авлига¹³²” юм. Дэлхийн маш олон орны Засгийн газрын дээд албан тушаалтнуудын дунд авлига түгээмэл тархсан байна. 2003 онд Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенци¹³³ батлагдаж байхад тус байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга¹³⁴ асан Кофи Аннан¹³⁵ энэ байдлыг “бугшмал тахал”¹³⁶ гэж оновчтой тодорхойлсон билээ.

Авлигын хэмжээ асар их байгаа бөгөөд дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний¹³⁷ таваас илүү хувийг залгиж байна. Хөгжиж буй орнууд гаднаас авч буй тусламжийн хэмжээнээсээ даруй 10 дахин их хэмжээний хөрөнгийг хууль бусаар алдаж байгаа юм.

ОХУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүний 44 хүртэлх хувийг авлигад суурилсан “сүүдрийн эдийн засаг”¹³⁸ бүрдүүлэх жишээтэй. Түүнчлэн авлигад идэгдсэн Засгийн газрууд заримдаа Мексикийн хар тамхины наймаачид, Афганистан, Иемений алан хядагчид зэрэг олон улсын гэмт хэрэгтнүүдийг орогнох таатай нөхцөлийг бүрдүүлдэг.

Гэхдээ улс төрийн авлигын хамгийн ноцтой үр дагавар нь ардчиллыг устгаж, хүний эрхийг хөсөрдүүлэхэд хүргэдэгт байгаа юм. Дэлхий дээр хамгийн их авлигатай гэж тооцогддог Сомали, Афганистан, Судан, Ирак, Сири зэрэг оронд хүний эрхийг байнга зөрчдөг. Дэлхий даяар хаа сайгүй ноёрхож байгаа авлигад идэгдсэн дэглэмийн золиос нь ядуу зүдүү, ямар ч эрх мэдэлгүй хүмүүс юм.

Украин болон Египетийн жишээнээс харахад л улс төрийн авлигыг сөрөн боссон тэмцэл маш олон улс орныг, түүнчлэн дэлхийг бүхэлд нь тогтворгүй байдалд оруулж байна. Улс төрийн авлигатай тэмцэж байгаа олон улсын хүчин чармайлт хангалтгүй байгаа нь илт юм. Төрлөөр устгах¹³⁹ болоод хүний эрхийн тэвчишгүй бусад зөрчлийн гай гамшиг нь 2002 онд Олон улсын эрүүгийн шүүх¹⁴⁰-ийг байгуулахад хүргэсэн билээ. Үүнтэй адилаар одоо Олон Улсын авлигын эсрэг шүүх¹⁴¹ байгуулах шаардлагатай тулгарч байна.

Улс төрийн авлига нь дэлхийн олон оронд үйлчилдэг албан тушаалтнуудын халдашгүй дархан байдлаас хамаардаг. Олон Улсын авлигын эсрэг шүүх нь дэлхийн бараг бүх улс оронд байгаа улс төрийн авлигыг гэмт хэрэгт тооцсон хуулийг сахин

¹³⁰ Shargh Daily

¹³¹ http://www.washingtonpost.com/opinions/mark-l-wolf-we-need-an-international-court-to-stamp-out-corruption/2014/07/22/a15ecc38-10ff-11e4-9285-4243a40ddc97_story.html

¹³² “Grand corruption”

¹³³ The U.N. Convention Against Corruption

¹³⁴ U.N. Secretary General

¹³⁵ Kofi Annan

¹³⁶ “insidious plague”

¹³⁷ Global Gross Domestic Product

¹³⁸ “shadow economy”

¹³⁹ genocide

¹⁴⁰ The International Criminal Court (ICC)

¹⁴¹ International Anti-Corruption Court (IAAC)

биелүүлэх талаарх яриа хэлэлцүүлгийг өрнүүлэх бас нэг үр дүнтэй боломж юм. Ингэхдээ НҮБ-ын Авлигын эсрэг конвенц зэрэг гэрээ, хэлэлцээрийн шаардлага болон Дэлхийн худалдааны байгууллага зэрэг байгууллагын үүрэг хариуцлагад хүч нөлөө үзүүлнэ. Олон Улсын Эрүүгийн Шүүхийн нэгэн адилаар Олон Улсын авлигын эсрэг шүүх нь *комплементарити*¹⁴² зарчмаар ажиллах бөгөөд энэ нь улс төрийн авлигыг зохих ёсоор яллаж чадахгүй байгаа, эсхүл яллахыг хүсэхгүй байгаа улс орнуудын албан тушаалтнуудыг яллах, шүүх тухай ойлголт юм. Энэ нь олон улс орнуудад улс төрийн авлигатай тэмцэх чадавхаа бэхжүүлэх болон тийм чадавхтай гэдгээ илэрхийлэх тодорхой хэмжээний урам зориг өгөх болно.

44. Оросын эмийн үйлдвэрлэлийн авлигын эрсдэл¹⁴³(2014.07.25)

ОХУ. Тус улсын Засгийн газар эм үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхэд анхаарч “Фарма 2020 Стратеги” хөтөлбөрийг баталлаа. Энэ хөтөлбөр нь Оросын эм үйлдвэрлэлийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, олон улсын эмийн үйлдвэрлэгч компаниудын бүтээгдэхүүнийг улс орондоо үйлдвэрлэх зорилготой юм.

Оросын эм үйлдвэрлэлийн салбар нь бүтээгдэхүүн, ноу-хау, хөгжлийн хувьд гадаадын үйлдвэрлэгчдээс ихээхэн хамааралтай байдаг. Гэсэн хэдий ч Оросын Засгийн газар өөрийн Зайлшгүй Эмийн Жагсаалт (ЗЭЖ) дахь дотоодод үйлдвэрлэгдсэн эмийн хувь хэмжээг ирэх 10 жилд 90 хувьд хүргэхээр төлөвлөж байна.

Стратегийн нэг зорилт нь төрийн худалдан авах ажиллагааны явцад дотоодод үйлдвэрлэсэн эмийг худалдан авахын тулд дотоодын үйлдвэрлэгчдэд илүү анхаарал хандуулах нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжсэн энэхүү стратеги нь олон улсын эм үйлдвэрлэгч компаниудад боломж болон хүндрэл, бэрхшээл аль алийг нь бий болгож байна.

ОХУ нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Олон улсын бизнесийн үйл ажиллагааны явцад гадаадын төрийн албан тушаалтныг хахуульдахтай тэмцэх тухай Конвенц¹⁴⁴-ийн гишүүн орон юм. Үүнтэй холбоотойгоор ОХУ өөрийн авлигын эсрэг эрх зүйн зохицуулалтыг Конвенциор тогтоосон хэм хэмжээнд нийцүүлэх арга хэмжээ авсан.

Жишээ нь, ОХУ-ын “Авлигатай тэмцэх тухай”¹⁴⁵ 2008 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 273 дугаар хуулиар нягтлан бодох бүртгэлийг хуурамчаар хийхээс урьдчилан сэргийлэх зорилготой хяналтын тогтолцоо хэрэгжүүлэх үүргийг компаниудад хүлээлгэсэн. Ялангуяа, ОХУ-ын Дээд шүүх¹⁴⁶ 2013 оны 7 дугаар сарын 9-нд “Хахууль болон авлигын бусад гэмт хэргийг шүүн тасалж байгаа практикийн тухай”¹⁴⁷ 24 дүгээр тогтоол гаргасан бөгөөд энэ тогтоолыг ОХУ-ын шүүгчид Оросын Эрүүгийн хуульд заасан залилан болон хээл хахуулийн гэмт хэргийг шүүн таслахдаа мөрдлөг болгодог.

Энэхүү тогтоолд төрийн албан тушаалтны хүсэлтээр гуравдагч этгээдэд өгсөн төлбөртэй холбоотой ОХУ-ын Авлигын эсрэг хууль болон барууны орнуудын авлигын эсрэг хуулийн зохицуулалтын ялгаатай талыг тодорхойлсон байдаг. Гуравдагч этгээдэд өгсөн төлбөрөөс төрийн албан тушаалтан тодорхой материалын ашиг хүртээгүй бол тэрхүү төлбөрийг хээл хахууль гэж үзэхгүй байхаар уг тогтоолд тайлбарласан байдаг.

¹⁴² complementarity

¹⁴³ <http://www.jdsupra.com/legalnews/corruption-risks-in-pharma-manufacturing-97742/>

¹⁴⁴ OECD Convention on Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions

¹⁴⁵ “On Counteracting Corruption”

¹⁴⁶ Russia’s Supreme Court

¹⁴⁷ “On Court Practices in Bribery and Other Corruption Crimes”

Энэхүү ялгаа нь АНУ-ын Гадаадын төрийн албан тушаалтныг хахуульдахыг хориглох тухай хууль¹⁴⁸ болон Английн Хээл хахуулийн эсрэг¹⁴⁹ зэрэг хуулийг дагаж мөрдөх үүрэгтэй гадаадын эмийн компаниудыг мухардалд оруулж байна. Жишээ авъя. ОХУ-ын төрийн өмчит эмнэлгийн захирал нь АНУ болон Английн холбогдох хуулийн дагуу төрийн албан тушаалтанд тооцогдох бөгөөд тэрхүү албан тушаалтан буяны санд хандив өгөхийг Английн эм үйлдвэрлэгч компаниас гуйсан бөгөөд хандиваас тухайн төрийн албан тушаалтанд эд материалын хувьд ямар нэг ашиг өгөхгүй бол энэ үйлдэл нь ОХУ-ын хуулийн дагуу гэмт хэрэг гэж тооцогдохгүй байхад АНУ болон Английн хуулиар гэмт хэрэгт тооцогдоно.

Өөр хоорондоо ялгаатай авлигын эсрэг эрх зүйн дэг журмуудын хооронд тэнцвэр барих нь түвэгтэй бөгөөд ийм бэрхшээл цаашид улам нэмэгдэнэ.

45. Эрдэмтэд болон их сургуулийн удирдлагууд баривчлагдав¹⁵⁰(2014.07.25)

БНХАУ. Хятадын их сургуулиудын олон тооны удирдах албан тушаалтнууд болон тэргүүлэх зэргийн эрдэмтдийг баривчлан хорьсон нь шинэ засгийн газрын авлигатай тэмцэх арга хэмжээний нэг хэсэг болж байна.

2013 оны 6 дугаар сард Бээжин хотын шүүхээс Бээжингийн Шуудан, цахилгаан холбооны их сургуулийн¹⁵¹ Компьютерийн шинжлэх ухаан, технологийн сургуулийн¹⁵² захирал асан Сүн Маоцин¹⁵³ судалгааны сангаас 680 мянган юань (64 мянган фунт стерлинг) ашиглан шамшигдуулсан гэмт хэрэгтээ 10.5 жилийн шоронд хоригдох ял сонссон нь хамгийн сүүлийн тохиолдол болж байна. Энэ оны 1 дүгээр сард Зэжиан Их Сургуулийн¹⁵⁴ химийн профессор бөгөөд тус их сургуулийн Байгаль орчны шинжлэх ухаан, технологийн институтын¹⁵⁵ захирал Чен Ийншү¹⁵⁶ 9.45 сая юанийг завшсан хэрэгтээ 10 жилийн хорих ялаар шийтгүүлсэн юм.

Сүн, Чен нар бол зөвхөн нэг хэсэг нь. Хятадын Коммунист намын Сахилгын хяналтын төв хороо¹⁵⁷-ны авч хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагааны хүрээнд бусад олон тооны шинжлэх ухааны байгууллагуудын удирдлагуудыг гэрийн хорионд оруулаад байгаагийн дотор Хятадын Шинжлэх ухаан, технологийн ассоциацийн¹⁵⁸ тэргүүн Шен Вейчен¹⁵⁹, улс орондоо нэр хүнд бүхий Сичуаны их сургууль¹⁶⁰, Зежианы их сургууль¹⁶¹, Өмнөдийн Анагаах ухааны их сургууль¹⁶² зэрэг их сургуулиудын дэд ерөнхийлөгч нар багтаж байна. Хятадын шинэ удирдлага 2003 онд засгийн эрхэнд гарснаас хойших хугацаанд хамгийн багадаа 10 их сургуулийн ерөнхийлөгч, эсхүл дэд ерөнхийлөгч нарыг авлигын хэргээр баривчилж, эсхүл мөрдөн шалгаж байна. Иймэрхүү мөрдөн шалгалтын дараа ихэнхдээ ял оноож шоронд хорьдог.

Энэ олон дээд зэргийн их сургуулиудын удирдлагууд, тэргүүлэх зэргийн эрдэмтдийг зайлуулсан нь санамсаргүй хэрэг биш гэж Бээжингийн Хуахуан хуулийн

¹⁴⁸ The FCPA

¹⁴⁹ UK Bribery Act

¹⁵⁰ <http://www.rsc.org/chemistryworld/2014/07/scientists-university-officials-caught-china-anti-corruption-drive>

¹⁵¹ Beijing University of Posts and Telecommunications

¹⁵² The school of computer and technology

¹⁵³ Song Maoqiang

¹⁵⁴ Zhejiang University

¹⁵⁵ Institute of Environmental Science and Technology

¹⁵⁶ Chen Yingxu

¹⁵⁷ Disciplinary commission

¹⁵⁸ The China Association for Science and Technology

¹⁵⁹ Shen Weichen

¹⁶⁰ Sichuan University

¹⁶¹ Zhejiang University

¹⁶² Southern Medical

компанийн¹⁶³ захирал Пенг Жиан¹⁶⁴ хэллээ. Тэрээр судалгааны ёс зүйн зөрчлийг шалгаж буй мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд оролцсон бөгөөд Хятадын олон тооны их сургуулиуд судалгаанд зориулсан их хэмжээний төсөв болон оюутны хотхоны үл хөдлөх хөрөнгийн бүтээн босголтын эрх¹⁶⁵ зэрэг үнэ цэнэтэй бусад хөрөнгийг эзэмшдэг нь авлигажсан гэрээ хэлэлцээрийн гол цөм нь болдог гэжээ. Их сургуулиудын удирдлагуудын холбогдсон ихэнх хэрэг нь оюутны хотхон барьж байгуулах болон багаж төхөөрөмж худалдан авах үйл ажиллагаатай холбоотой байна. Аж үйлдвэрийн хяналтын хамгийн шилдэг шинжээч бөгөөд Зежиан Их сургуулийн дэд ерөнхийлөгч асан Чу Жиан¹⁶⁶-ы хэрэг харин арай өөр. Тэрээр их сургуулийн харъяанд байсан компанийн мэдлийн төрийн өмчийг ашиглан шамшигдуулсан хэрэгт яллагдсан юм.

Эдгээр баривчилгаа нь боловсролын болон судалгааны ажлын төсөв нэмэгдэхийн хэрээр их сургуулиуд дахь авлигын нөхцөл байдал улам бүр ноцтой болж байгааг харуулж байна. Боловсролын яам хятадын шилдэг 10 сургууль судалгааны ажилд зориулан өнгөрсөн жил нийт 26.8 тэрбум¹⁶⁷ юань төсвөөс авсан хэмээн мэдэгдэв.

46. Тусламжийн байгууллагууд өнгөрсөн хойно нь биш өмнө нь бодох хэрэгтэй байна¹⁶⁸ (2014.08.01)

Япон. 2011 онд Японд болсон цунамигийн гамшгийн дараа Фукушимагийн ослыг мөрдөн шалгах бие даасан комисс¹⁶⁹-ийн дарга Киёши Курокава¹⁷⁰ энэхүү ослыг “урьдчилан харж, сэргийлж болох байсан, яахын аргагүй хүмүүсийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон осол” гэж тодорхойлсон. Энэ дүгнэлт бол 1995 оны Кобе¹⁷¹ хотод болсон аймшигт газар хөдлөлтийн дараа Япон улсын Засгийн газраас барилгад тавигдах дэлхийн хамгийн хатуу хэм хэмжээ¹⁷²-г мөрдүүлэх болсонтой холбоотой юм. Үүнээс ялгаатай нь газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд оршдог хөгжиж буй орнууд ихэнхдээ байгалийн гамшгийн өмнө бэлтгэлтэй байхад нь шаардлагатай бүтэц, зохион байгуулалт болон санхүүжилт дутагдалтай байдаг.

Газар хөдлөлт судлаач¹⁷³ Рожер Билхам¹⁷⁴ дараахь тооцоог урьдчилан гаргажээ. Үүнд Тегеран¹⁷⁵ хотод 7.0-оос дээш магнитуудын газар хөдлөлт болох юм бол тус хотод мөрдөж буй барилгын дүрэм журмын хангалтгүйгээс болж бараг нэг сая хүн амь үрэгдэнэ гэжээ. Хөгжиж буй орнуудын олон хот үүнтэй адил нөхцөлд байгааг тэрээр онцлон тэмдэглэсэн бөгөөд цөөхөн хэсгийг нь дурдвал Лима¹⁷⁶, Карачи¹⁷⁷, Катманду¹⁷⁸ хотуудыг хэлж болно гэсэн байна. Газар хөдлөлтийн идэвхтэй бүсүүдэд чанаргүй баригдсан орон сууцны барилгуудаар хүрээгээ тэлэн эрчимтэй явагдаж байгаа

¹⁶³ Beijing Huahuan law firm

¹⁶⁴ Peng Jian

¹⁶⁵ Campus real estate development right

¹⁶⁶ Chu Jian

¹⁶⁷ billion

¹⁶⁸ <http://ottawacitizen.com/news/world/aid-must-act-not-react>

¹⁶⁹ The Fukushima Accident Independent Investigation Commission

¹⁷⁰ Kiyoshi Kurokawa

¹⁷¹ Kobe

¹⁷² The building code

¹⁷³ seismologist

¹⁷⁴ Roger Bilham

¹⁷⁵ Tehran

¹⁷⁶ Lima

¹⁷⁷ Karachi

¹⁷⁸ Kathmandu

хотжилтыг “үл анзаарагдах үй олноор хөнөөх зэвсэг” гэж нэрлэхээс өөрөөр тодорхойлох аргагүй юм.

Барилгын дүрэм журмыг зохих шаардлагын дагуу тогтооход учирдаг гол саад тотгор бол авлига юм. Николас Амбрасейс¹⁷⁹ болон Рожер Билхам нарын судалгаагаар сүүлийн 30 жилийн хугацаанд тохиолдсон газар хөдлөлтүүдийн үед байшин барилга нурж сүйдсэний улмаас хүмүүс амь үрэгдсэн нь авлигын түвшин өндөр байсантай холбоотой болохыг тогтоожээ. Газар хөдлөлтийн үед хүмүүс амь үрэгдэхэд газар зүйн байрлал бага нөлөөлдөг, харин “газар хөдлөлтөд тэсвэртэй барилга”¹⁸⁰ барихад болон үүнтэй холбоотой дүрэм, журмыг мөрдүүлэхэд шаардлагатай хэмжээний санхүүжилт дутагдалтай байснаас ихээхэн хамаатай гэж тэдгээр судлаачид үзэж байна.

47. Баруун Африк дахь эбола¹⁸¹: Үхэл ба үл итгэгчид¹⁸²(2014.08.02)

Сьерра Леон. Тус улсын зүүн хэсгийн Кайлахун¹⁸³ дүүрэгт 5 дугаар сарын сүүлчээр эбола өвчин дэгдэх үед тус улсын засгийн газраас уг өвчний шинж тэмдэг болон түүнээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулж эхэлсэн байна. Нутгийн хүмүүсээс энэ анхааруулгыг хэн нь ч хайхарсангүй. Харин оронд нь энэ өвчнийг засгийн газар болон тусламжийн байгууллагууд санаатай тарааж байж магадгүй гэх мэт янз бүрийн таамаглал тархаж байна.

Өвчний тархалт Сьерра Леон улсын жирийн иргэд болон тус улсын засгийн газар, мөн тусламж үзүүлэгч барууны орнуудын хоорондын урт удаан хугацаанд архагшин даамжирсан үл итгэлцлийг тодорхой харуулж байна. Гадаадын буяны байгууллагын ажилтнуудыг эгнээндээ багтаасан багийнхан¹⁸⁴ өвчнөөр нас барагсдыг оршуулахаар Кайлухан тосгонд ирэхэд тэндхийн эмэгтэйчүүд, хүүхдүүд тэдний тусгай тэмдэг бүхий машины бараанаар бутран зугтжээ. Тосгоны эрчүүд нь тосгонд оршуулах цогцос байхгүй гээд багийнхныг хөөж туусан байна. Иймэрхүү зүйл хаа сайгүй болж байна.

Зарим Сьерра Леончууд засгийн газар эбола өвчтний цусыг худалдахыг санаархаж байна, эсхүл тэд хуучны зан үйл¹⁸⁵ хийхэд ашиглахын тулд өвчтний мөчийг салгаж авах гэж байна хэмээн үзэж үүнээс айж байгаагаа хэлжээ. Өөр зүйл бодож айж байгаа хүмүүс ч бас байв. Эмнэлгийн ажилчид тэднийг эболагаар тарина, нэг бол хлорт ариутгагч¹⁸⁶ шүршвэл өвчин тусна, эсхүл засгийн газар гадаадаас тусламж авахын тулд вирусyг зохиосон гэх мэтээр бодож байгаа юм.

Иймэрхүү итгэл үнэмшил үхэл хагацал дагуулж байна. Аль нэг суурин газарт эболагийн хохирогчийг ямар нэг зориулалтын тусгаарлагчаар ороохгүйгээр, эсхүл мэргэжлийн зааварчлагагүйгээр оршуулах бүрт өвчин тархах магадлал ихэсч байна. Тархалтын улмаас Сьерра Леон, Либери, Гвиней улсуудад 670¹⁸⁷ хүн амь насаа алдаад байна. Амь насыг нь аварч чадах зөвлөмжөөс тосгоныхон утгагүй байдлаар татгалзаж байгаа нь эмнэлгийн ажилчдын эгдүүцлийг хүргэх юм.

Ингэж төр, засагтаа итгэхгүй байх нь тодорхой учир шалтгаантай. Сьерра Леон 1961 онд Английн харъяанаас гарч тусгаар тогтносноос хойш энэ улсыг удирдаж байсан удаа дараагийн засгийн газрууд бүгд авлигын үүр уурхай болж байжээ.

¹⁷⁹ Nicholas Ambraseys

¹⁸⁰ “earthquake-resistant construction”

¹⁸¹ ebola

¹⁸² <http://www.economist.com/news/middle-east-and-africa/21610250-many-sierra-leoneans-refuse-take-advice-medical-experts-ebola-death>

¹⁸³ Kailahun

¹⁸⁴ burial team

¹⁸⁵ ritual

¹⁸⁶ chlorine disinfectant spray

¹⁸⁷ 2014 оны 8 дугаар сарын 2-ны байдлаар.

Тэрчлэн 20 жилийн турш Бүх ард түмний конгресс нам¹⁸⁸ дангаараа засгийн эрх барьж байв. Эдгээр он жилүүдэд нутгийн алслагдсан зүүн хэсгийн ард иргэд төр засгийн анхаарлын гадна орхигдсон юм. Одоо хэр хөдөө тосгодод төрийн үйлчилгээ бараг л алга байна.

Сьерра Леоны зүүн хэсгийн менде¹⁸⁹ хүмүүсийн дунд амьдарч байсан хүн судлаач¹⁹⁰ Мариан Ферме¹⁹¹ “ард иргэд болон засгийн газрын дунд бий болж, хэдэн арван жилээр үргэлжилж буй үл итгэлцэл нь засгийн газрын зүгээс хүмүүстэй ил тод бус, авлигач байдлаар хандаж байсны үр дагавар юм” гэж хэлсэн байна.

48.Хавтаст хэргүүд¹⁹² Лондонгийн цагдаагийн газар¹⁹³ дахь бугшмал авлигыг илчилж байна¹⁹⁴(2014.08.03)

Их Британи. Скотланд Ярд¹⁹⁵-д Лондон хотын зөвхөн нэг хэсгийг хариуцсан цагдаагийн газар дахь авлигын талаарх 260 хайрцаг баримт хадгалагдаж байгаа нь цочирдмоор юм. Шударга бус мөрдөгчдийн маш цөөхөн хэсгийнх нь хэргийг нотолж ял оноож чадсан байна.

2002 онд Английн цагдаагийн хамгийн өндөр албан тушаалтнуудын нэгээр ахлуулсан ажлын хэсэг “Тибериус”¹⁹⁶ нэртэй ажиллагааны явцад цуглуулсан асар их хэмжээний мэдээллийг нэгтгэн цагдаагийн нууц тайлан бэлтгэсэн юм. Энэ тайланд Нийслэлийн Цагдаагийн газар дотор авлига нэвт шингэсэн байна гэж дүгнэжээ.

Баримт материалаас үзвэл зүүн хойд Лондонгийн зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээ нь эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх чадварыг нь сулруулахын тулд Нийслэлийн цагдаагийн газарт төвөггүйхэн шургалж байжээ.

Нийслэлийн цагдаагийн газрын дэд комиссар Крайг Маккей¹⁹⁷-гийн бичснээр бол тэдгээр маш олон тооны хайрцагтай баримт нь Лондон хотын зүүн хойд хэсэг дэх Скотланд Ярдийн салбарт бугшсан гэмт хэргийн түвшинг илэрхийлж байгаа бөгөөд энэ байдал 12 жилийн өмнө “Тибериус” ажиллагаа явагдсанаас хойш бараг л хөндөгдөөгүй байна.

Дотоод хэргийн хорооны дарга Кейф Ваз¹⁹⁸-д явуулсан захиандаа ноён Маккей өөрийн удирдлагад ажилладаг офицеруудын үйлдсэн гэмт хэргүүдтэй холбоотой уул овоо шиг их нотлох баримт улам нэмэгдсээр байх бололтой гэжээ.

49.Авлигын эсрэг тэмцэл нь мухардмал байдалд орсон уу¹⁹⁹ (2014.08.08)

БНХАУ. Хятадын сонин, хэвлэлүүд 7 дугаар сарын 30-ны өдрийн тэргүүн нүүрэндээ аюулгүй байдлын асуудлыг өмнө нь хариуцаж байсан дарга Жоу Ёнканийг авлигын хэрэгт буруутган хэрэг үүсгэхээр болсон талаарх Коммунист намын Төв хорооны шийдвэрийг нийтэлсэн юм.

¹⁸⁸ The All people's Congress party

¹⁸⁹ Mende

¹⁹⁰ anthropologist

¹⁹¹ Mariane Ferme

¹⁹² files

¹⁹³ The Metropolitan Police

¹⁹⁴ <http://www.independent.co.uk/news/uk/crime/police-files-reveal-endemic-corruption-at-the-met-9644667.html#>

¹⁹⁵ Scotland Yard

¹⁹⁶ Tiberius

¹⁹⁷ Craig Mackey

¹⁹⁸ Keith Vaz, chairman of the Home Affairs Committee

¹⁹⁹ <http://www.npr.org/blogs/parallels/2014/08/08/338630914/chinas-president-says-his-anti-corruption-drive-is-deadlocked>

Хятад Улс авлигын эсрэг тэмцэлдээ ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байгаагийн жишээ бол нэгэн цагт тус улсын хамгийн их эрх мэдэл бүхий албан хаагчдын нэг байсан Жоу Ёнкангийн эсрэг үүсгэсэн энэ удаагийн авлигын хэрэг юм.

Авлигатай тэмцэхээр зорьж буй тус улсын энэхүү алхамд ялагч байхгүй байж болох юм хэмээн зарим ажиглагчид үзэж байгаа юм. Учир нь тус улс болон Коммунист намын дарга Ши Зиньпиний товч, тодорхой хэлсэн үг ихээхэн сонирхол татаад байгаа юм. Тэрээр “Авлигач болон авлигын эсрэг тэмцсэн 2 армийн тулаан мухардмал байдалд орсон” гэж 6 дугаар сарын сүүлчээр болсон намын Улс төрийн товчооны хаалттай хурлын үеэр хэлсэн байна. Мөн Ши Зиньпин “өөрийн эхлүүлсэн авлигын эсрэг тэмцэлд үхэл, амьдрал, эсхүл өөрийн нэр хүндийн алинд нь ч санаа зовохгүй байна” хэмээн хэлснийг нь зарим хэвлэлүүд “цочирдом мэдээ” хэмээн иш татан мэдээлж байсан юм.

Гэсэн хэдий ч түүний хэлсэн дээрх үгийг тодорхой хугацааны дараа төрийн хэд хэдэн мэдээллийн хэрэгсэл устгасан байна.

Үнэхээр Ши Зиньпиний удирдан чиглүүлж буй авлигын эсрэг тэмцлийг тус намын гишүүд болон нам доторх бүлэглэлүүдийн эсэргүүцэл өргөжин тэлж байгааг түүний энэ үг илэрхийлсэн байж болох юм.

Зарим ажиглагчдын үзэж байгаагаар Ши Зиньпиний авлигын эсрэг тэмцэл нь хэтэрхий тууштай байгаа. Тухайлбал, төрийн мэдээллийн хэрэгсэлд өгүүлснээр хоёрдугаар сараас хойших хугацаанд нэг сард ногдох авлигын хэрэгт шалгагдсан төрийн албан хаагчдын тоо 50 байгаа бол мөн хугацаанд авлигын хэрэгт шалгагдсан Засгийн газрын сайд болон түүнээс дээш түвшний төрийн өндөр албан хаагчдын тоо 2 байгаа юм.

Хятадын улс төрийн соёлд олон зууныг дамнан уламжлагдсан уламжлал болох улс төрийн өндөр албан тушаалтан гэмт хэрэгт холбогддоггүй бичигдээгүй хуулийг одоогийн удирдагчид эвдэж байгаа талаар тус улсын төрийн мэдээллийн хэрэгсэл өмнө нь тайлбар хийж байсан юм.

Авлигын талаарх шинжээч, Гуанжоу хотын “Zhongshan” их сургуулийн багш Гуо Венлиан “Beijing Youth Daily” сонинд өгсөн ярилцлагадаа “Одоогоор үлдээд байгаа авлигач албан тушаалтан буюу “ялаа”, “бар”-ууд өөрсдийг нь нэг нэгээр сонгож байгааг тэвчээртэй хүлээхгүй байж магадгүй. Барууд нийлээд дайрвал маш аюултай” гэсэн байна.

Одоогоор ямар нэгэн эсрэг дайралт болж байгаа талаар нотолгоо байхгүй юм. Гэсэн хэдий ч үнэн хэрэгтээ засгийн газраас Жоу Ёнканд мөрдөн байцаалт явуулан, хэргийг олон нийтэд зарлах хүртэл асар их хугацаа шаардсантай адил далд эсэргүүцэл аажмаар эхэлсэн байж магадгүй юм.

Хятадад жил бүр олон мянган үймээн гардгийн ихэнх нь орон нутгаас үүдэлтэй байдаг. Авлигач албан тушаалтнуудын улс төрийн сөрөг дайралтын талаар тус улсын удирдагч Дэн Сяопины нэгэн цагт хэлсэн аймшигт зөгнөлийг эргэн санахад хүргэж байна. Тэрээр “Хятад Улсад саад тулгарвал тэр нь Коммунист намын дотроос байх болно” гэж хэлж байсан билээ.

50. АНУ-ын ил тод байдлын цахим хуудсанд 619 тэрбум ам.доллар бүртгэгдээгүй байгааг тогтоожээ²⁰⁰(2014.08.05)

АНУ. Тус улсын төсвийн зарцуулалтын ил тод байдлыг хангах зорилго бүхий Засгийн газрын ил тод байдлын цахим хуудсанд хамгийн багаар 302 хөтөлбөрийн 619

²⁰⁰ <http://www.usatoday.com/story/news/politics/2014/08/05/federal-spending-transparency-money-missing/13485581/>

тэрбум ам.долларын зарцуулалт тусгагдаагүй байгааг тус улсын төрийн аудитын байгууллага болох Засгийн газрын Хариуцлагатай байдлын газар²⁰¹ тогтоосон байна.

2012 дугаар оны Засгийн газрын зарцуулалтыг хянасан тус байгууллагын тайланд дурдснаар дээрх мэдээлэл яагаад тусгагдаагүй байгаа нь одоогоор тодорхойгүй байгаа. Ил тод байдлын цахим хуудас "USASpending.gov"-нд байгаа мэдээллээс зөвхөн 2-7 хувийн мэдээлэл л "төсвийг захиран зарцуулсан байгууллагынхаа мэдээлэлтэй яг таг тохирч байгаа" юм.

Байгуулагдаад 6 жил болж буй тус цахим хуудсанд тусгаагүй мэдээллийн дунд буй зарим хөтөлбөрийн зарцуулалтаас танилцуулбал:

- Эрүүл мэнд, халамжийн яам 544 тэрбум орчим ам.доллартай тэнцэх хэмжээний зарцуулалтаа тайлагнаагүй байгаа бөгөөд үүний ихэнх хувь нь "Эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр" зэрэгт шууд зарцуулагддаг юм. Тус яам эдгээр хөтөлбөрийн зарцуулалтыг нэгдсэн дүнгээр нь тайлагнах ёстой аж.
- Дотоод яам нийт 265 хөтөлбөрийн 163-ын зарцуулалтыг цахим хуудсанд тусгаагүй байгаа юм. Засгийн газрын ил тод байдлын цахим хуудасны ерөнхий загварт тус хөтөлбөрүүдийн бүртгэлийн загвар тохирохгүй байсан гэж тус яам тайлбарлаж байна. Дотоод яамны нийт тайлагнаагүй байгаа зарлагын хэмжээ 5.3 тэрбум ам.доллар болж байна.
- Мөн Цагаан ордон өөрийн хариуцан хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдийнхээ аль ч хэсгийг мэдээлээгүй байна. Тухайлбал, Цагаан ордны шууд харьяанд байдаг Үндэсний эмийн хяналтын бодлогын газар ч зарцуулалтынхаа мэдээллийг өгөөгүй аж.

АНУ-ын Засгийн газрын төсвийн зарцуулалтын талаарх мэдээллийг олон нийтэд ил тод болгох зорилгоор өнгөрсөн жил Конгрессоос баталсан Цахим орчин дахь санхүүгийн ил тод, хариуцлагатай байдлын тухай хууль²⁰² хуулийг хэрэгжүүлэхээр Обамагийн захиргаа энэ үед ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Тус тайланд Засгийн газрын байгууллагуудын зарцуулалтыг мэдээлэх, тайлагнах байдалд тавих хяналтаа Менежмент, төсвийн газар нэмэгдүүлэх шаардлагатай байгааг онцлон "энэ дутагдлыг арилгахгүйгээр цахим хуудаснаас мэдээлэл авч ашиглахад төвөгтэй байх болно" гэж мөн дурджээ.

51. Авлигын эсрэг төрийн байгууллагууд нэгдээд байна²⁰³ (2014.08.05)

Австрали. Тус улсын Канберра хотод төвтэй Австралийн холбооны цагдаагийн газарт Авлига, луйврын хэрэгтэй тэмцэх төвийг байгуулаад байна.

Тус төвийг байгуулснаараа холбооны улсын түвшин дэх авлига, луйврын хэрэгтэй тэмцэх явдлыг шинэ түвшинд гаргана гэж үзэж байгаа. Тус төвийг Австралийн Татварын газар, Австралийн Үнэт цаас, хөрөнгө оруулалтын хороо, Австралийн Гэмт хэрэгтэй тэмцэх хороо, Австралийн Гааль, хилийн хамгаалалтын байгууллага, Гадаад харилцаа, худалдааны яам болон Батлан хамгаалах яам зэрэг төрийн байгууллагууд тус төвийг хамтран байгуулжээ.

"Төвийн үйл ажиллагааг Австралийн Холбооны цагдаагийн газарт төвлөрүүлэх бөгөөд төвийг байгуулсан яам, агентлагууд өөрсдийн салбарын асуудлаар тодорхой дэмжлэг үзүүлж, бодитойгоор хамтран ажиллах болно. Тус төвийн мөрдөн байцаагчид Мельбурн, Сидней, Канберра, Брисбен, Аделаид зэрэг хотуудад мөн байрлан ажиллаж, авлига, гадаадын албан тушаалтнуудын хээл хахуулийн гэмт хэрэг, онц ноцтой луйврын хэргүүдэд мөрдөн байцаалт явуулах болно" хэмээн Хууль зүйн сайд

²⁰¹ Government Accountability Office

²⁰² Digital Accountability and Transparency Act

²⁰³ http://www.psnews.com.au/aps/Page_psn4211.html

Мишээл Кэенэн мэдэгдэхийн зэрэгцээ “Австрали Улс Транспаренси интернэшнл байгууллагын Авлигын төсөөллийн индексийн дагуу дэлхийн авлигатай хамгийн бага улсын нэгээр тогтмол нэрлэгддэгээр бид бахархдаг. Тиймээс цаашид хамтын нөхөрлөлийн орнуудын түвшинд авлига, луйврын хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар өөрсдийн үйл ажиллагаагаа улам бүр өргөжүүлэх болно” гэж цохон тэмдэглэсэн байна.

52. Хонконгоор дамжуулан мөнгө угааж байгааг шалгаж байна²⁰⁴ (2014.08.04)

Энэтхэг. Энэтхэгийн Татварын тагнуулын газар²⁰⁵-аас мэдээлж байгаагаар Энэтхэг Улсын мөнгө угаагчдын хамгийн тааламжтай улс Хонконг болоод байгаа юм.

Энэтхэгийн олон тооны импортлогчид Хонконгод байршилтай хадгаламждаа хийсэн гадаад шилжүүлгээ нуухын тулд худалдааны дагалдах баримт дээрх мэдээллийг худлаа бичсэн хэргүүд удаа дараа гарсны дараа тус улсын Татварын тагнуулын газраас ийнхүү мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлээд байна.

Худалдааны дагалдах баримтын мэдээллээ хуурамчаар үйлдсэний үр дүнд тус улсын төсөвт орох ёстой байсан олон сая руппи орж чадахгүйд хүрээд байгаа юм.

Гадаад худалдаанд суурилсан мөнгө угаах үйл ажиллагааны схемд тус улсын томоохон аж ахуйн нэгжүүд оролцож байна хэмээн нэгэн эх сурвалжийн хэлснийг мэдээний “PTI” агентлаг дамжуулах үеэр мөн Татварын тагнуулын газраас энэ төрлийн аргыг ашиглан мөнгө угаах давтамж сүүлийн үед нэмэгдэж байгааг анхааруулжээ.

Гадаад шилжүүлэгт нэрээ нууцлан шилжүүлэхийн тулд худалдааны дагалдах баримтуудаа банканд худал мэдээлсний улмаас тэдний Хонконгод байршилтай данснуудад нь хууль бусаар ихээхэн хэмжээний доллар хяналтгүйгээр шилждэг байна.

Дотоодын инфляцийг хянахын тулд Энэтхэг, Хятад зэрэг улсууд валютынхаа урсгалыг хянаж байдаг юм.

53. Хатуу хяналтаар дамжуулан Камбож Улс шалгалтын үеэр бусдаас хуулах болон хээл хахуулийн асуудлаас ангижирсан байна²⁰⁶ (2014.08.05)

Камбож. Албаныхан болон ажиглагчдын үзэж байгаагаар боловсролын салбарын чанарыг сайжруулах шинэчлэлийн хүрээнд тус улсын ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчид шалгалтын үеэр хуулах, хээл хахууль өгөх явдал зогссон байна.

Тус улсын хэмжээнд 154 төвийн 3779 анги, танхимд 93456 сурагч 2 өдрийн турш шалгалт өгсөн юм.

Боловсролын сайд Хан Чуон Нарон “Энэ жилийн шалгалтын үеэр ямар ч хуулах асуудал байсангүй, учир нь сурагчдын шалгалт өгөхөөс өмнө бүх хүүхдүүдэд нэгжлэг хийсэн” хэмээн Синхуа агентлагт утсаар өгсөн ярилцлагадаа дурджээ.

Өнгөрсөн оны 9 дүгээр сард энэ албан тушаалд томилогдоод байсан сайд Хан Чуон Нарон “шалгалт яг 100 хувь цэвэр болж чадаагүй байж магадгүй, маш цөөн хүүхэд хуулах оролдлого гаргасан” гэжээ. Түүний хэлж байгаагаар шалгалтын анги, танхимд гар утас болон төрөл бүрийн электрон төхөөрөмж оруулахыг мөн хориглосон байна. “Шалгалтыг зохион байгуулах үеэр хянагчдын хэн нэгэнд хуулж байгаа нь илэрвэл тухайн хүүхдийн оноог автоматаар “тэг” болгосон гэж тэрээр хэлсэн байна.

²⁰⁴ http://www.chinadailyasia.com/hknews/2014-08/04/content_15154545.html

²⁰⁵ Directorate of Revenue Intelligence

²⁰⁶ <http://www.globalpost.com/dispatch/news/xinhua-news-agency/140805/roundup-cambodia-cleans-cheating-corruption-national-exams-s>

Энэ удаагийн шалгалтыг зохион байгуулах үеэр Боловсролын яам, тус улсын Авлигатай тэмцэх нэгжтэй хамтран ажилласан ба “шалгалтыг зохион байгуулах үеэр 26000 орчим хянагч, 2000 гаруй авлигатай тэмцэх ажилтан, сайн дурынхан байсан” байна. Мөн “шалгалтын үеэр шалгуулагчдын зүгээс ямар нэгэн байдлаар хээл хахууль өгөх оролдлого гаргасан бол тухайн хүүхдэд холбогдох шийтгэл ногдуулах байсан ч тийм тохиолдол шалгалтын үеэр илрээгүй” гэж тэрээр мэдэгджээ. Энэ нь тус улсын боловсролын системийг шинэчлэх ажлын нэг хэсэг нь юм.

Өнгөрсөн жилийн шалгалтын үеэр сурагчид биедээ хуулах цаас нуусан, эсхүл хянагчид мөнгө өгөх явдал ихээхэн түгээмэл байсан ч энэ жилийн шалгалтын үеэр тийм зүйл тохиолдоогүй байна. Мөн Камбожийн Хараат бус багш нарын холбооны ерөнхийлөгч Ронг Чонг “энэ жилийн шалгалт өмнөх жилүүдийнхээс хамаагүй дээр үр дүнг нь хүлээн зөвшөөрч болохуйц болсон” гэж мэдэгджээ.

Камбож Улсад ерөнхий боловсролын сургууль төгсөж байгаа сурагчид төгсөлтийн шалгалтаа амжилттай өгвөл өөрсдийн дуртай улсын болон хувийн их дээд сургуульд элсэн орох хүсэлт гаргах боломжтой болдог.

54. Багш нарын авлига, хээл хахуулийг таслан зогсоох ёстой²⁰⁷ (2014.08.05)

Мьянмар. “Сурагчдын хүсэлтээр, хамгийн их гомдол ирүүлсэн багш нарын авлига, хээл хахуулийн талаарх гомдлыг шийдвэрлэх мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх ёстой” хэмээн НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөлөгч Др Инь Инь Нве²⁰⁸ мэдэгдлээ.

“Ядуу гэр бүлээс гаралтай хүүхэд багш нарын ёс зүйгүй үйл ажиллагаанд хамгийн их өртөж байна. Хүүхдүүд багшаасаа сайн үнэлгээ авахын тулд тухайн багшийн хичээллүүлж буй хувийн, төлбөрт хичээл, сургалтад суух шаардлагатай болдог. Сурагчдаас нь хамгийн их гомдол ирүүлсэн багш нарын эсрэг арга хэмжээ авах ёстой. Албан ёсоор хичээл заах ёстой газрынхаа сурагчдад багш нар хувиараа төлбөрт хичээл оруулахыг боловсролын яам зөвшөөрөх ёсгүй” гэж тэрээр мэдэгдсэн юм.

Мьянмар Улсад багш нарын хүрэлцээгүй байдлаас үүдэлтэй авлига бий болдог. Тухайлбал, зарим сургалт сайтай сургуульд хүүхэд оруулахын тулд элсэлтийн төлбөрт 1000 ам.доллар авдаг бол ихэнх багш нар сурагчиддаа нэмэлт төлбөртэй хичээл заадаг. Уг төлбөрийг зарим эцэг, эх төлөх боломжтой байдаг ч төлбөр төлөх боломжгүй эцэг, эхтэй хүүхдүүдийн хувьд тэдний ялгаварлан гадуурхах шалтгаан болоод байгаа аж.

55. Өнгөрсөн онд мөрдөн байцаалт явуулсан хэргийн 82 хувийг шийдвэрлэсэн гэж Малайзын Авлигатай тэмцэх хорооны дарга мэдэгдлээ²⁰⁹ (2014.08.14)

Малайз. Өнгөрсөн онд мөрдөн байцаалт явуулсан нийт 976 авлигын гэмт хэргийн 82 хувь нь шийдвэрлэгдсэн байгаа нь (2012 онд 75 хувь нь шийдвэрлэгдсэнээс) өссөн үзүүлэлт болж байна. “Энэхүү үзүүлэлт нь Малайзын Авлигатай тэмцэх хороог авлигатай тэмцэх үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэхэд шаардлагатай стандарт хэм хэмжээнд хүрснийг илэрхийлж байна” хэмээн Малайзын Авлигатай тэмцэх

²⁰⁷ http://www.elevenmyanmar.com/index.php?option=com_content&view=article&id=7083:bribery-and-corruption-of-teachers-to-be-taken-action&catid=44:national&Itemid=384

²⁰⁸ Dr Yin Yin Nwe

²⁰⁹ <http://www.themalaymailonline.com/malaysia/article/macc-chief-said-82pc-of-investigations-solved-last-year#sthash.jcck6foM.dpuf>

хорооны дарга, тэргүүн комиссар Тан Шри Абу Кассим Мохамед жилийн тайлангаа танилцуулах үеэр мэдэгдлээ.

Тэрээр 2013 оны үйл ажиллагааны тайлангаа парламентын даргад гардуулсныхаа дараа “Малайзын авлигатай тэмцэх хороо авлигаас урьдчилан сэргийлэх байгууллагуудын хангах ёстой стандартуудыг давуулан биелүүлсэн гэдэгт итгэлтэй байна” гэжээ. Мөн “Малайзын Авлигатай тэмцэх хорооны өнөөгийн хүрсэн үр дүн олон улсын түвшинд анхаарал татаж байгаа”-г онцлон тэмдэглэсэн юм.

Дарга, тэргүүн комиссар Тан Шри Абу Кассим Мохамед “НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас гаргасан үнэлгээгээр НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийг хэрэгжүүлэх явцад Малайзын Авлигатай тэмцэх хороонд авлигатай тэмцэх 23 тэргүүн туршлага байна” гэснийг ч мөн дурдсан юм.

56. Европын комисс тусламжийн талаарх мэдээллийг ил тод болгох зорилгоор цахим хуудас нээсэн байна (2014.08.15)

Европын комисс. Европын холбооноос дэлхий дахинд үзүүлсэн хүмүүнлэгийн болон хөгжлийн тусламжийн талаар мэдээллийг ил тод байлгах зорилгоор Европын комисс "EU Aid Explorer" цахим хуудсыг нээсэн байна.

"EU Aid Explorer" цахим хуудсыг хөгжүүлэгчдийн үзэж байгаагаар томоохон тусламжийн талаар мэдээллийн сангуудыг нэгтгэсэн хамгийн анхны цахим хуудас болов.

Тус цахим хуудаснаас доноруудын үйл ажиллагааны хүрээнд аль байгууллага, улс хэдий хэмжээний мөнгө зарцуулсан, эдгээр тусламжийг ямар зүйлд зарцуулсан зэрэг мэдээллийг авах боломжтой юм.

Цахим хуудсанд дараахь хаягаар хандаж болно.

<https://euaidexplorer.jrc.ec.europa.eu/>

57. Шүгэл үлээгчийг хамгаалах хуулийг Засгийн газар дэмжлээ²¹⁰ (2014.08.21)

Словак. Шүгэл үлээгчдийг эрх зүйн орчинд хамгаалах хэрэгтэй бөгөөд Словакын Засгийн газрын 8 дугаар сарын чуулганаар Шүгэл үлээгчдийг хамгаалах хуулийг дэмжлээ.

Дотоод хэргийн сайд Роберт Калинак хуулийн төслийг танилцуулсан байна. “Уг хуулийг баталснаар Словак Улс олон улс дахь бизнесийн шилжүүлгүүдийн асуудлаарх Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх боломж бүрдэх юм” хэмээн “TASR” агентлаг мэдээлж байна.

Дотоод хэргийн сайд энэ хуулийг батлах нь аливаа хууль бус үйл ажиллагааг шүгэл үлээгчээр дамжуулан илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох үр дүнтэй гэжээ.

Хуулийн төслийг Транспаренси Интернэшнл Словак байгууллагатай хамтран боловсруулсан бөгөөд хуулийн төсөлд тухайлбал, ажил олгогчдын зүгээс шүгэл үлээгчид шийтгэл ногдуулах (ажлаас халах зэрэг)-ыг хориглосон заалтуудыг оруулсан бол мөн шүгэл үлээгчийг хамгаалах, улмаар хууль бус үйл ажиллагааны талаар мэдээлэл хүлээн авах, хяналт тавих чиг үүрэг бүхий 50 гаруй ажилтантай төрийн байгууллага байгуулахаар тусгажээ.

²¹⁰ http://spectator.sme.sk/articles/view/55010/10/government_approves_protection_of_whistleblowers.html

Хууль парламентаар батлагдвал 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болно.

58. Мьянмар улс мөнгө угаахтай тэмцэх зөвлөл байгууллаа²¹¹(2014.08.18)

Мьянмар. Тус улсын Дотоод хэргийн яамнаас мэдээлж байгаагаар мөнгө угаах явдалтай идэвхтэй тэмцэх зорилгоор “Мөнгө угаахтай тэмцэх төв зөвлөл”-ийг байгуулсан хэмээн Синхуа агентлагаас мэдээллээ.

Тус зөвлөл нь 15 гишүүнтэй бөгөөд Дотоод хэргийн сайд тэргүүлж, Цагдаагийн газрын дарга нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

Мөнгө угаахтай тэмцэх төв зөвлөл нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, энэ талаар баримтлах бодлогыг боловсруулах үндсэн чиг үүрэгтэй юм. Үүнээс гадна эх сурвалжийн мэдээлж байгаагаар зөвлөл “хөрш улс орон, бүс нутаг, олон улсын түвшин дэх мөнгө угаахтай тэмцэх байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой санхүүгийн мэдээллийг солилцох үүрэгтэйгээр ажиллах” юм.

Мьянмар Улс энэ оны 3 дугаар сард мөнгө угаахтай тэмцэх хууль баталсан.

59. Мөнгө угаах эрсдлийг тооцох Базелийн Мөнгө угаахын эсрэг индекс²¹²-ийн 2014 оны үр дүн зарлагдлаа²¹³(2014.08.13)

Базелийн институт. Улс орнуудад мөнгө угаах гэмт хэрэг гарах эрсдлийг тооцох Базелийн Мөнгө угаахын эсрэг индексийн 3 дахь удаагийн үр дүн буюу 2014 оны индекс зарлагдлаа. Ашгийн бус, бие даасан байгууллага болох Базелийн институтээс мөнгө угаах/терроризмыг санхүүжүүлэх явдлын эрсдлээр улс орнуудыг эрэмбэлэх зорилго бүхий энэхүү индексээ анх 2012 онд зарлаж байсан юм.

Энэ удаагийн Базелийн Мөнгө угаахын эсрэг индексийн үнэлгээнд нийт 162 улс орон хамрагдсан байна.

Базелийн Мөнгө угаахын эсрэг индекс нь улс орнуудын хэмжээнд явагдаж байгаа хууль бус санхүүжилт, шилжүүлгийн бодит дүнг тооцдоггүй юм. Зөвхөн тодорхой тооны шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн тухайн улс орны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх явдалд өртөх эрсдлийг үнэлэн гаргадаг юм.

Энэ удаагийн индексийн үр дүнгээр хамгийн их эрсдэлтэй улс орны жагсаалтад Иран (үнэлгээ 8.56), Афганистан (8.53), Камбож (8.39), Тажикстан (8.34) зэрэг улс орнууд орж байгаа бол хамгийн бага эрсдэлтэй улс орнуудад Финлянд (2.51), Эстон²¹⁴ (3.27), Словени (3.38) зэрэг улс орсон байна.

Индексийн үнэлгээ нь 0-10-ын хооронд утга авах бөгөөд 0 бол эрсдэлгүй, 10 бол өндөр эрсдэлтэйг илэрхийлж байгаа юм.

Харин манай улсын хувьд энэ оны индексийн үнэлгээ 6.14 гарч нийт 162 улс орноос эрсдлээрээ 66-д эрэмбэлэгдэж байна. Монгол Улсыг үнэлсэн уг индексийн үнэлгээ, эрэмбийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Базелийн Мөнгө угаахын эсрэг индекс, оноор

	2012		2013		2014	
	Үнэлгээ	Эрэмбэ	Үнэлгээ	Эрэмбэ	Үнэлгээ	Эрэмбэ
Монгол Улс	6.35	44	6.14	65	6.14	66

²¹¹ http://www.shanghaidaily.com/article/article_xinhua.aspx?id=235999

²¹² Basel AML index

²¹³ <http://index.baselgovernance.org/sites/default/files/documents/overall-score-ranking-2014.pdf>

Тайлбар: Үнэлгээ: 0-10 утга авах бөгөөд 0 бол эрсдэлгүй, 10 бол өндөр эрсдэлтэй, Эрэмбэ: Хамгийн их эрсдэлтэй улсыг эхэнд эрэмбэлсэн болно.

Энэхүү индексийн үнэлгээнд 2012 онд 144, 2013 онд 149, 2014 онд 162 улс орон тус тус хамрагдсан байна.

60. Албан тушаалаа урвуулан ашиглах явдлыг “хориотой сэдэв”²¹⁵ болгох шаардлага²¹⁶(2014.08.31)

Тайланд. Авлигыг нийгмийн хүрээнд байж болшгүй зүйл гэж үзэх үзлийг төлөвшүүлэх талаар даацтай арга хэмжээ авах нь үндэсний шинэчлэлийн гол түлхүүр байх ёстой гэж саяхны семинар дээр ярилцав.

Авлигын эсрэг иргэдийн сүлжээ байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга²¹⁷ Виира Сомквамкид²¹⁸ “албан тушаалаа хувийн ашиг сонирхлын төлөө ашиглах явдал замаа алдлаа, яагаад гэвэл хууль зөрчигчид хариуцлага хүлээхгүй байна, мөн тэд асуудлаас мултрах арга мөнгөөр шийдчихээд байна” гэж тэмдэглэв. Хүмүүс авлигатай холбогдохыг маш их эрсдэлтэй үйл ажиллагаа гэж үздэг тийм нөхцөл байдлыг бүрдүүлэх шаардлагатай байна. Одоогоор авлигатай холбоотой үйл ажиллагаанд холбогдсоноос олох ашиг нь сөрөг үр дагавраас илүү байна.

61. Авлигажсан Хятад орон ба Энэтхэгийн авах сургамж²¹⁹ (2014.08.31)

БНХАУ. Хятадын Ерөнхийлөгч Ши Зиньпин 9 дүгээр сард Энэтхэгт айлчлал хийхээр товлогдсоноос улбаалан хоёр удирдагчийг харьцуулах явдал эрчимтэйгээр эхлэв. 60 жил авлигатай зууралдсан Энэтхэгийн улс төрийн тогтолцоог өөрчилж чадна гэсэн итгэл найдвар төрүүлсэн учраас Нарендра Модид²²⁰ сонгуульд илт давуугаар ялсан нь гарцаагүй юм. Гэвч авлига нь Энэтхэг зэрэг орны сулхан ардчилалд төдийгүй Хятадынх шиг улс төрийн хатуу тогтолцоонд ч оршдог. Хөрш орны ах дүү нарт удирдагчаа сонгох боломж байгаагүй ч тэдний удирдагч (Ши Зиньпин) авлигын эсрэг тэмцлийг үйл ажиллагаандаа сонгосон юм.

Хятадын “авлига” буюу “фубай”²²¹ гэдэг үг нь “гуанши”²²² буюу “танил тал, холбоо сүлбээ” гэдэг ойлголтыг агуулсан соёлын үр дагавар байж магадгүй юм. “Зоу хоу мен”²²³ буюу “арын хаалга”, “та юу гуанши”²²⁴ буюу “тэр хүн танил тал ихтэй байсан” гэсэн үг хэллэг нь хятадуудын өдөр тутмын ярианд байнга хэрэглэгддэг. Хятад дахь авлигыг үндсэндээ баян чинээлгээрээ гайхуулах байдал²²⁵ болон хээнцэрлэж тансаглах хэнээрхэл²²⁶ ихээхэн дэвэргэдэг. Хятадын өмнөх Ерөнхийлөгч Ху Жинтао²²⁷ халаагаа өгөх үедээ Коммунист намыг ангалын ирмэгт байна гэж бодвол түүнийг цааш түлхэж унагаах хүчин зүйл нь авлига байх болно гэж тодорхойлон авлигын хор хөнөөлийг хүлээн зөвшөөрснөөр авлигатай хийх урт удаан тэмцлийн эхлэл тавигдсан. Энэ бол Ши болон намд өгсөн чухал анхааруулга байлаа.

Хятад дахь авлигын нөхцөл байдал Энэтхэгийнхээс ялгагдаад байх зүйлгүй. Ши, Модид нарын албан тушаалаа авсны дараахь гол ялгаа нь эсэргүүцэгчидээ

²¹⁵ taboo

²¹⁶ <http://www.bangkokpost.com/news/local/429639/?src=ilaw>

²¹⁷ Secretary-general of the People's Network Against Corruption

²¹⁸ Veera Somkwamkid

²¹⁹ <http://www.mainstreamweekly.net/article5146.html>

²²⁰ Narendra Modi

²²¹ fubai

²²² guanxi

²²³ zou hou men

²²⁴ ta you guanxi

²²⁵ ostentatious living

²²⁶ hedonism

²²⁷ Hu Jintao

хандаж байгаа хандлага байлаа. Ши тэдний эсрэг хатуу байр суурь баримталж байсан бол Модигийн аргадангуй байдлаар хандахаар шийдэн, заримд нь засгийн газарт чухал албан тушаал өгсөн байна.

62. Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч асны 500 000 ам.долларын хөрөнгийг АНУ хураан авлаа²²⁸(2014.09.04)

АНУ. АНУ-ын Засгийн газар 500.000 ам.долларын хөрөнгө хураан авлаа. Энэ нь Өмнөд Солонгос Улсын Ерөнхийлөгч асан Чун Доо Хван²²⁹ засаглалын жилүүддээ авлигын замаар олж авсан хөрөнгө бөгөөд түүнийхээ зарим хэсгийг мөнгө угаах замаар хөрөнгө оруулалт болгосон байжээ. Тэрхүү мөнгийг Чун Доо Хваны бэр нь Пенсилваниа²³⁰ муж дахь хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл²³¹-д хөрөнгө оруулсан байна.

АНУ-ын Хууль зүйн яамны Туслах прокурор²³² Жерард Калдвелл²³³ мэдэгдэлдээ “Чун Доо Хван ерөнхийлөгч байхдаа 200 сая илүү ам.долларын хээл хахууль авсан бөгөөд тэр мөнгийг хамаатан садангуудтайгаа хамтран АНУ болон Солонгос дахь банкуудаар дамжуулан угаасан” гэжээ.

Генерал Чун Доо Хван нь 1979 онд цэргийн эргэлтээр засгийн эрхэнд гарч ирсэн 1980 онд Гванжу²³⁴ хотод өрнөсөн ардчиллын төлөөх бослогыг дарах тушаал өгсөн бөгөөд үүний улмаас 250 орчим хүний амь нас хохирсон билээ.

63. Энэтхэгийн улсын эмнэлгүүд дэх авлигыг таслан зогсоох шаардлагатай гэж дүгнэв²³⁵(2014.08.23)

Энэтхэг. Тус улсын шинэ засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа эрүүл мэндийн тогтолцоон дахь гажуудлыг арилгах үйл ажиллагааны хүрээнд Засгийн газраас шийдвэр гаргав. Эрүүл мэндийн сайдын зүгээс “бугшмал авлига” гэж тодорхойлсон хууль бус үйл ажиллагааг улсын мэдлийн бүх эмнэлгийн хэмжээнд ямар байгаа талаар үнэлж цэгнэхийг энэхүү шийдвэрт заасан байна.

Жилдээ 74 тэрбум ам.доллар эргэлддэг эрүүл мэндийн салбар дахь албан тушаалаа урвуулан ашиглах явдлыг арилгана гэсэн амлалтыг Ерөнхий сайд Нарендра Модигийн засгийн газар өгсөн бөгөөд энэ салбарт эмч нар өвчтнийг тодорхой эмнэлэг рүү илгээх болон тодорхой эм бичиж өгснийхөө төлөө тэрхүү эмнэлэг болон эмийн компаниас нэмэлт төлбөр, бэлэг сэлт авах нь түгээмэл болсон.

Энэтхэгийн эрүүл мэндийн тогтолцоонд хувийн байгууллагууд давамгайлдаг бөгөөд улсын эмнэлгүүд нь ачаалал ихтэй, байнга өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах нөөц бололцоо дутмаг байдаг байна.

Зөвлөх үйлчилгээний ПвС²³⁶ компанийн судалгаагаар тогтоосноор Энэтхэгийн хувийн эрүүл мэндийн салбарын жилийн өсөлт 15 хувиар нэмэгдэж байгаа боловч эрүүл мэндийн салбарт төрөөс зарцуулж байгаа хөрөнгө тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүн²³⁷-ий 1 орчим хувийг эзлэх болсоор олон жил өнгөрч байна. Дэлхийн

²²⁸ <http://www.trust.org/item/20140904052948-9sln8/>

²²⁹ Chun Doo Hwan

²³⁰ Pennsylvania

²³¹ limited partnership

²³² U.S. Assistant Attorney at the Department of Justice

²³³ Gerard Caldwell

²³⁴ Gwangju

²³⁵ <http://www.reuters.com/article/2014/08/23/us-india-health-corruption-idUSKBN0GN0HM20140823>

²³⁶ PwC

²³⁷ Gross domestic product

банкны 2012 оны мэдээллийн сан²³⁸-гаас харвал Хятадын хувьд энэ үзүүлэлт 3 хувь, АНУ-ынх 8.3 хувь байна.

Дели хотын оношилгооны төвүүд болон эмч нарын хоорондох ашиг хуваалцдаг тохиролцооны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээллийн дараа засгийн газраас тодорхой үйл ажиллагаа явуулж эхэлсэн юм.

64. Камбожийн Ерөнхий сайд авлигын асуудлаар оролцогч талуудыг шүүмжиллээ²³⁹ (2014.09.04)

Камбож. Тус улсын Ерөнхий сайд Хун Сен²⁴⁰ тус улсын нийслэл Пном Пен хотод зохион байгуулагдсан Ази, номхон далайн бүсийн авлигын эсрэг зөвлөгөөнийг нээх явцдаа авлигатай тэмцэхэд хувийн хэвшлийнхэн болон олон улсын хамтын нийгэмлэгүүдийн оролцоог шүүмжлэхийн зэрэгцээ өөрийн Засгийн газрын авлигатай тэмцэх үйл ажиллагааг сайшаав.

Ази, номхон далайн бүс нутгаас олон арван тооны төлөөлөгч оролцож байгаа Бүсийн авлигын эсрэг 8 дахь удаагийн зөвлөгөөнийг нээж Хун Сен үг хэлэхдээ тус улс авлигатай тэмцэх зорилгоор соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, хууль сахиулах гэсэн гурван чиглэлээр амжилттай ажиллаж байна гэж тэмдэглэв.

Транспаренси Интернэшнл байгууллагын Авлигын төсөөллийн индексийн өнгөрсөн оны дүнгээр Камбож Улс 177 улсаас 160-д эрэмбэлэгдэж байсан бөгөөд тус улсад төрийн байгууллага болон шүүх засаглал дахь авлигыг ихээхэн шүүмжлэл дагуулдаг юм.

Гэсэн ч тус улсын Ерөнхий сайд ноён Хун Сен Камбож дахь авлигатай тэмцэх үйл ажиллагаанд хувийн хэвшлийнхэн тэнцүү хэмжээний хариуцлага үүрэх ёстойг санууллаа. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан судалгаагаар тус улс жил бүр ДНБ-ийхээ 10 орчим хувийг авлигын улмаас алддаг аж.

Тэрээр “хээл хахууль өгч байгаа тал бол хувийн хэвшил гэдгийг мартаж болохгүй. Хэрвээ хувийн хэвшил хээл хахууль өгөхөө зогсоовол төрийн албан хаагчид хаанаас хахууль авах билээ? Тиймээс хувийн хэвшлийнхнийг цэвэр хөрөнгө оруулалт хийх, улмаар хахууль өгөх явдлаа зогсоохыг уриалж байна” гэж тэмдэглэжээ.

Үүний зэрэгцээ Хун Сен Камбожийн эдийн засгийн талаар муу төсөөлөл түгээж буй олон улсын байгууллагуудад шүүмжлэлтэй хандаж байгаагаа илэрхийлсэн юм.

Швейцари Улсад байрлах Базелийн институцээс өмнөх сард зарласан Мөнгө угаахын эсрэг индекс²⁴¹-ээр Камбож Улс мөнгө угаах эрсдэл бүхий улсуудын жагсаалтын 3 дугаар байрт эрэмбэлэгдсэн юм.

“Олон улсын байгууллагуудын түгээж байгаа муу төсөөлөл, мэдээний хүнд бэрхийг Камбожтой адил олон тооны ядуу улс орнууд үүрч байгаа. Бид тэднийг хүлээн зөвшөөрөхгүй бол тэд тусламжийнхаа хэмжээг бууруулдаг. Энэ бол баян улс орнууд юу хүссэнээ хийж болдгийн илрэл” гэж тэрээр хэлжээ.

Ашгаас шударга бусаар хүртэхэд хүргэж буй өөрийн улс орнуудын компаниудын өмнөөс Камбож Улсад хөрөнгө оруулах санал тавьж буй дипломатуудыг мөн тэрээр шүүмжилсэн байна. “Камбож Улс ахиу ашиг хүртэх, өөрсдийн талын компаниуд нь бага ашгийг хүртэх санал тавьж надтай уулзсан ямар ч элчин сайдыг би мэдэхгүй. Энэ бол үнэн” гэж тэрээр хэлсэн байна.

Мөн энэхүү зөвлөгөөнийг нээх үеэрээ Ерөнхий сайд Хун Сен хурлын индэрт өөрийн хажууд суусан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

²³⁸ World Bank database

²³⁹ <http://www.cambodiadaily.com/news/hun-sen-blames-private-sector-for-corruption-67499/>

²⁴⁰ Hun Sen

²⁴¹ Anti-Money Laundering Index

(OECD)-тай хамтран уг зөвлөгөөнийг зохион байгуулж буй Азийн хөгжлийн банкны төлөөлөгчдөд хандан “болгоомжтой байх”-ыг сануулсан юм. Тэрээр Олон улсын валютын сангийн дарга Кристина Лагард, Дэлхийн банкны ерөнхийлөгч асан Пол Вулфовиц нарын холбогдоод байгаа шиг санхүүгийн гэмт хэргээс тэднийг ангид байх, энэ төрлийн хэрэг гарахаас сэргийлж байхыг Азийн хөгжлийн банкныханд сануулсан юм. Мөн “Манай Азийн хөгжлийн банканд ийм зүйл хараахан тохиолдоогүй байна. Азийн хөгжлийн банк маш болгоомжтой байх ёстой... Дэлхийн банк болон Олон улсын валютын сангийнхан шиг нэр хүндээ гутаахгүй гэдэгт би итгэж байна” гэж онцлов.

Түүний энэхүү шүүмжлэл мөн АНУ, Дэлхийн банк зэрэг олон улсын хамтын нийгэмлэгүүдэд мөн чиглэсэн юм. Тэрээр “гаалийн байгууллагын хувьчлах, улмаар хувийн хэвшлийнхэнд “гар буу, гранат, нисдэг тэргүүдийг” өгүүлэхээр өөрийг нь 2004 онд АНУ, Дэлхийн банк ятгаж байсан” гэж хэлжээ.

Зөвлөгөөнийг нээж хэлсэн түүний энэхүү үгсийг хүн бүр харилцан адилгүй хүлээн авсан юм. Тухайлбал, Шри Ланка Улсын Ерөнхий прокурор Капила Вайлдартн²⁴² Камбожийн авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаар зэрэг төсөөлөлтэй байгаагаа илэрхийлсэн юм. Тэрээр “Би юуг олж харсан бэ гэхээр Камбож Улс зөв замаар явж байна. Тэд үүнийгээ мэдэж байгаа, дэвшил гаргасан байна” гэж онцлов.

Камбожийн Засгийн газар Авлигатай тэмцэх алба²⁴³-ыг 2010 онд байгуулсан бөгөөд засгийн газраас их, дээд сургуулийн элсэлтийн шалгалтын үеэр бусдаас хуулах явдалтай тэмцэхээр томоохон алхмуудыг сүүлийн үед хийгээд байгаагийн зэрэгцээ зөвхөн цалин авдаг “сүнс” хэмээн нэрлэгдэх ажилтнуудын эсрэг ажиллагаа явуулахаа мэдэгдээд байгаа аж.

65. Үндэстэн дамнасан мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Мьянмар Улс илүү олон тооны гэрээ байгуулна²⁴⁴(2014.08.24)

Мьянмар. Улсын Санхүүгийн гэмт хэргийг мөрдөн байцаах товчооны дэд дарга, цагдаагийн хурандаа Ков Вин Тейнийн тус улс үндэстэн дамнасан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар харилцан мэдээлэл солилцох зорилгоор Япон, Их Британи зэрэг улстай гэрээ байгуулахаар хэлэлцэж байна. “Манай улсад хууль бус мөнгөний гадагш болон дотогш чиглэсэн урсгал аль аль нь байгаа. Тиймээс мөнгө угаахаас сэргийлэхийн тулд улс орнуудтай нягт холбоо тогтоох хэрэгтэй. Одоогийн байдлаар бид энэ асуудлаар 7 улстай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан бөгөөд Япон Улстай байгуулахаар ажиллаж байна” гэж мэдэгджээ.

Мөнгө угаах асуудлаар Мьянмар Улс хэдий 7 улстай гэрээ байгуулаад байгаа ч 1995 онд онд байгуулагдсан дэлхий дахинд 139 улс орны санхүүгийн тагнуулын нэгж²⁴⁵үүдийг эгнээндээ нэгтгэсэн “Egmont Group”-ийн гишүүн хараахан болоогүй байгаа юм.

“Egmont Group”-ийн зорилго нь терроризмыг санхүүжүүлэх болон мөнгө угаах асуудалтай тэмцэх хамтын ажиллагааг нэмэгдүүлэх хүрээнд дэлхийн санхүүгийн тагнуулын нэгжүүдийг хамруулсан форум зохион байгуулах, энэ асуудлаар дотоодын хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлэх, олон улсын хэмжээнд талууд харилцан мэдээлэл солилцох явдлыг дэмжих зэрэг үйл ажиллагаа явуулдаг юм.

Монгол Улсын Санхүүгийн мэдээллийн алба “Egmont Group”-д 2009 онд гишүүнээр элссэн юм.

²⁴² Kapila Waidyartne

²⁴³ Anti-Corruption Unit

²⁴⁴ http://www.elevenmyanmar.com/index.php?option=com_content&view=article&id=7307:myanmar-to-sign-more-agreements-to-prevent-transnational-money-laundering&catid=44:national&Itemid=384

²⁴⁵ Financial Intelligence Units

66. Олон улсын хөлбөмбөгийн холбоо (ОУХХ)-ны Аудит, хяналтын хорооны гишүүнийг мөнгө угаасан хэрэгт буруутган саатууллаа²⁴⁶(2014.09.07)

Олон улсын хөлбөмбөгийн холбоо. ОУХХ-ны Аудит, хяналтын хорооны гишүүн Канонер Ватсонг Кайманы Арлуудад мөнгө угаасан, хээл хахууль авсан хэрэгт буруутган саатуулсны дараа түүнээс ОУХХ тайлбар шаардав.

ОУХХ-ны Аудит, хяналтын хорооны найман гишүүний нэг, Карибын Хөлбөмбөгийн холбооны дэд ерөнхийлөгч Канонер Ватсон эдгээр хэргийг үгүйсгэж байгаа бөгөөд одоогоор батлан даалтад гарчээ.

“Ёс зүйн журмын дагуу Канонер Ватсонгон Аудит, хяналтын хороонд хэргийн талаар тайлбар өгөхийг шаардсан. Бодит мэдээллийг олж авсныхаа дараа шаардлагатай арга хэмжээг авах болно” хэмээн ОУХХ-ны Аудит, хяналтын хорооны тэргүүн Доменико Скала мэдэгдэв.

Канонер Ватсонг Кайманы Арлуудын авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийг зөрчсөн, түүнчлэн албан тушаалаа урвуулан ашигласан...сонирхлын зөрчилтэй” зэрэг хэрэгт буруутгаад байгаа гэж Кайманы Арлуудын авлигатай тэмцэх комиссар Дэвид Байнс²⁴⁷-ийн хэлжээ. Канонер Ватсоны хэрэгт Эрүүгийн хуулийн 133 дугаар зүйлд заасан “мөнгө угаах” хэрэгт мөн холбоотой хэмээн Дэвид Байнс хэлсэн байна. Эдгээр хэргүүд нь тус улсын Эрүүл мэндийн байгууллагын тэргүүнээр Канонер Ватсонг ажиллаж байх үед нэвтрүүлсэн картын цахим системийн төсөлтэй холбоотой цагдаа нарын эхлүүлээд байгаа мөрдөн байцаалтын үйл ажиллагаатай холбоотой байж болох юм.

67. Олборлох салбарын ил тод байдлын санаачилга: Шүүмжлэл болон шийдвэрлэх тухай саналууд²⁴⁸(2014.09.05)

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга. Байгалийн нөөц буюу олборлох болон уул уурхайн салбарт авлига их нүүрлэдэг. Ашигт малтмалын салбарыг ихэнх улс оронд улс төрийн эрх мэдэлтнүүдтэй холбоотой цөөхөн хэдэн баячууд хянаж, ард иргэд энэхүү баялгийн үр шимийг хүртэж чадахгүй, бусад салбарын өсөлт зэрэг нь удааширч байдаг тул “баялгийн хараал” хүртлээ гэдэг. Ашигт малтмалын салбар дахь авлигатай тэмцэх стратегийн нэг нь ил тод байдлыг нэмэгдүүлэх явдал юм. Энэхүү стратегийн нөлөөгөөр эрх зүйн хувьд, тухайлбал, ил тод байдлыг хангах хууль батлах зэргээр зарим нэг амжилтад хүрсэн ч хамгийн гол нь сайн дурын санаачилга чухал юм. Олборлох салбарын ил тод байдлын санаачилгын гишүүнд улс орон, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн төлөөлөл, хөрөнгө оруулагчид багтаж байна. Хэдийгээр гишүүнчлэл нь сайн дурынх ч гэсэн гишүүд нь зөвлөлийн тогтоосон журмыг дагаж мөрдөх ёстой. Аж ахуйн нэгжүүдийн хувьд гишүүн орнуудад олборлох салбарт хийж буй гэрээ хэлцлийн үнийн дүн, олж буй ашиг орлого болон үндэсний төсөвт хэдий хэмжээний мөнгө төлж байгаа зэргийг нээлттэй байлгах үүрэг хүлээдэг. Олборлох салбарын ил тод байдлын санаачилга 2002 онд байгуулагдсанаас хойш зарим нэг амжилтад хүрсэн, тухайлбал, олборлох компаниуд Нигерийн Засгийн газарт 8.3 тэрбум ам.долларын хэмжээний татварын өртэй ба энэ нь боловсролын салбарт 3 жил зарцуулсан хөрөнгөтэй дүйцэж байна. Хэдийгээр зарим нэг амжилт харагдаж байгаа ч Олборлох салбарын ил тод байдлын санаачилгад 3 том дутагдалтай тал байна. Үүнд: Хэдийгээр хичнээн хэмжээний ашиг орлого ашигт

²⁴⁶ <http://www.theguardian.com/football/2014/sep/07/fifa-financial-watchdog-arrested-money-laundering-charge>

²⁴⁷ David Baines

²⁴⁸ <http://globalanticorruptionblog.com/2014/09/05/the-extractive-industries-transparency-initiative-a-critique-and-proposed-reforms/>

малтмалын салбараас олж байгааг олон нийтэд зарлаж байхыг шаардаж байгаа ч энэхүү ашиг орлогыг хэрхэн зарцуулж буйг улс орнууд нээлттэй байлгах үүрэг хүлээдэггүй байна. Хоёрдугаарт, гишүүнчлэл нь хязгаарлагдмал байна. Гуравдугаарт, ил тод байхыг шаарддаг ч дан ганц ил тод байх нь хангалттай бус байгааг дурдах хэрэгтэй.

68. Ази-Номхон далайн орнууд мөнгө угаах чиглэлээр нэг алхмаар урагшлав²⁴⁹(2014.09.09)

Ази-номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК). Тус байгууллага нь Зүүн өмнөд Азийн орнуудын бүлгийг, ялангуяа Лаос, Камбож, Мьянмар зэрэг улсыг мөнгө угаах, зэрлэг ан амьтны хулгайтай тэмцэх чиглэлээр дорвитой ажил хийхгүй байна хэмээн буруушаав. Эдгээр гурван улс нь АПЕК-ийн гишүүн улс биш юм. АПЕК нь 21 гишүүн улсаас бүрдэх ба үүнд Филиппин, Австрали, Бруней Дарусалам, Канад, Индонез, Япон, Өмнөд Солонгос, Малайз, Шинэ Зеланд, Сингапур, Тайланд, АНУ, Тайвань, Хонконг, БНХАУ, Мексик, Папуа Шинэ Гвиней, Чили, Перу, ОХУ болон Вьетнам ордог байна. Хэдийгээр АПЕК-ийн гишүүн бус ч гэсэн Лаос, Камбож, Мьянмар улс нь мөнгө угаахтай тэмцэх юм бол “илүү ихийг” хожих байсан ба гол зорилго бол эдгээр гишүүн бус орнуудын илүү идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх явдал юм хэмээн АНУ-ын АПЕК-ийн ахлах төлөөлөгч Роберт Ванг мэдэгдэв. Өнгөрсөн жил болсон Зүүн өмнөд Азийн орнуудын Үндэстэн дамнасан гэмт хэргийн чиглэлээрх Удирдах албан тушаалтнуудын 13 дахь удаагийн уулзалтын үеэр Зүүн өмнөд Азийн орнуудад мөнгө угаах болон кибер гэмт хэрэг ихсэх хандлагатай байгаа талаар Вьетнамын Олон нийтийн аюулгүй байдлын яамны дэд сайд Ле Куй Вуонг анхааруулсан юм. Хэдийгээр мөнгө угаах асуудал Вьетнамд шинэ гэмт хэрэг хэдий ч сэжигтэй банкны гүйлгээ 650 бүртгэгдсэнээс 22 гүйлгээг сайтар хяналт шалгалт хийсэн байна. Мьянмар Улс энэ оны гуравдугаар сард Мөнгө угаах тухай хуулийг баталсан байна. 2015 онд болох АПЕК-ийн гишүүн орнуудын уулзалтыг Филиппин Улсад хийхээр болоод байгаа юм. 21 улс, газар нутаг орж буй АПЕК нь анх 1989 онд байгуулагдсан ба чөлөөт худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилготой байгууллага юм. Азийн ихэнх улсад өөр нэг тулгарч буй асуудал нь зэрлэг ан амьтны хулгайн ан агнуур болон худалдаа юм. Энэ нь зарим амьтдыг үхлийн ирмэгт хүргээд байна.

69. Вьетнамд чөлөөт хэвлэл мэдээлэл хөгжихөд ихээхэн бэрхшээлтэй байна²⁵⁰(2014.09.21)

Вьетнам. Сөүл хот дахь Зүүн өмнөд Азийн улс орнуудын холбоо (ASEAN) ба Солонгосын төвд зохион байгуулагдсан лекцийн үеэр Вьетнам Улсаас Өмнөд Солонгос Улсад суугаа элчин сайд Пам Хуу Чи илтгэл тавихдаа Вьетнамд чөлөөт хэвлэл мэдээлэл хөгжихөд ихээхэн бэрхшээлтэй хэмээн хэлсэн байна.

Вьетнам Улс сүүлийн 20 жилийн хугацаанд НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилтууд болох ядуурлыг бууруулах зэрэг олон тооны зорилтуудын шалгуурыг бүрэн хангасан амжилттай байгаа хэдий ч энэ байдал цаашид мөн амжилттай үргэлжлэх эсэх нь чөлөөт хэвлэл мэдээллээс ихээхэн хамааралтай болоод байгааг тус илтгэлийн үеэр элчин сайд Пам Хуу Чи онцлон тэмдэглэсэн байна.

²⁴⁹ <http://www.manilatimes.net/step-drive-vs-money-laundering-asean-urged/125517/>

²⁵⁰ <http://www.koreaherald.com/view.php?ud=20140921000286>

Вьетнам Улсыг чөлөөт хэвлэл мэдээллийн орчинг бүрдүүлэхгүй байгаа талаар удаан хугацааны турш “Freedom House” болон “Хил хязгааргүй сэтгүүлчид” зэрэг олон тооны байгууллагууд шүүмжилсээр байна.

Дэлхий дахинд хэвлэлийн эрх чөлөөг дэмжих ашгийн бус, Франц Улсад байрлах Хил хязгааргүй сэтгүүлчид байгууллагаас гаргасан Дэлхийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний индексийн 2013 оны судалгаагаар Вьетнам Улс 178 улс орноос 172-т эрэмбэлэгдэж байгаа юм. Энэ нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө хаагдмал Хойд Солонгос Улсынхтай ойролцоо дүн юм.

Вьетнам, Хятад гэсэн улс орнууд өөрийн интернэтийн орчинд хяналт тавьж блогчид болон олон нийтийн цахим сүлжээ ашиглагчдын эрхийг хязгаарлаж байгааг Дэлхийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний индексийн 2013 оны судалгааны тайланд онцолсон байдаг.

Сүүлийн нэг хүрэхгүй жилийн дотор Вьетнамын шүүхээс 12 блогчин болон интернэт хэрэглэгчдийг 13 хүртэл жилийн хугацаагаар хорихоор шийдвэрлэсэн зэрэг нь тус улсыг интернэт хэрэглэгчиддээ ял тулгасан байдлаар Хятадын дараа буюу энэ хэмжээгээрээ дэлхийд хоёрт ороход хүргээд байна.

“Вьетнам дахь хэвлэлийн эрх чөлөөг барууны шүүмжлэгчид буруу ойлгодог. Учир нь Вьетнамд байгаа сэтгүүлчид ямар нэгэн асуудал, эсхүл авлига болон орон нутгийн захиргааны байгууллагатай холбоотой асуудлуудаар шүүмжлэх боломжтой байдаг бол зөвхөн тус улсын Коммунист нам болон Вьетнам дахь улс төрийн системийг шүүмжлэх боломжгүй байдаг” гэж Элчин сайдын яамны ажилтан хэлсэн байна.

Зүүн өмнөд Азийн улс орнуудын холбоо-Солонгосын төвд зохион байгуулагдсан энэхүү лекц нь 2008 оноос хойш цуврал хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа бөгөөд 10 дугаар сарын 14-нд болох дараагийн лекцэд Өмнөд Солонгос Улсад суугаа Тайландын Элчин сайд Кулкумут Сингхара На Аудхаяа оролцож илтгэл тавих билээ.

70. Хил дамнасан авлигын гэмт хэрэгтэй тэмцэх шинэ төслийг Белингкат²⁵¹ цахим хуудас эхлүүлэв²⁵²(2014.09.29)

Их Британи. нь “Лондонгийн Хакерууд” цахим хуудас болон Зохион байгуулалттай гэмт хэрэг ба Авлигыг мэдээлэх төсөлтэй хамтран хил дамнасан авлигын гэмт хэрэгтэй тэмцэх шинэ төслийг эхлүүлэв. Энэхүү төсөл сэтгүүлч, судлаач, мөрдөн байцаагч нарын хооронд нээлттэй эх сурвалжийн мэдээлэл болон мөрдөн шалгахад шаардлагатай арга хэрэгслүүдийн талаарх мэдээллийг солилцох уулзалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулах замаар хэрэгжих юм. “Мэргэжлийн ур чадвар, арга хэрэгслийг зааж өгснөөр тэд өөрсдийн төслийг хэрэгжүүлэхдээ ашиглах боломжтой болох юм” хэмээн Белингкат төслийг санаачлагч, Сирийн асуудлын үеэр зэр зэвсгийн талаар блог нээн ажиллуулж байсан Браун Мосс хэлэв. Энэхүү төсөлд, тухайлбал, Эрэн сурвалжлах товчооны гишүүд “Файненшэл Таймс²⁵³” сонины сурвалжлагчид Питер Жукс, Крис Брэйс, Оз Катержи нар оролцож байна. Эрэн сурвалжлах эхний асуудал нь Зүүн Европоос Лондонгийн үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээр угаагдсан мөнгөний асуудлыг авч үзэх юм. Оролцогчид мэдээллийн эх сурвалжуудтай ажиллаж сурна. Тухайлбал, Зохион байгуулалттай гэмт хэрэг ба Авлигыг мэдээлэх төслийн эрэн сурвалжлах арга хэрэгслүүдтэй танилцан ашиглаж сурна. Үүнд: хил дамнасан асуудлуудыг эрэн сурвалжилж буй тул дэлхий дахины бизнес регистрийн мэдээллийг хэрхэн шүүх гэх мэт багтана. Бусад эх сурвалжуудад, жишээ нь, нээлттэй байдаг шүүхийн тогтоолууд орно. Энэхүү төслийн зорилго нь

²⁵¹ Bellingcat-Белингкат гэдэг нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн цахим хуудас юм

²⁵² <http://www.journalism.co.uk/news/new-bellingcat-project-to-investigate-cross-border-corruption/s2/a562610/>

²⁵³ Financial Times

мэдээллийн ил тод нээлттэй эх сурвалжуудын мэдээллийг хэрхэн олж болох, хэрхэн эдгээр мэдээллийг нэгтгэж үзэх зэргийг хүмүүст тайлбарлан өгөх юм.

71. Авлигатай тэмцэх үйл ажиллагааг улс төржүүлэхгүй байх ёстой²⁵⁴(2014.10.06)

Тайланд. Тайландын улс төрийн хоёр том хүчний харилцан эв нэгдэлтэй хамтран оршиж байгааг “өнгө ууссан” гэсэн хэллэгээр хэлдэг ч хариултгүй хэвээр буй асуудал бол авлигатай тэмцэх асуудалд маш ихээр улс төрждөг явдал юм. Одоогийн Үндэсний авлигатай тэмцэх хороо нь Тайландад шударга ёсыг тогтоох гэсэн нэгэн хэсэг хэвээр байсаар байна гэдэгтэй ихэнх хүмүүс санал нийлж байгаа ч дээд түвшнээсээ доод түвшин хүртэл өөрсдийн сэтгэл зүйн чиг хандлагыг өөрчлөхгүйгээр ямар ч үр дүнд хүрэхгүй юм. Учир нь Үндэсний авлигатай тэмцэх хороо нь нэг талаас магтуулдаг, нөгөө талаас шүүмжлүүлдэг, маргаан үүсгэдэг улс төрийн аппарат хэвээр байх нь байна. Манай “шинэчлэгчид” авлигатай тэмцэх шидэт томьёо гаргаж ирэхгүй бол Тайландын нэр хүнд олон улсын тавцанд навс унаад байна. Энэ нь Үндэсний авлигатай тэмцэх хороо дандаа алдаж байсан гэсэн үг биш юм. Нэр нөлөөтэй том улс төрчдөөс Ардчилсан намын ерөнхий нарийн бичгийн дарга асан Санан Качорнпрасартыг хөрөнгө, орлогын мэдүүлэг бага зэрэг зөрүүтэй байна гэсэн асуудлаар анх шалгасан байдаг. Түүнийг таван жилийн турш улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхийг нь хязгаарласан юм. Үүнтэй холбоотой нэг их маргаан гарч байгаагүй ба үүний дараа шударга ёсыг тогтоогчид Таксин Шинаватра болон түүний цэргүүдийг шалгаж эхэлсэн. Одоо Үндэсний авлигатай тэмцэх хороог дэмжих, хамгаалах, эсхүл шүүмжлэх асуудал бол дэндүү хожимдсон зүйл болно. Өнгөрсөн зүйл маань биднийг эдүгээд авчирч улмаар ирээдүйд хүргэдэг гэдгийг бид мэднэ. Бид авлигатай хуучин арга замаар тэмцвэл нөгөө л Тайланд орныг сүүлийн хэдэн жил доргиож байсан улс төрийн нөхцөл байдал үүснэ. Улс төрчдийн хоолойгоо сөөтөл маргалддаг тус улсын авлигатай тэмцэх ажлыг үр дүнтэй, хариуцлагатай, боломжтой болгохын тулд үндэсний ухамсрыг шинэчлэх асуудлаас гадна, нэгдүгээрт бид хуулиасаа эхлэх хэрэгтэй. Тайланд Улс авлигатай тэмцэх маш муу хууль, журамтай улс орнуудын нэг байсан байх. Улс төрийн гэрээ хэлэлцээр, дарамт шахалт ч байсан байх. Иймд авлигын хууль, журам зөрчигч нарыг улс төрийн харьяаллаас үл хамааран шалгахад хялбар, хурдан маш энгийн хууль тогтоомжтой байвал зохино. Хоёрдугаарт, мөрдөн байцаагч нар нь маш сайн хамгаалагдсан, олон нийттэй сайн харилцаа холбоотой байх хэрэгтэй. Учир нь тэдний ажилд олон нийтийн дэмжлэг туслалцаа маш чухал. Улс төрийн нөлөөллөөс ангид байхын тулд “маш нууц” гэсэн мэдээллийг аль болох олон нийтэд ил байлгах явдлыг хангах шаардлагатай. Гүйцэтгэх дээд байгууллагуудад “маш нууц” гэсэн мэдээлэл нь байх ёстой, байхгүй байх ёстой гэсэн асуудал нь өөрөө маргаантай юм. Ямартаа ч авлигатай тэмцэхэд “маш нууц” гэсэн асуудал байх ёсгүй юм. “Маш нууц” гэсэн асуудал өөрөө нуун далдлах, хээл хахууль үүсгэдэг. Ил тод, нээлттэй байх нь өнөөгийн Тай системд буглаад байгаа өрөөсгөл хандлагыг бууруулна. Гуравдугаарт, “шүгэл үлээгч”-ийг хамгаалах соёл болон эрх зүйн асуудлыг хангах шаардлагатай байна. Энэ бол олон нийтээс дорвитой хувь нэмэр авч болох цорын ганц зам юм. Мэдээжийн хэрэг төвийг сахих, олон нийтийг мэдээллээр хангах байдлыг дээшлүүлэх зэргээс гадна энэ хэрэгслийг бусад арга хэрэгслүүдтэй хамт ашиглах хэрэгтэй. Бид тус байгууллагыг бие даасан, хараат бусаар үйл ажиллагаа эрхлэх ёстой гэж байнга ярьдаг. Гэтэл бодит байдал дээр авлигатай тэмцэх асуудал эхнээсээ дуустал улс төржиж ирсэн. Улс төр өөрөө авлигыг үүсгэж байна. Авлигатай тэмцэх асуудлыг улс төржих явдлаас ангижруулах нь маш хүнд, хэцүү

²⁵⁴ <http://www.nationmultimedia.com/opinion/We-must-depoliticise-the-fight-against-corruption-30244807.html>

асуудал юм. Хэрэв авлигатай тэмцэх асуудлыг улс төрөөс ангид байлгах оролдлого хийхэд “шинэчлэгч”-дэд ямар нэгэн шалтгаан хэрэгтэй байгаа бол авлигын улмаас учирсан хохирол нотолгоо болно.

72. Олон улсын хөлбөмбөгийн холбооноос Монголын Хөлбөмбөгийн холбооны тэргүүнд 5 жилийн хориг тавилаа²⁵⁵(2014.10.15)

Олон улсын хөлбөмбөгийн холбоо. ОУХХ-ны Ёс зүйн хорооноос Монголын Хөлбөмбөгийн холбооны тэргүүн Б.Ганболдыг 5 жилийн хугацаанд улсын болон олон улсын түвшний хөлбөмбөгтэй холбоотой аливаа үйл ажиллагаанд оролцохыг хориглосон шийдвэр гаргаад байна.

Б.Ганболд нь 2009 онд Азийн хөлбөмбөгийн холбоон дахь ОУХХ-ны Гүйцэтгэх хорооны гишүүдийн сонгууль, 2011 онд ОУХХ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Азийн хөлбөмбөгийн холбооны тэргүүн асан Мохамед Бин Хаммам²⁵⁶-аас төлбөр хүссэн, хээл хахууль авсан нь тогтоогдсон байна. ОУХХ-ноос 57 настай Б.Ганболдыг Ёс зүйн дүрмийн 13 (Ёс зүйн ерөнхий дүрэм), 18 (Үйл ажиллагааныхаа талаар мэдэгдэх үүрэг), 19 (Сонирхлын зөрчил), 20 (Бэлэг болон бусад шан харамж хүсэх), 21 (Авлига, хээл хахууль), 42 (Хамтран ажиллах ерөнхий дүрэм)-ийн заалтуудыг зөрчсөн болохыг тогтоосон байна.

ОУХХ-ноос гаргасан дээрх шийдвэр нь 2014 оны 10 дугаар сарын 15-наас хүчин төгөлдөр үйлчилж эхлэх юм.

2011 онд ОУХХ-ны Ерөнхийлөгчийн суудалд ноён Сепп Блаттертай хамт өрсөлдөж байсан, Катарын иргэн 65 настай Мохамед Бин Хаммамыг ОУХХ-ноос 2012 оны 12 дугаар сард хөлбөмбөгтэй холбоотой аливаа үйл ажиллагаанд оролцох эрхийг нь бүх насаар нь хориглосон шийдвэр гаргаж байсан байна.

73. Пакистаны авлигатай тэмцэх байгууллага “шүдгүй”²⁵⁷ (2014.10.09)

Пакистан. Пакистан дахь Транспарэнси Интернэшнл байгууллагын захирал Адил Гилани тус улсын Үндэсний хариуцлагатай байдлын товчоог сүүлийн жил гаруй хугацаанд авлигын томоохон хэргүүдийг таслан зогсоох талаар дорвитой алхам хийж чадахгүй байна гэж шүүмжлэн, тус байгууллагыг “шүдгүй байгууллага” хэмээн нэрлээд байна.

Транспарэнси Интернэшнл Пакистан байгууллагын захирлын үзэж байгаагаар Пакистан Улсад нүүрлээд буй томоохон асуудлуудын нэг болох авлигыг устгах, авлигатай тэмцэх үйл ажиллагааг сайжруулахын тулд Үндэсний хариуцлагатай байдлын товчоонд “мэс засал хийх” хэрэгтэй байгаа.

Үндэсний хариуцлагатай байдлын товчооны дарга асан Адмирал Фаших Бохари нэгэн удаа мэдэгдэхдээ Пакистан улс өдөр бүр 8 тэрбум хүртэл руппиг авлигын улмаас алдаж байна хэмээн мэдэгдэж байсан юм.

Адил Гиланийн үзэж байгаагаар Үндэсний хариуцлагын товчоонд томоохон албан тушаал хашиж байгаа эрхмүүдийг өмнөх Засгийн газрын үед томилсон бөгөөд өөрсдийг нь томилсон өмнөх Засгийн газрын гишүүд болон Ерөнхий сайдын авлигын хэргийн эсрэг тус байгууллага ямар нэгэн алхам хийж чадахгүй байна.

²⁵⁵ <http://www.fifa.com/aboutfifa/organisation/bodies/news/newsid=2457464/>

<http://www.theguardian.com/football/2014/oct/15/fifa-suspend-mongolian-fa-president-bribes>

²⁵⁶ Mohamed Bin Hammam

²⁵⁷ <http://nation.com.pk/national/09-Oct-2014/nab-has-become-a-toothless-body-tranparency>

74.Мьянмар Улсын газрын тос, байгалийн хийн компаниуд ил тод байдлаараа “дэлхийд түүчээ” болж байна²⁵⁸(2014.10.09)

Мьянмар. “Global Withness” байгууллагын мэдээлж байгаагаар байгалийн нөөцөөр баялаг Мьянмар Улсын газрын тос, байгалийн хийн томоохон компаниудын талаас илүү хувь нь өөрийн жинхэнэ эздийнхээ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч байгаагаараа “дэлхийд түүчээ” болж байна.

Зөвхөн 4 сарын өмнө л тус байгууллагаас Мьянмарын газрын тос, байгалийн хийн салбарыг маш нууцлаг хэмээн шүүмжилж байсан юм.

Уул уурхайн салбарт ажиллаж байгаа компани болон Засгийн газар уул уурхайн үйл ажиллагаанаас хэдий хэмжээний орлого олж, хэдийг хэмжээтэй татвар төлж, Засгийн газар хэдийг хүлээн авч байгаа талаар ил тод байдлыг хангах зорилго бүхий Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга²⁵⁹-д Мьянмар Улс гишүүнээр элсэхээр нэрээ дэвшүүлээд байгаа.

Дэлхийн газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудын авлигын эсрэг сүлжээ болох Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын олон улсын хурлыг Мьянмар Улс зохион байгуулан явуулахаар төлөвлөн ажиллаж буй бөгөөд “Global Withness” байгууллагаас Мьянмар Улсыг ялангуяа, олборлох үйлдвэрлэлийн салбарын компаниудыг өөрийн жинхэнэ эзэмшигчийн талаарх мэдээллийг ил тод болгох шаардлагатай хэмээн өмнө нь мэдэгдэж байсан юм.

“Global Withness” байгууллагын шинжээч Жуман Куббагийн “Дэлхий дахинд, Их Британи зэрэг улс орнууд компанийн жинхэнэ эзэмшигчийн талаар бүртгэлийг бий болгохоо амладаг. Гэхдээ бид Мьянмар Улсын компаниудын жинхэнэ эзэмшигчийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл олж авах боломжтой болж байгаа нь анхных юм. Мьянмарын газрын тос, байгалийн хийн салбарын хувийн 15 компани бидэнд жинхэнэ эзэмшигчийнхээ талаар бүхий л мэдээллийг өгч байна” гэж тэмдэглэв.

Сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд Мьянмарын газрын тос, байгалийн хий, усан цахилгаан станц, мод боловсруулах болон уул уурхайн салбарын компаниудын мэдээллийг олж авахад ихээхэн хүндрэлтэй байсны зэрэгцээ эдгээр компаниуд нь армийн төлөөлөлтэй нягт холбоотой байсаар ирсэн юм. Өөрөөр хэлбэл, дэлхийн хамгийн их авлигатай, ядуу улсын нэг болох тус улсын байгалийн нөөцөөс олж байгаа олон сая ам.доллартай тэнцэх орлогын талаарх мэдээлэл олон нийтэд ил тод бус байсаар ирсэн юм.

Мьянмарын байгалийн нөөцийн ихэнх хэсэг нь тус улсын үндэстний цөөнхийн нутаг дэвсгэрт байдаг бөгөөд түүнийг ашиглах асуудал засгийн газар, үндэстэн ястан болон армийн бүлэглэлүүдийн хооронд ихээхэн маргаантай байдаг юм.

Өнгөрөгч 6 дугаар сард “Global Withness” байгууллага тус улс дахь дээрх салбаруудад үйл ажиллагаа явуулж буй компаниудын хаалттай байдлаас үүдэлтэйгээр улсын төсвийн орлого буурч магадгүй хэмээн анхааруулж байсан юм. Тухайн үед зөвхөн 13 компанийн эзэмшигчийн талаарх мэдээлэл ил тод болгоод байсан юм.

Түүнээс хойш газрын тос, байгалийн хийн салбарын нийт 36 компани мэдээллээ ил тод болгоод байгаагийн 17 нь эзэмшигчийнхээ талаарх мэдээллийг цогц байдлаар гаргасан.

“Global Withness”-ийн шинжээчийн үзэж байгаагаар “Мьянмар Улс уг салбарт өдөөгч хүчин зүйлс ашиглавал хувийн компаниуд өөрийн жинхэнэ эзэмшигчийнхээ талаарх мэдээллийг ил тод болгоход бэлэн байгаа” юм.

Гэвч орон нутгийн болон олон улсын хэмжээний 11 компани өөрийн жинхэнэ эзэмшигчийнхээ талаарх мэдээллийг илрүүлээгүй байгаа нь эдгээр компаниудын

²⁵⁸ <http://www.trust.org/item/20141009170052-qwoia>

²⁵⁹ The Extractive Industries Transparency Initiative (EITI)

авлигын эрсдлийг бууруулах талаар цаашид илүү их ажил хийх шаардлагатай байгааг илэрхийлж байгаа юм. Эдгээр компаниудын дунд Канадын “Pacific Hunt”, Нидерландын “CAOG s.a.r.l.”, Энэтхэгийн “Oilmax energy” зэрэг томоохон компаниуд багтаж байгаа юм.

Шинжээч Жуман Кубба “Дэлхий дахинд, авлигач улс төрчид болон бизнесменүүд газрын тос, байгалийн хий, байгалийн нөөцөөс хулгайлахын тулд нууц компаниудын ард нуугдсан байдаг. Энэ асуудлыг шийдэхийн тулд Мьянмар Улс түүхийн хуудсыг эргүүлэх хэрэгтэй” хэмээн мэдэгдсэн байна.

75.Донор байгууллагууд ил тод байдлын шалгуурыг хангаж чадахгүй байна²⁶⁰(2014.10.10)

“Төлсөн авснаа нийтэл” байгууллага. Тус байгууллагаас гаргадаг “Тусламжийн ил тод байдлын индекс²⁶¹”-ийн 2014 оны дүнгээр дэлхийн томоохон тусламжийн байгууллагуудын хагасаас илүү хувьд нь ил тод байдлын шалгуурыг хангахгүй, хаалттай хэлбэрээр үйл ажиллагаа нь явагдаж байгааг тогтоосон байна.

Томоохон тусламжийн байгууллагууд болох Герман Улсын Гадаад харилцааны яам, Их Британийн Батлан хамгаалах яам, Францын Сангийн яам, Японы Гадаад харилцааны яамд уг индексээр доогуур үнэлгээтэй гарсан байна.

Үүнээс гадна Хятадын тусламжийн ил тод байдлын үнэлгээ 2.2 гарсан нь тус улс 2 дахь жилдээ уг индексийн хамгийн сүүлийн байрыг эзэлж байгаа дүн болоод байна.

Энэ оны индексийн дүнгээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр 90.64 үнэлгээтэйгээр АНУ-ын Мянганы Сорилтын Корпорацийг ардаа орхин тэргүүн байрт орсон нь НҮБ-ын байгууллага индексийг тэргүүлж байгаа анхны тохиолдол болоод байна.

Энэ индекст нийт 68 тусламжийн донор байгууллагуудыг хамруулсан бөгөөд тэдний 22 байгууллагын ил тод байдал “маш хангалтгүй”, 15 байгууллагын ил тод байдал “хангалтгүй” гэж үнэлэгдсэн. Эдгээрээс зөвхөн 7 байгууллага “маш сайн хангалттай”, 8 байгууллага “хангалттай” гэсэн үнэлгээ авсан байна.

Тусламжийн ил тод байдлын индекс, 2014 он

Байгууллагын нэр	Оноо	Эрэмбэ	Байгууллагын нэр	Оноо	Эрэмбэ
НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр	90.6	1	Их Британи - Гадаад яам	35.8	35
Их Британийн Олон улсын хөгжлийн агентлаг	88.3	2	АНУ-ын - Төрийн сан	34.8	36
АНУ-ын - Мянганы сорилтын корпораци	86.9	3	ОУВС	31.6	37
GAVI	86.7	4	АНУ-ын Батлан хамгаалах яам	30.8	38
Азийн хөгжлийн банк	83.8	5	Дэлхийн банк	30.6	39
Швед	83.3	6	Чех	29.5	40
Дэлхийн банк	82.3	7	Эстон	28.2	41
Африкын хөгжлийн банк	74.5	8	Норвеги	27.6	42
Америк хоорондын хөгжлийн банк	73.9	9	Португали	26.5	43
Глобаль сан	73.3	10	Франц	24.7	44
Канад DFATD	71.7	11	ЕИВ	24.6	45
ЕС-FPI	69.1	12	ЕСБХБ	24.5	46
ЕС-DEVCO	68.2	13	Австри	19.1	47

²⁶⁰ <http://www.theguardian.com/global-development/2014/oct/10/aid-donors-failing-transparency-targets-publish-what-you-fund>

²⁶¹ Aid Transparency Index

UNICEF	64.6	14	Латви	19.0	48
ЕС-ELARG	61.8	15	Бельги	18.8	49
ЕС-ECHO	59.9	16	Люксембург	18.8	50
Герман - GIZ	53.9	17	Словак	18.3	51
Швейцари	53.8	18	Словени	17.8	52
Нидерланд	53.8	19	Япон - Гадаад харилцааны яам	17.0	53
Герман - KfW банк	50.8	20	Итали	15.6	54
Испани	50.6	21	Польш	14.4	55
Дани	49.6	22	Хорват	11.8	56
Гейтс сан	46.6	23	Румын	10.6	57
Финлянд	46.3	24	Франц - Санхүү, аж үйлдвэрийн яам	10.3	58
Австрали	45.9	25	Бразил	9.6	59
Шинэ Зеланд	45.1	26	Их Британийн - Батлан хамгаалах яам	9.6	60
Ирланд	42.5	27	Герман - Гадаад харилцааны яам	9.1	61
Франц - Маеди	42.4	28	Унгар	8.3	62
НҮБ-ын ОСНА	41.3	29	Болгар	8.2	63
АНУ-ын - Pefar	40.7	30	Мальта	6.6	64
АНУ-ын USAID	40.3	31	Литв	6.5	65
АНУ	38.8	32	Кипр	5.9	66
Япон - ЖАЙКА	37.2	33	Грек	4.7	67
Өмнөд Солонгос	36.9	34	Хятад	2.2	68

76. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) том компаниуд үндэстэн дамнасан гэрээ байгуулахдаа дунджаар 14 сая ам.долларыг хээл хахуульд зарцуулдаг болохыг тогтоов²⁶²(2014.12.02)

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага. ЭЗХАХБ-аас хээл хахуулийн 400 хэрэгт дүн шинжилгээ хийсэн ба эдгээр хэргийн 57% нь төрийн худалдан авах ажиллагааны гэрээнд ялах зорилготой байжээ.

2014 оны 12 дугаар сарын 02-нд гарсан уг тайланд дурдснаар томоохон компаниудын оролцсон үндэстэн дамнасан хээл хахуулийн хэргийн дийлэнх нь өндөр хөгжилтэй улс орнуудад үйлдэгддэг ба энэ талаар тухайн компаниудын удирдлагууд нь мэдэж байдаг. Өөрөөр хэлбэл, ЭЗХАХБ-аас сүүлийн 15 жилийн хугацаанд болсон том компаниудын оролцсон хээл хахуулийн 400 хэрэгт дүн шинжилгээ хийхэд дунджаар нэг хэлцлийн үнийн дүнгийн 11 хувь буюу 14 сая ам.долларыг хээл хахуульд зарцуулсан байна.

Эдгээр хээл хахуулийн дийлэнх хувь нь хөгжиж буй улс орнуудад бус харин өндөр хөгжилтэй барууны улс орнуудын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд аливаа худалдан авах ажиллагаа, гэрээнд ялахын тулд зарцуулсан байдаг.

Тайланд дурдснаар хээл хахуулийн хэмжээ нь тухайн хэлцлээс олох ашгийн 34.5%-тай тэнцүү байдаг юм.” Тус байгууллагаас мэдээлж байгаагаар хээл хахуулийн хэрэг нууцлаг, далд явагддаг бөгөөд энэ дүн бол зөвхөн “мөсөн уулын оройн хэсэг” байж болох талтай юм.

²⁶² <http://www.theguardian.com/business/2014/dec/02/oecd-report-14m-dollars-bribes-company-dealsm>

ЭЗХАХБ-аас гаргасан энэхүү тайлан нь нийтдээ 41 улс оронд (7 улс нь ЭЗХАХБ-ын гишүүн бус боловч, ЭЗХАХБ-ын Хээл хахуулийн эсрэг конвенцид нэгдсэн) 1999 оны 2 дугаар сараас 2014 оны 6 дугаар сарын хугацаанд гадаадын төрийн албан хаагчдыг хахуульдсан компани, хувь хүмүүсийн оролцсон хээл хахуулийн хэрэгт дүн шинжилгээ хийсэн тайлан юм.

Нийт хэргийн 2/3 нь 4 салбарт гарчээ. Эдгээр салбарууд нь: Уул уурхай (19%), барилга (15%), тээвэр, агуулах (15%), мэдээлэл, холбоо (10%) юм. Нийт хэргийн 25 орчим хувь нь төрийн өмчийн компаниудын ажилтнуудад хээл хахууль амласан, өгсөн байгаа ба 11% нь гаалийн ажилтнууд байв. Харин нийт хэргийн 5 орчим хувь нь тухайн улсын өндөр албан тушаалтнуудад хээл хахууль өгсөн хэрэг эзэлж байгаа бөгөөд өндөр албан тушаалтнуудад өгсөн хээл хахуулийн хэмжээ нийт хээл хахуулийн 11%-тай тэнцүү байна.

Төрийн худалдан авах ажиллагаанд ялахын тулд хээл хахууль өгсөн хэрэг 57%-ийг эзэлж байгаа бол гаалийн хяналтыг нэвтрэх 6%, татварын хөнгөлөлт авах 6%-ийг тус тус эзэлж байна.

Нийт хэргийн 41%-д нь тухайн компанийг удирдах түвшний албан хаагчид оролцсоноос 12%-д нь гүйцэтгэх захирлын түвшний албан хаагчид оролцсон, харин доогуур түвшний албан хаагчид 3-4 хэрэгт л оролцсон байна.

“Авлига нь хөгжил, өсөлтийг зогсоож байна. Авлигад шийтгэл ногдуулж байх хэрэгтэй” хэмээн ЭЗХАХБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Анхель Гурриа энэ үеэр хэлсэн байна. Тэрээр мөн “Компанийн засаглалын хамгийн чухал асуудал бол бизнесийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал байх ёстой. Төрийн худалдан авах ажиллагаа шударга, ил тод, хариуцлагатай байх шаардлагатай байна” гэжээ.

ЭЗХАХБ-ын үзэж байгаагаар дэлхийн улс орнууд авлига, хээл хахуулийг бууруулахын тулд авлигын гэмт хэрэгт ногдуулж буй хариуцлагын (санкц) хэмжээг нэмэгдүүлэх, мөн шүгэл үлээгчдийг сайн хамгаалах хэрэгтэй байгааг дурдсан байна.

77. Вьетнамын Куанг Нгай мужид авлигын талаарх мэдээлэлд 500 ам.доллар өгнө²⁶³(2014.11.26)

Вьетнам. Вьетнамын Куанг Нгай муж дахь Коммунист намын Дотоод асуудал хариуцсан газраас авлигатай тэмцэх үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхийн тулд авлигатай холбоотой бодитой мэдээлэл, нотолгоо ирүүлсэн хүн бүрт 10 сая хүртэл вьетнам донг буюу 500 орчим ам.доллар хүртэл мөнгө өгөхөөр болсон байна. Энэ аргыг нэвтрүүлээд буй 3 дахь муж нь Куанг Нгай болоод байна.

Куанг Нгай муж дахь авлигатай холбоотой бүхий л мэдээлэл, баримт, нотолгоог дотоод болон гадаадын шүгэл үлээгчид Дотоод асуудал хариуцсан газарт өөрийн биеэр шууд болон шууд бус байдлаар Э-мэйл, факс, утас (055.3821237, 0913428304)-аар өгч болох юм.

Мэдээллийн чанар болон хэргийн шинж чанараас нь хамааруулан Дотоод асуудал хариуцсан газар мэдээлэл бүрт 500000 вьетнам донг (25 ам.доллар)-оос 10 сая вьетнам донг (500 ам.доллар) хүртэл өгөх юм. Мэдээж хэрэг мэдээллийн нууцлалыг бүрэн хангасан байна.

“Бидний хэрэгжүүлж буй энэ арга бол авлигын эсрэг иргэдийг илүү үр дүнтэй тэмцэх боломжийг олгож байгаа алхам юм” хэмээн тус мужийн Дотоод асуудал хариуцсан газрын дарга Во Тай Нгуен мэдэгдсэн байна.

²⁶³ <http://english.vietnamnet.vn/fms/society/117329/quang-ngai-province-to-pay--500-for-corruption-information.html>

Куанг Нгай мужийн намын хорооны тоон мэдээллээр сүүлийн 2 жилийн хугацаанд тус мужид намын гишүүн 113 хүнийг мөн намын 3 байгууллагыг авлигын талаарх хууль, тогтоомж зөрчсөн болохыг тогтоож, шийтгэл ногдуулсан байна.

Өнгөрсөн 6, 7 дугаар сард Лам донг болон Йен Бай мужууд уг мэдээлэл худалдан авах аргыг нэвтрүүлээд байгаа талаар мэдээлж байсан юм.

78. Авлигачдаа олоход нь Хятадад Франц тусална²⁶⁴(2014.12.02)

Франц. Тус улсын Хууль зүйн яамны Эрүүгийн асуудал хариуцсан газрын дарга Роберт Геллийн мэдэгдэж байгаагаар Хятад улсаас авлигын хэрэгт сэжиглэгдэж байгаа хүн Францын нутаг дэвсгэр дээр байгаа бол Франц Улс Хятадад туслах, хэрэгтнийг Бээжинд шилжүүлэн өгөхөд бэлэн байна.

Дарга Ши Зиньпиний удирдсан авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй “үнэгний ангууч” ажиллагааны хүрээнд Хятад Улс эх орноо орхин гарсан авлигачдыг хайсаар байгаа юм.

Роберт Гелли “Ройтерс” агентлагт мэдээлснээр Хятадын холбогдох байгууллагууд “авлигаар баяжсан, бусад улс оронд орогнохыг хүч байгаа, бохир мөнгөөрөө улс орнуудад хөрөнгө оруулалт хийсэн” хэрэгт сэжиглэгдэж буй хүмүүсийнхээ нэрсийн жагсаалтыг Францын талд өгөхөөр болсон байна.

Эдгээр жагсаалтад 10 орчим хүний нэр байж магадгүй бөгөөд тэдний 2-3 нь Францад байх боломжтой юм. Бусад хүмүүсийн хувьд Европын аль нэг улсад байгаа, гэхдээ одоо болон өмнө нь Франц Улстай холбоотой байсан хүмүүс юм гэж Роберт Гелли мэдэгдсэн байна.

Одоогийн байдлаар Хятад Улс эдийн засгийн гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа, эх орноо орхин гарсан 288 хүнийг баривчилсан хэмээн Синхуа мэдээний агентлагаас мэдээлсэн юм.

Хятадад авлигын хэрэгт сэжиглэгдэж байгаа хүмүүсийн хамгийн ихээр зорьж буй газар бол АНУ, Канад, Австрали болоод байгаа бөгөөд эдгээр улстай Хятадын тал сэжигтнийг шилжүүлэн өгөх гэрээг одоо болтол хийгээгүй юм. Хэдий тийм ч Австралийн цагдаагаас Хятадын авлигач хүмүүсийн хөрөнгийг илрүүлэх, хураах үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх болсон талаар өмнө нь мэдэгдэж байсан билээ.

79. Транспаренси Интернэшнл байгууллагаас Авлигын төсөөллийн индексийн 2014 оны дүнг зарлалаа²⁶⁵(2014.12.03)

Транспаренси Интернэшнл. Тус байгууллагаас 20 дахь удаагийн буюу 2014 оны Авлигын төсөөллийн индексийн үр дүнг 12 сарын 3-нд зарлалаа. Энэ оны индексийн дүнгээр сүүлийн хэдэн жилийн хугацаанд эдийн засгийн өсөлт нь өндөр байгаа Хятад (100 оноо авахаас 36 оноо), Турк (45), Ангол (19) зэрэг улсуудын үнэлгээ өмнөх оныхоос 4-5 оноогоор буурсан дүнтэй байна.

“Аливаа улс орны удирдагчид болон өндөр түвшний албан тушаалтнууд албан тушаалаа ашиглан төсвийн хөрөнгийг хувийн зорилгоор ашиглах явдал тухайн улс орны эдийн засгийн өсөлтийг сүйтгэж, авлигатай тэмцэх хүчин чармайлтыг үгүй хийдгийг 2014 оны Авлигын төсөөллийн индекс харууллаа” хэмээн Транспаренси Интернэшнл байгууллагын дарга Хосе Угаз хэлсэн байна.

Энэ удаагийн индексийн дүнгээр нийт 175 орныг үнэлсэн бөгөөд эдгээр улсын 121 улс буюу 2/3-аас илүү нь 50-иас доош үнэлгээтэй гарсан байна (0-авлигад автсан,

²⁶⁴ <http://www.reuters.com/article/2014/12/02/us-france-china-justice-idUSKCN0JG1IQ20141202>

²⁶⁵

http://www.transparency.org/news/pressrelease/corruption_perceptions_index_2014_clean_growth_at_risk

100-авлигагүй). Дани улс 2014 онд 92 оноогоор уг жагсаалтыг тэргүүлсэн бол тус бүр 8 оноотойгоор Хойд Солонгос, Сомали улсууд хамгийн сүүлийн байрт орсон.

Хэд хэдэн улсын үнэлгээ 4 болон түүнээс дээш хэмжээгээр өсч/буурсан дүнтэй байна. Үнэлгээ нь хамгийн их буурсан/сөрөг/ улс бол Турк (-5) болон Ангол, Хятад, Малави, Руанда тус бүр (-4) болоод байна. Харин үнэлгээ нь өссөн /ерэг/ улс бол Зааны ясан эрэг, Египет, Сент-Винсент, Гренадин (+5), Афганистан, Иордан, Мали, Свазиланд (+4) болоод байна.

Монгол Улс

Транспаренси интернэшнл байгууллагын Авлигын төсөөллийн индексийн 2014 оны дүнгээр Монгол Улс 39 гэсэн үнэлгээтэйгээр 80 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна. Өмнөх оныхтой харьцуулахад манай улсын үнэлгээ +1-ээр нэмэгдэж, эрэмбэ 3 байраар ахисан эерэг дүнтэй байна. Монгол Улсыг үнэлэхэд ашигласан 7 үзүүлэлтээс Дэлхийн эрх зүйн төслийн Хууль дээдлэх ёсны индекс 33-аас 32 буурсан хэдий ч, Дэлхийн эдийн засгийн форумын Үзэл бодлын судалгааны үр дүн 32-оос 41 болж өссөн нь ийнхүү үнэлгээ өсөхөд эерэгээр нөлөөлсөн байна.

Үүнээс гадна манай улстай адил 80 дугаар байрт Бенин, Босни Герцеговин, Эль Сальвадор, Марокко улс орсон байна.

80. Солонгосын прокурорын үйл ажиллагаа дэлхийн анхаарлыг татаж байна²⁶⁶ (2014.12.17)

Өмнөд Солонгос. Нэгэн цагт Солонгос Улсыг удирдаж байсан төрийн тэргүүний гэр бүл болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүдийг авлигын хэрэгт буруутай болохыг нь нотолж байгаа тус улсын прокурорын систем Азийн улс орнуудын анхаарлыг татах болжээ.

Сөүл хот дахь тус улсын Дээд прокурорын газар²⁶⁷-ын үйл ажиллагаатай танилцахаар 2010 оноос хойш Ойрх Дорнод болон Азийн зарим улс орнуудын төлөөлөгчид ажлын айлчлал хийгээд байгаа юм. Өөрөөр хэлбэл, зөвхөн 2014 оны байдлаар 26 улсын 136 хууль сахиулах чиг үүрэг бүхий албан хаагчид тус байгууллагын мөрдөн байцаалтын орчин болон ноу-хаутай танилцахаар ирсэн байна.

Солонгосын Дээд прокурорын газрын Эрүүгийн бодлогын хэлтсийн дарга Ким Жин-сокийн хэлж байгаагаар бусад улс орнуудаас ирж байгаа төлөөлөгчдийн зарим нь авлигатай тэмцэж байгаа Солонгосын туршлагыг сониучирхдаг бол зарим нь мөрдөн байцаалтын хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг гайхдаг байна.

“Тухайлбал, Хятадын дарга Ши Зиньпин 2013 оноос хойш авлигын эсрэг томоохон кампанит ажиллагааг эхлүүлээд байгаа бөгөөд хамгийн сүүлд зүүн-өмнөд Хятадын Фужиан мужийн прокурорууд хүрэлцэн ирсэн. Хятадын нийгмийг хамгаалах байгууллагын ажилтнуудад байдаг шиг эрүүгийн гэмт хэрэгт Хятадын прокурор мөрдөн байцаалт явуулах эрх байдаггүй гэж ойлгож байна. Хятадын төлөөлөгчдөд Солонгосын прокурорын систем буюу гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулж, цагдаагийн үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа энэ систем ихээхэн сэтгэгдэл төрүүлсэн байх” хэмээн Ким Жин-сок хэлсэн юм.

Тэрээр “Хятад Улсад нийгмийг хамгаалахын ажилтнуудыг хянах ямар ч нэгж байдаггүй гэдэг нь тэд албан тушаалын байдлаа урвуулан ашиглах хуулийн цоорхой байгааг илэрхийлж байна” гэдгийг онцолсон юм.

Өмнөх ерөнхийлөгчдийн гэр бүл болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүдийн үйлдсэн авлигын хэргийг илрүүлэхэд ихээхэн бэрхшээлтэй байдаг байсан бол прокурорт бүх эрх мэдэл шилжсэн энэ систем ихээхэн үр дүнтэй байгаа. Өмнө нь

²⁶⁶ https://www.koreatimes.co.kr/www/news/people/2014/12/178_170855.html

²⁶⁷ Supreme Prosecutors' Office

Солонгос Улсад өндөр түвшний авлигын хэрэг болон улс төрийн намын санхүүжилттэй холбоотой авлигын хэргийг Мөрдөн байцаах газарт шалгадаг байсан ба энэ чиг үүрэг прокурорт бүрэн шилжсэн юм.

Авлигын эсрэг тэмцэж буй Солонгосын прокурорын энэхүү систем Тайланд Улсын прокурорынхны анхаарлыг мөн ихээхэн татдаг.

2010 оноос хойш жил бүр Тайланд Улсаас олон тооны прокурор ирж өндөр түвшний авлигын гэмт хэрэгтэй тэмцэж буй Солонгосын прокуроруудын туршлагаас суралцаж байна.

Солонгосын прокуроруудын туршлага мөн Азийн бусад улс орнуудын анхаарлыг ч мөн татсаар байна. Өнгөрсөн онд Саудын Араб, Оман зэрэг улсын төлөөлөгчид мөн туршлага судалсан байна.

Авлигын гэмт хэрэгт орчин үеийн технологи ашиглах замаар гэмт хэрэг улам бүр боловсронгуй хэлбэртэй болж байгаатай уялдуулан Дээд прокурорын газрын хэргийн талаар нотлох баримт цуглуулах болон түүнд шинжилгээ хийх дижитал төхөөрөмж болон тусгай тоноглогдсон машины үйл ажиллагаа, шинжилгээний төвийн хамгийн сүүлийн үеийн арга техникүүдийг бусад улсын төлөөлөгчид ихээхэн сонирхдог хэмээн Ким Жин-сок хэлсэн байна.

2008 онд Дээд прокурорын газар нь дэргэдээ орчин үеийн технологийн өөрчлөлттэй уялдах байдлаар Үндэсний дижитал шинжилгээний төв²⁶⁸-ийг байгуулсан байна. Уг төвд хэргийн баримт, нотолгоонд дүн шинжилгээ хийх хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг ашиглан мэргэшсэн прокурор, салбар бүрээс өндөр мэргэжлийн шинжээчдийг авч ажиллуулдаг байна.

81.Хятадын авлигатай тэмцэх байгууллага 2015 оноос гар утасны аппликейшн ашиглахаар төлөвлөж байна²⁶⁹ (2014.12.28)

БНХАУ. Хятадын Сахилгын хяналтын төв хороо 2015 оны 1 дүгээр сараас тус улсын авлигын эсрэг кампанит ажиллагаанд оролцогчдын тоог өргөжүүлэх зорилгоор шинээр гар утасны аппликейшн ажиллуулж эхлэхээр болжээ. Хятадын Коммунист намын Сахилгын хяналтын төв хорооны цахим хуудсан дахь мэдэгдэлд дурдснаар уг аппликейшн нь Коммунист нам болон Засгийн газрын авлигын эсрэг үйл ажиллагаа болон авлигын гэмт хэргийн явцын талаар онцлог мэдээллүүдийг тухай бүр хэрэглэгчдэд хүргэж байх юм.

Өнгөрөгч 9 дүгээр сард цахим ертөнцөд үйл ажиллагаагаа эхлүүлсэн Сахилгын хяналтын төв хорооны албан ёсны цахим хуудас одоогийн байдлаар хандалт ихтэй цахим хуудасны нэг болоод байгаа юм. Тус цахим хуудсаар өндөр түвшний “бар” болон доогуур түвшний “ялаа” нарын авлигын хэргийн талаар тухай бүр мэдээлж байгаа юм.

Хятадын интернэт хэрэглэгчдийн ихэнх хэсэг нь тус цахим хуудсыг авлигын эсрэг кампанит ажлын талаарх мэдээллийг цаг тухай бүр хүргэдэг, хамгийн итгэл хүлээсэн цахим хуудас хэмээн үзэх болсон байна. Сахилгын хяналтын төв хорооноос бэлтгэсэн телевизийн нэгэн баримтат нэвтрүүлэгт дурдснаар тус байгууллага нөлөөллийн хүрээгээ улам бүр өргөжүүлэхийн тулд авлигач албан тушаалтнуудын талаарх мэдээллийг тодорхой цагт хэрэглэгчдэд хүргэдэг байна.

²⁶⁸ National Digital Forensic Center

²⁶⁹ http://news.xinhuanet.com/english/china/2014-12/28/c_133883455.htm

82. Хятадын тал хууль бус хөрөнгөө буцаан авах зорилгоор АНУ-тай гэрээ байгуулахаар ажиллаж байна²⁷⁰ (2014.12.29)

БНХАУ. Хятад Улс авлигын кампанит ажлынхаа хүрээнд хууль бусаар олсон хөрөнгөө хилийн чанадад байршуулсан авлигач албан тушаалтнуудын эсрэг АНУ-тай гэрээ байгуулан ажиллахаар төлөвлөж байна хэмээн тус улсын төрийн мэдээллийн хэрэгслээр мэдээллээ.

Хятад Улс “Үнэгний ангууч”²⁷¹ ажиллагааны хүрээнд өөрийн хил хязгаараас аль хэдийн гараад байгаа албан хаагч, бизнес эрхлэгчид болон тэдний хууль бус хөрөнгийг эрэн хайсаар байгаа юм.

Гэвч барууны улс орнууд гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх гэрээг Хятад Улстай байгуулахаас зайлсхийж байгаа юм. Учир нь тус улсын шүүхийн системийн шударга байдалд ихээхэн шүүмжлэлтэй байдаг юм. Үүнээс гадна хүний эрхийн байгууллагууд авлигын гэмт хэрэгтэнд цаазаар авах ял оногдуулах, хууль сахиулах байгууллагууд нь хүний эрхийг зөрчих явдал түгээмэл байна хэмээн үздэг билээ.

“Чайна Дэли” агентлагийн мэдээлж байгаагаар Хятадын Ардын банк, АНУ-ын Сангийн яамны Санхүүгийн гэмт хэргийг илрүүлэх сүлжээ (FinCEN)-ээр дамжуулан АНУ дахь хууль бус хөрөнгийг буцаан авах талаар хэлэлцээр хийж байгаа.

FinCEN-ийн хэвлэлийн төлөөлөгч Стефан Худак Хятадын талтай гэрээ байгуулахаар хэлэлцээр хийж байгаа эсэхэд тайлбар өгөхөөс татгалзсан юм. Тэрээр “авлига, мөнгө угаах болон санхүүгийн террористуудаас санхүүгийн системээ хамгаалахыг тулд гадаад улс орнуудын ижил төстэй байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох байдлаар ажиллаж байгаа” гэжээ.

Хятадын төрийн мэдээллийн хэрэгслээр тус улс үүнтэй ижил төрлийн гэрээг өнгөрөгч оны 12 дугаар сарын эхээр Канад Улстай байгуулсан талаар мэдээлж байсан юм. “Чайна Дэли”-ээс мэдээлж байгаагаар Хятадын Ардын банк энэ төрлийн гэрээг Австрали Улстай мөн байгуулахаар ажиллаж байгаа аж.

83. Сингапур Улсын хөгжсөн шалтгаан нь авлигын эсрэг тэмцэж чадсанд оршино²⁷²(2014.12.03)

Сингапур. Авлигын эсрэг тэмцэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж буй Сингапур Улсад бусад улс орны бодлого боловсруулагчид анхаарлаа хандуулах цаг нь иржээ.

Транспаренси Интернэшнл байгууллагаас жил бүр гаргадаг Авлигын төсөөллийн индексийн 2014 судалгаагаар 7 дугаар байрт жагссан тус улсын хөгжиж буй түүх нь бусад улсынхтай л адил юм.

1965 он хүртэл колонийн дарангуйлал доор байсан тус улс арав гаруй жил үргэлжилсэн бослогын дараа бүрэн бие даасан улс болж, нийгмийн шилжилт хийж чадсан юм. Үүнээс гадна өндөр хөгжсөн тус улс өмнө нь өнөөгийн хөгжлийн замдаа дөнгөж орж буй улс орнуудын л нэгэн адил маш муу эдийн засгийн тогтолцоо, боловсролын түвшин доогуур ард иргэдтэй байсан. Хүчтэй бодлогоор авлигыг хазаарлаж чадснаар хүчирхэг эдийн засгийн тогтолцоотой болж, ард иргэдээ ядуурлаас гаргаж чадсан нь ийнхүү бусад улс орнуудын сонирхлыг нь татах болжээ. Гэвч Сингапур Улсын энэхүү хөгжлийн зам нь бусад улсын хувьд туршлага болох эсэх нь эргэлзээтэй юм.

²⁷⁰ <http://www.reuters.com/article/2014/12/29/us-china-corruption-idUSKBN0K706A20141229>

²⁷¹ "Fox Hunt

²⁷² <http://globalanticorruptionblog.com/2014/12/03/just-how-relevant-for-developing-nations-is-singapores-experience-combating-corruption/>

Нэн тэргүүнд, өнөөгийн хөгжиж буй улс орны хувьд ядуу улсаас хөрөнгөтэй улс болж шилжих алхам хамгийн хүч шаардсан, төвөгтэй асуудал болоод байгаа. Харин колонийн дэглэмээс бие даасан улс болж, харьцангуй буурай хөгжилтэй байсан тус улсын хувьд хүн ам нь англи хэлээр ярьдаг, худалдааны төв бүсэд байдаг нь давуу тал болж эдийн засаг нь хурдацтай өссөн байна. Ядуу буурай улсаас хөрөнгөтэй улс болон шилжих тухайн цагт тус улсад авлигатай тэмцэх л тулгамдсан асуудал болоод байжээ. Улмаар АНУ болон баруун Европын улсуудын түүхийг эргэж харахад тэд ч бас авлигатай тэмцэх талаар дорвитой алхам хийж чадаагүй байжээ. Тэд баян улс болсныхоо дараа л авлигыг /их, бага хэмжээгээр/ дарж чадсан байна.

Нэгэнт хөрөнгөтэй улс төрийн албан хаагчиддаа өндөр цалин өгч, ингэснээр хээл хахууль авахыг бууруулж, авлигын эрч хүчийг сааруулж чадсан туршлага тус улсад бий. Дээрх арга хэмжээг аваагүй бол тус улсын хөрөнгөөс засгийн газрын ажилтнууд хууль бус замаар хуримтлал бий болгож, улмаар тус улсын хөгжилд аюул учрах байж.

Сингапур Улсын авлигатай амжилттай тэмцэж чадсан хамгийн чухал хүчин зүйл нь гүйцэтгэх засаглалыг нэг намын хүчтэй бодлогоор барьж байсанд оршиж байна. Ашиг сонирхлоороо нэгдсэн олон бүлэглэлийг тараах “улс төрчдийн шийдвэр” нь авлигын эсрэг авах арга хэмжээг зөв замд нь оруулжээ.

84. ОХУ-ын 3 албан тушаалтан тутмын 1 нь авлига, хээл хахууль авч байна²⁷³(2014.12.09)

ОХУ. Тус улсын Үндэсний Авилгын эсрэг хороо²⁷⁴-ны дарга Кирилл Кабанов “Манай улсын 3 албан тушаалтан тутмын 1 нь авлига, хээл хахуультай холбоотой байгаа нь орон нутагт тархсан авлигатай тэмцэх арга хэмжээ авахад маш их бэрхшээлтэй байна. Төрийн албан тушаалтнуудын бараг 30 хувь нь хээл хахуульд автагдсан” гэж хэлсэн байна.

1990-2000 оны хооронд ОХУ-д бага цалинтай, хяналтын тогтолцоо муу, албан тушаалтнууд хахууль авч орлого олдог байсан ужгирсан уламжлалаасаа ангижрахын тулд тэмцээр байгаа боловч төдийлөн үр дүнд хүрэхгүй байна.

Авлигын эсрэг хорооны дарга Кирилл Кабановын хэлснээр хамгийн түрүүнд тулгамдаад байгаа асуудал бол бизнесийн хүрээний авлига, энэ хүрээний авлигыг устгахгүй бол хээл хахуульд автсан төрийн албан тушаалтнуудтай тэмцэх нь ямар ч боломжгүй зүйл болж байна.

Түүнийг ийнхүү мэдэгдэл гаргахаас ердөө нэг хоногийн өмнө ерөнхийлөгчийн захиргааны албаны дарга Сергей Иванов “Хээл хахуулийн эсрэг тэмцэлд амжилт гарч байгаа, ОХУ-ын төрийн албан тушаалтнууд өөрсдөд нь хээл хахууль санал болгож буй хүмүүсийн талаар мэдэгдэх нь нэмэгдэж байна. Бид энэ жил 3000 гаруй хээл хахууль өгөх гэсэн хүмүүсийн талаарх гомдол хүлээн авсан нь төрийн албан тушаалтнуудын дунд хариуцлага нэмэгдэж байгааг харуулж байна” гэж мэдэгдсэн байна.

85. Өндөр түвшний авлигатай хэрхэн тэмцэх вэ?²⁷⁵(2014.12.05)

Египет. Тус улсын шүүх тус улсын ерөнхийлөгч асан Хосни Мубаракын холбогдсон улсын хөрөнгөнөөс ойролцоогоор 1.2 тэрбум ам.доллар хулгайлсан гэх авлигын хэргийг хэрэгсэхгүй болгож шийдсэн байна.

Авлигын тэр дундаа өндөр түвшний авлигын гэмт хэрэгтнүүд олноороо нийгэмд чөлөөтэй алхсаар л байна. Хосни Мубарак шиг хүмүүст улсынхаа, ард иргэдийнхээ мөнгөнөөс хулгайлаад ямар үр дагавар гарах нь сонин биш. Тэд иргэдийнхээ төлөө

²⁷³ <http://www.themoscowtimes.com/business/article/one-in-3-russian-officials-is-corrupt/513033.html>

²⁷⁴ National Anti-Corruption Committee

²⁷⁵ http://www.huffingtonpost.ca/priya-sood/mubarak-corruption_b_6275886.html

ажиллана гэж амлан төрийн өндөр албан тушаалыг хашдаг ч үнэн хэрэгтээ өөрсдийн байдал, эд хөрөнгөө л нэмсэн байдаг.

Өндөр түвшний авлига үнэндээ өнөөдөр дэлхийг дарангуйлж байна.

Иргэд болон албан байгууллагууд авлигын эсрэг бэхжүүлэх арга хэмжээг тал бүрээс хэрэгжүүлж байгаа сайхан мэдээ байна. Олон улсын хамтын нийгэмлэг 2015 болон цаашид хэрэгжүүлэх тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэвшүүлж байна. Иргэний нийгмийн байгууллагууд нийлж засаглалын зорилтыг тодорхойлж байна. Үнэн хэрэгтээ 2014 онд Нээлттэй нийгмийн хүрээлэн тогтвортой хөгжлийн зорилтуудыг үр дүнтэй, хариуцлагатай, хүртээмжтэй гэж тодорхойлсон. Дэлхийн иргэд ч бас тэдний төлөө дуу хоолойгоо нэгтгэж байна. НҮБ-ын судалгааны үр дүнгээр “Шударга, хариуцлагатай, ажил хэрэгч Засгийн газар” гэсэн тогтвортой хөгжлийн зорилтыг дэвшүүлсэн. Хамгийн сонирхолтой нь, Засгийн газар нь анх удаа авлига, хээл хахуулийн асуудлыг шийдвэрлэх талаар засаглалын зорилгодоо тусгаж, авч хэлэлцэж байна.

Гэсэн хэдий ч өндөр түвшний авлигатай тэмцэх маш ирээдүйтэй алхмууд байгаа ч, юу хийж хаанаас эхлэхээ мэдэхгүй байна.

86. Малайзын Авлигын эсрэг комисс бүтцийн авлигад дайн зарлав²⁷⁶(2014.10.19)

Малайз. Ликёр, тамхины хууль бус наймаанд оролцож байсан Гаалийн газрын дарга болон зарим нэг албан хаагчийг баривчилснаар Малайзын Авлигын эсрэг комисс бүтцийн авлигатай тэмцэх шийдвэр гаргалаа. Тус газрын урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн орлогч дарга Датук Мустафар Али “авлигын төрөл дотор нэлээд хүндэд ордог, авлигаар олж буй мөнгө нь ч их, бүтцийн, эсхүл зохион байгуулалттай авлига гэдэг нь хэсэг нэгжээрээ, эсхүл газар, хэлтэс бүхэлдээ авлигаар ашиг олохоор үгсэн тохиролцож үйлдэх явдал” гэж хэлсэн байна. Хэдийгээр Малайз Улсад авлига халдварт өвчний түвшинд хүрээгүй ч одоо л арга хэмжээ авахгүй бол асуудал хүндрэх төлөвтэй байгааг тэмдэглэжээ. Малайз дахь зохион байгуулалттай авлигын асуудал Индонез, Энэтхэг Улсын түвшинд хүрээгүй ч Авлигын эсрэг комисс нь цагдаагийн байгууллага болон бусад хууль хяналтын байгууллагуудтай хамтын ажиллагааг зохицуулах зэрэг зохих арга хэмжээ авч асуудлыг эрт шийдвэрлэхээр ажиллаж байна хэмээн хятад хэлээр өдөр тутам гардаг Наньян Сян Пау сонинд ярилцлага өгөхдөө тэрээр дурдсан байна. Бид дараагийн долоо хоногт Цагдаагийн байгууллагын ерөнхий хянагч Тан Шри Халид Бакартай уулзаж тэдний хэрэгжүүлж буй арга хэрэгсэл, стратегитэй танилцан тэдний нөхцөл байдлыг ойлгож авах юм. Тухайлбал, шинээр байгуулагдсан Стандартын хяналт, шударга байдлын хэлтсийн үйл ажиллагаа гэх мэт. Тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй зөвхөн байгуулаад (Стандартын хяналт, шударга байдлын хэлтэс) орхиж болох талтай тул бид цагдаагийн стратегиудыг мэдэж байх хэрэгтэй юм. Нөгөө талаас Малайзын 2010 онд батлагдсан Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хятад гаралтай малайзууд төдийлөн итгэл үнэмшилтэй хандаж чадахгүй, илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх, эсхүл шүүхэд гэрчээр оролцохыг хүсэхэд дэмжиж ажиллахгүй байгааг Мустафар онцлов. Малайзад 4 жилийн өмнөөс тус хууль хэрэгжиж эхэлсэн ба Авлигын эсрэг комисст 39 хүн гэрч болж байсныг тэрээр тэмдэглэв. Тэрээр гэрчийг төр хамгаалах үүрэгтэй тул хятадууд Авлигын эсрэг комисст итгэх хэрэгтэй гэдгийг онцлов.

²⁷⁶ <http://www.thesundaily.my/news/1203332>

87. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд авлигатай тэмцэхэд чухал үүрэгтэй²⁷⁷(2014.10.23)

Индонез. Авлигатай тэмцэхэд олон нийтийн хэвлэлүүд маш чухал үүрэгтэй хэмээн шинжээч мэдэгдэв. “Зөвхөн олон нийт л авлигыг хянаж, авлигаас урьдчилан сэргийлж чадна. Тухайлбал, гэр бүлээрээ авлигад өртөж авлигачид болсон олон жишээг бид харсан. Нөхөр, эхнэр, хүүхдүүд нь бүгд авлигын хэрэгт хамт оролцсон” хэмээн Авлигатай тэмцэх газрын орлогч дарга Бамбанг Виджожанто ярилцлагын үеэр мэдэгдсэн. Тэрээр орон нутгийн хэвлэлийн хэрэгслүүд олон нийтэд авлигын эсрэг боловсрол олоход туслалцаа үзүүлэх хэрэгтэй байгааг дурдаад, тухайлбал, тосгон дахь радиостанц гэх мэт Индонезийн олон нийтийн хэвлэлийн хэрэгслүүд авлигын эсрэг дуу хоолойг хүргэж байх хэрэгтэй байна. Авлигын эсрэг комисс болон Индонезийн радио сүлжээтэй хамтран авлигатай тэмцэх чиглэлээр соён гэгээрүүлэх хөтөлбөр боловсруулсан байна. Ихээр тархсан авлигаас хохирогч индонезийн иргэд хамтран авлигатай тэмцэх шаардлагатай байгааг Бамбанг онцолсон. Авлигатай тэмцэх төрийн бодлогын нэг сул тал бол олон нийтийг энэхүү ажилд төдийлөн сайн татаж оруулаагүйд оршиж байна. Гэтэл бусад нийгмийн үр дагавраас гадна тус үзэгдлийн улмаас төр ихээр алдагдалд орж байна. Жишээ нь, эрүүл мэндийн салбар дахь авлигын улмаас эрүүл мэндийн сайн тусламж авч чадаагүйгээс эхийн эндэгдэл өсөх магадлал өндөр юм. Авлигын эсрэг комисс байгуулагдан үйл ажиллагаа явуулсан 10 жилд 248 триллион рупий буюу 20.58 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний төрд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлсэн байна. Авлигын эсрэг комисс болон Индонезийн радио сүлжээтэй хамтарч ажилласнаас хойш радиогийн ажилтнууд болон тэдний сонсогч нар авлигыг ойлгодог болсон хэмээн Индонезийн радио сүлжээний захирал Синам М.Сутарно тэмдэглэлээ. Индонезийн 17 бүс нутагт олон нийтийн хэвлэлийн 423 радио байдаг ба нэг хэсэг, нэг тосгон, эсхүл нэг бүлэгт ойролцоогоор 250 сонсогч байдаг байна. “Авлигын ойлголттой болсноор жишээ нь, тосгоны оршин суугч тосгоны захиргааны албан хаагчдаас асуулт асуух зоригтой болсон байдаг. Тосгоны хурлыг шууд радиогоор дамжуулдаг” хэмээн Синам яриу.

88. Дотоод хэргийн сайд Тайланд Улсын бүх газар нутгаас авлигатай холбоотой гомдол хүлээн авах төв байгуулахаар болов²⁷⁸(2014.11.17)

Тайланд. Дотоод хэргийн сайд генерал Анупонг Паожинда²⁷⁹ тус улсын бүх нутгийг хамруулсан авлигын хэрэг шалгах хороо байгуулахаар болсон байна. Ингэснээр хүмүүс авлигын асуудалтай холбоотой гомдлыг Дамгонгам (Damrongtham) төв болон түүний Тайландын нутаг дэвсгэр дэх бүх салбаруудаар дамжуулан өгч болох юм байна. Авлигын гэмт хэрэг нь хүнд гэмт хэрэг бөгөөд ялангуяа, орон нутагт чухал хэмээн генерал мэдэгдсэн байна. Авлигын хэрэг шалгах хороо нь дүүргийн дарга, мужийн амбан захирагч нартай холбоотой гомдлыг шалгах юм. Иргэд засгийн газрын төслүүдтэй холбоотой ч гомдол өгч болно. Авлигын асуудалд буруутай хэн ч байсан хуулийн дагуу хариуцлага хүлээх болно хэмээн генерал онцолсон байна.

89. Гадаадынханд хээл хахууль өгөх асуудлыг олон засгийн газар шийдэж чадахгүй байна²⁸⁰(2014.10.23)

Транспаренси интернэшнл. Зөвхөн 4 улс гадаадын төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн компаниудыг шалгаж шийтгэл ногдуулах асуудлыг идэвхтэй хийж байна

²⁷⁷ <http://www.thejakartapost.com/news/2014/10/23/community-media-important-fighting-corruption-kpk.html>

²⁷⁸ http://thainews.prd.go.th/centerweb/newsen/NewsDetail?NT01_NewsID=WNPOL5710220010010

²⁷⁹ Anupong Paojinda

²⁸⁰ <http://www.trust.org/item/20141023172817-ohl3n>

хэмээн Транспаренси интернэшнл байгууллагын гаргасан судалгааны тайланд дурдагджээ. Гадаадын төрийн албан хаагчдад хээл хахууль өгөх асуудлыг гэмт хэрэгт тооцох тухай конвенцид нэгдэн орсон 41 улсын талаас илүү хувь нь тус асуудалтай тэмцэж чадахгүй байна. Эдгээрт Япон, Өмнөд Солонгос, Голланд болон гол экспортлогч орнууд багтаж байна. Газар нутагтаа үйл ажиллагаа эрхлэн, татвараа төлж, ажлын байр бий болгож байгаа ч гадаад улсад хээл хахууль өгч буй ихэнх улс орны засгийн газруудад улс төрийн хүсэл зориг дутагдаж байна хэмээн Транспаренси интернэшнл байгууллагын судалгааны тайланг боловсруулагчдын нэг Адам Фолдс ярьсан байна. Арав дахь удаагийн тайланд дурдагдснаар АНУ, ХБНГУ, Англи, Швейцари гэсэн 4 улс тэргүүлэн ажиллаж байна. Хил дамнасан хээл хахууль цэцэглэж байгаагийн нэг шалтгааныг мөрдөн байцаагчид шалгах нөөц хүрэлцэхгүй байгаатай холбож байна. Улс төрийн хүсэл зориггүй байна гэдэг нь хууль хяналтын байгууллагууд хангалттай хөрөнгө нөөцгүй байгаатай холбоотой гэжээ. Ямар төрлийн эрүүгийн гэмт хэрэг шалгаж, яллах гэж байгааг тодруулахад мөн бэрхшээлтэй тулгардаг. Учир нь гадаад улсад болж буй гадаадын төрийн албан хаагчдыг хээл хахуулийн хэргийг шалгах асуудал маш хэцүү байдаг. ЭЗХАХБ-ын Хээл хахуулийн эсрэг конвенцийн гишүүн улсууд нь дэлхийн экспортын гуравны нэгийг үйлдвэрлэгч болон шууд хөрөнгө оруулагч нарын бараг 90 орчим хувийг эзэлдэг хэмээн Транспаренси интернэшнл байгууллага мэдэгдэв. Хээл хахуулиар бизнес хийх нь сайн нийлүүлэгч нарыг гэрээлж чадахгүй болох, хууль бус төлбөрийг нөхөхийн тулд үнэ хэт өндөр болох, татвар бүрдүүлж чадахгүйд хүрэх, байгаль орчныг бохирдуулах зэрэг дэлхийн хөгжилд хохирол учруулдаг байна. Шинэ ажлын байр бий болгох, эсхүл боловсролд зарцуулах хангалттай хөрөнгө байдаггүй учир эдгээр хохирол нь хөгжиж буй орнуудад илүүтэйгээр тод харагддаг. Тэгэхдээ хээл хахууль бизнест ч хохирол учруулдаг. Урт хугацаандаа гадаадад хээл хахуулиар бизнес эрхэлж буй компаниуд сул, өрсөлдөх чадвар буурах аюултай юм. Хэрэв тэдгээрийн бүтээгдэхүүн хангалттай сайн байсан юм бол тэд хээл хахууль өгөөд байх шаардлага байхгүй юм. Конвенцийн дагуу өөрсдийн үүргээ биелүүлж чадахгүй байгаа улс орнууд авлигаас ангид дэлхийн худалдаа бий болгоно гэсэн зорилгодоо хүрч чадахгүй юм хэмээн тайланд онцолсон байна. Улс болгон өөрсдийн хууль хяналтын үйл ажиллагааг идэвхжүүлж болно. Ингэхийн тулд хууль хяналтын салбарт хөрөнгө мөнгө төсөвлөж, дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Эдгээр байгууллагууд энэ ажлыг хийх чадвартай ч хийхгүй байгаа юм гэсэн байна. Өнгөрсөн жилийн үр дүнтэй харьцуулахад зөвхөн Канад, Шинэ Зеланд гэсэн 2 улс гадаадын төрийн албан хаагчдад хээл хахууль өгөх асуудалтай тэмцэх ажилд үр дүнг сайжруулж чадсан бол Болгар, Дани улс тус үзүүлэлтийг бууруулсан байна. Бүртгэлийн байгууллагуудад шаардлагатай өөрсдийн жинхэнэ хөрөнгө оруулагчдаа ил болгох тухай компаниудад тавьж буй шинэ шаардлага илүү чухал гэж тайлан онцолсон байна. Учир нь компаниудын хөрөнгө оруулагчдын нэрсийг нууц байлгах нь мөнгө угаахад ашиглагддаг ба гадаадын төрийн албан хаагчдад хээл хахууль өгөхийг таслан зогсоох явдлыг улам хэцүү болгодог гэжээ.

90. Авлигын эсрэг тэмцэл дэх их сургуулиудын үүрэг²⁸¹ (2014.11.13)

Их сургуулиудын Компостелагийн холбоо. Их сургуулиудын Компостелагийн холбоо²⁸²-ны гишүүн 68 их сургууль, мөн түүнчлэн Дэлхийн их сургуулиудын консорциум²⁸³, их сургуулиудын 700 гаруй профессорыг эгнээндээ нэгтгэсэн Урлаг, шинжлэх ухааны дэлхийн академи²⁸⁴ зэрэг байгууллагууд хамтран өнгөрөгч 9 дүгээр

²⁸¹ <http://www.universityworldnews.com/article.php?story=20141113110707222>

²⁸² The Compostela Group of Universities

²⁸³ The World University Consortium

²⁸⁴ The World Academy of Art and Science

сард нэгэн тунхаглал гаргалаа. Энэхүү тунхаглалын зорилго нь дээд боловсролоор дамжуулан ёс зүйн болон авлигын эсрэг боловсрол олгох явдал юм.

Дээд боловсролын салбарынхан энэхүү Познаны тунхаглал²⁸⁵-ыг баталснаараа засгийн газрууд, бизнесын салбар, иргэний нийгмийн авлигын эсрэг хийж буй тэмцэлд нэгдэж нийлэх анхны алхам нь болов. Үнэхээр ч цаг нь болсон байлаа.

Авлигын эсрэг тэмцэл идэвхтэй өрнөж эхэлсэн 1990-ээд оны дунд үеэс олон тооны тайлан илтгэл гарч, гэрээ конвенц, эрх зүйн акт батлагдсан билээ. Эдгээр нь бүгд ил тод, шударга, хариуцлагатай байдлыг сахин хангах, түгээн дэлгэрүүлэх зорилгыг агуулсан бөгөөд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Хээл хахуулийн эсрэг конвенц²⁸⁶, Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенц²⁸⁷, Европын холбооны авлигын эсрэг тайлан²⁸⁸ зэргийг жишээ татаж болно.

Авлигын эсрэг шинэчлэл, үйл ажиллагааг харьцангуй өргөн хэмжээгээр хэрэгжүүлсэн хэдий ч 1996 оноос хойш 21 улсын авлигын түвшин тодорхой хэмжээгээр буурч, 27 улсын түвшин нэмэгдээд байна.

Үзэл санааны шинэ хандлага хэрэгтэй байгааг хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага²⁸⁹, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага²⁹⁰, Европын Холбооноос саяхан хийсэн судалгаанууд нь хүн амын эрүүл мэнд, сайн сайхан байдалд олон янзын нийгмийн хүчин зүйлүүд хүчтэй нөлөө үзүүлдэг болохыг харуулж байна.

Авлига болон ёс зүйн хувьд тэвчишгүй зуршил, зан авираас амжилттай урьдчилан сэргийлэхийн тулд ял шийтгэл хүлээлгэх болон төрийн албадлагын бусад арга хэмжээ хэрэглэхийн зэрэгцээ бид авлигач, хууль бус, нийгэмд харш зан авирыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийг судалж ойлгох²⁹¹, задлан шинжлэх²⁹² шаардлагатай байна.

Их сургуулиудын хичээлийн хөтөлбөр²⁹³ нь авлигач, нийгэмд харш зан авирыг үл тэвчих үзэл санааг түгээн дэлгэрүүлэх агуулгаар дутагдаж байгааг цохон тэмдэглэх нь чухал байна.

Дээд боловсролын салбар дахь эдгээр асуудлуудыг зайлшгүй шийдвэрлэх тодорхой шалтгаанууд байгаа юм.

Нэгдүгээрт, авлига бол дэлхий нийтийн хэмжээнд ардчилал, эдийн засгийн баялаг, хүмүүсийн сайн сайхан байдалд аюул занал учруулж буй гол хүчин зүйлүүдийн нэгд тооцогдож байна.

Хоёрдугаарт, доод болон дээд түвшний²⁹⁴ авлигын аль аль нь мөнгөөр илэрхийлэгдэх шууд хохирол учруулахын зэрэгцээ нийгмийн итгэлцлэлийг бууруулж, нийгэм дэх хэм хэмжээг гажуудуулж байна. Нийгмийн гишүүдийн хамтран хэрэгжүүлж буй ихэнх үйл ажиллагааны явцад нийгмийн итгэлцэл зайлшгүй шаардагддаг. Тиймээс нийгмийн итгэлцэл алдагдах нь эргээд улс орнуудын төрийн татвар хураах чадавхийг бууруулах үр дагавартай.

Гуравдугаарт, аливаа нийгэм авлигажсан тогтолцоо болон ёс суртахуунгүй байдалд автсанаар эдийн засгийн хямралд орох нөхцөлийг бий болгодог. Эдийн засаг, санхүүгийн хямралын цаад шалтгаан нь юу ч байлаа гэсэн олон тооны засгийн газар хямралын үед хэмнэлтийн горимыг хэрэгжүүлдэг.

²⁸⁵ The Poznan Declaration

²⁸⁶ The OECD Anti-Bribery Convention

²⁸⁷ The United Nations Convention against Corruption

²⁸⁸ The European Union Anti-Corruption Report

²⁸⁹ World Health Organization

²⁹⁰ International Labour Organization

²⁹¹ To understand

²⁹² To challenge

²⁹³ curricula

²⁹⁴ Petty and grand corruption

Эдийн засгийн хямрал болон хэмнэлтийн горим нийлээд ажилгүйдэл, ядуурал, тэгш бус байдлыг хөөрөгдөх бөгөөд эдгээр нь эргээд шууд болон шууд бус байдлаар үй олныг хамарсан өвчин зовлон, үхэл хагацал, зовиур шаналалд хүргэдэг.

Мөн түүнчлэн хямралын уг шалтгаантай ямар нэг холбоогүй хүмүүст хэмнэлтийн горим хүнд цохилт болдог бөгөөд улмаар энэхүү нөхцөл байдал нь манай ардчилсан тогтолцоон дахь итгэлцэл²⁹⁵, хууль ёсыг хүндэтгэн дагах²⁹⁶ үзлийг сулруулдаг.

Сөрөг эргэх холбоо²⁹⁷-ны улмаас дээрх нөхцөл байдал нэлээд төвөгтэй нийгмийн мухардал²⁹⁸ бий болгодог бөгөөд түүнээс мултарч гарахад маш хэцүү байдаг. Нобелийн шагналт Элинор Остром²⁹⁹-ийн анхааруулан хэлснээр учир шалтгаан, мэдлэгт суурилсан үзэл санаа³⁰⁰-г өрөөсгөлөөр шүтсэнээс болоод дээд боловсролын тогтолцоог оролцуулаад нийгэм бүхэлдээ нийгмийн мухардлаас үүдэн гарч буй асуудлуудыг зөвөөр тунгаан шийдвэрлэж чадах чадваргүй үй олон хувь хүмүүсийг бий болгосон байна.

Өнөөгийн боловсролын тогтолцоо нь хувийн явцуу ашиг сонирхолдоо хөтлөгдсөн хүмүүсийг бөөн бөөнөөр нь бэлтгэн гаргаж байгааг өөрчлөн илүү их холистик хандлагыг нэвтрүүлэх шаардлагатай. Нийгмийн үнэт зүйл, түүнчлэн бүх нийтийн эрүүл мэнд, хөгжил дэвшлийг түгээн дэлгэрүүлэхийн төлөө чармайн зүтгэх ёс зүй, авлигын эсрэг үзэл санаа энэхүү хандлагад чухал байр суурь эзлэх юм.

Итгэлцлэл бол эдийн засгийн үр ашигтай байдал болон өсөлттэй нягт холбоотой ойлголтоос үүдэлтэй нийгмийн үнэт зүйлд тооцогдох ёстой.

Нийгмийн үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэхийн тулд бид өнөөгийн нөхцөл байдлыг бий болгосон шалтгааны цаана бүр угт нь байгаа үндсэн шалтгаанд анхаарал хандуулах ёстой. Эдгээр нь авлигач зан үйлийг нөхцөлдүүлэгч хүчин зүйлүүд юм. Тэрхүү зан үйл нь төрийн болон хувийн хэвшлийн янз бүрийн түвшин дэх шийдвэр гаргагчдын эрхэмлэх үнэт зүйлийн үнэлэмжээс угшилтай байдаг. Тэдгээр шийдвэр гаргагчдийн ихэнх нь их сургуульд боловсрол эзэмшдэг билээ.

91. Украины улс төрчдийг худлыг илрүүлэх төхөөрөмжөөр шалгана³⁰¹(2014.11.18)

Украин. Тус улсын Батлан хамгаалахын сайд Стефан Полторак болон бусад 9 албан тушаалтан худлыг илрүүлэх төхөөрөмжөөр шалгуулав.

Энэхүү шалгалт нь Украины засгийн газраас хэрэгжүүлж буй авлигатай тэмцэх үйл ажиллагааны нэг хэсэг юм. Ерөнхийлөгч Петро Порошенко авлигатай тэмцэх тухай хэд хэдэн хуулийг баталсан бөгөөд тэдгээр хуулийн дагуу Украины авлигатай тэмцэх товчоо байгуулагдаж байгаа бөгөөд товчоо нь төрийн өндөр албан тушаалтныг мөрдөн шалгах чиг үүргийг гүйцэтгэнэ. Товчооны захирал нь зөвхөн нэг удаа долоон жилийн хугацаагаар томилогдоно. Товчооны 700 ажилтныг шалгаруулан авах үед мөн худлыг илрүүлэх төхөөрөмжөөр шалгах юм.

Төсвийн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий бүх албан тушаалтнуудыг уг төхөөрөмжөөр шалгаж байх бөгөөд энэ үйл ажиллагаа Полторак болон түүний албан тушаалтнуудаар эхэлж байгаа юм байна. Полторацыг оролцуулаад эдгээр 12 албан тушаалтны 9 нь сорилыг амжилттай давжээ. Үлдсэн 3 албан тушаалтан сорилыг өгсөн

²⁹⁵ trust

²⁹⁶ legitimacy

²⁹⁷ the negative feedback loop

²⁹⁸ social trap

²⁹⁹ Elinor Ostrom

³⁰⁰ rationalism

³⁰¹ <http://www.newsweek.com/ukraine-petro-poroshenko-stepan-poltorak-defense-minister-ukraine-lie-detector-285397>

эсэх, өгсөн бол давж чадсан эсэх, эсхүл сорилыг өгөх боломжгүй байсан эсэх зэрэг асуултад Ерөнхийлөгчийн тамгын газраас тодорхой хариулт өгөөгүй байна.

92. Пакистаны боловсролын тогтолцоон дахь авлигын нөлөөлөл³⁰²(2014.12.16)

Пакистан. Авлигаас шалтгаалаад Пакистаны боловсролын тогтолцоон дахь хөрөнгө оруулалт хангалттай хэмжээнд байж чадахгүй байна.

Боловсрол дахь авлига нь тогтолцооны дээд түвшингээс доод түвшнийг бүхэлд нь хамарсан ердийн хэм хэмжээ болж тогтсон байна. Боловсролын салбар дахь авлигын талаарх ард иргэдийн гомдлын тоо нь газрын асуудал болон худалдан авах ажиллагааны талаарх гомдлын дараа гуравдугаарт орохоор байна.

Ихэнх хүмүүс огт байхгүй багш нарт цалин, огт байхгүй сургуульд зардал төсөвлөж зарцуулдаг талаар мэдээлэл ирүүлдэг. Түүнчлэн сургуулийн байшин барилгын нөхцөл байдал маш муу, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулдаг талаар болон сандал, ширээ, ундны ус, бие засах газар зэрэг зайлшгүй хэрэгцээний зүйлс хангалтгүй байдаг талаар гомдол, шүүмжлэл тасрахгүй байна.

Пакистаны Засгийн газар нийт 13094 сургуулийн үйл ажиллагаанд зориулж 8 тэрбум рупи буюу 80 сая ам.долларыг зарцуулдаг. Харамсалтай нь тэдгээр сургуулиудын 8000 гаруй нь зөвхөн дансан дээр байдаг сургууль юм. Тэдгээрийн нэлээд хэд нь нийслэлд бүртгэлтэй гэжээ.

Синдх мужийн Дээд Шүүхээс 2013 онд танилцуулсан тоон мэдээгээр мужийн нийт 48227 сургуулийн 4540 нь зохих ёсоор үйл ажиллагаагаа явуулдаггүй, 2181 нь бодитоор оршдоггүй, 542 нь тухайн орон нутгийнхаа нөлөө бүхий хүмүүсийн мэдэлд очсон байдаг гэжээ.

Балочистан мужид байдал бүр ч эмгэнэлтэй байна. Тэндхийн 12500 сургуулийн 6000 нь өөрийн байргүй бөгөөд багш нар нь улс төрчдийн нэр, нөлөөг ашиглан өөрсдийн дураар ажилд орж, ажиллах сургуулиа тааваараа шилж сонгож явдаг байна.

93. Хэзээ ч төгсөхгүй авлига³⁰³ (2014.11.20)

Өмнөд Солонгос. Хэрэв хяналт шалгалт хангалтгүй бол төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдэд албан тушаалаа урвуулан ашиглах явдал ихээр гарахыг төрийн өмчийн оролцоотой Солонгосын цахилгаан эрчим хүчний корпораци³⁰⁴ харуулж байна. Кепсо мэдлэг, мэдээллийн сүлжээ компани³⁰⁵ нь өөрийн бизнесийн үйл ажиллагаанд харш хуулийн төслийг батлуулахгүйн тулд хууль тогтоогчдыг лоббидсон тухай мэдээллийг цагдаагийн байгууллага олж авсан байна. Үүнээс гадна удирдлагуудын хуурамч томилолтод нэлээд хөрөнгө зарлагадсан талаарх баримтуудыг олсон байна. Зарим тохиолдолд тус компанийн туслан гүйцэтгэгч компаниас хээл хахууль авсан болон үнэтэй бэлэг, тухайлбал, седан машин авсан асуудлыг прокурорууд шалгаж байна. Компаниудын лоббидох авьяас чадвар өндөр ба зохион байгуулалт сайтай байдаг. Тухайлбал, Программ хангамж худалдан авах тендерт жижиг, дунд компаниудыг хамгаалах зорилгоор төрийн өмчийн оролцоотой том компаниудыг оролцохыг хориглосон тухай хууль өргөн барих болоход тэр даруйд нь зорилтот бүлэг зохион байгуулж төр барьж буй болон сөрөг хүчний намын 2 хууль тогтоогчтой холбоо тогтоож

³⁰² <http://blog.transparency.org/2014/12/16/corruptions-effects-on-education-in-pakistan/>

³⁰³

<http://koreajoongangdaily.joins.com/news/article/article.aspx?aid=2997554&cloc=joongangdaily|home|online>

³⁰⁴ Korea Electric Power Corporation (Kepco)

³⁰⁵ Kepco Knowledge, Data & Network Co. (KDN)

тэдгээрт тус бүрд нь 10 сая вон (9000 ам.доллар)-оос 18 сая воний улс төрийн хандив өгсөн ба компанийн 500 ажилтны нэрийн өмнөөс 100.000 вон өгсөн. Одоогийн үйлчилж байгаа системээр тодорхой хувь хүнээс бага хэмжээний улс төрийн хандив өргөхөд татварын хөнгөлөлт эдэлдгийг Кепсо мэдлэг, мэдээллийн сүлжээ компани (KDN) ашигласан байна. Хууль тогтоогчдын зохион байгуулсан арга хэмжээний үеэр тэдний борлуулж байсан номноос компанийн удирдлагууд зуу зуугаар нь худалдан авсан байна. Ингээд эцэст нь төрийн өмчийн оролцоотой томоохон компаниудыг хориглосон заалт ороогүй хууль батлагдсан. Кепкогийн ажилтнууд болон удирдлагуудаас 1.1 тэрбум воны хуурамч томилолтын зардлуудыг гаргуулж авахаар болсон байна. Зарим ахлах албан тушаалтнууд машин болон их хэмжээний бэлэн мөнгө авсан асуудалд буруутгагдсан байна. Иймд төрийн өмчийн оролцоотой компаниудын шинэчлэлийг тус компаниас эхлэн хийх хэрэгтэй юм. Хууль батлах үйл ажиллагаан дахь дөрвөн хууль тогтоогчийн үүрэг, ролийг тогтоох зэргээр нарийн шалгах шаардлагатай юм.

94. Батлан хамгаалах салбар дахь авлигатай тэмцэх зорилгоор Засгийн газар хамтарсан баг байгуулав³⁰⁶(2014.11.21)

Өмнөд Солонгос. Тус улсын Батлан хамгаалах салбар дахь авлигатай тэмцэх зорилгоор прокурор, цэрэг, төрийн албан хаагч зэргээс бүрдсэн хамтарсан баг байгуулагдав. Энэ нь батлан хамгаалахын албаны хүмүүс болон батлан хамгаалах салбарын аж ахуйн нэгжүүдтэй холбоотой гомдол ихээр гарах болсонтой холбоотой юм. Түүнчлэн цэргийн худалдан авалт хариуцсан байгууллага болон цэргийн компаниуд дахь тэтгэвэртээ гарсан албан хаагчидтай холбоотой байна. Тусгай баг нь прокурор, цэргийн прокурор, цагдаа болон бусад төрийн байгууллагуудын албан хаагчид зэрэг 105 хүнээс бүрдсэн бөгөөд цэргийн худалдан авалтын үйл ажиллагааны зөрчлүүдийг шалгах юм. Батлан хамгаалах салбар дахь авлигын асуудал нь ужгарсан өвчин ба энэ нь зөвхөн төрийн төсөв санхүүд хохирол учруулаад зогсохгүй үндэсний аюулгүй байдлыг сулруулна” хэмээн Ерөнхий Прокурор мэдэгдэв.

95. БНХАУ-ын цэргийн салбар дахь авлига³⁰⁷ (2014.11.07)

БНХАУ. Тус улсын Ардын чөлөөлөх армийн³⁰⁸ Логистикийн хэлтсийн харьяанд байсан Аудитын газрыг Дарга Ши Зиньпингийн шууд удирдлагад байдаг Цэргийн төв хорооны харьяанд шилжүүлэх шийдвэр нэлээд дэмжлэг авч байна. Дээрх шийдвэрийг цэргийн удирдах албан тушаалтнуудын эрх мэдлээ хэтрүүлэх хэд хэдэн томоохон хэргүүд гарсны дараа гаргасан байна. Өөрөөр хэлбэл, энэ талаар Ардын чөлөөлөх армийн Логистикийн хэлтсийн орлогч дарга асан Гү Жуншан, Цэргийн төв хорооны дэд дарга асан Шү Цайхоу нар мэдэгдээд “одоо Армийн Аудитын газар илүү бие даасан статустай болно” хэмээн мэдээлсэн юм.

Зарим хэвлэл мэдээлэл, шинжээчид цэргийн энэ шилжилт нь цэрэг армийн авлигын эсрэг авч буй арга хэмжээг нэмэгдүүлэх болно, хурдан хугацаанд гаргасан энэ шийдвэр нь армид байгаа авлигыг үндсээр нь устгах шууд үр дүнтэй арга хэмжээ болох болно хэмээн онцолсон байна.

БНХАУ-ын “Циньхуа” Их Сургуулийн хуулийн мэргэжилтэн Лю Чинлон “Энэ шилжилт нь армийн менежментэд шинэчлэлийг авчрах зөв гарц болно” хэмээн Чайна Дэйли-д ярьсан байна.

³⁰⁶ <http://english.yonhapnews.co.kr/news/2014/11/21/0200000000AEN20141121004400315.html>

³⁰⁷ www.bbc.com/news/world-asia-china-29947544

³⁰⁸ People's Liberation Army's

Түүнтэй нэгэн адил үзэл бодлыг илэрхийлсэн Коммунист намын түүхч Шие Чунтаогийн онцолсноор сүүлийн үед шуугиан дэгдээгээд байгаа өндөр түвшний авлигын хэргүүд нь энэ өөрчлөлтийг хийх үндсэн шалтгаан болсон" гэжээ.

Хавай Ньюс-д мэдээлснээр аудитын ажлыг бие даасан болгох гэсэн энэ хөдөлгөөн нь цэрэг арми өөрийгөө илүү хүчтэй авлигын эсрэг кампанит ажилд бэлтгэж байгаагийн дохио юм.

96. Дэлхийн Улсуудын Бизнесийн Авлигын Эрсдлийн Индексийг танилцууллаа³⁰⁹ (2014.11.11)

“Тракс матрикс” интернэшнл. Тус байгууллага анхны бизнесийн авлигын эрсдлийн индекс (матриц)-ийг гаргаж дэлхий нийтэд зарлалаа.

Одоог хүртэл дэлхийн улс орнуудын бизнесийн авлигын эрсдлийн талаар найдвартай мэдээлэл байхгүй байгаа нь Гадаад дахь авлигын тухай хууль (FCPA) болон олон улсын авлигын эсрэг дүрэм журмыг зөрчих боломжийг бизнесийн байгууллагууд болон компаниудад олгож байна.

Төрийн байгууллагын авлигын нөхцөл болон түүнтэй холбоотой бизнесийн эрсдлийг үнэлэхэд компаниудад туслах зорилгоор Тракс матрицыг гаргасан байна.

Тракс матрицыг бүтээх судалгааны ажлын нэг хэсэг болгож АНУ-ын тохируулагч агентлаг болон дэлхийн томоохон хуулийн фермүүдтэй хамтран ажилласан байна.

Тракс матриц нь Дэлхийн улс орон бүрийн бизнесийн авлигын эрсдлийг 1-100 онооны хооронд тооцсон ба уг тоо өндөр байх тусам тухайн улсын бизнесийн авлигын эрсдэл төдий чинээ их гэсэн үг бөгөөд уг программ нь дөрвөн үндсэн үзүүлэлт, есөн дэд үзүүлэлтээр улс орнуудыг үнэлсэн ба үүнд засгийн газартай харилцах байдал, авлигын эсрэг хууль ба хэрэгжилт, засгийн газар ба иргэдэд үйлчлэх үйлчилгээний ил тод байдал зэрэг багтсан байна.

Улс орнуудыг нийт оноогоор нь жагсаахад гарах индексийг ашиглаж болох боловч нийт оноонд багтсан тодорхой эрсдлийн хүчин зүйлийн үр дүнг харж, нийт оноог юу хөтөлж байгааг тогтооход ашиглаж болно. Энэ нь нийт бизнесийн авлигын эрсдлийн хувьд улс орон хаана асуудалтай байгааг тогтоох боломжийг олгохоос гадна үндсэн болон дэд үзүүлэлтийг өөрсдийн хэрэгцээндээ ашиглаж болох юм байна.

Тракс матрицын дагуу бизнесийн авлигын хамгийн өндөр эрсдлийн оноотой 10 улс нь: Нигер, Йемен, Ангол, Узбекистан, Камбож, Гвинеа, Бурунди, Чад, Өмнөд Судан, Вьетнам улсууд байна.

Харин бизнесийн авлигын хамгийн бага эрсдлийн оноотой 10 улс нь: Ирланд, Канад, Шинэ Зеланд, Хонконг, Швед, Финлянд, Сингапур, Япон, Герман, АНУ болж байна.

Монгол Улс нь Тракс матрицын бизнесийн авлигын эрсдээр 71 оноотойгоор Дэлхийн 197 орны 156-д орсон байна.

³⁰⁹ <http://www.prnewswire.com/news-releases/trace-introduces-global-business-bribery-risk-index-282258761.html>

**ХОЁР. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА 2013 ОНД**

1. Авлигын эсрэг академик санаачилгаас онлайн цонх нээв³¹⁰ (2013.01.23)

Авлигын эсрэг академик санаачилга. Тус санаачилгаас НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны “TRACK” цахим хуудсанд <http://www.track.unodc.org/Academia/Pages/Home.aspx> гэсэн онлайн цонхыг нээсэн байна.

Авлигын эсрэг академик санаачилга нь дээд боловсролын байгууллага, үндэсний мэргэжилтэн, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг авлигын эсрэг сургалт, судалгааны асуудал /хууль, бизнес, криминалистик болон улс төрийн шинжлэх ухаан зэрэг/-д хандуулах, дэмжлэг үзүүлэх зорилготой төсөл юм. Уг цахим хуудсанд авлигын эсрэг боловсрол олгох сургалтын материалиудыг байршуулж 20 дэд сэдэв, судалгааны ажил болон бусад академик сэдэв зэрэг өөр эх үүсвэрээс нэгтгэсэн 600 орчим мэдээлэл багтсан бөгөөд санаачлагчдын зүгээс цаашид хамрах сэдвийн хүрээг өргөжүүлэх, тодорхой сэдэв, материалын хүрээнд эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллахаар зорьж байна.

2. ОХУ-ын Төв банк: 2012 онд 50 тэрбум орчим ам.доллар Орос Улсаас хууль бусаар гадагшаа шилжсэн³¹¹ (2013.02.20)

ОХУ. Оросын Төв банкиг сүүлийн 11 жил удирдаж байгаа Сергей Игнатов “Ведомости” сонинд өгсөн ярилцлагадаа 2012 онд Орос Улсаас “хууль бусаар” 50 тэрбум ам.доллар гадагш шилжсэн бөгөөд энэ мөнгөний тал хувь нь нэг бүлэг хүмүүсийн оролцоотой байсан гэжээ. Гэхдээ тэр дээрх бүлэг хүмүүсийг нэрлэхээс татгалзсан бөгөөд эдгээр шилжүүлэг нь хар тамхины тээвэрлэлт, хууль бус импорт, хээл хахуулийн мөнгөний төлбөр зэрэг байж болох юм гэв. Төв банкны судалгаагаар 49 тэрбум ам.доллар буюу ДНБ-ий 2.5 хувьтай тэнцэх хэмжээний валют Орос улсаас хууль бусаар гадагш шилжүүлсэн болохыг тогтоосон. Уг судалгаагаар 14 тэрбум ам.доллар нь худалдааны үйл ажиллагаанд, 35 тэрбум ам.доллар нь “тодорхой бус” хөрөнгийн шилжүүлэгтэй холбоотой байжээ.

3. Засгийн газар, бизнес дэх авлига газар бүр л бий³¹² (2013.02.21)

Дэлхийн санхүүгийн шударга байдал. Авлига бол түгээмэл, өргөн тархсан хүн төрөлхтний дутагдал юм. Аливаа нийгэмд хүмүүс давуу байдал олж авч чадахгүй гэдгээ мэдэх мөчид тэд хууль бус шийдвэр гаргахад хүрдэг. Улс үндэстнүүд авлигын эсрэг үйл ажиллагааг зогсоох зорилгоор олон тооны хуулийг баталж, мөрдөж байгаа ч мөнгөний хүч, эрх мэдэл болон бусад нөхцөл байдлаас үүдэлтэйгээр авлига оршин тогтносоор л байна.

Мөнгө, эрх мэдэл байгаа л бол тэнд авлига байх магадлалтай. Олон улсын авлигын эсрэг хяналтын бүлэг буюу бидний хэлж заншснаар Дэлхийн санхүүгийн шударга байдлаас³¹³ гаргасан судалгаагаар 2001-2010 онд, хөгжиж буй улс орнуудаас 5.86 триллион ам.доллар хууль бусаар хилийн чанадад гарсан байна. Эдгээр улс орнуудыг тэргүүлэгч БНХАУ-аас сүүлийн 10 жилийн хугацаанд хууль бусаар хилийн

³¹⁰ <http://www.track.unodc.org/Academia/Pages/Home.aspx>

³¹¹ <http://blogs.ft.com/beyond-brics/2013/02/20/central-bank-nearly-50bn-taken-out-of-russia-illegally-in-2012/#axzz2LWccETPw>

³¹² <http://www.voanews.com/content/corruption-in-government-business-can-be-found-everywhere/1607603.html>

³¹³ Global financial integrity

чанадад 2.75 триллион ам.доллар гарсан бол жагсаалтын хоёрдугаарт Мексик Улсаас 476 тэрбум ам.доллар, 5 дугаар байрт ОХУ-аас 152 тэрбум ам.доллар, Нигер Улс 129 тэрбум ам.доллараар Африкын улсын жагсаалтыг тэргүүлж, дэлхийн жагсаалтын 7 дугаар байрт тус тус оржээ.

Дэлхийн санхүүгийн ил тод байдлын байгууллагын Ерөнхийлөгч Раймонд Вакерийн хэлснээр “Энэ дүр зургаас харахад албан хаагчдад өгч буй хээл хахуулийн дүн нь дээрх хэмжээтэй харьцуулахад маш бага дүн эзэлж байгаа. Засгийн газруудад ажиллаж байгаа албан хаагчдын хээл хахуулийн үнийн дүн үнэхээр бага бөгөөд дээрх дүнгийн зөвхөн 3-5 хувьтай л тэнцүү байдаг. Энэхүү хил дамнасан мөнгөний урсгалын хамгийн том хэсэгт арилжааны татвараас зайлсхийх явдал болж байгаа бөгөөд нийт дүнгийн 60-65 хувьтай тэнцүү байна. Дэлхийн санхүүгийн шударга байдлын хамгийн сүүлийн үеийн судалгаагаар хөгжиж буй улс орнуудаас шилжүүлж буй хөрөнгийн хууль бус гадагшлах урсгал нь нэг жилд ойролцоогоор 1 триллион ам.долларт хүрсэн” байна.

4. Авлигатай тэмцэх нь “Төгсөшгүй дайн”³¹⁴ (2013.12.10)

Индонез. Авлигатай тэмцэхэд зөв алхам хийж байгаа гэдэгтээ тус улсын Авлигыг устгах хороо 10 жилийн дараа ч итгэлтэй байгаагаа илэрхийллээ. Төрийн ордонд болсон нэгэн арга хэмжээний үеэр Индонезийн Авлигыг устгах хорооны дарга Абрахам Самед³¹⁵ хэлэхдээ тус хороо зөв замаар явж байгааг дурдан “Авлигыг устгах хороо хараат бусаар, мэргэжлийн түвшинд, хичээнгүйлэн, хүчин чармайлт гарган ажиллаж байгаа” гэжээ.

“Анх 2003 онд Ерөнхийлөгч асан Мегавати Сукарнопутри³¹⁶-ийн удирдлага доор үйл ажиллагаагаа эхэлж байсан хороо энэ хугацаанд авлигын гэмт хэргийн шинж бүхий нийт 70000 мэдээлэл хүлээн авч ажилласан. Индонез Улс дахь авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагаа амжилттай байна гэж үзэн олон улсын “Ramon Magsaysay” шагналыг 2013 оны 8 дугаар сард бидэнд олгосон” гэж Абрахам Самед хэлсэн байна.

Абрахам Самед “Авлигыг устгах хороо хараат бусаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хорооны явуулж буй мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх хэнийг ч хүлээн зөвшөөрөхгүй” гэж тэмдэглэсэн байна.

Авлигыг устгах хороо 2013 онд хэдэн нөлөө бүхий этгээдүүдийг саатуулан шалгасан нь тус хорооны энэ богино түүхэн дэх хамгийн том ажиллагааны тоонд зүй ёсоор орж байгаа юм.

Тухайлбал, Сингапурт байрлалтай газрын тосны худалдааны компанийн нэгэн төлөөлөгчөөс хээл хахууль авсан хэрэгт тус улсын газрын тос, хийн асуудал зохицуулах байгууллагын тэргүүн Руди Рубиандини³¹⁷-ийг, мөн 10 дугаар сард, орон нутгийн сонгуулийн маргаантай холбоотой хээл хахууль авсан хэмээн үзэж Үндсэн хуулийн цэцийн ерөнхий шүүгч Акил Мохтар³¹⁸ нарыг Авлигыг устгах хорооны мөрдөн байцаагчид баривчилсан юм.

Мөн түүнчлэн спортын цогцолборын авлигын хэрэгт холбогдсон Спортын сайд асан Анди Малларанг³¹⁹ болон Ардчилсан намын дарга асан Анас Урбанингрум³²⁰ нарыг саатуулаад байгаа зэрэг юм.

³¹⁴ <http://www.thejakartaglobe.com/news/fighting-corruption-is-an-endless-battle/>

³¹⁵ Abraham Samad

³¹⁶ Megawati Soekarnoputri

³¹⁷ Rudi Rubiandini

³¹⁸ Akil Mochtar

³¹⁹ Andi Mallarangeng

³²⁰ Anas Urbaningrum

Индонез Улс нь “Транспаренси интернэшнл” байгууллагын Авлигын төсөөллийн индексийн 2013 оны үнэлгээгээр 177 улсаас 114 дүгээр байрт орсон нь дэлхийн хамгийн их авлигатай улс орнуудын нэг болж байгаа юм.

Ерөнхийлөгч Сусило Бамбанг Юдоёоно авлигатай тэмцэнэ гэдэг бол Индонез Улсын “шийдвэрлээгүй асуудал” бөгөөд “хэзээ ч төгсөшгүй зорилт” гэдгийг онцлон “ирэх 5, эсхүл 10 жилийн хугацаанд Индонез Улс авлигаас бүрэн ангижирна гэдэгт итгэж болохгүй. Авлигыг устгана гэдэг бол бид үүний эсрэг ямар нэгэн ажиллагааг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэх ёстой гэсэн үг юм”, “Авлигаас урьдчилан сэргийлнэ, устгана гэдэг бол төгсөшгүй дайн юм” гэжээ.

5. Авлигын гэмт хэргийн улмаас ОХУ-д 271 сая гаруй ам.долларын хохирол учирсан³²¹ (2013.05.12)

ОХУ. Тус улсын Мөрдөн байцаах хорооны дарга Александр Бастрыкин³²²-ний хэлснээр сүүлийн хоёр жилийн хугацаанд авлигын гэмт хэргийн улмаас ОХУ-д 271 сая гаруй ам.долларын хохирол учирсан байна.

ОХУ-ын Төрийн “Дум”-ын Аюулгүй байдал, авлигын эсрэг хорооны хуралд Мөрдөн байцаах хорооны дарга Александр Баструкин “авлигын гэмт хэргийн улмаас 9 тэрбум рублийн хохирол учирсан. Авлигын гэмт хэрэгт холбогдсон хүмүүсээс хураасан хөрөнгийн хэмжээ 4 тэрбум рубль байгаа ба 1600 гаруй албан тушаалтнуудыг 2012-2013 онд авлигын хэргээр шалгасан бөгөөд тэдгээрээс 16 нь шүүгч, 216 нь өмгөөлөгч байсан” гэж мэдэгдсэн юм.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн удирдлага доор шинээр авлигатай тэмцэх нэгж байгуулах шийдвэрийг Владимир Путин гаргаад байгаа юм. “Уг нэгж нь авлигатай тэмцэх талаар өнөөгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагад санал дэвшүүлэх чиг үүрэгтэй” гэж Кремлиэс мэдээлжээ.

6. Авлигатай тэмцэх агентлаг аяллын зардлын зарцуулалтыг шалгана³²³ (2013.11.23)

Тайвань. Тус улсын Хууль зүйн яамны дэргэдэх Авлигын эсрэг агентлагаас төрийн албан хаагчид болон орон нутгийн захиргааны албан хаагчдын гадаад улс орнуудад “танилцах аялал” байдлаар үрэлгэн зарцуулалт хийх, төрийн хөрөнгийг зориулалтын бусаар ашигладаг эсэхэд шалгалт хийхээр болоод байна.

Өнгөрөгч наймдугаар сард “People First Party” намын Тайчжун хот дахь зөвлөх Туан Вей-ю³²⁴ Япон Улсад хийсэн 4 өдрийн танилцах аяллын дараахь ажлын тайландаа зөвхөн гуравхан үг бичсэн нь олон нийтэд ил болсон юм. Энэ үйл явдлын дараа Засгийн газрын ажилтнууд гадны улс орнуудад явахтай холбоотой аяллын бүх зардлыг татвар төлөгчдийн мөнгөнөөс зарцуулж байгааг шүүмжлэгчид эсэргүүцжээ.

Хокло буюу Тайвань хэлээр “Yao siu zan (妖受讚)” буюу “хэтэрхий сайхан байлаа” гэсэн гуравхан үгээс Туан Вей-ю-гийн тайлан бүрдсэн байжээ.

Тайвань Улсын төрийн албан хаагчид нэг жилийн хугацаанд ийм төрлийн зугаалга маягийн аялал 87 удаа зохиосон байгаа нь дунджаар 4 өдөр тутамд нэг аялал

³²¹ <http://en.ria.ru/russia/20131205/185261405/Corruption-Cost-Russia-271M-Over-2-Years--Chief-Investigator.html>

³²² Alexander Bastrykin

³²³ <http://www.taipetimes.com/News/taiwan/archives/2013/11/23/2003577505>

³²⁴ Tuan Wei-yu

ногдож байгаа юм. “Төрийн албан хаагчид хувийнхаа тансаг аялалд зориулан төсвийн мөнгө зарцуулсан аяллын тоогоор энэхүү шалгах ажлыг хязгаарлахгүй” гэж тус агентлагаас мэдээлжээ.

“Хил давуулан хууль бусаар бараа тээвэрлэхийг хянах байдлын талаар судлах” нэртэйгээр Тайвань Улсын Засгийн газрын нэгэн агентлагаас 15 хүний бүрэлдэхүүнтэй баг 12 өдрийн турш Орос, Норвеги, Дани, Швед Улсад танилцах аялал хийсэн ба хүн бүрт 4,900 ам.долларын зардал гаргасан байгаагаас тус агентлагийн шалгалт эхлэх юм. “Дээрх улс орнууд дахь Тайван Улсын Консулын ажилтнууд ямар нэгэн зөвлөгөөн, санал бодлоо солилцох арга хэмжээнд оролцоогүй бөгөөд тэдний багийн хөтөлбөрийн ихэнх хэсэг сонирхолтой цэнгээн, аялагчдын очих дуртай газруудын жагсаалтаас бүрдэж байсан” байна.

Туан Вей-ю гурван үгтэй тайлан бичсэндээ уучлалт гуйсан бөгөөд Дотоод хэргийн яамнаас түүнийг хилийн чанадад гаргасан зардлынхаа талаар бүрэн хэмжээний тайлан бичиж өгөхийг шаарджээ.

7. Ши Зиньпиний авлигатай тэмцэх үйл ажиллагаа³²⁵ (2013.11.23)

БНХАУ. Дарга Ши Зиньпинийг өмнөх удирдагчдаас илүү авлигын эсрэг хатуу тэмцэл хийнэ гэсэн хүлээлт бий болоод байсан ч одоогийн байдлаар мөрдөн байцаалтын албан ёсны мэдээллийн дагуу авлигын эсрэг явуулсан мөрдөн байцаах арга хэмжээний тоо өмнөх оныхоос маш бага зөрүүтэй байна.

Хятад Улсын Ардын Дээд прокурорын газрын мэдээллээр 2013 онд хилийн чанадад болон тус улсын хэмжээнд мөрдөн байцаалт явуулсан авлигын гэмт хэргийн тоо өмнөх оныхтой ижил түвшинд байгаа юм.

“Reuters” агентлагийн шинжээчийн үзэж байгаагаар сүүлийн нэг жилийн хугацаанд мөрдөн байцаалт явуулсан өндөр албан тушаалтнуудын тоог өмнөх удирдагчдынхтай ижил түвшинд очих магадлалтай байгаа бол сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад цөөн хүний эсрэг мөрдөн байцаалт явуулсан байж магадгүй байгаа юм.

Ши Зиньпиний авлигын эсрэг үйл ажиллагааг Хятадын төрийн мэдээллийн хэрэгслээр байнга онцлон мэдээлж байснаас энэ статистик мэдээлэл өөр байгаа юм. Нэг жилийн өмнө Ши Зиньпин Коммунист намын даргаар сонгогдохдоо зөвхөн доогуур түвшний албан хаагчид буюу “ялаа”-тай тэмцэх бус мөн өндөр, дээгүүр түвшний албан хаагчид болох “бар”-ын авлигыг үндсээр нь устгахаа амлаад байсан юм.

Шинжээчдийн үзэж байгаагаар “Ши Зиньпин хэтэрхий олон албан хаагчдыг шоронд хийснээр тус улсын Коммунист нам болон засгийн газрынхны хүрээнийхний дургүйцлийг хүргэхээс болгоомжилж байж магадгүй” аж.

Пенсилванийн их сургуулийн Хятадын авлига судлаач Юхуа Ван³²⁶ “Хүн бүр баривчлагдах талаар санаа зовох түвшинд хүргэхийг тэд хүсэхгүй. Хэрвээ тус намын хүн бүр баривчлагдах талаар санаа нь зовж эхэлнэ гэдэг нь жинхэнэ гамшиг байх болно” гэж хэлжээ.

Зарим шинжээчийн үзэж байгаагаар “Сүүлийн 10-аад жилийн хугацаанд жил бүрийн авлигын гэмт хэрэгт явуулсан мөрдөн байцаалтын тоо ойролцоо байгаа нь мөрдөн байцаах байгууллагууд мөрдөн байцаалт явуулах хамгийн бага зорилтот түвшин байдлаар тогтоосон тодорхой тоотой байж магадгүй” юм.

Ардын Дээд прокурорын газрын 2008-2012 оны ажлын тайланд дурдснаар өнгөрсөн жил тус улсын Засгийн газрын байгууллагууд авлигын хэргээр 35648 хүнийг мөрдөн байцаасан байна.

³²⁵ <http://www.reuters.com/article/2013/11/23/us-china-corruption-insight-idUSBRE9AM0CN20131123>

³²⁶ Yuhua Wang

Ардын Дээд Прокурорын газрын энэхүү мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн Гүржийн Төрийн их сургуулийн профессор Андрей Вэдман³²⁷ “Миний таамаглалаар бол 2013 оны эцсийн байдлаар мөрдөн байцаалт явуулсан хэргийн тоо 2012 оны нийт дүнтэй маш ойролцоо гарах байх” хэмээн онцлов.

Сахилгын хяналтын төв хороо болон түүний орон нутаг дахь салбар нэгжүүдээс авлигын гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулдаг ч зөвхөн Коммунист намын гишүүдтэй холбоотой хэргийг л илүүтэй шалгадаг бөгөөд тус хороо энэ жил мөрдөн байцаалт явуулсан хэргийнхээ талаарх тоо мэдээллийг нийтэд тусгайлан зарлаагүй байгаа ч прокурорын газрын энэхүү тоонд тус хорооны шалгасан хэргийн дүн орсон байгаа юм.

Авлигын гэмт хэргийн улмаас байцаагдсан хүний тоо 2003 оноос хойш тогтвортой байна. 2003-2007 оны хооронд жилд дунджаар 33495 хүнийг мөрдөн байцаасан бол 2008-2012 оны хооронд 33569 хүнийг мөрдөн байцаасан байгаа нь маш ойрхон дүн юм.

8. Канадын Ерөнхий сайдын ажлын албаны дарга асан хээл хахууль, луйврын хэргээр буруутгагдлаа³²⁸ (2013.11.22)

Канад. Тус улсын Морьт цагдаагийн газраас Ерөнхий сайд Стивен Харпер³²⁹-ийн ажлын албаны дарга асан Нигель Райт³³⁰-ийг хээл хахууль, луйврын хэрэгт буруутган шүүхэд шилжүүлээд байгаа юм.

Тус цагдаагийн газраас мэдээлж байгаагаар Сенатор Майк Даффи³³¹ хууль бусаар 90.000 канад доллар (86.150 ам.доллар)-ын төсвийг луйвардахад Нигель Райтийг туслалцаа үзүүлсэн гэж үзэж байна.

Нигель Райт нь өнгөрсөн 5 дугаар сард Ерөнхий сайдын ажлын албаны даргын ажлаас чөлөөлөгдсөн бол харин Майк Даффи энэ сарын эхээр Сенатын танхимаас хөөгдөөд байгаа юм.

Сенатор төсвийн зарцуулалтын журмыг зөрчин 90.000 канад долларын чек бичиж Майк Даффийд өгсөн хэрэг нь нийтэд ил болсны дараа тэрээр албан тушаалаасаа чөлөөлөгдсөн юм.

Мөн хавтаст хэрэгт дурдснаар “Сенатын танхимын аудитын тайланд Майк Даффийн асуудлыг нуун дарагдуулах зорилгоор Нигель Райт нь хууль тогтоогчдод нөлөө үзүүлсэн” гэжээ.

Ерөнхий сайдын ажлын албаны цахим захидлуудаас уг хэргийн материалд хэсэгчлэн оруулсан бөгөөд уг материалаас үзэхэд Ерөнхий сайд Стивен Харпер ч уг луйврын талаар илүү ихийг мэдэж магадгүй байгаа юм. Гэхдээ Ерөнхий сайдыг энэхүү хэрэгт оролцсон, эсхүл энэ хэргийн талаар мэдэж байсан эсэхийг шууд нотлох баримт байхгүй бөгөөд Ерөнхий сайд Стивен Харпер энэхүү хууль бус санхүүжилттэй холбоотой юу ч мэдээгүй гэдгээ илэрхийлсэн юм.

Гэвч сөрөг хүчний тэргүүн Том Мулкайр³³² “Ерөнхий сайд үүнийг мэдэхгүй байсан гэдэг нь хэр үнэмшилтэй вэ гэдэг бол асуулт. Энэ бол ямар ч үнэмшилгүй зүйл” гэж тэмдэглэжээ.

Нигель Райт “Би албан үүргийнхээ хүрээнд л шийдвэр гаргасан, миний хийсэн үйлдэл хуулийн дагуу байсан гэдэгт итгэлтэй байна” гэж мэдэгдсэн байна.

³²⁷ Andrew Wedeman

³²⁸ <http://news.yahoo.com/canadian-pms-ex-top-aide-accused-bribery-fraud-224544111.html>

³²⁹ Stephen Harper

³³⁰ Nigel Wright

³³¹ Mike Duffy

³³² Tom Mulcair

9. Вьетнамын банкир хөрөнгө шамшигдуулсан хэргээр цаазаар авах ял авлаа³³³ (2013.11.26)

Вьетнам. Тус улсын төрийн өмчийн “Agribank”-ны Санхүүгийн салбарын дарга асан болон түүний бизнесийн хамтрагч нарт 25 сая ам.доллар шамшигдуулсанд нь цаазаар авах ял оноосон талаар Вьетнамын төрийн мэдээллийн хэрэгслээр мэдээллээ.

Өөрөөр хэлбэл, нэгэн үе Вьетнамын төрийн өмчийн “Agribank”-ны Санхүүгийн салбарын даргын үүргийг гүйцэтгэж байсан 58 настай Ву Куок Хао³³⁴ болон барилгын компанийн захирал 56 настай Данг Ван Хай³³⁵ нарт цаазаар авах ял оногдуулсан байна.

Төрийн мэдээллийн хэрэгслээр мэдээлснээр “хөрөнгө шамшигдуулсан, буруу менежмент хийсэн, албан тушаалаа урвуулан ашигласан луйврын хэргүүдийг үйлдэж улсад онц их хэмжээний хохирол учруулсных нь улмаас уг ялыг оногдуулсан” байна.

Хо Ши Мин хотод 9 өдөр үргэлжилсэн уг хэргийн шүүх хуралд яллагдагчаар нийт 11 хүн оролцсон бөгөөд бусад 9 яллагдагчид тус улсын эдийн засгийн холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн хэмээн үзэж 14 хүртэл жилээр шоронд хорихоор болсон байна.

Санхүүгийн лизингийн гэрээнүүдийг хуурамчаар үйлдэж 2008 оны 4 дүгээр сараас 2009 оны 3 дугаар сарын хооронд төрийн өмчөөс 25 сая ам.долларын хөрөнгийг шамшигдуулсан, албан тушаалаа урвуулан ашигласан хэрэгт дээрх хүмүүсийг буруутгаж байсан юм.

Вьетнам улс нь дэлхийн хамгийн их авлигатай улс орнуудын нэг бөгөөд тус улсын коммунист Засгийн газраас авлигатай тэмцэхээ амлаад байсан юм.

"Хээл хахууль авсан албан хаагч, төрийн албан тушаалтнуудад хатуу шийтгэл оногдуулах болно" хэмээн тус улсын шадар сайд Нгуен Суан Фук³³⁶ авлигын эсрэг ярилцлагын үеэр төрийн албан хаагчдад өмнө нь анхааруулсан билээ.

10. Ойн салбарын буруу менежмент, албан тушаалаа урвуулан ашигласан хэмжээ 7 тэрбум ам.доллар³³⁷ (2013.11.11)

Индонез. Тус улсын төсөвт 2007-2011 оны хооронд орох ёстой байсан 7 тэрбум гаруй ам.долларын хөрөнгийг ойн салбарын хууль бус мод бэлтгэл, салбарын буруу менежменттэй холбоотойгоор алдсан болохыг “Human Rights Watch” байгууллага мэдээлсэн бөгөөд энэ дүн нь тус улсын эрүүл мэндийн салбарын төсвийн зардлаас ч илүү байгаа юм.

Индонезийн Засгийн газар мод бэлтгэл, ойжуулалтын үйл ажиллагаанаас орсон орлогын хэмжээ 2011 онд ердөө 300 сая ам.доллар байсан гэж “Human Rights Watch” байгууллагын ажилтан Эмили Харвелл³³⁸ хэлсэн байна.

Тэрээр “бидний тооцсон 7 тэрбум ам.долларын дүн бол маш бага юм. Учир нь тооцоололд модыг хууль бусаар хилээр гаргах үйл ажиллагааны алдагдлын дүн ороогүй байгаа” гэв.

Индонезийн улсын төсөв болон урсгал тэнцэл энэ онд алдагдалтай гарсан, засаглалын сул байдал нь төсвийн орлогыг бууруулах нэгэн нөхцөл болж байгааг

³³³ <http://www.aljazeera.com/news/asia-pacific/2013/11/vietnam-banker-sentenced-death-fraud-2013111662741522258.html>

³³⁴ Vu Quoc Hao

³³⁵ Dang Van Hai

³³⁶ Nguyen Xuan Phuc

³³⁷ <http://www.bloomberg.com/news/2013-11-10/forest-misuse-costs-indonesia-7-billion-in-revenue-report-says.html>

³³⁸ Emily Harwell

энэхүү тайланд онцолсон байна. Ойн салбараас орох ёстой орлого зөвхөн 2011 онд нийт 2 тэрбум гаруй ам.доллараар буурсан нь тус улсын эрүүл мэндийн салбар дахь засгийн газрын зарлагаас ч өндөр байгаа юм.

Эмили Харвэлл “хэдий хэмжээний модыг модон эдлэл, тавилга зэрэг үйлдвэрлэл, хэрэглээнд зарцуулсныг хууль ёсны дагуу нийлүүлсэн модны хэмжээтэй харьцуулан судалсан. Хууль ёсны дагуу бэлтгэсэн модны хэмжээ болон үйлдвэрлэл, хэрэглээнд зарцуулсан модны хэмжээнээс маш их зөрүүтэй байсан. Тиймээс энэхүү зөрүү нь хууль бусаар нийлүүлсэн модны хэмжээг илэрхийлэх бөгөөд уг хэмжээгээр төлбөр, хураамжийн орлого буурсан гэсэн үг юм” гэж хэлжээ.

Индонезийн Авлигыг устгах хорооны 2012 оны судалгаагаар Засгийн газрын 20 байгууллага дундаас Ойн яам төрийн үйлчилгээг хүргэх хамгийн бага стандарт онооны түвшнээс ч бага үнэлгээ авчээ.

11.Худал хэлдэг оюутнууд төрийн албанд орохыг илүү хүсч байна³³⁹ (2013.11.18)

Энэтхэг. Харвард болон Пенсильванийн их сургуулийн судлаачид Энэтхэг Улсын Бангалор хотын оюутнуудын дунд нэгэн сорилт судалгаа явуулахад энгийн сорилтод худал хэлж байгаа оюутнууд төрийн албаны ажилд орохыг илүү хүсч буйг тогтоосон байна.

Өөрөөр хэлбэл, дээрх сургуулийн судлаач нар Энэтхэг Улсад сургуулиа төгсөж байгаа 600 гаруй оюутныг энэхүү сорилт судалгаандаа оролцуулсан байна. Судалгааны үеэр хэд хэдэн сорилт тоглоомыг тоглуулсны нэг нь оюутнуудыг өөрсдөөр нь шоо хаяулж ямар тоо буусныг нь асуусан байна. Өндөр тоо буусан оюутнууд илүү их төлбөр төлөх ёстой гэж үзсэн бөгөөд оюутан бүр шоог 42 хоёр удаа хаясан байна.

Судлаачид тухай оюутан худлаа хэлсэн эсэхийг мэдэхгүй ч оюутнуудын хэлж байгаа тоо нь санамсаргүй байдлаар буух магадлалт тооноос өөр байсан. Өөрөөр хэлбэл, шоог 42 удаа хаяхад 5-6 удаа өндөр тоо буух магадлалтай байдаг. Уг туршилтаас худал, үнэн хэлдэг оюутнуудыг ялгаж тогтоосон байна.

“Энэхүү сорилт тоглоомоос бид худал хэлдэг, шударга бус оюутнуудыг олсон бөгөөд тэднээс ямар ажилд орохыг нь асуухад тэд шударга оюутнуудаас илүүтэйгээр төрийн албаны ажилд орохыг хүсч байсан. Сорилтыг хуурч, худал хэлж байгаа байдал бол тухайн оюутан бодит амьдралд төрийн албаны ажилд ороод залилах хандлагатай байж болохыг урьдчилан харууллаа” гэж тус судалгааг зохион байгуулагчид үзсэн байна.

Төрийн албаны ажилд худал хэлэгч оюутнууд ийнхүү орохыг илүүд үзэхэд нөлөөлөгч хүчин зүйлсийн нэг бол төрийн албаны авлигач байдал байж болохыг уг судалгаа харуулсан байна.

Тухайлбал, Харвардын их сургуулийн профессор Рема Ханна³⁴⁰ “Төрийн албаны тухайн албан тушаалыг авлигад өртөх эрсдэл өндөртэй гэж үзвэл шударга хүн тухайн ажилд орохыг хүсэхгүй байх. Авлигатай тэмцэхийн тулд улс орнууд хүмүүсийг хаана, ямар ажилд орохыг илүүд үзэж байгаагаар нь хянах шинэ арга зам нээж олох хэрэгтэй” гэж хэлжээ.

³³⁹ <http://www.latimes.com/science/sciencenow/la-sci-sn-cheating-students-government-jobs-corruption-20131118,0,2929974.story#ixzz2ldkBFHJQ>

³⁴⁰ Rema Hanna

12. Хятадын сэтгүүлч, Анголийн хүний эрхийн төлөө тэмцэгч нар Транспаренси Интернэшнл байгууллагын “Шударга ёсны шагнал”-ын эзэд боллоо³⁴¹ (2013.11.08)

Транспаренси Интернэшнл. Тус байгууллагын 2013 оны “Шударга ёсны шагнал”-ын эздээр Хятадын сэтгүүлч Ло Чанпин³⁴², Анголийн хүний эрхийн төлөө тэмцэгч, сэтгүүлч Рафаэль Маркес де Морайш³⁴³ нар болсныг зарлалаа.

Хоёр ялагч бол дэлхий дахинд өөрсдийгөө эрсдэлд учруулан байж авлигын гэмт хэрэгтэй тэмцэж буй олон мянган иргэд, байгууллагын нэгэн жишээ юм. Өмнөх шагналын эзэд болох Шри Ланкийн сэтгүүлч Ласанта Викрематунге³⁴⁴, Оросын хуульч Сергей Магнитский³⁴⁵ нар авлигын эсрэг тэмцснээр амь насаа алдсан юм.

2000 оноос шагналыг олгож эхэлснээс хойших хугацаанд шагналын эздээр тодроод байгаа сэтгүүлчид, засгийн газрын ажилтнууд, иргэний нийгмийн төлөөллүүдийг “авлигын эсрэг тэмцэж болно” гэсэн итгэл үнэмшил нэгтгэдэг юм.

Транспаренси интернэшнл байгууллагын дарга Хугетт Лабелл³⁴⁶ “энэ удаагийн манай 2 ялагч бол хээл хахууль, нууц гэрээ хэлцэл, эрх мэдлээ урвуулан ашиглах явдлыг эцэс болгохын төлөө тэмцэж буй бид бүхний төлөөлөл юм” гэж хэлжээ.

Хятадын сэтгүүлч Ло Чанпин нь тус улсын өндөр албан тушаалтан буюу Хятадын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороон дарга асан Лю Тиэнан³⁴⁷-ийн байгуулсан хууль бус санхүүгийн гэрээ, хэлцлүүдийн талаар бүрэн хэмжээний баримтыг өөрийн ажилладаг санхүүгийн сэтгүүлд нийтэлсэн юм. Энэхүү нийтлэлийн дараа Засгийн газраас шалгалт явуулж 2013 онд Лю Тиэнанийг нам, төрийн албан тушаалаас нь буулгасан юм.

Анголийн хүний эрхийн төлөө тэмцэгч, сэтгүүлч Рафаэль Маркес де Морайш нь өөрийн Засгийн газрын авлига, хууль бус үйл ажиллагааг илчлэн бичсэнийхээ дараа 1999 онд шоронд хоригдож байсан юм. Дээрх байдлыг үл харгалзан эрх мэдэлтнүүдийн авлигын талаар тухайлбал, газрын тосны салбарын авлига, очир эрдэнийн худалдаан дахь хууль бус үйл ажиллагааны талаар өөрийн блогоор дамжуулан илчлэн бичсэн юм.

13. Европын холбоо шүгэл үлээгч³⁴⁸ дийг сайн хамгаалснаар авлигын эсрэг илүү ихийг хийх ёстой³⁴⁹ (2013.11.05)

Транспаренси Интернэшнл. Тус байгууллагын “Европ дахь шүгэл үлээлт” сэдэвт судалгаагаар Европын холбооны ихэнх улсуудад авлигын эсрэг шүгэл үлээгчдээ хамгаалах эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна.

Шүгэл үлээгчид нь авлигаас урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэхэд онцгой үүрэгтэй байдаг ч Европын холбооны зөвхөн 4 улсад буюу Их Британи, Словени,

³⁴¹

http://www.transparency.org/news/pressrelease/chinese_journalist_and_angolan_human_rights_activist_win_transparency_inter

³⁴² Luo Changping

³⁴³ Rafael Marques de Morais

³⁴⁴ Lasantha Wickrematunge

³⁴⁵ Sergei Magnitsky

³⁴⁶ Huguette Labelle

³⁴⁷ Liu Tienan

³⁴⁸ Шүгэл үлээгч гэдэг нь аж ахуйн нэгж, байгууллага дахь ёс зүйгүй, хууль бус үйл ажиллагааны талаарх мэдээллийг нийтэд ил болгосон одоо ажиллаж байгаа эсхүл өмнө нь ажиллаж байсан ажилтан (орч.)

³⁴⁹

http://www.transparency.org/news/pressrelease/eu_countries_must_do_more_to_combat_corruption_by_better_protecting_whistle

Румын, Люксембург Улсад тэднийг хамгаалах эрх зүйн орчин хангалттай бүрдсэн байгааг тус судалгаагаар тогтоосон байна. Европын холбооны бусад 23 улсын 16 нь шүгэл үлээгчдийг эрх зүйн орчинд зарим байдлаар хамгаалсан, 7 улсад нь эрх зүйн хангалттай орчин бүрдээгүй, огт байхгүй байжээ.

Транспаренси интернэшнл байгууллагын Европ, төв Азийг бүсийн захирал Энн Кох³⁵⁰ “Авлигатай тэмцэхэд шүгэл үлээгчдийн оролцоо маш чухал. Хэрвээ ихэнх газруудад хангалттай эрх зүйн орчин бүрдээгүй л бол өөрсдийгөө эрсдэлд учруулахыг тэд хүсэхгүй бөгөөд цөөн хэдэн хүн, эсхүл зоригтой хүмүүс л өөрсдийн олж мэдсэн гэмт хэргийн талаар шүгэл үлээдэг” гэж хэлжээ.

Европын холбооны бүх улсыг олон улсын стандарт тухайлбал, Транспаренси интернэшнл байгууллагын боловсруулсан “Шүгэл үлээгчдийн эрх зүйн олон улсын зарчим”-д тулгуурлан шүгэл үлээгчдийг хамгаалах эрх зүйн цогц орчин бүрдүүлэхийг санал болгосон байна. “Шүгэл үлээгчдийн эрх зүйн олон улсын зарчим”-ыг (http://www.transparency.org/whatwedo/pub/international_principles_for_whistleblower_legislation) -аас үзэж болох юм.

14. Авлига болон бусад гэмт хэргийг мөрдөн шалгахад дэмжлэг үзүүлэх шинэ цахим хуудсыг нээв³⁵¹ (2013.10.21)

Авлига болон бусад зохион байгуулалттай гэмт хэргийг мэдээлэх төсөл (OCCRP). OCCRP-өөс хил дамнасан гэмт хэргийг мөрдөн байцаах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Investigative Dashboard” [<http://www.investigativedashboard.org>] цахим хуудсыг шинэчлэн гаргажээ. Уг цахим хуудас нь дэлхий дахинд гарч буй авлигын хэргийн талаар хүмүүс өөрт байгаа мэдээллээ дамжуулах, эсхүл уг цахим хуудасны мэдээллийн сангаас хувь хүн, аж ахуйн нэгжийн талаарх сонирхсон мэдээллээ хайж олох боломжийг олгож байгаа юм. Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн консорциумын гишүүн Паул Раду³⁵², Дрю Салливан³⁵³ болон бусад сайн дурынхны баг уг цахим хуудсыг хөтлөн явуулж байна.

Энэхүү цахим хуудаснаас Панам, Швейцари, Люксембург зэрэг улс орны албан ёсны мэдээллүүд болон үндэсний аж ахуйн нэгжийн бизнес регистрийн сангийн мэдээллээс хайлт хийх боломжтой юм. Мэдээллийн санд хараахан оруулаагүй байгаа зарим улс орнуудын хувьд хэрэглэгчид цахим хуудасны дотоод линкэд холбоотой байгаа 450 гаруй цахим хуудас, гадаад мэдээллийн сангаас хайлт хийх боломжтой бөгөөд хэрэглэгчид мөн ямар нэгэн компанийн захирал, хувьцаа эзэмшигч болон санхүүгийн тайлангийн талаарх мэдээллийг уг цахим хуудсанд өөрсдөө байршуулах боломжтой юм. Дээрх цахим хуудасны дотоод линкэд холбоотой байгаа ихэнх цахим хуудсанд бүртгүүлснээр үнэгүй мэдээлэл авах боломжтой болно.

Хэрвээ хувь хүн, аж ахуйн нэгжийн талаар хайлт хийгээд хүссэн мэдээлэл олохгүй байгаа бол “Ask for Expert Help” цонхоор цахим хуудасны багийнхнаас тусламж хүсч дэлгэрэнгүй мэдээлэл олж авч болох юм.

Цахим хуудасны багийнхнаас тусламж хүсэхийн тулд уг цахим хуудсанд бүртгүүлсэн байх шаардлагатай бөгөөд хайж байгаа компани, хувь хүнийхээ талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг өгснөөр цахим хуудасны багийнхан оновчтой хайлт хийх боломж бүрдэх юм.

³⁵⁰ Anne Koch

³⁵¹ <http://www.icij.org/blog/2013/10/new-website-assist-crime-and-corruption-investigations>

³⁵² Paul Radu

³⁵³ Drew Sullivan

15. НҮБ-ын хурлаар Азийн улс орнуудын авлигын эсрэг стратегийн талаар зөвлөмж гаргав³⁵⁴ (2013.10.29)

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба. Зүүн өмнөд Азийн улс орнуудыг авлигатай тэмцэх бие даасан стратеги боловсруулан хэрэгжүүлэхийг НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба санал болгожээ. Энэ хүрээнд Малайзын Куала Лампур хотноо Авлигын эсрэг стратегийн Азийн бүсийн хурлыг 2013 оны 10 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд Малайзын Засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн сан, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба хамтран зохион байгуулсан байна.

Хуралд оролцогч улс орнуудын авлигын эсрэг стратегийн хэрэгжилт, хяналтын механизм, туршлага, ололт амжилтын талаар хэлэлцэж "Авлигын эсрэг стратегийн Куала Лампурийн зөвлөмж"-ийг боловсруулсан байна. Хуралд Азийн улс орнуудын авлигатай тэмцэх болон үндэсний төлөвлөгөөний байгууллага, хууль, шүүх, гүйцэтгэх засаглалын төлөөллүүд, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Ази, Номхон далайн Авлигын эсрэг санаачилга, Транспаренси интернэшнл зэрэг байгууллагын төлөөлөл оролцсон юм.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны Авлигын эсрэг бүсийн зөвлөх ноён Шервин Мажлесси³⁵⁵ "энэ хурлаар авлигын эсрэг стратегиа сайжруулах гэж буй болон шинээр стратегиа боловсруулах гэж буй улс орнуудад олон улсын болон мэргэжилтнүүдийн зөвлөмжийг хүргэх зорилготой" гэж тэмдэглэж байна.

Авлигын эсрэг стратегийн Куала Лампурийн зөвлөмжөөс:

- Улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын хүрээнд: Авлигын эсрэг стратеги боловсруулахдаа улс орнууд улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын байдлаа харгалзан үзэх;
- Улс төрчдийн хувьд: Авлигын эсрэг сайн стратеги боловсруулах үйл ажиллагааг ерөнхийд нь чиглүүлэх, шаардлагатай нөөцийг ашиглах зэрэгт улс төрчдийн дэмжлэг, манлайлал зайлшгүй шаардлагатай хүчин зүйлийн нэг юм.
- Нээлттэй, ил тод байдал: Авлигын эсрэг стратеги боловсруулах үйл явцын эхлэх шатнаас л нээлттэй, ил тод байдлыг бүрдүүлэх;
- Хамтын ажиллагааг өргөжүүлэх: Авлигын эсрэг стратеги нь түүнийг боловсруулах, мөн түүнчлэн хэрэгжүүлэх, хяналт тавих шат бүрт байгууллагын хоорондын болон байгууллагын доторх хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн байх ёстой.
- Ойлгомжтой, тодорхой байх: Стратеги нь тодорхой, оновчтой, ойлгомжтой байх ёстой.
- Бүтэц, загвар: Стратегийг боловсруулах, эсхүл хэрэгжүүлэхэд зохимжтой нэгдсэн нэг агуулга, загвар байхгүй бөгөөд стратеги нь тодорхой хэрэгцээ шаардлага, тухай улсын чадавх зэргээс хамаарна.
- Стратегийн дотоод загвар: Үндэсний авлигын эсрэг стратегид хяналт тавих, үнэлгээ хийх механизмыг тусгах.
- Суурь болон зорилтот түвшний шалгуур үзүүлэлт тодорхой байх: Суурь түвшин болон хэрэгжилтийн төлөв байдлыг тодорхой хэмжигдэхүйц, тухайн зорилтот түвшинд хүрсэн эсэхийг тодорхойлохуйц шалгуур үзүүлэлттэй байх.

³⁵⁴ <http://www.unodc.org/southeastasiaandpacific/en/2013/10/anti-corruption/story.html>

³⁵⁵ Shervin Majlessi

16. Индонезийн авлигатай тэмцэх “Lapor” цахим хуудсанд өдөр бүр 1000 мэдээлэл ирж байна³⁵⁶ (2013.10.21)

Индонез. Тус улсын Засгийн газрыг технологийн сайн шийдэл болсон бүтээгдэхүүн гаргана гэдэгт маш олон хүн эргэлзэж байсан. Энэхүү эргэлзээг тайлах нэг зүйл бол “Lapor” цахим хуудас болж байна. “Lapor” цахим хуудсыг Индонезийн авлигын эсрэг зэвсэг болгон ашиглахаар шийдсэн бөгөөд түүнийг “Lapor”-ийг Нээлттэй засаглал нэгж болон Засгийн газрын Ерөнхийлөгчийн “УКР4” нэгжүүд хамтран бүтээжээ.

“Lapor” нь цахим хуудас, гар утасны аппликейшн, мессеж зэргээр дамжуулан Индонезийн Засгийн газрын үйл ажиллагааны талаар иргэд мэдээлэл боломжийг олгосон цахим хуудас юм. Энэ хуудсанд ирсэн мэдээлэл нь улс төрчдийн үйлдсэн авлигын гэмт хэргийн мэдээллээс эхлээд цагдаагийн ажилтнуудын хээл хахууль авах хүртэлх өргөн хүрээг хамарч байна.

Энэхүү цахим хуудсыг Индонез Улсын 200000 гаруй хэрэглэгчид ашиглаад байгаа бөгөөд өдөрт дунджаар 1000 орчим мэдээлэл ирдэг байна. Дээрх мэдээллийн 78 хувь нь Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл байсан байна. Lapor цахим хуудсыг “Twitter” хуудсаар дагагчдын тоо өсч 5000 гарчээ.

Одоогийн байдлаар, “Lapor”-ыг нь Jakarta, Bandung болон Засгийн газрын 67 яам, агентлагтай холбоод байгаа юм. Өдөр бүр 1000 мэдээлэл ирүүлж байна гэдэг нь энэхүү цахим хуудас маш үр дүнтэй, мэдээлэх шилдэг технологийн хэрэгсэл болсныг илэрхийлэхийн зэрэгцээ Индонезийн иргэдийн мэдээлэл өгөх хамгийн шилдэг технологи болж байгаа юм.

17. Филиппин Улсын Дээд шүүхээс шүүх засаглал дахь авлигын хэрэг болон хэрэгт нөлөөлөх нөлөөллийг хянах нэгж байгууллаа³⁵⁷ (2013.10.17)

Филиппин. Тус улсын Дээд шүүхээс шүүх засаглал дахь авлигын хэрэгт мөрдөн байцаалт явуулах, хөндлөнгийн нөлөөллийг хянах “Arlene” хэмээх нэртэй нэгжийг байгууллаа.

Тус нэгжийг Шүүхийн холбооны тэргүүн Марвик Леонен³⁵⁸ тэргүүлэх бөгөөд гишүүдээр нь Дээд шүүхийн тэтгэвэрт гарсан хоёр шүүгч ажиллах юм.

Дээд шүүхийн хэвлэлийн албаны дарга Теодор Тэ³⁵⁹-гийн хэлснээр “Үндэсний мөрдөн байцаах газар, Шүүхийн удирдлага, шүүгчийн хэргийг шүүх газрууд мөрдөн байцаалтын ажил явуулахын тулд шүүгч Марвик Леонен-ы нэгжээр хэлэлцүүлэн, зөвшөөрөл авч баталгаажсан байх ёстой. Эмх цэгцгүй байдал болон үйл ажиллагаа, үр дүнгийн давхардал зэргээс зайлсхийхийн тулд дээрх байгууллагууд шүүх засаглал дахь одоо шалгаж буй бүх хэргийн талаар тус нэгжид танилцуулж баталгаажуулах ёстой” гэж тэмдэглэв.

³⁵⁶ http://www.techinasia.com/lapor-indonesia-200000-users/?utm_source=rss&utm_medium=rss&utm_campaign=lapor-indonesia-200000-users

³⁵⁷ <http://newsinfo.inquirer.net/509087/sc-creates-body-to-probe-corruption-and-decision-brokering-at-judiciary#ixzz2i8P5cnRi>

³⁵⁸ Marvic Leonen

³⁵⁹ Theodore Te

18. Хөгжиж буй улс орнуудын үндэстэн дамнасан компаниуд авлигатай тэмцэхэд бэлэн үү³⁶⁰ (2013.10.17)

Транспаренси Интернэшнл. Энэтхэг, Хятад зэрэг хөгжиж буй улс орны үндэстэн дамнасан компаниуд асар хурдан өргөжин томорч байгаа ч эдгээр компаниуд олон нийтэд илүү хариуцлагатай байх ёстой хэмээн тус байгууллага үзэж байна.

Транспаренси Интернэшнл байгууллагаас “Корпорацийн ил тод байдал: Хөгжиж буй улс орнуудын үндэстэн дамнасан корпорациудыг үнэлэх нь” сэдэвт 52 хуудас тайланг гаргав. Уг тайланд хөгжиж буй 16 улс орны томоохон үйл ажиллагаатай 100 компанийг үнэлсэн байна.

Энэхүү үнэлгээгээр 0 үнэлгээ авсан компани нь хамгийн ил тод бус, 10 үнэлгээ авсан нь хамгийн ил тод бөгөөд дээрх компаниудын 75 хувь нь 5-аас доош үнэлгээ авсан байна.

Үнэлгээг авлигын эсрэг үйл ажиллагааных нь талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй эсэх, компанийн бүтэц, үйл ажиллагааныхаа зардлын талаар тухайн үйл ажиллагаа явуулж буй улс орноо мэдээллээр хангадаг эсэх зэрэгт үндэслэн гаргасан байна.

“BRICS” (Бразил, Орос, Энэтхэг, Хятад, Өмнөд Африк)-ийн улс орнуудын дотроос Хятадын компаниуд хамгийн муу үнэлгээтэй гарсан байгаа нь хятадын компаниуд үйл ажиллагааныхаа стандартыг нэмэгдүүлэх томоохон алхмуудыг зайлшгүй хийх шаардлагатай байгааг илэрхийлж байгаа юм.

Транспаренси интернэшнл байгууллагын захирал Хугетт Лабелл “Дэлхийн нийтийн авлигатай тэмцэх үйл ажиллагаанд хөгжиж буй улс орнууд өөрсдөө үүрэг хүлээж оролцох цаг нь болсон. Хөгжиж буй улс орнуудын компаниуд өөрсдийн нөлөөллөө нэмэгдүүлэхийн тулд олон улсын түвшинд авлигыг бууруулах үйл ажиллагаанд оролцох ашиглах хэрэгтэй байна. Дэлхий дахинд өрнөж байгаа бизнесийн үйл ажиллагаа ил тод бус байна гэдэг нь дээрх бизнес, компаниудад итгэх орон нутгийнхны итгэл буурах, улмаар компаниудын үйл ажиллагааны нэр төрд хохирол учруулах эрсдэлтэй юм. Үндэстэн дамнасан компаниуд засгийн газарт хэдий хэмжээтэй төлбөр төлж буй, эсхүл хэдий хэмжээний татвар төлж байгаа талаар хүмүүс мэдэх эрхтэй” гэжээ.

Компанийн ил тод байдал: Маш ил тод болон ил тод бус компани

Маш ил тод (100%)	Ил тод бус (0%)
Emirates Airlines (Арабын нэгдсэн Эм.)	Anshan Iron and Steel Group (Хятад)
Johnson Electric (Хятад)	Chery Automobile (Хятад)
Petronas (Малайз)	China National Offshore Oil Corporation (Хятад)
Shanghai Electric (Хятад)	China Shipbuilding Industry Corporation (Хятад)
United Company Rusal (Орос)	Chint Group (Хятад)
	Galanz Group (Хятад)
	Geely – Zhejiang Geely Holding Group (Хятад)
	Huawei Technologies (Хятад)
	Mabe (Мексик)
	Odebrecht Group (Бразил)
	Wanxiang Group (Хятад)

360

http://www.transparency.org/news/pressrelease/time_has_come_for_emerging_market_companies_to_fight_corruption

19. Эцэг, эхчүүд “од” сургуулиудад хүүхдээ сургахын тулд 3000 ам.доллар төлөхөд бэлэн³⁶¹ (2013.10.07)

Вьетнам. Хүүхэддээ хамгийн сайн боловсрол олгохыг хүссэн Вьетнамын эцэг, эхчүүд “од” сургуулиудад хүүхдээ сургахын тулд олон мянган долларын төлбөр төлөхөд бэлэн байна.

Транспаренси интернэшнл байгууллагаас гаргасан Дэлхийн авлигын тайланд дурдснаар Вьетнамын боловсролын салбар авлигатай байгааг онцолсон юм.

Сүүлийн жилүүдэд чанартай боловсрол ихээр шаардагдах болсон нь Вьетнамын эцэг, эхчүүдийн дунд нэр хүндтэй, алдартай сургууль, /тэдний нэрлэдгээр “од” сургуульд/ хүүхдээ сургахыг хүссэн эцэг, эх нэмэгдсэн байна.

Вьетнам гэр бүлийн 40 гаруй хувь нь өрхийн орлогынхоо 10 гаруй хувийг хүүхдийнхээ сургалтад зарцуулдаг болохыг сүүлийн үед хийсэн судалгаагаар тогтоосон байна.

Уг судалгаанд онлайн хэлбэрээр 20000 иргэнийг хамруулсан бөгөөд судалгаанд хамрагдсан эцэг, эхийн 62 хувь нь өөрсдийн хүүхдүүдээ “од” сургуулиудад сургахын тулд хээл хахууль өгөх, эсхүл хувийн харилцаатай өндөр албан тушаалтнуудыг давуу байдал болгон ашиглана гэж хариулжээ.

Энэхүү судалгаагаар нэр хүндтэй сургуулиудад хүүхдээ сургахын тулд нийт 3000 ам.доллар, дунд түвшний сургуулиудад хүүхдээ сургахын тулд 300-800 ам.долларыг хээл хахуульд төлөхөд бэлэн байгааг онцолсон байна.

Вьетнам Улсад сард 500 ам.долларын орлоготой хүн “өндөр цалинтай”-д тооцогддог бөгөөд тус улсын нэг хүнд ногдох жилийн орлого нь 1700 ам.доллартай тэнцүү байдаг.

Энэхүү бага орлоготой эцэг, эх сайн орчинд хүүхдээ сургахын тулд 1000 ам.доллар төлөх нь “боломжийн” гэж үзсэн байна.

Судалгаагаар эцэг, эхийн 71 хувь нь сайн сургуульд хүүхдээс сургахын тулд мөнгө зарцуулах нь маш энгийн зүйл хэмээн хариулсан байна.

Боловсролын салбар дахь авлига түгээмэл зүйл болсон бөгөөд төрийн боловсролын үйлчилгээг хүртэх олон нийтийн боломжийг үгүй хийж байгаа юм. Зөвхөн баян, орлого өндөртэй гэр бүлээс гаралтай хүүхдүүд л сайн боловсрол олж авах боломжтой байгаа нь ядуу, орлого багатай гэр бүлийн хүүхдүүд боловсрол эзэмших бага боломжтойг илэрхийлж байна.

20. Боловсролын салбар дахь авлига ядууралд дарамт учруулах нь³⁶² (2013.10.01)

Транспаренси Интернэшнл. Тус байгууллагаас 2013 оны 10 дугаар сарын 1-нд гаргасан судалгааны тайланд дурдснаар боловсролын салбар дахь авлига дэлхий дахины ядууралд харилцан адилгүй дарамт учруулж байгааг тогтоосон байна.

Энэхүү судалгаагаар дэлхийн 5 хүн тутмын 1 нь өнгөрсөн жил боловсролын салбарт хээл хахууль өгчээ. Мөн түүнчлэн суралцах боломж хязгаарлагдмал байдаг дэлхийн ядуу улс оронд 3 хүн тутмын 1 нь боловсролын салбарт хээл хахууль өгсөн байна.

³⁶¹ <http://english.vietnamnet.vn/fms/education/86154/parents-willing-to-pay--3-000-for-a-seat-at--star--schools.html>

³⁶² <http://www.rferl.org/content/corruption-education-report/25123364.html>

Судалгааны тайланг боловсруулсан ахлах редактор Гарет Свини³⁶³-ийн хэлснээр “боловсролын үйлчилгээг авах хүсэл нь сургуулийн удирдлагууд суралцагчдын гэр бүлээс хууль бусаар мөнгө авах томоохон хөшүүрэг болж байна. Боловсролын үйлчилгээнээс хол, ядуу өрх хүүхдүүддээ боловсрол олгохын тулд нэмэлт төлбөр төлөх байдалд хүргэж байна” гэжээ.

Боловсролын салбарт төлөгдөж буй хээл хахуульд зөвхөн багш, сургуулийн удирдлагууд буруутай биш юм. Хууль бусаар нэмэлт төлбөр төлөх нь ихэвчлэн багш, сургуулийн удирдлагууд цалин бага байдагтай холбоотой байна. Учир нь боловсролын салбарын санхүүжилтийг сургуульдаа очихоос нь өмнө өндөр албан тушаалтнууд шамшигдуулах явдал мөн өндөр байгаа юм.

Судалгаагаар боловсролын салбар авлигад хамгийн өртөмтгий салбар болж байна. Учир нь ихэнх улс оронд засгийн газрын зардлын ихээхэн хэсгийг боловсролын салбарт зарцуулдаг ч энэ салбарт хяналт сул байдаг юм.

Боловсролын салбарт зөвхөн хууль бус нэмэлт төлбөрийн хэлбэрээр авлигын асуудал илэрч байгаа бус юм. Энэ салбарт мөн ихээхэн хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой луйвар, танил талаараа асуудлыг шийдэх, зарим улс оронд хэзээ ч үйл ажиллагаа явуулахгүй “сүнс³⁶⁴” сургуулийг барьж байна.

2013 оны “Авлигын тайлан: Боловсрол”-д багш, сургуулийн удирдлагуудын ёс зүйн дүрмийг засгийн газрууд бий болгох, хариуцлагатай сайн системийг байгуулж авлигыг зогсоохыг уриалсан байна. Мөн түүнчлэн сургуулийн үйл ажиллагаа, үйл ажиллагааны тайланд эцэг, эх, сурагчдын оролцоог нэмэгдүүлэх замаар хяналт тавих шаардлага байгааг тогтоосон байна.

“Эцэг, эхийн оролцоог бид хамгийн чухал хэсэг нь гэж үзэж байна. Сургуулийн орчны хууль бус үйл ажиллагаанд эцэг, эхийн тавих үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, улмаар эцэг, эхчүүд хүүхдүүддээ боловсрол олгохын тулд оруулж буй хөрөнгө оруулалт хэрхэн зарцуулагдаж байгааг өөрсдөө хянах шаардлагатай” гэж Гарет Свини нэмж хэлжээ.

21.Хээл хахууль, авлигын хэрэгт шийтгэл хүлээлгэдэггүй байдал нь Афганистан Улсад үзүүлэх тусламжийн хэмжээг бууруулж магадгүй³⁶⁵ (2013.09.28)

Афганистан. Авлигатай тэмцэх хараат бус байгууллага буюу Мониторинг, үнэлгээний хороо (Monitoring and Evaluation Committee(МЕС))-ийн тэргүүн Драго Кос³⁶⁶-ийн уламжилж байгаагаар “Афганистан Улс дахь авлигын хэрэг шийтгэгддэггүй явж ирсэн байдал болон Засгийн газраас авлигыг хязгаарлах талаар тодорхой арга хэмжээ авахгүй бол тус улс дахь олон улсын тусламжийн хэмжээ буурах” юм.

МЕС-ийн тэргүүн Драго Кос Ройтерс агентлагт өгсөн мэдээлэлдээ “Афганистан Улсад буй хамгийн том асуудал бол шийтгэл хүлээлгэдэггүй байдал болоод байна. Хүмүүс шийтгэл хүлээсэн авлигачийг мэдэхгүй, ард түмэн Засгийн газарт итгэхээ больсон” гэжээ.

Афганистан Улс нь хамгийн их авлигатай улсын тоонд ордог бөгөөд авлигын эсрэг эрс арга хэмжээ авахгүй бол сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд тус улсын эдийн засгийг дэмжих зорилготой олон улсын тусламжийн хэмжээ буурах аюулд хүрээд байгаа юм.

³⁶³ Gareth Sweeney

³⁶⁴ Ghost буюу бүртгэлээс харахад үйл ажиллагаа явуулж мэт боловч бодит байдалд үйл ажиллагаа явуулахгүй байгаа

³⁶⁵ <http://www.trust.org/item/20130928134445-1735e/?source=hpeditorial>

³⁶⁶ Drago Kos

2014 оны эцэс гэхэд гадаадын ихэнх цэргийн хүчнүүд Афганистанаас гарахаар төлөвлөж байгаа бөгөөд хөгжлийн төслүүд дэх олон улсын хяналт, аюулгүй байдлын асуудал онцгой анхаарал татаж байгаа юм.

2011 онд МЕС-ийг байгуулсан нь Афганистан дахь авлигатай тэмцэх үйл ажиллагаанд шинэ шатанд гарч байна гэж тодорхойлж байсан ч үйл ажиллагаа нь хангалттай биш байгаа юм.

Драго Косийн хэлснээр зарим яамд тус байгууллагын зөвлөмжүүдийг үл ойшоож байгаа бөгөөд сүүлийн 6 сарын хугацаанд ямар ч төрийн өндөр албан тушаалтан яллагдах, эсхүл халагдах үзэгдэл болоогүй байна.

“Өмгөөлөгчийн болон цагдаагийн байгууллагаас ямар ч арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байна. Хандивлагчид хэрэгжүүлж буй төслөө зогсооно. Улмаар шинэ төсөл хэрэгжүүлэхэд нь ч энэ байдал муугаар нөлөөлнө” гэж Драго Кос хэллээ.

Өнгөрсөн жил Токио хотод болсон зөвлөгөөнөөр 80 улс болон олон улсын байгууллагын төлөөлөгчид 4 жилийн хугацаанд Афганистан Улсад 16 тэрбум ам.долларын тусламж үзүүлэхээ амлаж байсан юм. Гэвч авлигатай тэмцэх үйл ажиллагаандаа эрс арга хэмжээ авахыг санхүүжүүлэгч талууд хүсч байсан юм.

22. Тайландын Аудитын ерөнхий газар авлигатай тэмцэхээр цахим хуудас ажиллуулж эхэллээ³⁶⁷ (2013.09.28)

Тайланд. Тус улсын Аудитын ерөнхий газраас авлигатай тэмцэх үйл ажиллагаанд гомдол, мэдээлэл хүлээн авах, ард иргэдийнхээ авлигын гэмт хэргийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор цахим хуудас [“www.oaganticorruption.com”](http://www.oaganticorruption.com) ажиллуулж эхлээд байна.

Аудитын ерөнхий газрын дэд даргын мэдээлснээр “уг цахим хуудас үйлдэгдсэн авлигын гэмт хэргийн талаар гомдол, мэдээл хүлээн авахын зэрэгцээ иргэдэд авлигын гэмт хэргийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх боломжийг олгож байгаа” гэжээ. Дэд даргын цохон тэмдэглэснээр, ялангуяа Аудитын ерөнхий газрын албан хаагчидтай холбоотой хууль бус аливаа хэргийн талаар гомдол мэдээлэл ирүүлэхийг уриалж, тус цахим хуудас ирүүлсэн мэдээллийг шалган, шийдвэрлэлтийн талаарх хариуг шуурхай мэдэгдэн, шаардлагатай тохиолдолд уг гомдол мэдээллийг шүүхэд шилжүүлэх юм.

Энэ цахим хуудас мөн иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийг Тайландын орон нутаг, муж бүрээр нь харах боломжийг олгож байгаа нь тухайн хугацаанд хэдэн гомдол мэдээлэл ирсэн, хэдэн сэжигтэй тохиолдол шүүхэд шилжсэн байгааг харах боломжтой билээ.

23. Авлигач шүүгч хатуу шийтгэгдэх ёстой³⁶⁸ (2013.08.15)

БНХАУ. Хятадын Дээд шүүхийн ерөнхийлөгч Чжоу Цян³⁶⁹ мэдэгдэхдээ “шүүгчид хууль, ёс зүйн дүрэм зөрчвөл энэ нь Хятадын шүүхийн систем болон шүүгчийн найдвартай байдалд ичгэвтэр хэрэг болно. Тиймээс хууль зөрчсөн шүүгчдийг хатуу чанга шийтгэж байх ёстой. Хятадын шүүгчдийн оролцсон гэмт хэрэг, шүүгчийн нэр хүнд, бүрэн эрхээ урвуулан ашигласан явдал зэргээс шүүгчид сургамж авах хэрэгтэй. Өнөөгийн Хятадын шүүхийн системд ёс зүй муутай, мэргэжлийн чадваргүй, авлигач байдал байсаар байгаа нь Хятадын шүүхийг хүндрэлтэй байдалд оруулж байна” гэжээ.

Тэрээр Хятадын шүүх шүүгчдийнхээ мэдлэгийг дээшлүүлэх, шүүгчдийн буруугаар ашиглаж байгаа хуулийн цоорхойг үндсээр нь арилгах хэрэгтэй байгааг цохон тэмдэглэсэн байна.

³⁶⁷ http://thainews.prd.go.th/centerweb/newsen/NewsDetail?NT01_NewsID=WNPOL5609190010005

³⁶⁸ http://www.chinadaily.com.cn/china/2013-08/15/content_16897739.htm

³⁶⁹ Zhou Qiang

Шүүхээс шүүгчдэд тавих хяналтаа нэмэгдүүлэх, түүнчлэн авлигаас урьдчилан сэргийлэх үр ашиг бүхий механизмыг бүрдүүлэх шаардлагатайг мөн онцолсон байна.

Хятадын Дээд шүүхийн ерөнхийлөгчийн хэлсэн энэхүү мэдэгдэл нь Шанхай хотын дээд шүүхийн 4 шүүгчийг тус хотын нэгэн шөнийн клубээс биеэ үнэлэгчдийг хөлслөн авсан хэрэгт буруутган ажлаас нь халсны дараа болж байгаагаараа онцлогтой ажээ.

24. Индонезийн Авлигыг устгах хороо авлигатай тэмцэхийн тулд радио суваг нээв³⁷⁰ (2013.08.18)

Индонез. Тус улсын Авлигыг устгах хороо олон нийтийг хамарсан авлигын эсрэг систем байгуулахын тулд нэгэн радио сувгийг нээсэн байна.

Индонезийн Авлигыг устгах хорооны дэд дарга Аднан Панду Пражах³⁷¹ “Хүмүүс ‘KanalKPK’ радиогоор дамжуулан авлигын хэргийг чөлөөтэй мэдээлж болно. Мэдээлэл тэднээс шууд олон нийтэд хүрнэ, олон нийтэд хүрснээр эдгээр хэргүүд илчлэгдэх болно” гэж тэмдэглэж байна.

“Авлигатай тэмцэж буй хууль сахиулах байгууллагад ажиллаж байгаа хүмүүсийн тоо авлигач хүмүүсийн тооноос цөөн байна. Тиймээс авлигатай тэмцэх системийг өргөжүүлэхгүйгээр, авлигачдыг цөөрүүлэхэд хүндрэлтэй юм. Авлигыг устгах хорооны үзэж байгаагаар энэ радио бол хүмүүсээр дамжуулан авлигатай тэмцэх хүчтэй системийг байгуулах нэг хэрэгсэл, тийм ч учраас энэ систем хөгжиж цаашид авлигаас урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл болно. Энэ үе бол мэдээлэл, харилцаа холбооны эрин, тиймээс Авлигыг устгах хороо Индонезийн бүх иргэдтэй харилцаа холбоо тогтоох боломжтой байх ёстой” хэмээн Авлигыг устгах хорооны дэд дарга радиог нээхдээ хэлсэн байна.

Авлигыг устгах хороо нь төрийн мэдлийн радио станцтай хамтарч ажиллаж байгаа бөгөөд эхний удаа өдөрт нэг цагийн нэвтрүүлэг дамжуулна. Цаашид бусад радиотой хамтран ажиллаж үйлчилгээгээ улам өргөжүүлэх болно хэмээн тус байгууллагын дэд дарга хэлэв.

25. Транспаренси Интернэшнл байгууллага Дэлхий нийтийн авлигын хэмжүүр³⁷² судалгааг зохион байгууллаа³⁷³ (2013.07.09)

Транспаренси Интернэшнл. Тус байгууллага 8 дахь удаагийн Дэлхийн авлигын хэмжүүр судалгааны үр дүнг 2013 оны 7 дугаар сарын 9-ний өдөр зарлалаа. Энэ жилийн судалгаа нь урьд өмнө хийж байсан судалгаануудаас өргөн хүрээнд буюу 107 улсын 114000 иргэнийг хамруулж явуулсан байна.

Дэлхий дахинд явуулсан энэхүү судалгааны үр дүнгээр авлига бол түгээмэл үзэгдэл болсныг харуулсан байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 27 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд төрийн байгууллага, институцээс үйлчилгээ авахдаа хээл хахууль өгсөн гэж хариулсан нь өмнөх судалгаануудын үр дүнгээс сайжраагүй байна.

Транспаренси Интернэшнл байгууллагын дарга Хугетт Лабеллийн хэлснээр “дэлхий дахинд хээл хахууль өгөх явдал маш их байна”.

³⁷⁰ <http://www.antara.co.id/en/news/90306/kpk-opens-radio-streaming-service-to-fight-corruption>

³⁷¹ Adnan Pandu Prajahe

³⁷² Global Corruption Barometer

³⁷³

http://www.transparency.org/news/pressrelease/bribe_paying_still_very_high_worldwide_but_people_ready_to_fight_back

Дэлхийн авлигын хэмжүүр судалгааны дүгээр 36 улс орон цагдаагийн байгууллагыг хамгийн их авлигатай гэж үзсэн бөгөөд эдгээр улс орнуудаас судалгаанд хамрагдсан хүмүүсийн дунджаар 53 хувь нь цагдаа хээл хахууль төлөхийг шаардсан гэжээ. Мөн 20 улс оронд шүүх засаглал хамгийн их авлигатай гэж нэрлэгдсэн бол эдгээр улс орны иргэдийн дунджаар 30 хувь нь хээл хахууль төлөхөөр шүүх засаглалын системтэй холбогдсон гэж хариулжээ.

Авлигатай тэмцэх үйл хэрэгт “Их-20”-ийн улс орнуудаас томоохон алхам, манлайлал хэрэгтэй байгаа юм. “Их-20”-ийн 17 улсыг судалгаанд хамруулсан бөгөөд судалгаанд хамрагдсан дээрх улсын иргэдийн 59 хувь нь авлигатай тэмцэх үйл хэрэгт засгийн газрууд нь ямар нэгэн үр дүнтэй ажил хийхгүй байна” хэмээн үзсэн байна.

Дэлхийн авлигын хэмжүүр судалгаа-2013 (Монгол Улс)

Д/д	Асуулт	Хариулт /судалгаанд оролцогчдын хувь/
1.	Сүүлийн хоёр жилийн хугацаанд Монгол Улсын авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн бэ?	Их өссөн -28% Өссөн-20% Өөрчлөгдөөгүй-32% Буурсан-18% Маш их буурсан-1%
2.	Монгол Улсын төрийн байгууллага дахь авлига ямар түвшний асуудал бэ?	Ноцтой асуудал-86% Асуудал-7% Бага асуудал-5% Ямар ч асуудал биш-2%
3.	Төр, засгаас авлигатай тэмцэхээр явуулж байгаа бодлого, арга хэмжээг хэрхэн үнэлэх вэ?	Маш үр дүнтэй-2% Үр дүнтэй-23% Үр дүнтэй ч биш/ үр дүнгүй ч биш-36% Үр дүнгүй-28% Ямар ч үр дүнгүй-11%
4.	Монгол Улс дахь авлига хамгийн их тархсан институц аль нь вэ?	Улс төрийн намд-65% Их хурал/ хууль тогтоох байгууллага-63% Цэрэг/арми-27% Төрийн бус байгууллага-16% Хэвлэл мэдээлэл-39% Шашны байгууллага-11% Бизнесийн байгууллага-45% Боловсролын системд-63% Шүүх засаглалд-73% Эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээнд-71% Цагдаа-66% Төрийн албан хаагчдад-77%
5.	Сүүлийн 12 сарын хугацаанд танай өрхийн хэн нэгэн төрөөс дараахь үйлчилгээг авахдаа хээл хахууль өгсөн үү?	Боловсролын үйлчилгээнд төлсөн-34% Шүүхэд төлсөн-35% Эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээнд-35% Цагдаад төлсөн-39% Газрын алба-21% Татварын байгууллага-22% Бүртгэл, зөвшөөрөл олгох үйлчилгээнд-19% Нийтийн үйлчилгээ-8%

Судалгааны тайланг Англи, Франц, Араб, Орос, Испани хэлээр гарсан байна.

26. Вьетнам Улс дунд сургуулиудад авлигын эсрэг хичээл орно³⁷⁴ (2013.06.19)

³⁷⁴ <http://tuoitrenews.vn/education/10855/vietnam-to-teach-anticorruption-courses-in-high-school>

Вьетнам. Тус улсын Засгийн газрын албан ёсны цахим хуудсанд мэдээлснээр ирэх хичээлийн жилээс эхлэн дунд сургуулиудын сурагчдад авлигаас урьдчилан сэргийлэх хичээл зааж эхлэх юм байна.

Засгийн газрын шийдвэрээр 2009 оны сүүлээс 3 жилийн туршилтын хөтөлбөр хэрэгжсэн бөгөөд энэ оны 9 дүгээр сар буюу 2013-2014 оны хичээлийн жилээс хөтөлбөрийг жинхэлж, дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлигын эсрэг хичээл орохоор болсон байна.

Ерөнхий сайд Нгуен Тан Зунг³⁷⁵-ийн тогтоолын дагуу энэхүү хичээлийг заахтай холбоотойгоор багш нарыг сургах үйл ажиллагааг Улсын хянан шалгах байгууллага хариуцаж байна.

Улсын хянан шалгах байгууллагын мэдэгдснээр Вьетнам Улсад авлига нэмэгдэж байгаа. Өнгөрсөн жил авлигын 49 хэргийг шалгасан бөгөөд эдгээрийн улмаас 132.7 тэрбум вьетнам донг (6.3 сая ам.доллар) –ийн хохирол учирсан байна.

27. Ойрын туслах нь хээл хахуулийн хэрэгт холбогдсоны дараа Чехийн Ерөнхий сайд огцрохоо мэдэгдлээ³⁷⁶ (2013.06.16)

Чех. Тус улсын Засгийн газрын ажилтан Жана Нагяаво хээл хахуулийн хэрэгт холбогдсоны дараа Ерөнхий сайд Петр Нечас³⁷⁷ албан тушаалаасаа огцрохоо мэдээллээ. Тэрээр мөн уг явдлаас өмнө Чехийн Иргэний ардчилсан намын даргын албан тушаалаас огцрохоо мэдэгдсэн юм.

Тус улсын цагдаагийн байгууллага төрийн албан хаагчдыг хамарсан нэгжлэг, шалгалт хийж найман хүнийг баривчилсны дотор Засгийн газрын танхимын тэргүүн бөгөөд Ерөнхий сайдын туслах Жана Нагяава багтсан нь түүнийг ийнхүү огцроход хүргэсэн байна.

Ерөнхий сайдын энэхүү шийдвэр нь 2010 онд парламентын сонгуулийн дараа 3 нам хамтран байгуулсан эвслийн Засгийн газрыг тараахад хүргэж болох юм. Гэхдээ Ерөнхий сайд Петр Нечас–ийн үзэж байгаагаар дараа жил болох парламентын сонгууль хүртэл энэ удаагийн Засгийн газрыг өөрчлөхгүй байж магадгүй юм. Тэрээр “одоогийн нөхцөлд энэ бол хамгийн сайн шийдвэр” гэж хэлсэн юм. “TOP 09” нам болон “Либерал Ардчилсан нам”-ууд уг төлөвлөгөөг хүлээн зөвшөөрөөд байгаа юм. “TOP 09” намын дэд дарга, Сангийн сайд Мирослав Калоусек “энэ Засгийн газрыг үргэлжлүүлэн ажиллуулахад бид бүхий л боломжит арга хэмжээг авах үүрэгтэй” гэж хэлжээ.

Энэхүү нөхцөл байдлыг шийдвэрлэхэд хэдий хэмжээний хугацаа хэрэгтэй нь тодорхойгүй бөгөөд намууд хэлэлцээрээ яаралтай хийх хэрэгтэй байгаа юм.

28. Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн олон улсын консорциум нууц компаниудын ард байгаа эздийг илчлэх оффшор бүсийн мэдээллийн санг дэлгэв³⁷⁸ (2013.06.28)

Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн олон улсын консорциум. Түүхэнд анх удаа Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн олон улсын консорциум (ЭССОУК) нийт 10 оффшор бүсийн нууцаас дэлгэхэд туслах зорилгоор “Оффшор нууц мэдээллийн сан”-г олон нийтэд дэлгэж байна.

³⁷⁵ Nguyen Tan Dung

³⁷⁶ http://www.washingtonpost.com/world/europe/czech-prime-minister-announces-he-will-resign-after-top-aid-is-charged-with-bribery/2013/06/16/07222460-d6ce-11e2-ab72-3f0d51ec1628_story.html

³⁷⁷ Petr Necas

³⁷⁸ http://offshoreleaks.icij.org/?utm_source=email&utm_campaign=app-announcement&utm_medium=publici-email

Оффшор нууц мэдээллийн санд доорх линкээр орж, оффшор бүсийн олон мянган нууц компани, сан болон итгэмжилсэн компаниудын мэдээллээс хайлт хийж, оффшор компаниуд, тэдний жинхэнэ эзэн, сүлжээний талаар мэдээлэл олж авах боломжтой юм (<http://thecenterforpublicintegrity.cmail5.com/t/t-l-ztkkjt-pdkkiklk-g/>).

Мөн түүнчлэн <http://offshoreleaks.icij.org/> цахим хуудас юм.

Энэхүү мэдээллийн сан нь ЭССОУК, 58 улс орны 112 сэтгүүлчтэй хамтран шинжилгээ хийсэн оффшор бүсийн 2.5 сая нууц файлын нэг хэсэг юм.

Өнгөрсөн 4 дүгээр сараас хойш ЭССОУК-ын оффшор бүсийн нууцын талаар олж авсан энэхүү материалд үндэслэн дэлхий дахинд 40 гаруй хэвлэл мэдээллийн байгууллага /*Guardian, Le Monde, Süddeutsche Zeitung, Norddeutscher Rundfunk, Washington Post, Canadian Broadcasting Corporation* зэрэг/-ууд мэдээ, нийтлэл гаргасан юм.

29. АНУ-ын Төрийн Департментын Консулын газрын ажилтан виз олгох ажлаас их хэмжээний мөнгө завшжээ³⁷⁹ (2013.05.23)

АНУ. АНУ-ын Төрийн Департментын Консулын газрын ажилтан Майкл Т. Шестак³⁸⁰ виз олгох үйл ажиллагаагаар Вьетнам иргэдээс хэдэн сая ам.доллартай тэнцэх хэмжээний хээл хахууль авсан байжээ. Түүний энэ хэрэгт мөрдөн байцаалт явуулсан бөгөөд хэрэгт сэжиглэн Калифорни мужид баривчилсан байна.

Энэ хэрэгт мөрдөн байцаалт явуулсан АНУ-ын Төрийн Департментын мөрдөн байцаагч Симон Диницийн бичгээр мэдэгдэж байгаагаар “Төрийн Департментын гадаад үйлчилгээний ажилтан Майкл Т. Шестак нь АНУ-д хууль ёсоор нэвтрэх виз авах хүсэлтэй Вьетнам иргэдээс тус бүр 50000-70000 хүртэлх ам.долларыг хээл хахуульд шаардан авч байсан” гэжээ.

Майкл Т. Шестак нь 2012 оны 9 дүгээр сар хүртэл Хо Чи Мин хот дахь АНУ-ын Консулын газар цагаачлалын бус визийн хэсгийн даргаар ажиллаж байсан юм.

“Тэрээр хээл хахуульд авсан мөнгө оффшор банк ашиглан Вьетнамаас гарган Хятадаар дамжуулан мөнгө угаадаг байсан бөгөөд Бангкок хотод энэхүү мөнгөөрөө үл хөдлөх хөрөнгө худалдаж авсан хэмжээн” мөрдөн байцаагч хэлжээ. “2012 оны 5 дугаар сарын 1-нээс 9 дүгээр сарын 6 хүртэл консулын газар 31386 ширхэг цагаачлалын бус визийн хүсэлт хүлээн авч тэдний 35.1 хувийг л буцаасан байхад мөн энэ хугацаанд Майкл Т. Шестак нь 5489 визийн хүсэлт хүлээн авч 8.2 хувийг л буцаасан” байсан байна.

30. Авлигач төрийн албан хаагчдад өндөр насны тэтгэвэр олгохгүй байж магадгүй³⁸¹ (2013.05.28)

Тайвань. Тус улсын Төрийн албаны сайд Чан Чэ-шэнийн хэлснээр “Төрийн албан хаагчийн тэтгэврийн тухай хууль³⁸²”-д нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаа бөгөөд нэмэлт, өөрчлөлт нь төрийн албан хаагч авлигын хэргээр яллагдсан бол түүнд өндөр насны тэтгэвэр олгохгүй байх заалт юм. Сайдын хэлснээр тус улсад сүүлийн 13 жилийн хугацаанд авлигын хэргээр яллагдаж байсан, тэтгэвэрт гарсан 127 төрийн албан хаагч байгаа бөгөөд тэдэнд 1.3 тэрбум орчим тайвань доллартай тэнцэх тэтгэврийн санг зарцуулсан байна. Сайд Чан Чэ-шэнийн хэлснээр “Төрийн албан

³⁷⁹ <http://www.mcclatchydc.com/2013/05/23/192116/foreign-service-officer-made-millions.html#.UbqmGcp8M68>

³⁸⁰ Michael T. Sestak

³⁸¹ <http://www.chinapost.com.tw/taiwan/national/national-news/2013/05/28/379735/Corrupt-civil.htm>

³⁸² the Civil Servant Retirement Act

хаагчийн тэтгэврийн тухай хууль”-д авлигын хэргээр 7 ба түүнээс дээш жилийн хорих ял авсан төрийн албан хаагчдад тэтгэвэр өгөхгүй, мөн авлигын хэрэгт холбогдож байсан, тэтгэвэр авч байгаа төрийн албан хаагчид тэтгэврийн мөнгөө улсад эргүүлэн төлөх заалтыг нэмж байгаа” юм.

Сайдын мэдээлснээр 1998-2011 оны хооронд авлигын хэрэгт холбогдсон 530 төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр авсан байна. Авлигын хэрэгт холбогдсон тэтгэвэрт гарсан 530 төрийн албан хаагчийн 127-г авлигын хэрэгт буруутайг нь тогтоосон бөгөөд эдгээр буруутай албан хаагчийн 41 нь тэтгэврээ бүтэн авсан, 82 нь сар бүрээр авч байгаа юм.

Энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлахтай холбоотой, авлигын хэрэгт шалгагдаж байгаа төрийн албан хаагчдаас тэтгэвэрт гарах тухай ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэхээ түр зогсоогоод байгаа бөгөөд хэрэв тэтгэвэрт гарсныхаа дараа авлигын хэрэгт оролцсоныг нь тогтоовол тэд тэтгэврээ буцааж өгөх шаардлагатай.

“Төрийн албан хаагчийн тэтгэврийн тухай хууль”-д оруулж байгаа өөр нэгэн өөрчлөлт бол төрийн албан хаагч 10 жилийн хугацаанд үр дүнгийн үнэлгээгээр 3 удаа “С үнэлгээ” авах, эсхүл 2 жил дараалан “С үнэлгээ” авсан бол албан тушаалаас нь чөлөөлнө гэсэн заалтыг нэмэхээр төлөвлөж байгаа ч зарим хүмүүсийн үзэж байгаагаар энэ заалтыг уг хуульд орох ёсгүй хэмээн үзэж байгаа юм.

31. Энэтхэг Улс батлан хамгаалах салбар дахь авлигатай тэмцэнэ³⁸³ (2013.06.01)

Энэтхэг. Дэлхийн зэвсэг худалдан авагч томоохон армийн нэг болох Энэтхэгийн арми батлан хамгаалах салбарт зэвсэг худалдан авах үйл ажиллагаанд авлигыг арилгах чиглэлээр шинэ бодлого авч хэрэгжүүлэхээ мэдэгдлээ. Энэхүү мэдэгдэл нь Ерөнхий сайд Манмохан Синх батлан хамгаалах салбар дахь авлигатай тэмцэхээ хэлсний дараа болж байгаа юм.

Батлан хамгаалахын сайдын хэлснээр “шинэ бодлогоор дэлхийд дөрөвдүгээрт ордог тус улсын армийн зэвсэг худалдан авах үйл ажиллагаанд “ил тод байдлын өндөр стандарт” тогтоохыг зорьж байгаа.

Энэтхэг Улс нь армийн тоног төхөөрөмжөө сайжруулах зорилгоор байлдааны онгоц, нисдэг тэрэг, артиллер, өөрөө явагч зэрэг томоохон худалдан авалт хийх олон тооны хэлэлцээрийг хийж байгаа юм.

Мөн Италийн “Finmeccanica” компани Энэтхэгт 12 нисдэг тэрэг худалдах 748 сая ам.доллар (560 сая евро)-ын гэрээ байгуулахын тулд хээл хахууль өгсөн гэж буруутгагдаж байгаа бөгөөд энэ хэрэгт мөрдөн байцаалт явуулахын тулд гэрээг түр хойшлуулаад байгаа юм.

Италийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлснээр “Finmeccanica гэрээг байгуулахын тулд Энэтхэгийн албаныханд 50 сая орчим евротой тэнцэх хэмжээний хээл хахууль өгсөн байж болзошгүй” хэмээн тус улсын Прокурор үзэж байгаа юм.

32. Олон улсын хөлбөмбөгийн холбоо (ОУХХ)-ны хүндэт ерөнхийлөгч Жоао Авеланж авлигын хэргийн улмаас ажлаасаа огцорлоо³⁸⁴ (2013.04.30)

Олон улсын хөлбөмбөгийн холбоо. Тус холбооны ерөнхийлөгчөөр 1974-1988 онд ажилласан Жоао Авеланж болон бусад 2 ажилтныг 1990-ээд оны үед Дэлхийн аваргын тэмцээнийг дамжуулах эрх худалдах үйл ажиллагаанаас хээл хахууль авсан хэрэгт холбоотой хэмээн ОУХХ-ны Ёс зүйн хороо үзсэн бөгөөд үүний дараа ОУХХ-ны

³⁸³ [www.khaleejtimes.com/kt-article-display-](http://www.khaleejtimes.com/kt-article-display-1.asp?xfile=data/international/2013/June/international_June22.xml§ion=international)

[1.asp?xfile=data/international/2013/June/international_June22.xml§ion=international](http://www.khaleejtimes.com/kt-article-display-1.asp?xfile=data/international/2013/June/international_June22.xml§ion=international)

³⁸⁴ <http://www.bbc.co.uk/sport/0/football/22351630>

ерөнхийлөгч асан 96 настай Жоао Авеланж хүндэт ерөнхийлөгчийн албан тушаалаасаа огцорлоо.

ОУХХ-ноос “International Sport and Leisure (ISL)” компанид дэлхийн цомын тэмцээний зах зээлд онцгой эрх олгосон юм. ISL компани нь дэлхийн цомын тэмцээнийг телевизээр дамжуулах эрхийг худалдах худалдаанаас олон саяыг олсон юм. Гэвч уг компани нь 2001 онд их хэмжээний өрийн улмаас дампуурсан бөгөөд түүнээс хойш ОУХХ-той байгуулсан гэрээг Швейцарийн холбогдох байгууллагууд шалгаж эхэлсэн байна.

33. Тайваны Засгийн газрын хуучин тэргүүн авлигын хэргээр шоронд хоригдов³⁸⁵ (2013.04.30)

Тайвань. 2 сая гаруй ам.долларын хээл хахууль авсан хэргээр Тайваны Засгийн газрын ерөнхий нарийн бичгийн дарга асан Лин Ю-Шихийг 7 жил 4 сар шоронд хорихоор яллав.

Лин Ю-Ших нь удирдах “Kuomintang” намын дэд дарга бөгөөд Ерөнхийлөгч Ма Ин-жоуийн итгэмжит хүн байсан юм. Түүнийг 60 орчим сая тайван долларын (2.03 сая ам.доллар) хээл хахууль авсны дараа авлигын хэрэгт буруутай нь тогтоогдсон бөгөөд шүүхээс түүнд хорих ял ногдуулахын зэрэгцээ 15.8 сая тайван доллараар торгосон байна.

Тайпей дүүргийн шүүхийн хэвлэлийн төлөөлөгч Хуан Чун-мин сэтгүүлчдэд өгсөн мэдээлэлд “Линийг 4 заалтаар буруутгаж байсан бөгөөд хээл хахууль авахын тулд эрх мэдлээ ашигласан болон тодорхойгүй эх үүсвэрээс хөрөнгөжсөн гэсэн 2 хэрэгт гэм буруутайг нь тогтоож ялласан” гэжээ. Түүний хэлснээр Лин-гийн эхнэр, ээж болон хоёр авга нь уг мөнгө угаах гэмт хэрэгт холбоотой болох нь мөн тогтоогдсон гэжээ.

2010 онд түүнийг хууль тогтоогч байхдаа төрийн хэд хэдэн гэрээ байгуулахад хээл хахууль авсан хэмээн нэгэн бизнесмен буруутгасны дараа өнгөрсөн жилийн 6 дугаар сард Засгийн газраасаа огцорсон юм. Тэрхүү бизнесмен нь орон нутгийн хэвлэлийнхний олж авсан Лин-гийн хээл хахууль авахтай холбоотой аудио бичлэгийг хийсэн юм.

34. Өмнөд Африк нууцын тухай хууль баталсныг шүүмжлэгчид хээл хахууль нуух хэрэгсэл гэж үзэж байна³⁸⁶ (2013.04.25)

Өмнөд Африк. Тус улсын парламент гурван жил үргэлжилсэн эрх зүйн шүүмжлэлийг эцэс болгон төрийн нууцын зохицуулалтын нэгэн хууль баталлаа. Төрийн нууцыг хамгаалах тухай хууль нь Ерөнхийлөгч Жакоб Зума³⁸⁷-гийн засаглалын хугацааны төлөвлөгөөний нэг хэсэг байсан юм.

Шүүмжлэгчид энэхүү хуулийг эрх мэдлээ урвуулан ашиглах боломжийг нээсэн хууль боллоо гэж үзэж байгаа юм. Учир нь Жакоб Зума-гийн тэргүүлж буй Африкын Үндэсний Конгресс болон тэдгээртэй холбоотой авлигын хэргийг мэдээлсэн сэтгүүлч, шүгэл үлээгчдийг энэхүү хуулиар шоронд хорих үндсийг бүрдүүлээ гэж үзэж байгаа юм.

Авлигын асуудлыг олон улсын хөрөнгө оруулагчид байнга анхаарлаа хандуулж байдаг. Зэрэглэл тогтоох “Fitch Ratings” байгууллагаас энэ оны эхээр Өмнөд Африкын зээлжих эрхийг бууруулсан шалтгаануудын дотор авлига нэмэгдсэн, Засгийн газрын үйл ажиллагааны гүйцэтгэл буурсан зэрэг үнэлгээтэй байгаа.

³⁸⁵

<http://www.google.com/hostednews/afp/article/ALeqM5iuOsqmh9QRUTH3TyQazBWtY169Hw?docId=CNG.6046ca1fda9108ebaab354226e87426b.881>

³⁸⁶ <http://www.chicagotribune.com/news/sns-rt-us-safrica-secrecybre93o0vm-20130425,0,2543291.story>

³⁸⁷ Jacob Zuma

Шүүмжлэгчид болон сөрөг хүчнийхэн уг хуулийн талаар Үндсэн хуулийн шүүхэд хандахаар төлөвлөөд байгаа юм. Хууль нь арми, цагдаа болон үндэсний аюулгүй байдлын агентлагийн мэдээллийн системийн талаарх зохицуулалтыг илүүтэйгээр авч үзсэн юм. Хуулиар хээл хахуулийг нуусантай холбоотой эрүүгийн гэмт хэрэг байсан ч, нууц мэдээллийг тархаах болон хууль бусаар эзэмшвэл 25 жил хүртэл шоронд хорихоор заасан юм.

Нууцын тухай хууль нь анхны төсөлдөө бараг Засгийн газрын бүх байгууллагын мэдээллийг хамруулахаар төлөвлөсөн байсан ч шүүмжлэгчдээс ирсэн хүчтэй эсэргүүцлийн дүнд зарим зүйл заалт нь хасагдсан юм.

Нууцын тухай хуулийг Африкын Үндэсний конгрессын 189 гишүүн дэмжиж, 74 гишүүн эсэргүүцэж, баталсан бөгөөд процессын дагуу Ерөнхийлөгч Жакоб Зума гарын үсэг зурснаар хэрэгжиж эхлэх юм. Зума нь ерөнхийлөгч болохоосоо өмнө армийн гэрээтэй холбоотой хээл хахуулийн хэрэгт буруутгагдаж байсан ч хожим нь хэрэгсэхгүй болгосон юм. Мөн өмнөд Африкын хууль сахиулах байгууллага болох Улсын Прокурорын байгууллагаас Жакоб Зумагийн хувийн эдлэнг сайжруулах зорилгоор татвар төлөгчдийн мөнгөнөөс 23 сая орчим ам.долларыг ашигласныг шалгаж байгаа бөгөөд Засгийг газраас “аюулгүй байдлыг сайжруулах зайлшгүй байдлын улмаас уг мөнгийг зарцуулсан, ямар ч хууль бус зарцуулалт болоогүй” гэж тайлбарлаж байгаа юм.

35. Францын цахилгаан холбоо компанийн захирал авлигын хэргээр шүүхэд дуудагдав³⁸⁸ (2013.04.25)

Франц. Тус улсын Цахилгаан холбоо компанийн гүйцэтгэх захирал Степан Ричардыг Засгийн газрын алба хашиж байх үетэй нь холбоотой авлигын хэрэгт холбогдуулан тус улсын шүүхэд дуудаад байна.

“Credit Lyonnais” банкны 1993 оны хэрэгтэй холбоотойгоор Бернард Тапей-д учирсан 285 сая евро (\$370.37 million)-гийн хохирлыг барагдуулах талаар Засгийн газрын шийдвэрийг холбогдох байгууллагууд нь мөрдөн шалгасаар байгаа юм.

Степан Ричард нь тухайн үед Францын сангийн сайд асан Кристин Лагардын зөвлөх бүрэлдэхүүнд орж ажиллаж байжээ. Тэрээр Францын өдөр тутмын сонин “Le Monde”-д төсөв болон санхүүгийн асуудал хариуцсан шүүхэд дуудагдсанаа илэрхийлж “надад энэ хэрэгт ямар ч нуух зүйл байхгүй” гэж мэдэгдсэн юм.

Мөн Кристин Лагард нь дээрх хэрэгтэй холбоотойгоор энэ 5 дугаар сарын сүүлээр шүүхэд асуугдахаар мөн дуудагдаад байна.

36. Египетийн сангийн сайд асан Бутрос-Галийг эчнээгээр бүх насаар нь яллав³⁸⁹ (2013.04.23)

Египет. Кайр хотын эрүүгийн хэргийн шүүхийн мэдээлснээр Египет Улсын сангийн сайд асан Бутрос-Гали³⁹⁰-ийг эчнээгээр³⁹¹ авлигын гэмт хэрэгт холбон бүх насаар нь шоронд хорихоор яллажээ.

Бутрос-Гали нь Хосни Мубаракыг төрийн тэргүүн байх үед Сангийн сайдын үүргийг гүйцэтгэж байсан бөгөөд мөн түүний авга ах Буртос Буртос-Гали нь 1992-1996 онд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын албыг хашиж байсан юм.

³⁸⁸ <http://www.chicagotribune.com/business/sns-rt-us-francetel-ceo-probobre93o0fv-20130425,0,4686342.story>

³⁸⁹ <http://www.reuters.com/article/2013/04/23/us-egypt-court-idUSBRE93M0G520130423>

³⁹⁰ Youssef Boutros-Ghali

³⁹¹ in absentia

Тэрээр улсаасаа оргон гарсан бөгөөд 2011 онд түүнийг эчнээгээр авлигын хэрэгт буруутган 30 жилийн хугацаанд шоронд хорих ял ногдуулаад байсан юм.

Тэтгэлгээр олгох хүнсний газын купонд шилжүүлэх байсан 13 сая Египетийн паунд буюу 1.9 сая ам.долларын сангийн хөрөнгийг үрэгдүүлсэн явдалд түүнийг буруутгасан юм.

Тус улсад 2011 оны бослогоор Мубаракын засаглалыг унгах үед албан тушаал хашиж байсан олон тооны эрх мэдэлтнүүд хээл хахуулийн хэргээр удаа дараа яллагдаж, зарим нь шалгагдаж байгаа юм. 84 настай Мубарак, дотоод хэргийн сайд асан Хабиб ал-Адлийн хамт 800 гаруй жагсагчдын амийг хөнөөсөн хэрэгт буруутгагдан өнгөрсөн 6 дугаар сард яллагдсан юм.

Мубарак болон Хабиб ал-Адли нарыг бүх насаар нь шоронд хорихоор ялласан ч шүүхээс хэргийг дахин шүүхээр болоод байгаа юм. Гэвч энэ сард болсон шүүх хурлаас уг хэргийг түр түдгэлзүүлж байгаа юм.

37. Хонконг Улсын Авлигын эсрэг хорооны дарга асан эх газрынханы бэлэгт ихээхэн хэмжээний мөнгө зарцуулж байжээ³⁹² (2013.04.23)

Хонконг. Тус улсын Авлигын эсрэг хорооны комиссар асан Тимоти Тонг Хин-мина³⁹³ нь тус хорооны даргаар 5 жил ажиллах хугацаандаа албан ёсны айлчлал, бэлэг, зоогт зарцуулах зардлаа хэтрүүлсэн хэрэгт буруутгагдаж байна.

Авлигын эсрэг хороо нь Тонг-ийг удирдаж байх хугацаанд нийт 220000 хонконг долларыг бэлгэнд зарцуулсан бөгөөд үүний 154000 хонконг долларыг эх газрын төрийн байгууллага болон холбогдох байгууллагын албан хаагчдад бэлэг болгон өгсөн гэж тус улсын Хууль тогтоох зөвлөлөөс мэдээллээ.

Мөн Тонг нь албан ёсны айлчлалд 757921 хонконг долларыг зарцуулсан, бөгөөд албан тушаалд байх хугацаандаа нийт 34 албан айлчлал хийсний 19 нь эх газарт хийсэн айлчлал байгаа юм.

Тонг 2007-2008 оны санхүүгийн жилийн хугацаанд нэг удаа Хятадын дээд прокурорт 4140 хонконг долларын үнэ бүхий чулуун сийлбэр, 2010-2011 онд Авлигатай тэмцэх байгууллагуудын олон улсын холбооны ерөнхийлөгчид 2082 хонконг долларын үнэ бүхий алчуур бэлэглэсэн байна. Мөн түүний бэлэглэсэн 48 бэлэг нь 500 хонконг доллараас өндөр үнэтэй байгаа нь тус улсын төрийн албан хаагчийн бэлэгний үнийн хязгаарыг давсан байна.

38. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба: Зүүн Ази, Номхон далайн бүс дэх улс хоорондын зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлийн мөнгөний урсгал жилд 90 тэрбум ам.доллар³⁹⁴ (2013.04.16)

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба. Тус албанаас 2013 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр гаргасан тайланд Зүүн Ази, номхон далайн бүс дэх зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл хууль бус зах зээлээс ойролцоогоор жилд 90 тэрбум ам.долларыг олдог гэжээ. Энэ нь Мьянмар Улсын ДНБ-ий хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний дүн юм.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас гаргасан “Зүүн Ази, Номхон далайн бүс дэх улс хоорондын зохион байгуулалттай гэмт хэргийн үнэлгээ” гэсэн энэхүү тайлан нь Зүүн Ази, Номхон далайн бүс дэх улс хоорондын зохион байгуулалттай гэмт хэргийн талаарх анхны цогц судалгаа юм. Энэхүү тайланд хүн

³⁹² <http://www.scmp.com/news/hong-kong/article/1221689/icacs-ex-boss-spent-big-mainland-gifts>

³⁹³ Timothy Tong Hin-ming

³⁹⁴ http://www.unodc.org/documents/southeastasiaandpacific/Publications/2013/TOCTA_EAP_web.pdf

худалдаалах, хууль бусаар барааг хил нэвтрүүлэх, мансууруулах бодис, байгаль орчны гэмт хэрэг (мод үйлдвэрлэл, электрон хэрэгслийн хог хаягдал, озон задлагч бодис), хуурамч бараа болон эмийн үйл ажиллагаанаас гэмт хэргийн бүлэглэлийн олж буй жилийн орлогын талаар дэлгэрэнгүй тусгасан байна.

Тайлангийн нээлт Сидней хотод болсон бөгөөд Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны дэд захирал ноён Сандип Чавла “энэхүү тайлан нь хууль бус хил давуулах худалдааны үйл ажиллагаа, түүний энэ бүс нутагт өрнөж байгаа, хаана үйлдэгдэж байгаа, хэзээ, хэн, яагаад явуулж байгаа талаарх дүрслэл юм” гэж тэмдэглэж байна.

Энэхүү тайланд хууль бус барааг хил давуулах үйл ажиллагаанаас 24.4 тэрбум ам.доллар, хууль бус мод үйлдвэрлэлээс 17 тэрбум ам.доллар, геройны үйл ажиллагаанаас 16.3 тэрбум ам.доллар, метамфетамин 15 тэрбум ам.доллар, хуурамч эмийн худалдаанаас 5 ам.доллар, хууль бус электрон хэрэгслийн хог, хаягдлаас 3.75 тэрбум ам.долларыг Зүүн Ази, номхон далайн бүс дэх гэмт хэргийн бүлэглэлүүд жил бүр олж байгааг тооцсон байна.

Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны Зүүн Ази, Номхон далайн бүсийн төлөөлөгч ноён Жереми Дуглас “улс хоорондын гэмт хэргийн үйл ажиллагаанд дэлхий нийтээрээ анхаарлаа хандуулах шаардлагатай болжээ. Энэ гэмт хэргээс хууль бусаар олж байгаа орлогоор хөрөнгө, компани худалдаан авч, түүгээрээ авлигыг бий болгож байна” гэж хэлжээ.

Судалгааны тайланг дараахь линкээс үзэж болно.

http://www.unodc.org/documents/southeastasiaandpacific//Publications/2013/TOCTA_EA_P_web.pdf

39. Францын ерөнхийлөгч Олланд: Татвараас зугтах газар үгүй болгоно³⁹⁵ (2013.04.10)

Франц. Тус улсын Ерөнхийлөгч Франсуа Олланд³⁹⁶ хэвлэлийн бага хурлын үеэр “дэлхийн дахинд болон европын бүсэд татвараас зугтах бүсүүдийг үгүй болгох³⁹⁷ хэрэгтэй юм” гэжээ. Мөн тэрээр Францын банкууд хэрэглэгчдийнхээ нэрсийн жагсаалтыг улс улсаар нь гарган дэлхий дахинд мэдээлэх ёстой. Татвараас зугтах газраас татгалзсан ямар ч улстай Франц улс бүх талаараа хамтран ажиллахад бэлэн” гэжээ.

Энэ нь Францын сангийн сайд асан Жером Кахузакыг Швейцарын банк дахь нууц дансандаа 600000 евро эзэмшиж байсан хэргээр буруутгагдсаны дараа болж байгаа юм. Мөн ноён Жером Кахузакыг санхүүгийн мэдээллээ буруу мэдээлсэн гэж түүнийг Социалист намаас хөөгөөд байгаа юм.

Ерөнхийлөгч, сайд асан Жером Кахузакын талаар “шүүгчид энэ хэрэг дээр ажиллаж байгаа. Тэд өөрсдийн шүүлтээ явуулна”. Ноён Жером Кахузак Үндэсний ассамблейд эргэн ирэх хэрэггүй байх. Миний бодлоор “энэ бол хүний мөн чанарын асуудал. Хэн нэгэн парламентдаа худлаа хэлээд яаж эргэн ирж чадна гэж?” гэж тэмдэглэж байна.

³⁹⁵ <http://www.bbc.co.uk/news/world-europe-22094194>

³⁹⁶ Francois Hollande

³⁹⁷ eradication

40.Хээл хахуулийн улмаас төрийн албан хаагч 29 сая ам.долларын торгууль төлнө³⁹⁸ (2013.12.17)

ОХУ. Дотоод яамнаас мэдээлж байгаагаар хээл хахууль авахаар завдсан төрийн албан хаагчид 950 сая рубль (29 сая ам.доллар)-ын торгууль ногдуулсан нь Орос Улсын түүхэн дэх хамгийн том торгууль болоод байна.

Москвагийн тойргийн Ленин дүүргийн нэгдүгээр орлогч дарга асан Лев Львовыг хээл хахууль авахаар завдсанд буруутай болохыг нь тогтоож тус бүсийн шүүхээс уг шийдвэрийг гаргасан байна.

Орон нутгийн барилгын нэгэн компанийн шинээр баригдсан орон сууцны барилгад худалдах зөвшөөрөл олгохын тулд Лев Львов 2011 онд тус компаниас 500000 ам.долларын хээл хахууль шаардсан хэмээн Дотоод яамнаас мэдэгдээд байгаа юм.

Шүүхээс тус барилгын компаниас мөнгө авч байхдаа баригдсан, Лев Львовийн хамсаатан Игорь Комаровт мөн 500 сая рублийг торгууль ногдуулсан байна.

Мөрдөн байцаах хорооны дарга Александр Бастрыкин “Орон нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын 1600 гаруй албан хаагч сүүлийн 2 жилийн хугацаанд авлигын хэрэгт холбоотой болох нь тогтоогдсон. Энэ хугацаанд 9 тэрбум рубльтэй тэнцэх хэмжээний хохирлыг Орос Улсад учруулсан” гэж мэдэгдэж байсан юм.

Транспаренси Интернэшнл байгууллагын судалгаагаар дэлхийн тэргүүлэх эдийн засагтай улсуудаас хамгийн их авлигатай нь Орос Улс болохыг тогтоосон бөгөөд Пакистан, Гамби, Мали Улстай ижил байрт орсон юм.

41.Хятад Улс 2014 онд Эрүүл мэндийн салбар дахь авлигын “хар жагсаалт”-ыг гаргана³⁹⁹ (2013.12.27)

БНХАУ. Хятад Улс эрүүл мэндийн салбар дахь авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд хээл хахууль өгсөн нь тогтоогдсон, эрүүл мэндийн салбар дахь тоног төхөөрөмж болон эм, эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн “хар жагсаалт”-ыг гаргахаар болжээ.

Авлигын гэмт хэрэгт холбогдсон үйлдвэр, хувь хүний нэгдсэн жагсаалтыг гаргаж олон нийтэд нээлттэй байршуулах болно хэмээн Үндэсний эрүүл мэнд, Гэр бүл төлөвлөлтийн хорооноос мэдээлсэн юм. Уг мэдээллийн дагуу 2014 оны 3 дугаар сараас эхлэн энэхүү жагсаалтыг гарган, хэрэгжүүлж эхлэх юм.

Хар жагсаалтад орсон компаниудыг тухайн хэрэгт холбогдсон бүс нутагтаа 2 жилийн хугацаанд борлуулалтын үйл ажиллагаа явуулахыг нь хориглох юм. Мөн уг жагсаалтад 5 жилийн хугацаанд хоёр болон түүнээс дээш удаа орсон компанийг үндэсний хэмжээнд 2 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулахыг нь хориглох юм.

Хятад Улс дахь эрүүл мэндийн салбар, ялангуяа дотоодын болон олон улсын эм, эмийн бүтээгдэхүүн болон хуурай сүү үйлдвэрлэгч компаниудын авлигын асуудал олны анхаарлын төвд байсан жил бол өнгөрөгч 2013 он байв.

Эдгээр хэргүүдийн хамгийн том нь Британийн эм үйлдвэрлэгч “GlaxoSmithKline” компанийн оролцсон мөрдөн байцаалт байсан юм.

³⁹⁸ http://rapsinews.com/anticorruption_news/20131217/270130408.html

³⁹⁹ <http://www.reuters.com/article/2013/12/27/china-corruption-idUSL3N0K615R20131227>

Хятад Улсын эрүүл мэндийн салбарын 2011 оны зарлага болох 357 тэрбум ам.долларын хэмжээ 3 дахин нэмэгдэж 2020 он гэхэд 1 их наяд ам.доллар болно гэсэн урьдчилсан тооцоог зөвлөгөө өгөх “McKinsey” фирм гаргаад байгаа юм. Энэ нь Хятад Улс эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эм, эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын хувьд хамгийн их ашиг олох зах зээл болох хандлагатай байгааг илэрхийлж байна.

Уг хар жагсаалтад зөвхөн Хятадын шүүхээс буруутай нь тогтоогдсон компаниудаас гадна авлигын жижиг хэрэг буюу санхүү, эрүүл мэндийн салбараас захиргааны шийтгэл хүлээсэн компаниудыг ч хамруулах юм.

Үндэсний эрүүл мэнд, Гэр бүл төлөвлөлтийн хорооноос мэдэгдэж байгаагаар хар жагсаалтад орсон нэгжүүдийг албан ёсны нэр, хаяг, хуулийн төлөөлөгч болон холбогдсон хэргийнх нь талаар мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулах юм.

Журмын дагуу тус улсын бүсийн эрүүл мэндийн газрууд 1 сарын дотор өөрсдийн жагсаалтын төслийг Үндэсний эрүүл мэнд, Гэр бүл төлөвлөлтийн хороонд ирүүлэх ёстой юм.

42. Авлигын эсрэг хичээлийг анхан шатнаас нь заана⁴⁰⁰ (2013.12.17)

Африк. Африкын улс орнуудад анхан шатны боловсрол олгох сургуулиас нь эхлэх хүүхдүүдэд авлигын эсрэг хичээл заах ёстой гэж Бүх Африкын парламент (БАП)-ын төлөөлөгчид үзэж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх Африкын конвенцийг баталсны 10 жилийн ойг 12 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд Танзани Улсын Арша хотод тэмдэглэн өнгөрүүлэх үеэр энэхүү саналыг хэлэлцэн баталсан гэж БАП дахь Уганда Улсын төлөөлөгч Какоба Оньяанго⁴⁰¹ хэлсэн байна.

Тэрээр “ёс суртахуун, зөв төлөвшлийг маш эрт үеэс нь хүүхдүүдэд суулгах ёстой гэж бид үзсэн. Тиймээс ийнхүү хичээл заах нь тэднийг ёс суртахуунтай иргэн болоход нь туслах бөгөөд энэхүү ёс суртахуун нь авлигатай тэмцэхэд дэмжлэг болох болно” хэмээн тэмдэглэн хэлэв.

Авлигатай тэмцэх байгууллага, боловсрол болон хуулийн байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн БАП-ын төлөөлөгчид авлигатай тэмцэхэд боловсролын байгууллагын үүрэг оролцооны талаар хэлэлцсэн юм.

БАП-ын төлөөлөгчдийн үзэж байгаагаар уг конвенцийг соёрхон батлаагүй улс орнууд ч ялгаагүй энэхүү саналыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Африкын авлигын эсрэг конвенцид одоогоор 34 улс орон нэгдэн орсон байгаа юм.

Мөн төлөөлөгчдийн үзэж байгаагаар Засгийн газруудыг авлигатай тэмцэх байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор санхүүжилтийг нь нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

⁴⁰⁰ <http://www.newvision.co.ug/news/650587-mps-want-anti-corruption-taught-in-schools.html>

⁴⁰¹ Kakoba Onyango

43. Балба Улсын Авлигатай тэмцэх байгууллага төрийн 35000 албан хаагчид торгууль ногдуулав⁴⁰² (2013.12.30)

Балба. Балбын авлигатай тэмцэх байгууллага (СИАА) хөрөнгө, орлогын мэдүүлэгээ гаргаж өгөөгүй 35000 төрийн албан хаагчид 5000 балбын рупи (хүн бүрт 52 ам.доллар)-тэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулсан байна.

Хүнд сурталтнуудыг бохир аргаар хөрөнгөжихөөс сэргийлэхийн тулд төрийн албанд орсноос хойш 60 хоногийн дотор, мөн санхүүгийн жил дуусахаас 60 хоногийн өмнө төрийн албан хаагчид хөрөнгийнхөө талаар дэлгэрэнгүй мэдээлэх үүрэгтэй.

СИАА-ийн хэвлэлийн төлөөлөгч Шрээдхар Сапкота⁴⁰³ Синхуа агентлагт утсаар мэдээлэхдээ “өөрсдийн хөрөнгийнхөө талаар мэдээлэхдээ хайхрамжгүй хандсан албан хаагчдад бид торгууль ногдуулахаар болсон” гэсэн юм.

Түүний хэлснээр уг шийтгэлийг ногдуулсан албан хаагчдын дотор доод түвшний алба хаагч, мөн элчин сайд хүртэл багтаад байгаа юм.

"Яамдын нарийн бичгийн дарга нарт холбогдох байгууллагуудынхаа албан хаагчдын торгуулийн мөнгийг 30 хоногийн дотор төлж барагдуулах шаардлага хүргүүлсэн. Мөн яамдад энэ хугацаанд дээрх албан хаагчдыг хөрөнгийнхөө талаар дэлгэрэнгүй мэдээлэл гаргуулан авах үүрэг өгсөн" гэж Шрээдхар Сапкота хэлсэн юм.

Олон улсын байгууллагуудын хэд хэдэн судалгаагаар Балба Улс нь дэлхийн хамгийн их авлигатай улс орнуудын нэгд тооцогддог юм.

⁴⁰² http://www.business-standard.com/article/news-ians/nepal-s-anti-graft-body-fines-35-000-state-employees-113123000733_1.html

⁴⁰³ Shreedhar Sapkota

С

Салбар, үйл ажиллагаа

авлига7, 8, 9, 11, 12, 17, 18, 19, 20, 24,
26, 27, 28, 29, 31, 32, 34, 35, 39, 40, 42,
43, 44, 47, 48, 51, 53, 55, 59, 63, 64, 65,
68, 70, 71, 74, 77, 81, 82, 86, 89, 90, 91,
94
авлигатай тэмцэх 6, 13, 14, 18, 21, 26, 27,
29, 30, 34, 36, 37, 44, 45, 49, 50, 51, 54,
55, 59, 60, 62, 64, 65, 66, 69, 71, 76, 77,
83, 84, 85, 88, 89, 90, 98, 99, 100
авлигач 8, 14, 41, 88, 92
авлигын..6, 8, 9, 10, 11, 13, 17, 25, 27, 29,
33, 35, 36, 40, 41, 42, 43, 45, 47, 49, 60,
61, 62, 63, 64, 65, 66, 67, 68, 74, 76, 78,
83, 93, 94, 96, 98, 99
авлигын гэмт хэрэг10
ардчилсан..... 22, 33, 34, 54, 75, 91
армийн71
аудит51
Аудитын71, 88
аюул.....24, 64, 68
багш 14, 41, 44, 70, 87, 91
байгаль орчин.....31
Банк11, 50, 57, 58, 63, 74, 83, 92, 97
батлан хамгаалах..... 20, 42, 57, 71, 93
бизнес.....6, 9, 11, 53, 63, 67, 74, 82, 85
бизнесийн ... 10, 16, 26, 27, 29, 31, 36, 45,
59, 64, 70, 72, 79, 85
Боловсрол .. 12, 25, 31, 66, 68, 69, 70, 74,
86, 87, 99
боловсролын 12, 24, 25, 38, 43, 44, 51,
63, 68, 69, 70, 74, 86, 87, 99
Боловсролын.... 15, 34, 35, 38, 43, 44, 70,
86, 87, 90
боловсролын салбар 68, 86, 87
валют74
гаалийн байгууллага11
гадагш шилжсэн12, 74
газрын24, 90
газрын тос.....56, 57, 75
гэмт хэрэг.... 12, 15, 16, 18, 20, 37, 42, 46,
52, 53, 62, 66, 67, 88, 95, 97
донор57
ёс зүйн 9, 22, 23, 24, 38, 68, 87, 88
ёс суртахуун99

зарцуулсан ... 7, 30, 42, 45, 51, 77, 80, 92,
95, 96
засаглал.....24, 32, 84, 96
Засгийн газар . 7, 9, 11, 17, 26, 27, 29, 34,
36, 45, 48, 50, 56, 65, 70, 74, 79, 83
ил тод.9, 15, 18, 22, 23, 27, 28, 32, 40, 41,
42, 45, 51, 52, 54, 56, 57, 59, 68, 72, 75,
83, 85, 93
ил тод байдал..... 27, 57, 72, 83, 85
иргэд65, 66
итгэл..... 24, 28, 39, 47, 62, 65, 81, 85
компани....7, 27, 56, 59, 70, 71, 82, 85, 92,
93, 94, 97
конвенц68
луйврын 15, 18, 42, 43, 78, 79
Мансууруулах бодис 22, 74, 83, 96, 97
мод бэлтгэл79
мөнгө..7, 15, 16, 17, 20, 23, 33, 34, 43, 44,
45, 46, 48, 49, 50, 51, 52, 59, 63, 65, 67,
71, 77, 86, 87, 92, 94, 96, 98
мөнгө угаах . 15, 16, 33, 34, 43, 46, 48, 49,
50, 51, 52, 63, 94
мөрдөн байцаалт ... 41, 42, 44, 61, 77, 78,
84, 92, 93, 98
мэдлэг70, 71
мэдээлэл10, 11, 14, 16, 20, 23, 29, 32, 42,
45, 50, 52, 53, 54, 56, 59, 60, 63, 65, 70,
71, 72, 74, 75, 77, 82, 84, 85, 88, 89, 90,
92, 100
нам11, 17, 40, 41, 53, 62, 77, 81, 91
намын 9, 14, 17, 21, 31, 37, 40, 41, 54, 59,
60, 62, 64, 70, 72, 75, 76, 77, 78, 91, 94
нийгэм..... 13, 68, 69, 83
нийтийн..13, 21, 22, 26, 28, 30, 52, 53, 54,
68, 69, 85, 86, 89
нууц..19, 20, 40, 54, 57, 67, 81, 91, 92, 95,
97
нууцын95
оффшор..... 9, 10, 91, 92
прокурор 13, 15, 23, 48, 50, 61, 62, 71
прокурорын..... 10, 15, 22, 61, 62, 77, 78
радио66, 89
сайд ...6, 10, 15, 22, 30, 35, 41, 42, 43, 45,
46, 48, 49, 52, 53, 66, 69, 75, 78, 79, 91,
92, 93, 95, 96, 97, 100
санхүү 30, 32, 99

санхүүгийн .7, 8, 10, 15, 16, 17, 18, 23, 33,
46, 50, 63, 68, 74, 75, 81, 82, 95, 96, 97,
100
санхүүжилтэд15
Сенатын.....78
Стратеги36, 83
судалгаа .15, 22, 23, 26, 27, 80, 89, 90, 96
сурах25
сургалт44, 74
сургууль 23, 26, 37, 44, 67, 86
сурталчилгаа 13, 14
танилцах аялал76
татвар9, 10, 14, 56, 67, 68, 76, 85, 95
татварын..... 9, 10, 11, 13, 42, 51, 59, 71
төлүүлсэн.....7, 13
төрийн албан хаагч71, 92, 93, 98
төрийн албан хаагчид .. 12, 49, 76, 93, 98,
100
Төрийн албаны.....80, 92
төрийн байгууллага..... 45, 49, 89, 90, 96
төрийн нууцын94
тэтгэвэр.....92, 93
тээвэр32, 59
улс төрийн .6, 9, 17, 21, 27, 32, 35, 36, 41,
47, 51, 53, 54, 62, 64, 67, 71, 74
урьдчилан сэргийлэх.... 27, 33, 36, 39, 43,
45, 49, 50, 59, 65, 81, 89, 91, 99
Уул уурхайн56
Үндсэн хуульд.....21, 22
хар тамхи.....19
хар тамхины35, 74
хариуцлагатай .. 13, 21, 22, 48, 54, 55, 59,
65, 68, 85, 87
хичээл 44, 90, 91, 99
хөрөнгө ...7, 10, 12, 13, 17, 20, 21, 28, 29,
30, 31, 42, 48, 49, 51, 54, 60, 67, 70, 79,
87, 92, 94, 97, 100
хөтөлбөр..... 36, 42, 57, 66, 68, 83, 91
Хуулийн45
хууль 6, 7, 9, 10, 11, 14, 15, 16, 17, 19, 20,
21, 22, 26, 27, 31, 33, 34, 35, 36, 37, 43,
45, 46, 47, 48, 49, 50, 51, 54, 60, 61, 63,
64, 65, 67, 68, 69, 70, 71, 72, 74, 75, 76,
77, 78, 79, 80, 81, 83, 87, 88, 89, 90, 92,
93, 94, 95, 96, 97
хууль сахиулах 49, 61, 63, 89, 95
хууль тогтоох.....96
хээл хахуулийн... 6, 11, 12, 19, 21, 29, 32,
36, 37, 42, 43, 58, 59, 64, 65, 67, 68, 74,
75, 91, 95, 96, 98
хээл хахууль. 6, 7, 8, 9, 11, 17, 20, 28, 29,
33, 36, 43, 44, 48, 49, 51, 54, 55, 59, 64,

66, 67, 70, 75, 78, 81, 84, 86, 89, 90, 92,
93, 94, 98
хээл хахуульд 6, 8, 11, 58, 64, 86, 92
хяналт ..7, 9, 10, 15, 17, 21, 22, 45, 52, 53,
61, 65, 70, 83, 87, 88
цагдаа 8, 10, 14, 51, 71, 90, 95
Цагдаагийн 19, 20, 40, 46, 65
цахим хуудас 10, 16, 42, 45, 53, 62, 82,
84, 88, 92
шамшигдуулсан..... 14, 37, 38, 79
шийтгэл..11, 14, 44, 45, 59, 60, 66, 68, 79,
87, 99
шинжилгээ 23, 58, 59, 62, 78, 92
шударга ...7, 18, 19, 21, 22, 23, 32, 49, 54,
59, 63, 65, 68, 74, 75, 80
шүгэл.....45, 65, 81, 82
шүгэл үлээгч54, 81
шүгэл үлээгчдийг хамгаалах.....45, 82
шүүгч.10, 18, 22, 24, 36, 75, 76, 84, 88, 89
шүүх .18, 21, 22, 23, 35, 36, 49, 53, 64, 79,
83, 84, 88, 90, 96
шүүх засаглал 49, 84, 90
шүүхийн .18, 22, 23, 24, 36, 53, 63, 84, 88,
89, 94, 95
эдийн засаг 31, 35, 64, 83
эмнэлгийн 28, 37, 39, 48, 90
эмч23, 28, 48, 49
эрсдлийг46, 57, 72
эрүүл мэнд..... 24, 32, 68, 69, 98, 99
Эрүүл мэнд42, 90
эрүүл мэндийн.... 9, 23, 24, 28, 33, 48, 66,
79, 80, 98, 99
эрүүл мэндийн салбар ... 9, 28, 48, 66, 80,
98
эрх мэдэл.....24, 41, 61, 74
эрчим хүч29, 31
эрэн сурвалжлах53, 82
Эрэн сурвалжлах.....53, 91
ял .6, 11, 28, 37, 40, 53, 63, 68, 79, 93, 94,
96

У

Улс, олон улсын байгууллага

Авлига болон бусад зохион
байгуулалттай гэмт хэргийг мэдээлэх
төсөл82
Авлигын эсрэг академик санаачилга....74
Австрали16, 17, 19, 20, 42, 43, 52, 58, 60,
63
Австри.....57

Ази-номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК).....	52	Марокко	21, 61
Ангол.....	21, 60, 61, 72	Мексик.....	16, 52, 75, 85
АНУ 7, 9, 11, 12, 15, 16, 32, 33, 37, 41, 42, 48, 49, 50, 52, 57, 58, 60, 63, 64, 67, 72, 92		Монгол.....	46, 50, 61, 72, 90
Афганистан.....	16, 35, 46, 61, 87, 88	Мьянмар .	16, 30, 44, 46, 50, 52, 56, 57, 96
Африк.....	39, 99	Мянганы сорилтын корпораци.....	57
Базелийн институт	46	Нигер.....	21, 24, 72, 75
Балба	22, 25, 27, 100	Норвеги.....	7, 57, 77
Бангладеш.....	27, 29	НҮБ	4, 22, 35, 36, 44, 45, 52, 57, 58, 65, 74, 83, 95, 96
Бельги.....	58	НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба	4, 22, 83, 96
БНХАУ ...	10, 11, 14, 17, 26, 28, 30, 37, 40, 47, 52, 62, 63, 71, 74, 77, 88, 98	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга.....	51
Болгар.....	9, 58, 67	Олон улсын стандартын байгууллага (ISO)	31
Болив	16, 21	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага	68
Босни Герцеговин	61	Олон улсын хөл бөмбөгийн холбоо.....	51, 55, 93
Бразил	16, 58, 85	ОХУ.....	16, 36, 37, 52, 64, 74, 75, 76, 98
Бутан.....	21	Өмнөд Африк	85, 94
Вьетнам .	11, 33, 52, 53, 59, 72, 79, 86, 90, 91, 92	Өмнөд Солонгос	48, 52, 53, 58, 61, 67, 70, 71
Герман	16, 20, 58, 72	Пакистан	16, 27, 55, 70, 98
Грек.....	9, 16, 21, 58	Панам	16, 82
Дани	58, 61, 67, 77	Папуа шинэ Гвиней	18
Дэлхийн санхүүгийн шударга байдал	74	парламент	11, 94, 99
Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага .	68	Перу	16, 52
Европын комисс	45	Польш	9, 58
Европын холбоо	8, 81	Португали	57
Египет	61, 64, 95	Румын	6, 9, 58, 82
Индонез ...	6, 13, 52, 65, 66, 75, 76, 79, 84, 89	Сингапур	29, 52, 63, 64, 72
Ирак	35	Словак	9, 45, 58
Иран.....	15, 34, 46	Словени.....	46, 58, 81
Ирланд.....	58, 72	Сомали	35, 61
Испани	58, 90	спортын.....	34, 75
Итали	9, 17, 22, 58	Судан	21, 35, 72
Их Британи	16, 33, 40, 50, 56, 57, 81	Сьерра Леон.....	39
Их сургуулиудын Компостелагийн холбоо	67	Тажикстан	46
Казахстан.....	29	Тайвань.....	52, 76, 77, 92, 94
Камбож	43, 44, 46, 49, 50, 52, 72	Тайланд .	13, 18, 21, 47, 52, 54, 58, 62, 66, 88
Канад	9, 16, 52, 57, 60, 63, 67, 72, 78	Тракс матрикс интернэшнл.....	72
Кени	21	Транспаренси Интернэшнл	13, 21, 25, 27, 28, 29, 33, 43, 45, 49, 55, 60, 63, 66, 67, 81, 83, 85, 86, 89, 98
Кувейт	16	Турк.....	10, 11, 60, 61
Лаос	16, 52	Узбекистан.....	72
Ливи	7	Украин.....	35, 69
Люксембург.....	58, 82	Унгар.....	9, 58
Малави	61	Филиппин.....	7, 52, 84
Малайз.....	44, 52, 65, 85	Финлянд.....	46, 58, 72
Мали	61, 98		

Франц.....	16, 53, 57, 58, 60, 90, 95, 97	Шинэ Зеланд	18, 52, 58, 72
Хойд Солонгос	53, 61	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага	58
Хонконг	10, 29, 43, 72, 96	Энэтхэг.7, 8, 16, 23, 27, 29, 43, 47, 48, 65, 80, 85, 93	
Хорват.....	9, 58	Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн олон улсын консорциум	91
Хятад .6, 10, 11, 12, 14, 15, 17, 31, 41, 43, 47, 53, 58, 60, 61, 63, 77, 85, 98, 99		Эстони	57
Чад.....	72	Япон.....	24, 34, 38, 50, 52, 58, 67, 72, 76
Чех	9, 57, 91		
Швед	9, 33, 57, 72, 77		
Швейцари	49, 58, 67, 82		

Холбоо барих

Хаяг:

МОНГОЛ УЛС АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
5-р хороолол, Сөүлийн гудамж 41
Улаанбаатар хот 14250

Утас:

7011-0251, (976)-11-311919,
1800-1969 /Энгийн утасны тариф/

Факс:

(976)-70112458

Э-мэйл:

contact@iaac.mn

Вэбсайт:

<http://www.iaac.mn>